

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГА

МОНГОЛ УЛСЫН АРАВДУГААР БУЮУ  
2015 ОНЫ ТАЙЛАН



2016 оны 12 дугаар сар

## АГУУЛГА

Товчлолууд ба тодорхойлолтууд .....	1
Тайлангийн индекс.....	3
1 Танилцуулга .....	5
1.1 Танилцуулга .....	5
1.1.1 Холбогдох мэдээлэл.....	5
1.1.2 Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг роль .....	6
1.2 Оролцогчид.....	6
1.3 Талархал .....	7
2 Гүйцэтгэлийн хураангуй.....	7
2.1 Салбарын тойм .....	7
2.2 ОУИТБС-ын оролцоо.....	7
2.3 Тайлангийн цар хүрээ.....	7
2.4 Засгийн газрын нийт орлого .....	8
2.4.1 Нийт олборлох үйлдвэрлэлийн салбараас засгийн газрын хүлээн авсан орлого .....	8
2.4.2 Тохируулгын цар хүрээнд засгийн газрын хүлээн авсан орлого .....	9
2.4.3 Тохируулгын хамрал.....	9
2.4.4 Засгийн газар болон компанийн тохируулсан урсгалын харьцуулалт.....	10
2.5 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал .....	10
2.5.1 Засгийн газар.....	10
2.5.2 Төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН).....	11
2.5.3 Хувийн компаниуд.....	12
2.5.4 Хураангуй .....	13
2.6 Гол асуудлууд.....	14
2.6.1 Нүүрсний борлуулалт .....	14
2.6.2 Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон лицензийн мэдээлэл .....	14
2.6.3 Тайлагнаагүй компаниуд .....	15
3 Монголын олборлох салбар.....	16
3.1 Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого .....	16
3.1.1 Эрх зүйн хүрээ ба олборлох салбарт гарсан хууль эрх зүйн өөрчлөлтүүд (шаардлага 2.1) .....	16
3.1.2 Монгол улсын засгийн газрын 2016-2020 он хүртэлх хугацааны мөрийн хөтөлбөр.....	27
3.1.3 Төсвийн бодлого (шаардлага 2.1) .....	30
3.2 Уул уурхай .....	32
3.2.1 Монголын ашигт малтмалын нөөц .....	32
3.2.2 Стратегийн ач холбогдол бүхий ордууд .....	36
3.2.3 Бичил уурхай.....	38
3.2.4 Засаглал.....	42
3.2.5 Лиценз олголт .....	43
3.2.6 Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох болон шилжүүлэх үйл явц (шаардлага 2.2.a.i).....	44
3.2.7 Лиценз олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд (шаардлага 2.2.a.i) .....	50
3.2.8 Тусгай зөвшөөрөл авах өргөдлийн статистик мэдээлэл .....	51
3.2.9 2015 онд шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүд (шаардлага 2.2.a.iii).....	52
3.2.10 Тусгай зөвшөөрлийн бүртгэл (шаардлага 2.3) .....	54

3.3	Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын ажил, (шаардлага 3.1)	55
3.3.1	2015 онд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажил	55
3.3.2	Хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хайгуулын үйл ажиллагаа	57
3.3.3	Үйлдвэрлэл	58
3.3.4	Экспорт	59
3.4	Газрын тос болон хий	60
3.4.1	Нөөц	60
3.4.2	Газрын тосны лиценз олголт	60
3.4.3	2015 онд байгуулсан бүтээгдхүүн хуваах гэрээ (шаардлага 2.2)	62
3.4.4	Гэрээний талаарх олон нийтийн мэдээлэл (шаардлага 2.4)	63
3.4.5	Үйлдвэрлэл	63
3.4.6	Экспорт	63
3.5	Олборлох салбарын зүгээс эдийн засагт оруулсан хувь нэмэр	63
3.5.1	Олборлох аж үйлдвэрийн хэмжээ	63
3.5.2	Олборлох салбараас орсон засгийн газрын нийт орлого	64
3.5.3	Олборлох үйлдвэрлэлийн экспорт	65
3.5.4	Олборлох аж үйлдвэрлэл дэх хөдөлмөр эрхлэлт	65
3.6	Засгийн газрын институт	65
3.6.1	Уул уурхайн яам (ууя)	66
3.6.2	Ашигт малтмалын газар (амг)	66
3.6.3	Газрын тосны газар	66
3.6.4	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам (бонхажя)	67
3.6.5	Хөдөлмөрийн яам	67
3.6.6	Татварын алба	67
3.6.7	Гаалийн ерөнхий газар	68
3.6.8	Цөмийн энергийн комисс	68
3.6.9	Үндэсний аудитын газар	69
3.6.10	Төрийн өмчийн хороо	69
3.7	Олборлох салбар дахь төрийн оролцоо	69
3.7.1	Төрийн өмчийн компаниуд (төк) шаардлага 2.6(b)	69
3.7.2	Газрын тосны салбар дахь төрийн оролцоо	83
3.7.3	Засгийн газар болон төаан-үүдийн санхүүгийн харилцаа (шаардлага 2.6.a)	83
3.7.4	ТӨААН хоорондын гүйлгээ (шаардлага 2.6)	85
3.7.5	Зээл болон зээлийн баталгаа (шаардлага 2.6(б))	86
3.7.6	Зээлийн баталгаа	88
3.7.7	МУХБ-наас энэхүү нэгтгэлд хамрагдсан компаниудад уул уурхайн бус чиглэлээр олгосон санхүүжилт	88
3.7.8	Орон нутагт хийгдэж буй төлбөр (шаардлага 4.6)	90
3.7.9	Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөр (шаардлага 6.2)	92
3.8	Төсвийн үйл явц болон орлогын хуваарилалт	92
3.8.1	Ерөнхий	92
3.8.2	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (шаардлага 5.2)	98
3.8.3	Хүний хөгжлийн сан	101
3.8.4	Ирээдүйн өв сан	103
3.8.5	Төсвийн тогтворжуулалтын сан	104
3.9	бусад асуудлууд	105
3.9.1	Бенефициар өмчлөгч (шаардлага 2.5)	105
3.9.2	Гэрээний ил тод байдал	107
4	Тохируулгын цар хүрээ болон арга аргачлал	110
4.1	Танилцуулга	110

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны нэгтгэл тайлан

4.2	Цар хүрээг тодорхойлох.....	111
4.2.1	Танилцуулга .....	111
4.2.2	Цар хүрээ ба эхлэлийн семинар.....	111
4.2.3	Санхүүгийн урсгалуудын сонголт .....	112
4.2.4	Засгийн газрын байгууллагуудын сонголт.....	113
4.2.5	Компаниудын сонголт.....	113
4.2.6	2015 оны тохируулгад ашигласан маягтууд.....	116
4.2.7	Мэдээллийн нэгтгэл ба харьцуулалт.....	116
4.2.8	Материаллагийн босго.....	117
4.2.9	Мэдээллийг задлах түвшин .....	117
4.3	Тайлан, мэдээллийн найдвартай байдал.....	118
4.3.1	Монгол улсын аудитын орчин нөхцөл.....	118
4.3.2	ОУИТБС-ын тайлангийн найдвартай байдлыг баталгаажуулах явц .....	119
5	Тохируулгын үр дүн.....	120
5.1	Тохируулгын үр дүн .....	120
5.1.1	Анхлан тайлагнасан урсгалуудын хураангуй.....	120
5.2	Анхны тохируулаагүй зөрүү болон тайлагнаагүй компаниуд.....	121
5.2.1	Анхны зөрүү .....	121
5.2.2	Тохируулаагүй үлдсэн зөрүү .....	122
5.2.3	Тайлагнаагүй компаниуд .....	125
5.3	Нэгтгэлийн үр дүн .....	126
5.3.1	Улсын хэмжээний нэгтгэлийн үр дүн (орлогын урсгалаар).....	126
5.3.2	Орон нутгийн хэмжээний урсгалын нэгтгэлийн үр дүн: орлогын урсгалаар....	128
6	Бусад асуудлууд.....	129
6.1	Бэлэн бус орлого (шаардлага 4.1.c) .....	129
6.2	Дэд бүтцэд хөрөнгө оруулах ба бартерын солилцоо (шаардлага 4.1.d) .....	129
6.3	Нийгмийн зарцуулалт (шаардлага 6.1).....	131
6.4	Тээврийн орлого (шаардлага 4.1.f) .....	132
6.5	Хандив .....	133
6.6	Нөхөн сэргээлтийн мэдээлэл.....	134
6.6.1	Төрөөс байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд баримтлах бодлого ..	134
6.6.2	Байгаль орчныг хамгаалах тусгай данс.....	135
6.6.3	Уул уурхайн салбарын нөхөн сэргээлт, 2006-2015 .....	136
6.7	Цахим тайлагналын систем .....	137
6.7.1	Цахим тайлагналын системийн танилцуулга .....	137
6.7.2	Цахим тайлагналын системийн байдал.....	138
7	Зөвлөмж .....	138
7.1	Өмнөх жилийн зөвлөмжийн хэрэгжилт .....	138
7.2	Тайлагналын талаар цаашид зөвлөмж.....	139
7.2.1	Бүтээгдэхүүн хуваах гэрээ олон нийтэд ил тод бус байна.....	139
7.2.2	Тусгай зөвшөөрлийн мэдээлэл.....	140
7.2.3	ТӨААН-ийн нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлага .....	141
7.2.4	ТӨААН-ийн санхүүгийн менежмент.....	141
7.2.5	Баталгаажуулалт .....	141
7.2.6	Цахим тайлагналын систем .....	142
7.2.7	Хараат бус нэгтгэгчийг томилох цаг хугацаа.....	144
	Хавсралтууд .....	145

**Энэхүү тайлан болон хавсралтуудыг Монголын ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын албаны хүсэлтээр, санаачлагын зорилгын үүднээс МОУИТБС-ын Үндэсний Зөвлөл болон Ажлын Хэсгийн оролцогч талуудын хэрэгцээнд зориулсан болно.**

*ОУИТБС-ын шаардлага болон Ажлын даалгаврын дагуу ил тод болох шаардлагатай зарим мэдээллүүдийг хавсралтаар харуулсан ба их хэмжээний мэдээлэл агуулсан зарим хавсралтуудыг ашиглахад хялбар байх үүднээс ОУИТБС-ын Засаглалыг дэмжих төслийн вебсайтад Ms Excel форматаар ил тод тавьсан.*

Хавсралтын дугаарууд	Хавсралтын тайлбар	Хавсралтыг үзэх линк
1, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11а, 12, 13, 14, 15, 18, 19, 21, 21а, 21б, 22, 23, 26, 27а, 27б, 28, 29, 30, 31	Үндсэн тайлантай хамт хэвлэгдэх ба ОУИТБС-ын засаглалыг дэмжих төслийн сайтад тавигдана.	<a href="http://www.eitimonqolia.mn/mn/r/econciliation-report">http://www.eitimonqolia.mn/mn/r/econciliation-report</a>
2, 3, 11б, 11в, 16а, 16б, 16в, 16г, 16д, 16е, 16ё, 16ж, 16з, 17, 20а, 20б, 24, 25	Үндсэн тайлангаас тусдаа ОУИТБС-ын засаглалыг дэмжих төслийн сайтад тавигдана.	<a href="http://www.eitimonqolia.mn/mn/r/econciliation-report">http://www.eitimonqolia.mn/mn/r/econciliation-report</a>

**ТОВЧЛОЛУУД БА ТОДОРХОЙЛОЛТУУД**

<b>ААН</b>	Аж ахуйн нэгж	Entity
<b>ААНОАТ</b>	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Corporate Income Tax
<b>Ам.доллар</b>	Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт	United States Dollars
<b>АМГТГ</b>	Ашигт малтмал газрын тосны газар	Mineral Resources and Petroleum Authority
<b>АМНАТ</b>	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	License fee for exploitation and exploration of mineral resources
<b>АНУ</b>	Америкийн нэгдсэн улс	United States of America
<b>АОУС</b>	Аудитын Олон Улсын Стандарт	International Standards on Auditing
<b>БЗД</b>	Баянзүрх дүүрэг	Bayanzukh district
<b>БНСУ</b>	Бүгд Найрамдах Солонгос улс	Republic of Korea
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард улс	Republic of China
<b>БО</b>	Байгаль орчин	Environment
<b>БОННУ</b>	Байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	Environmental Impact Assessment
<b>БОНХАЖЯ</b>	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	Ministry of Environment, Green Development and Tourism
<b>БХГ</b>	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	Product Sharing Agreement
<b>ГТГ</b>	Газрын тосны газар	Petroleum Authority
<b>ГТЕГ</b>	Гааль, татварын ерөнхий газар	General Authority of Customs and Tax
<b>ДДЦС</b>	Дарханы дулааны цахилгаан станц	Thermal Power Plant of Darkhan Aimag
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдхүүн	Gross Domestic Product
<b>ДЦС</b>	Дулааны цахилгаан станц	Thermal Power Plant
<b>ЗГ</b>	Засгийн газар	Government
<b>ЗДТ</b>	Засаглалыг дэмжих төсөл	Governance Support Project
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар	Governor's office
<b>МНБ</b>	Мэргэшсэн нягтлан бодогч	Certified Public Accountant
<b>МОУИТБС</b>	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	Mongolia Extractive Industry Transparency Initiative
<b>МТ</b>	Мэдээллийн технологи	Information Technology
<b>МУ</b>	Монгол улс	Mongolia
<b>МУЗГ</b>	Монгол улсын Засгийн газар	Government of Mongolia
<b>МУУА</b>	Монголын уул уурхайн үндэсний ассоциаци	Mongolian Mining Corporation
<b>МУХБ</b>	Монгол улсын Хөгжлийн банк	Development Bank of Mongolia
<b>МУАГ</b>	Монголын Үндэсний аудитын газар	National Audit Office of Mongolia
<b>МХЕГ</b>	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	State Professional Inspection Agency
<b>Мян.тн</b>	Мянган тонн	Thousand tonnes
<b>НББ</b>	Нягтлан бодох бүртгэл	Accounting
<b>НББОУС</b>	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт	International Accounting Standards
<b>ННФ</b>	Нээлттэй нийгэм форум	Open Society Forum
<b>НӨАТ</b>	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Value Added Tax
<b>НҮБХХ</b>	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр	United Nations Development Programme

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

<b>ОНХНС</b>	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	Local Development Consolidated Fund
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан	Local Development Fund
<b>ОТ</b>	Оюу толгой	Oyu Tolgoi
<b>ОТАХ</b>	Олон талт ажлын хэсэг	Multi-Stakeholder Working Group
<b>ОХУ</b>	Оросын холбооны улс	Russia Federation
<b>СБД</b>	Сүхбаатар дүүрэг	Sukhbaatar district
<b>СТОУС</b>	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт	International Standards on Financial Reporting
<b>СЯ</b>	Сангийн яам	Ministry of Finance
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага	Non-governmental Organization
<b>ТБТГ</b>	Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар	Fiscal Policy and Planning Department
<b>ТӨААН</b>	Төрийн өмчит аж ахуйн нэгж	State-Owned Entities
<b>ТӨК</b>	Төрийн өмчит компани	State-Owned Companies
<b>ТӨХ</b>	Төрийн өмчийн хороо	State Property Committee
<b>ТӨХК</b>	Төрийн өмчит хувьцаат компани	State-Owned Joint Stock Company
<b>ТУЗ</b>	Төлөөлөн удирдах зөвлөл	Board of Directors
<b>ТЭЗҮ</b>	Техник эдийн засгийн үндэслэл	Technical and Economic Feasibility Study
<b>УБТЗ</b>	Улаанбаатар төмөр зам	Ulaanbaatar railway
<b>УИХ</b>	Улсын их хурал	Parliament of Mongolia
<b>УКЦС</b>	Уул уурхайн кадастын цахим систем	Mining Cadastral System
<b>УУЯ</b>	Уул уурхайн яам	Ministry of Mining
<b>ҮСХ</b>	Үндэсний статистикийн хороо	National Statistical Committee
<b>ХАБЭА</b>	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Labor Safety and Occupational Hygiene
<b>ХДС</b>	Хөгжлийг дэмжих сан	Development Support Fund
<b>ХК</b>	Хувьцаат компани	Joint Stock Company
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Limited Liability Company
<b>ХУД</b>	Хан-Уул дүүрэг	Khan-Uul District
<b>ХЯ</b>	Хөдөлмөрийн яам	Ministry of Labor
<b>ЦЭГ</b>	Цөмийн энергийн газар	Nuclear Energy Agency
<b>ЧД</b>	Чингэлтэй дүүрэг	Chingeltei District
<b>ШШГЕГ</b>	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	General Executive Agency of Court Decision
<b>ЭДЦС</b>	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц	Thermal Power Plant of Erdenet
<b>ЭМНДШ</b>	Эрүүл мэндийн нийгмийн даатгалын шимтгэл	Health and Social Insurance Premium

ТАЙЛАНГИЙН ИНДЕКС

ААН, 20, 64	ОНХС, 104, 105
ААНОАТ, 16, 100, 129	ОТ, 138
ам.доллар, 40, 41, 65, 92	ОТАХ, 12, 13, 113, 119, 120, 123, 125, 127, 140
АМГТГ, 21, 22, 30, 39, 47, 58, 60, 66, 68, 143, 148	ОҮ, 15, 146
АМНАТ, 99, 101, 108, 128, 129	ОҮИТБС, 11, 12, 14, 15, 60, 75, 88, 117, 118, 121, 128, 132, 144
АНУ, 46, 139	ОХУ, 82
АОУС, 11, 126, 127	СБД, 97
БЗД, 97	СТОУС, 126
БНСУ, 74	СЯ, 100, 119
БНХАУ, 42, 137	ТББ, 48, 85, 89, 140
БО, 129, 134	ТБТГ, 100
БОННУ, 93	ТЕХ, 34
БОНХАЖЯ, 31, 36, 73, 89, 119, 142	ТӨААН, 18, 19, 20, 79, 84, 91, 139, 146, 148, 150
БХГ, 21, 66, 67, 68, 89, 147	ТӨК, 16, 75, 85, 126
ГТГ, 36, 73, 89	ТӨҮГ, 93
ГТЕГ, 119	ТӨХ, 75, 85
ДДЦС, 81, 91	ТӨХК, 21, 91, 136, 137
ДНБ, 14, 22, 41, 64, 69	ТУЗ, 84, 85, 126, 149
ДЦС, 81, 91	ТЭЗҮ, 87, 93
ЗГ, 28, 72, 77, 79, 82, 85, 125, 129, 133, 146	УБТЗ, 77
ЗДТГ, 90, 97, 98	УИХ, 25, 28, 31, 32, 33, 35, 74, 79, 90, 95
ЗЗ, 91	УКЦС, 60
МНБ, 33	УУЯ, 72, 117
МОУИТБС, 14, 15, 16, 17, 151	ҮСХ, 123
МТ, 150	ХАБЭА, 48
МУ, 57, 77, 82, 111	ХДС, 138
МУЗГ, 45	ХК, 18, 78
МУУУА, 115	ХУД, 97
МУХБ, 94	ХХК, 18, 78, 117, 128
МУАГ, 125, 126, 149	ХЯ, 119
МХЕГ, 31, 97	ЦЭГ, 61
мян.тн, 42	ЧД, 97
Мян.тн, 39	ЧУ, 77
НББ, 118, 126	ш, 90
НББОУС, 148	ШШГЕГ, 77
НДЕГ, 119	ЭДЦС, 81, 91
ННФ, 115	ЭМНДШ, 108
НӨАТ, 23, 100, 128, 136	
НҮБХХ, 86	
ОНХНС, 105	



МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны нэгтгэл тайлан

“Харт Нойрс” Лтд  
Мэргэшсэн Нягтлан бодогчид  
89 High Street Thame, Oxfordshire  
3EH England

Tel: 44 01844 21 88 36  
Website: [www.hart-nurse.co.uk](http://www.hart-nurse.co.uk)

“Улаанбаатар Аудит Корпораци” ХХК  
“Маргад Центр” Төв 4 дүгээр давхар,  
Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо,  
Их тойруу, Улаанбаатар хот  
Монгол Улс  
Утас: 976-11-321844, 329430, 70110744  
Факс: 976-11-321844  
Вебсайт: [www.ulaanbaatar-audit.mn](http://www.ulaanbaatar-audit.mn)

**Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод  
Байдлын Санаачилгын Ажлын Хэсэг**

Монгол Улсын ОУИТБС-ын Засаглалыг дэмжих төсөл  
Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж,  
Тушин компаний байр, 314 тоот

2016 оны 11 сарын 18-ны өдөр

Англи Улсын “Харт Нойрс” Лтд ба Монгол Улсын “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн консерциум нь МОУИТБС-ын 10 дугаар тайлан буюу 2015 оны Нэгтгэлийн ажлыг (“Гэрээт ажил”) хийхээр сонгогдон, гэрээ байгуулсан билээ.

Монголын уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2015 онд Засгийн газарт төлсөн материаллаг төлбөр хийгээд Засгийн газрын хүлээн авсан материаллаг орлогын урсгалын аудитын нэгтгэлийн гэрээт ажлыг 2016 оны 07 дугаар сарын 19-нөөс 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгээс баталсан Гүйцэтгэх ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг Холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4400 буюу Санхүүгийн мэдээлэлд тохиролцсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажлын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.

Бид нэгтгэсэн болон бидний анхааралд өртсөн зүйлсээ энэхүү тайлан, түүний хавсралтуудаар тайлагнаж байна. Учир нь гүйцэтгэсэн горимууд нь нэгтгэлийн болон шалгах ажлыг АОУС буюу Шалгах Ажлын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэх зорилго агуулаагүй бөгөөд бидний зүгээс энэхүү тайланд харуулсан тодорхой мэдээллүүд, тэдгээртэй холбогдох аливаа гүйлгээнүүдэд ямар нэгэн баталгаа өгөх үүрэггүй юм.

Энэхүү тайлан нь Ажлын даалгаварт тусгагдсан зүйлсийн хүрээнд Олон талт ажлын хэсэгт болон Үндэсний Зөвлөлд мэдээлэхэд зориулагдсан болно.

Тус тайлан нь зөвхөн заагдсан зүйлсийн хүрээнд хийгдсэн бөгөөд аливаа нэгэн нэгжийг бүхлээр нь хамарсан санхүүгийн тайлангуудийн хүрээнд хийгдээгүй.

“Харт Нойрс” Лтд  
Мэргэшсэн Нягтлан бодогчид

“Улаанбаатар Аудит Корпораци” ХХК

## 1 ТАНИЛЦУУЛГА

### 1.1 ТАНИЛЦУУЛГА

#### 1.1.1 ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга бол (“ОУИТБС”) газрын тос, байгалийн хий, олборлох салбарт ил тод байдал, тайлагналыг сайжруулахад зориулсан глобал стандарт юм. Монгол улсын Засгийн газар ОУИТБС-ыг хүлээн авч байгаа тухайгаа 2006 онд зарласан бөгөөд дагалдан хийгдэх ажлуудыг хэрэгжүүлж, ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийг болон Олон талт оролцогчдын ажлын хэсгийг (“ОТАХ”) Засгийн Газар, үүл уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөлөл оролцуулан байгуулсан юм.

ОУИТБС-д нэгдсэнээс эхлэн ОУИТБС-ын есөн удаагийн тайланг Монгол улс бэлтгэн гаргасан бөгөөд одоогийн энэ арав дахь удаагийн тайлангийн Хараат бус хянагч-нэгтгэгчээр “Харт Групп” болон “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн хамтарсан консерциум томилогдсон юм.

2016 онд дахин шинэчилж, 2016 оны 2-р сарын 24-25-нд Лима хотод хуралдсан ОУИТБС-ын олон улсын хуралдаанаар баталсан ОУИТБС-ын Стандарт нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зарчмууд болон шаардлагуудыг агуулдаг.

2016 оны ОУИТБС-ын энэ стандарт нь ОУИТБС-ын мэдээллийг цуглуулахад тайлан гаргалтын одоогийн системүүдийг ашиглах, үр дүнг ил тод байлгахыг улс орнуудад хөхүүлэн дэмждэг. Энэ Стандарт нь олборлох үйл ажиллагааг эзэмшиж, ашиг хүртэж байгаа хувь хүмүүсийн тухай мэдээллийг одоо ил болгохыг шаарддаг. Олборлох төслүүдийн тендерт оролцож, ажиллаж, хөрөнгө оруулж байгаа компаниуд өөрсдийн бенефициар өмчлөгчид буюу ашиг хүртэгч эзэд нь хэн бэ гэдгийг мэдээллэдэг байхыг бүх улс орнууд баталгаажуулах шаардлагатай юм. Энэ шаардлага 2020 оны 1-р сарын 1-с эхлэн албан ёсоор хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

ОУИТБС-ын чанарыг баталгаажуулах механизм буюу ОУИТБС-ын шаардлагуудыг улс орнууд баримталж байгаа эсэхийг шалгаж тогтоодог баталгаажуулалтыг 2016 оны ОУИТБС-ын Стандартын хүрээнд улам боловсронгуй болгосон юм. Энэ Стандартыг дагаж мөрдөх журмыг өөрчлөөгүй боловч гишүүнчлэл бүхий улс орнуудын харилцан адилгүй байдал, минимум шаардлагуудыг давуулан биелүүлэх чармайлтууд, хэрэгжүүлэх явцаа үргэлжлүүлэн сайжруулж байгаа зэргийг үнэлгээ дүгнэлтэд өргөн хүрээнд харгалзах юм. Өдгөө Монгол улсад ОУИТБС-ыг баталгаажуулах үйл явц үргэлжилж байна.

2016 оны ОУИТБС-ын стандартын бусад онцлог талууд бол ОУИТБС-ын тайлангуудад дэвшүүлсэн саналуудыг төрийн байгууллагууд, ОТАХ сайтар анхаарч, холбогдох үйл ажиллагаанууд явуулж байгаа эсэх, тэгснээр олборлох үйлдвэрлэлийн удирдлагын хүрээнд шаардлагатай шинэчлэл, өөрчлөлтүүд хийгдэж байгаа эсэх, тодорхойгүй, ойлгомжгүй зүйлсийг тодорхой болгох, зөрчигдөж байгаа зүйлсийг залруулах зорилгоор бусад шинэчлэлүүд хийгдэж буй эсэхийг онцлон анхаардаг явдал юм.

Энэхүү тайлан нь ОУИТБС-ын хамгийн сүүлд буюу 2016 оны 2-р сард шинэчлэгдсэн стандартын дагуу Монгол улсад хийгдэж байгаа ОУИТБС-ын анхны тайлан юм.

### 1.1.2 ХАРААТ БУС ХЯНАГЧ-НЭГТГЭГЧИЙН ҮҮРЭГ РОЛЬ

Монгол улсын ОУИТБС-ын арав дахь удаагийн нэгтгэл тайланг гүйцэтгэгч Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүрэг ролийг Ажлын даалгаварт тодорхойлсон бөгөөд үндсэн элементүүд нь дараах байдалтай байна. Үүнд:

- Тайланд тусган нэгтгэхээр ОТАХ-ийн санал болгосон хамрах хүрээг шалган нягталж, санал дүгнэлт гаргах,
- Тайланд оруулах мэдээллийг цуглуулахын тулд мэдээлэл авах загвар маягтууд боловсруулж бэлтгэх, ОТАХ-ийн шийдсэний дагуу тайлан гаргахад шаардагдах төрийн болон хувийн байгууллагуудад тэдгээр маягтыг хүргүүлэх,
- Тайлан гаргах байгууллага, иргэдээс мэдээлэл авахдаа цахим тайлагналын систем, мэдээлэл авах маягтууд, зохих бусад хэрэгслүүдийг ашиглах,
- Хүлээж авсан мэдээллийг харьцуулж, аль болох өргөн хүрээг хамруулан нэгтгэх,
- Тайланд тусгасан санхүүгийн мэдээллийн хамрах хүрээний талаар дүгнэх, шаардлагатай бол, тайлан гаргах процессыг ирээдүйд сайжруулахын тулд санал дэвшүүлэх,
- Тайланд тусгасан орлого, төлбөрийн мэдээллийг болон Монгол улсын олборлох салбарт холбогдох бусад мэдээллийг нэгтгэж, ОТАХ-ийн хэвлэн нийтлүүлэх тайланг боловсруулж бэлтгэх.

Бидний бэлтгэсэн энэхүү тайлангийн зорилго бол Нэгтгэл тайланг бэлтгэх зорилгын хүрээнд Ажлын даалгаварт тодорхойлсон асуудлуудын талаар ОТАХ болон Үндэсний Зөвлөлд мэдээлэл өгөх явдал юм.

Тус тайланг Англи, Монгол хэлээр бэлтгэсэн бөгөөд хэрэв Англи, Монгол хувилбарын хооронд аливаа зөрчил, тохирохгүй зүйлс гарвал Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

## 1.2 ОРОЛЦОГЧИД

Тайлан, мэдээллийг нэгтгэхэд оролцсон талууд нь:

- Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас материаллаг орлого хүлээн авч байгаа төрийн болон орон нутгийн төрийн байгууллагууд,
- Олборлох салбарыг хянах, зохицуулах, тайлан гаргуулах хариуцлага бүхий Засгийн Газрын яам, агентлагууд (3.6 бүлгийг үзнэ үү)
- Олборлох салбарт ажиллаж байгаа төрийн өмчийн компаниуд (3.7 бүлгийг үзнэ үү)
- Холбогдох шийдвэрийн дагуу, төрийн байгууллагуудад материаллаг төлбөр төлж байгаа, олборлох салбарын компаниуд, (4-р бүлгийг үзнэ үү) зэрэг юм.

Нэгтгэл тайланд оролцож байгаа төрийн байгууллагууд, компаниудын тухай мэдээллийг 4.2 бүлэг болон Хавсралт 1 болон 2-оос үзнэ үү.

### 1.3 ТАЛАРХАЛ

“Харт Нойрс Лтд” болон “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн Консорциум нь биднийг Засгийн Газар, төрийн төрөл бүрийн байгууллага, агентлагуудын болон олборлох компаниудын голлох удирдлага, ажилтнуудтай хийх хурал уулзалтыг зохион байгуулахад тусалж, тэдгээр байгууллагаас зөвшөөрөл, албан бичиг баримтууд авах, явуулахад тусалж, бусад ажлуудад дэмжлэг үзүүлсэн Ерөнхий сайдын ахлах зөвлөх, МОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Энхбаяр, МОУИТБС-ын Засаглалыг дэмжих төслийн Ш.Цолмон зохицуулагчтай хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

## 2 ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

### 2.1 САЛБАРЫН ТОЙМ

Олборлох үйлдвэрлэл нь Монголын эдийн засгийн голлох салбар юм. 2015 онд ДНБ-ний 16.7%, 4.1 тэрбум ам.долларын экспортоос орлого олж, нийт экспортын 88%-ийг эзэлж байна.

Засгийн газар нь олборлох компаниудаас орлогынхоо томоохон хэсгийг бүрдүүлдэг бөгөөд 2015 онд олборлох салбараас 1,422 тэрбум төгрөг (ойролцоогоор 750 сая ам.доллар) хүлээн авсан байна. Түүнчлэн төрөөс уул уурхайн компаниудад хувь эзэмших байдлаар, тухайлбал Эрдэнэс Монгол, түүний салбар компаниудыг 100% эзэмшиж, Оюу толгой алт-зэсийн ордын 34%-ийг эзэмшиж олборлох үйл ажиллагаанд шууд оролцдог.

### 2.2 ОУИТБС-ЫН ОРОЛЦОО

МУ-ын Засгийн газар нь 2005 оны 12 сард ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр шийдэж, 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс ОУИТБС-ын нэр дэвшигчээр элссэн. Баталгаажуулалтыг амжилттай давснаар 2010 оны 10 дугаар сарын 19-ний өдөр бүрэн нийцсэнд тооцогдсон.

ОУИТБС-ыг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш Монгол улс нь 9 удаагийн тайлан гаргасан. Энэхүү тайлан нь ОУИТБС-ын 10 дахь удаагийн тайлан бөгөөд ОУИТБС-ын 2016 онд хамгийн сүүлд шинэчлэгдсэн шинэ Стандартын дагуу толилуулж буй эхний тайлан юм.

ОУИТБС-ын Монгол дахь хэрэгжилт нь ОУИТБС-ын Стандартын заалтуудад нийцэж буй эсэхийг үнэлдэг ОУИТБС-ын баталгаажуулалтаар Монгол улс 2 удаа үнэлүүлсэн.

### 2.3 ТАЙЛАНГИЙН ЦАР ХҮРЭЭ

Энэхүү тайлан нь уул уурхай, газрын тос болон хийн салбар дахь дараах сэдвүүдийг хамарсан. Үүнд:

- эдийн засгийн хувь нэмэр
- үйлдвэрлэл болон экспорт
- олборлох салбар дахь төрийн оролцоо
- лиценз болон гэрээний ил тод байдал
- ашигт малтмал, газрын тосны нөөцийн тойм

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

- нийгмийн зардал болон нөхөн сэргээх үйл ажиллагаа
- компанийн өмчлөл

Сүүлийн сэдвийн тухайд Монголын ОУИТБС нь бүх олборлох үйлдвэрлэлийн компаниудын бенефициар өмчлөгчийн мэдээллийг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн албан ёсоор ил тод болгох ОУИТБС-ын Шаардлагад хэрхэн нийцүүлэх талаар аль хэдийн судалж байна. Энэхүү тайланг бэлтгэх зорилгоор компаниудаас өмчлөлийнхээ талаарх тодорхой мэдээллээ ил тод болгохыг хүссэн.

Түүнчлэн, МОУИТБС-ын Ажлын хэсэг нь 202 компани (10 ТӨААН-үүдийг оролцуулаад) –ийн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн төлбөрийг тайлагнахаар баталсан бөгөөд Засгийн газрын 31 байгууллага (21 орон нутгийн байгууллагыг оролцуулаад) нь эдгээр компаниас хүлээн авсан орлогоо тайлагнасан.

Орлого болон төлбөрүүдийг харьцуулж, тохируулсан бөгөөд дэлгэрэнгүй үр дүнг энэхүү тайлан болон Хавсралт 9, 10-д тусгасан.

### 2.4 ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО

#### 2.4.1 НИЙТ ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРААС ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮЛЭЭН АВСАН ОРЛОГО

Засгийн газар нь олборлох үйлдвэрлэлийн бүх компаниудаас хүлээн авсан орлогоо МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлагнасан.

Эхлэлийн тайлангийн явцад тодорхойлсон үндсэн үйл ажиллагаа нь олборлох үйлдвэрлэлийн бус компаниудыг хассаны дараагаар ОУИТБС-ын тохируулганд оролцоогүй компаниудыг оролцуулаад Засгийн газрын тайлагнасан нийт олборлох салбарын орлого (тохируулгын дараах) нь дараах байдалтай байна. Үүнд:-

Засгийн газрын байгууллага	Засгийн газрын орлого – бүх ОУ-ийн компаниуд Сая төгрөгөөр
Гааль, татварын ерөнхий газар	936,669
Газрын тосны газар	195,160
Нийгмийн даатгалын ерөнхий газар	127,637
Төрийн өмчийн хороо	0
Ашигт малтмалын газар	36,975
Хөдөлмөрийн яам	16,556
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	480
<b>Дэд дүн: Улсын түвшин</b>	<b>1,313,479</b>
Аймаг	108,022
Дүүрэг	692
<b>Дэд дүн: Орон нутгийн түвшин</b>	<b>108,714</b>
<b>Нийт</b>	<b>1,422,192</b>

Энэхүү ОУИТБС-ын тайлангийн цар хүрээнд нийцсэн санхүүгийн урсгал бүрээс олсон нийт орлогын дэлгэрэнгүйг, баталсан материаллаг<sup>1</sup>-ийн түвшнээс доогуур орлогыг хамруулаад Хавсралт 6-д харуулав.

## 2.4.2 ТОХИРУУЛГЫН ЦАР ХҮРЭЭНД ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮЛЭЭН АВСАН ОРЛОГО

### 2.4.2.1 Тохируулгын өмнөх болон дараах цар хүрээний орлого

МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлагнагдсан бүх орлогын урсгалыг хамруулсан ба эдгээр урсгалууд нь нэгтгэл тайланд хамрагдсан 192 компани болон 10 ТӨК-иудын орлогын урсгалаар хязгаарлагдсан. Засгийн газрын тайлагнасан эдгээр компаниуд болон ТӨК-иудаас хүлээн авсан орлогыг хураангуйлбал:

Засгийн газрын байгууллага Сая төгрөгөөр	Анхлан тайлагнасан ЗГ- ын орлого	Тохируулгын дараах ЗГ-ын орлого	Өөрчлөлт %-иар
Гааль, татварын ерөнхий газар	1,034,416	931,609	-11%
Газрын тосны газар	187,039	195,110	4%
Нийгмийн даатгалын ерөнхий газар	118,769	119,454	1%
Ашигт малтмал, газрын тосны газар	24,166	24,315	1%
Хөдөлмөрийн яам	0	16,556	100%
Байгаль орчин, аялал жуулчлалын яам	0	480	100%
<b>Дэд дүн: Улсын түвшин</b>	<b>1,364,391</b>	<b>1,287,526</b>	<b>-6%</b>
Аймаг	72,933	105,486	31%
Дүүрэг	703	553	-27%
<b>Дэд дүн: Орон нутгийн түвшин</b>	<b>73,635</b>	<b>106,039</b>	<b>31%</b>
<b>Нийт</b>	<b>1,438,027</b>	<b>1,393,565</b>	<b>-3%</b>

Анхлан тайлагнасан орлого нь тохируулга хийхээс өмнөх Засгийн газрын байгууллагуудын цахим тайлагналын системд оруулсан урсгал юм. Тохируулгын дараах орлогын урсгал нь Хараат бус нэгтгэгчийн хийсэн тохируулгын дараах үр дүн болно.

Газрын тосны газар (одоо Ашигт малтмал, газрын тосны газар)-ын орлого болон аймгийн засаг захиргааны газрын дүн өссөн нь Засгийн газар анхны тайландаа мэдээллээ дутуу оруулсанаас үүдсэн. Гааль, татварын ерөнхий газрын орлого буурсан нь Оюу толгой компанийн ААНОАТ болон Ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс орсон нийт 92.5 тэрбум төгрөгөөс үүдэлтэй буюу уг төлбөрийг 2015 оноос өмнө мөнгөөр төлсөн байсан.

## 2.4.3 ТОХИРУУЛГЫН ХАМРАЛ

Засгийн газрын тохируулсан орлого нь 1.39 их наяд төгрөг бөгөөд энэ нь олборлох салбараас Засгийн газарт орсон гэж тайлагнасан нийт урсгал (1.42 их наяд төгрөг)-ын 97.9%-ийг эзэлж байна.

<sup>1</sup> ОУИТБС-ын Стандарт 2016, Шаардлага 4.1.г

## 2.4.4 ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН КОМПАНИЙН ТОХИРУУЛСАН УРСГАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ

Тохируулгын үр дүнг доорх хүснэгтэнд хураагуйлав. Үүнд:

Тохируулсан нийт урсгал		Зөрүү
Засгийн газар	Компани	
сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
1,393,565	1,392,037	1,528
Тайлагнаагүй компаниудаас хүлээн авсан гэж ЗГ-ын тайлагнасан орлого		(1,640)
<b>Тайлбарлагдаагүй зөрүү</b>		
Компанийн төлснөөс илүү тайлагнасан ЗГ-ын орлого		(168)
Компанийн төлснөөс бага тайлагнасан ЗГ-ын орлого		56
<b>Цэвэр тайлбарлагдаагүй зөрүү</b>		<b>(112)</b>

Ажлын хэсгийн баталсан 202 компаниас 8 компани нь МОУИТБС-ын цахим тайлагналын систем болон Хараат бус нэгтгэгчийн явуулсан тохируулгын маягтуудаар тайлагнаагүй<sup>2</sup>.

## 2.5 МЭДЭЭЛЛИЙН ИЖ БҮРЭН, ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ

### 2.5.1 ЗАСГИЙН ГАЗАР

#### 2.5.1.1 МОУИТБС-д Цахим тайлагналын системийг ашиглах нь

Ажлын цар хүрээг тодорхойлсон өдөр (2016 оны 7 дугаар сарын 19) Засгийн газрын хоёр байгууллага буюу Хөдөлмөрийн яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлангаа оруулаагүй байсан.

#### 2.5.1.2 Удирдлагын баталгаажуулалт

Бид нэгтгэл тайлангийн мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор 10 төрийн яам, агентлаг руу бидэнд ирүүлсэн мэдээллүүд нь үнэн зөв гэсэн Удирдлагын хариуцлагын захидлыг баталгаажуулж ирүүлнэ үү гэж хүссэн боловч 4 байгууллагаас хариу ирж, 6 байгууллага хариу ирүүлээгүй.

№	Нэр	Анхны нэгтгэлийн зөрүүгийн мэдээлэл	Анхны нэгтгэлийн зөрүүгийн тайлбар	Удирдлагын төлөөллийн захидал
1	Ашигт малтмал, газрын тосны газар	○	√	√
2	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	○	√	×
3	Гаалийн ерөнхий газар	○	√	×
4	Сангийн яам	○	√	×
5	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	○	√	×
6	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар	○	√	√
7	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	√	√	×
8	Уул уурхайн яам	-	-	√
9	Зам тээврийн яам	○	√	×
10	Татварын ерөнхий газар	○	√	√

<sup>2</sup> Дэлгэрэнгүйг Бүлэг 5.2.3-аас харна уу.

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

- *Шаардлагагүй*
- o *Эксэль файл хүлээн авсан, гарын үсэг зурсан баримт хүлээн аваагүй*
- ✓ *Гарын үсгээр баталгаажсан баримт хүлээн авсан*
- x *Хүлээн аваагүй*

Монголын ОУИТБС-ын ОТАХ-ийн шаардлагын дагуу ОУИТБС-ын нэгтгэл тайлангийн тоон мэдээлэл нь зохистой баталгаажсан байх ёстой. Өөрөөр хэлбэл зохистой форматаар тайлагнагч нэгжүүд болох Засгийн газар болон компанийн ахлах удирдлагаас бичгэн баталгаа авах юм. Тайлагнагч Засгийн газрын байгууллагуудаас зургаа нь энэ шаардлагыг хангаагүй.

### **2.5.1.3 Аудитын баталгаажуулалт**

Үндэсний аудитын газраас аудитыг нь хийсэн Засгийн газрын байгууллагууд нь ОУИТБС-ын цахим тайлагналын системд оруулж тайлагнасан тоон мэдээллээ баталгаажуулсан аудиторын мэдэгдлийг ирүүлээгүй. 2016 оны буюу дараагийн ОУИТБС-ын тайлангийн тоон мэдээллүүдийг баталгаажуулахын тулд 2017 оны ажлын төлөвлөгөө нь хийгдэж, УИХ-ын Төсвийн байнгын хороогоор батлагдахаас өмнө ҮАГ-тай энэ асуудлаар зөвшилцөх хэрэгтэй.

2015 оны Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг харахад бидний анзаарснаар ҮАГ нь 5 ТӨААН-д “хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна. Үүний нэг нь “Эрдэнэс Монгол” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотойгоор нийт 123 тэрбум төгрөгийн зөрчилд хязгаарлалттай дүгнэлт өгсөн нь томоохон асуудал боловч нийт Засгийн газрын дүнтэй харьцуулахад материаллаг биш байна.

## **2.5.2 ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖ (ТӨААН)**

### **2.5.2.1 Цахим тайлагналын системийг Монголын ОУИТБС-д ашиглах нь**

Ажлын цар хүрээг тодорхойлсон өдөр (2016 оны 7 дугаар сарын 19) хэд хэдэн ТӨААН-үүд нь МОУИТБС-ын цахим системд тайлагнаагүй байсан. Эдгээр нь:

- Эрдэнэс Монгол ХХК
- Эрдэнэс Тавантолгой ХК
- Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК
- Тавантолгой ХК
- Багануур ХК

### **2.5.2.2 Удирдлагын харьцуцлагын захидал**

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс “Эрдэнэс Монгол” компани Удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй байна.

### **2.5.2.3 Аудиторын мэдэгдэл**

Нэгтгэлд хамрагдсан ТӨААН-үүдээс Баян тээг ХК, Тавантолгой ХК, Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК зэрэг ТӨААН-үүд ОУИТБС-ын тайланд тусгагдсан тоон мэдээллээ Аудитын олон улсын стандартын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлантайгаа үялдуулсан гэдгийг баталгаажуулсан аудиторын мэдэгдлийг ирүүлсэн. Үлдсэн ТӨААН-үүд нь аудиторын мэдэгдлийг ирүүлээгүй.



#### **2.5.2.4 Аудитлагдсан санхүүгийн тайлан**

Дараах дөрвөн ТӨААН нь Ажлын хэсгийн шаардлагад нийцүүлэн аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй. Үүнд:-

- Тавантолгой ХК
- Могойн гол ХК
- Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК
- Эрдэнэс Тавантолгой ХК

Хүлээн авсан санхүүгийн тайланг хянаж үзэхэд хэд хэдэн асуудлаар аудитын дүгнэлтийг хязгаарласан байсан. Хөндлөнгийн аудиторын гаргаж тавьсан асуудлууд нь нягтлан бодох бүртгэлийн зөрүү, ТӨААН-ийн тасралтгүй ажиллах чадвар болон нөхөн сэргээлтийн нөөц байгуулаагүй, эсвэл тооцооллыг сайжруулдаггүй гэсэн утгатай байсан.

Олборлолтын явцад болон дараах байгаль орчны нөхөн сэргээлт нь компанийн нийгмийн хариуцлагыг харуулж байгаа бөгөөд ТӨААН-үүд нь зохистой бөгөөд иж бүрэн нөхөн сэргээлтийг хийх хэмжээний зардлын төлөвлөгөөг боловсруулж буй эсэх, нөхөн сэргээлтийн зардлыг цаашид санхүүгийн тайландаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу тусгасан эсэхийг баталгаажуулахын тулд Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь Ашигт малтмал, газрын тосны газартай хамтран ажиллах шаардлагатай гэж бид зөвлөж байна.

Хараат бус аудиторын Нягтлан бодох бүртгэлийн зөрүүний тодруулгатай холбоотой зөвлөмжөөс харахад ТӨААН-үүдийн санхүүгийн удирдлагын чадавхийг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

---

### **2.5.3 ХУВИЙН КОМПАНИУД**

#### **2.5.3.1 Цахим тайлагналын системийг Монголын ОУИТБС-д ашиглах нь**

Нэгтгэлд хамрагдсан 192 компани (ТӨААН-ийг оруулаагүй)-иас 115 компани нь анхлан цахим тайлагналын системийг ашиглан төлбөрөө тайлагнасан. 76 компани нь МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлан мэдээгээ ирүүлээгүй бөгөөд эдгээр компаниудаас нэмэлт маягтаар мэдээллийг цуглуулсан.

Цахим тайлагналын системийг ашиглах шаардлагыг чухалчлах болон практик хүндрэл (тайланг оруулах хугацаа хэр нийцтэй байгаа г.м) байгаа эсэхийг тодорхойлох, эдгээр хүндрэлийг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг олборлох үйлдвэрлэлийн компаниудтай цаашид илүү ихээр ажиллах шаардлагатай байна.

#### **2.5.3.2 Удирдлагын баталгаа**

Тайланд хамрагдсан 192 компаниас (ТӨААН-үүдийг оруулаагүй) 45 компани нь Ажлын хэсгийн баталсан горимтой үл нийцэж, Удирдлагын хариуцлагын захидлыг баталгаажуулж ирүүлээгүй.

#### **2.5.3.3 Аудиторын мэдэгдэл**

Түүнчлэн бүх компаниуд (ТӨААН-дийг оруулаагүй)-иас холбогдох аудиторуудаасаа мэдэгдэл гаргуулж өгөхийг хүссэн. 94 компани нь ОУИТБС-д ирүүлж буй тайлангаа “Аудитын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн, аудитлагдсан санхүүгийн тайлантайгаа уялдуулсан” гэсэн баталгаажуулсан аудиторын мэдэгдлээ ирүүлсэн.

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Энэ нь өмнөх тайлангуудад нэг ч ийм захидал компаниуд өгдөггүй байсантай харьцуулахад дэвшилттэй байна.

### **2.5.3.4 Аудитлагдсан санхүүгийн тайлангийн хэсэг**

192 компаниас 73 компани нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн хуулбараа ирүүлсэн ба үүнээс нэг аудитын тайлан нь хязгаарлалттай дүгнэлт авсан байсан бол үлдсэн нь зөрчилгүй дүгнэлт авсан болсон.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хүссэний зорилго нь тайлагнаж буй компаниудын баталгаажуулалтын орчин нөхцлийг шалгах боломжтой болох юм. Энэ шаардлагыг хангахын тулд компаниудтай цаашид илүү хамтран ажиллах шаардлагатай байна.

### **2.5.4 ХУРААНГУЙ**

Засгийн газраас Удирдлагын хариуцлагын захидал ирүүлээгүй үед Засгийн газрын тайлагнасан дүнд баталгаа байхгүй юм. Хараат бус нэгтгэгч нь толилүүлсан дүнгүүдийг аудитладаггүй бөгөөд тайлагнагч нэгжүүдээс ирүүлэх баталгаажуулалтад найддаг.

Удирдлагын хариуцлагын захидлыг төрийн өмчийн 2 ААН-ээс бусад нь ирүүлсэн ба ТӨААН-ийн санхүүгийн тайланд өгсөн аудитын хязгаарлалт нь ТӨААН-үүдийн тайлагналыг сайжруулалт хэрэгтэйг харуулж байна. Бид хоёр ТӨААН-үүдийн санхүүгийн тайлантай танилцаж чадаагүй.

Нэгтгэлд хамрагдсан компаниудын 76% нь удирдлагын хариуцлагын захидлаа, 49% нь аудиторын мэдэгдлээ ирүүлсэн. Бидний үзсэн (тайлагнагч компаниудын 37%) бараг бүх санхүүгийн тайлан нь аудитын зөрчилгүй дүгнэлттэй байсан нь компанийн тоон дүнд баталгаажуулалтын түвшинг сайжруулах томоохон хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Тайлант оны хувьд хамгийн том компаниудын ирүүлсэн баталгаажуулалтын мэдээлэл нилээд дутуу байна.

Компанийн нэр	Аудитын тайлан	Аудиторын мэдэгдэл	Удирдлагын хариуцлагын захидал	Тайлагнасан дүн (тэрбум төгрөг)	Зэрэглэл	Нийт төлбөрт эзлэх хувь
Оюу Толгой ХХК	✓	×	✓	515.2	1	37.0%
Эрдэнэт Үйлдвэр ХХК	✓	×	✓	358.3	2	25.7%
Петрочайна Дачин Тамсаг ХХК	✓	×	✓	189.6	3	13.6%
Монголын Алт МАК ХХК	×	×	✓	48.2	4	3.5%
Энержи Ресурс ХХК	✓	✓	✓	39.7	5	2.9%
Цайртминерал ХХК	✓	✓	✓	34.8	6	2.5%
Доншен газрын тос (Монгол) ХХК	✓	✓	✓	14.4	7	1.0%
Болдтөмөр Ерөө Гол ХХК	×	×	✓	14.0	8	1.0%
Багануур ХК	✓	✓	✓	10.4	9	0.7%
Саусгоби Сэндс ХХК	✓	✓	✓	10.4	10	0.7%

## 2.6 ГОЛ АСУУДЛУУД

### 2.6.1 НҮҮРСНИЙ БОРЛУУЛАЛТ

Төрийн өмчит нүүрсний компаниудын хийдэг томоохон ажил гүйлгээнүүдийн нэг нь төрийн өмчит дулааны цахилгаан станцуудыг цахилгаан үйлдвэрлэхэд шаардлагатай нүүрсээр хангадаг явдал юм.

Нүүрс олборлодог ТӨААН-үүдийн ирүүлсэн мэдээлэл болон АМГТГ-ын статистик мэдээллийг үндэслэн бид 2015 оны нийт нүүрсний борлуулалтын орлого болон борлуулсан хэмжээг хураангуйлсан.

№	Станцууд	ДЦС-ын... хувийг нийлүүлдэг	Нийлүүлсэн нүүрс				1 тн нүүрсний дундаж үнэ ам.доллар	1 тн дулааны нүүрсний дундаж үнэ /дэлхийн зах зээл/
			Мян.тн	сая.төг	1 тн нүүрсний дундаж үнэ	1 тн нүүрсний өртөг төгрөг		
<b>Багануур ХК</b>								
1	"ДЦС-4" ТӨХК	60%	1,635	43,467	26,588	29,300	\$ 13.24	\$ 38.12
2	"ДЦС-3" ТӨХК	100%	1,267	33,542	26,480			
3	"ДЦС-2" ТӨХК	100%	225	5,684	25,321			
4	"ДДЦС" ТӨХК	60%	108	2,697	25,069			
5	"Амгалан ДС"ХХК	100%	39	1,037	26,590			
6	"БНДС" ТӨХК	100%	59	1,618	27,612			
<b>Шивээ-Овоо ХК</b>								
1	"ДЦС-4" ТӨХК	40%	1700	35,802	21,060	21,060		
<b>Шарын гол ХК</b>								
1	"ДДЦС" ТӨХК		273	7,664	28,093			
2	"ЭДЦС" ТӨХК		286	8,026	28,037	28,065		

Дулааны нүүрсний олон улсын зах зээлийн ханшийг АМГТГ-ын 2015 оны статистик мэдээллээс авсан.

### 2.6.2 БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ БОЛОН ЛИЦЕНЗИЙН МЭДЭЭЛЭЛ

#### 2.6.2.1 Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Бид 2015 онд хийгдсэн БХГ-үүдийн олон нийтэд нээлттэй байх ёстой мэдээллийн эх үүсвэрийг олж үзэж чадаагүй ба 2015 онд хийгдсэн бүх БХГ-үүдийн хуулбарыг хүссэн.

ОУИТБС-ын 2013 оны тайлантай холбоотойгоор Уул уурхайн сайдаас Хараат бус Хянагч-нэгтгэгчид ирүүлсэн албан бичиг, 2014 оны хууль эрх зүйн өөрчлөлтөөс үүдэж эдгээр мэдээллийг нийтэд ил тод танилцуулах ёстой гэж бид ойлгож байгаа. АМГТГ бидний хүсэлтэд "АМГТГ нь гэрээний нэг тал болохын хувьд гэрээлэгчид мэдэгдэн хариу ирүүлсний дараа гэрээг ил тод болгох нь зүйтэй" гэсэн үтга бүхий хариу ирүүлсэн. Иймд Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс 2015 онд БХГ байгуулсан "Ренова илч" ХХК-д хандан БХГ-ний хуулбарыг хүссэн боловч компанийн зүгээс гаргаж ирүүлээгүй байна.

Энэхүү тайлан гарах хүртэл бид эдгээр БХГ-үүдийн хуулбарыг олж аваагүй.

### **2.6.2.2 Уул уурхайн лиценз**

АМГТГ нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх бүх лицензийн жагсаалт (Хавсралт 16-аас харна уу)-ыг ирүүлсэн. Энэхүү жагсаалтад лиценз олгосон огноог харуулсан бөгөөд энэ мэдээллийг ашиглавал 2015 онд шинээр олгосон бүх лицензийг харах боломжтой.

АМГТГ нь хоёр төрлийн тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний нэгтгэлийг гаргадаг:

- i. 2010-2015 он хүртэлх жил бүрийн эцэст хүчинтэй байгаа ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн нэгтгэл;
- ii. 2015 оны туршид шинээр олгогдсон, цуцлагдсан, шилжүүлсэн болон бусад өөрчлөлтийг харуулсан хөдөлгөөний шинжилгээ;

2015 онд олгосон лицензийн тоо нь эдгээр 3 мэдээллүүдээс өөр байгаа бөгөөд АМГТГ нь энэ зөрүүгийн шалтгааныг тайлбарлаж чадаагүй.

---

### **2.6.3 ТАЙЛАГНААГҮЙ КОМПАНИУД**

Найман компани нь МОУИТБС-ын цахим тайлагналын системд болон бидний явуулсан маягтаар Хараат бус нэгтгэгчид тайлангаа ирүүлээгүй. Засгийн газар нь эдгээр компаниудаас хүлээн авсан 1.64 тэрбум төгрөгийг тайлагнасан бөгөөд энэ нь нийт ЗГ-ын хүлээн авсан дүнтэй харьцуулахад материаллаг биш байна. Гэхдээ эдгээр компаниудыг МОУИТБС-ын Ажлын хэсэг нь нэгтгэлд хамруулахаар тодорхойлсон. Ажлын хэсэг эсвэл Үндэсний зөвлөл нь нэгтгэлд хамрагдсан бүх компаниудыг ОУИТБС-ын тохируулгад хамруулж, оролцуулахад тодорхой арга хэмжээ авч ажиллаж байхыг зөвлөж байна.

### 3 МОНГОЛЫН ОЛБОРЛОХ САЛБАР

Ашигт малтмалын хуулийн 9.1.11-д заасны дагуу Засгийн газрын холбогдох шийдвэрээр Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 19.9 хувьд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдох боломжтой юм байна. 2016 оны эхний улирлын байдлаар энэ нь 9.5 хувьтай байгаа нь цаашид олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын тоо өссөөр байхыг харуулж байна.

Уул уурхайн салбар сүүлийн 3 жилийн дунджаар Монгол Улсын төсвийн нийт орлогын 42 хувь, татварын орлогын 52 хувийг, экспортын орлогын 78.4 хувийг тус тус бүрдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) 30 хувь, аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний 70 хувийг үйлдвэрлэсэн байна.

Түүнчлэн энэ салбарын татварын орлого нь төсвийн орлогын бүрдүүлэлтээр 2014 онд 26 хувь, 2015 онд 20.1 хувийг эзэлж байгаа нь улсын эдийн засгийн томоохон хөдөлгөгч хүчин, хүнээ хөгжүүлэх болон нийгмийн хөгжлийн бусад хэрэгцээг хангах тулгуур эх үүсвэрийн нэг болж байгааг харуулж байна.

Мөн нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 71 хувийг уул уурхай, 8 хувийг барилга, 3 хувийг банк санхүү, 3 хувийг төмөр замын салбар тус тус эзэлдэг бөгөөд олборлох салбараас олон орлого жил бүр нэмэгдэх хандлагатай байна.

#### 3.1 ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БОЛОН ТӨСВИЙН БОДЛОГО

##### 3.1.1 ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БА ОЛБОРЛОХ САЛБАРТ ГАРСАН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ШААРДЛАГА 2.1)

Энэ бүлэгт Монгол улсад Олборлох үйлдвэрлэл болон санхүүгийн дүрэм, журамтай хамааралтай голлох хууль тогтоомжийн тоймыг агуулсан. Мөн Монгол улсын Засгийн газрын 2016 оноос 2020 онуудын хооронд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн тойм болон Ашигт малтмалын тухай хуульд 2015 онд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу уул уурхайн лицензтэй холбоотой хийгдсэн ажлын хураангуйг багтаасан.

###### 3.1.1.1 Монгол улсын Эрдэс баялагийн салбар дахь хуулиуд

Одоогийн байдлаар уул уурхайн салбар нь ойролцоогоор 30 хууль, 40 гаруй журам, заавраар зохицуулагдаж байна. Энэ салбарын анхны эрх зүйн баримт бичиг нь Богд хааны 1913 онд баталсан "төрөл бүрийн ордыг зохицуулах журам" ба хамгийн сүүлийн үеийн хууль эрх зүйн бичиг баримт нь Ашигт малтмалын тухай хууль бөгөөд Монгол Улсын Парламент (Улсын Их Хурал) 2015 онд тус хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчлэл болон хууль батлагдсанаас хойш 2006 онд энэ хуулинд өнөөг хүртэл 18 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

#### Гол хуулиуд

- Ашигт малтмалын тухай хууль, 2006
- Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд, 2015
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001
- Газрын тосны тухай хууль, 2014

- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, 2015
- Цөмийн энергийн тухай хууль, 2009
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Аудитын тухай хууль, 1997, 2015
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2001, 2015
- Татварын ерөнхий хууль, 2008

#### **Бусад хуулиуд**

- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012
- Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2010
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, 2008
- Гаалийн татвар болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль, 2012
- Газрын хэвлийн тухай хууль, 1988
- Газрын тухай хууль, 2002
- Газрын төлбөрийн тухай хууль, 1997
- НӨАТ-ын тухай хууль, 2006, 2015
- Ойн тухай хууль, 2012
- Үл хөдлөх эд хөрөнгийн татварын тухай хууль, 2000

2015 онд шинээр хуулиуд мөрдөгдөж эхлээгүй боловч Ирээдүйн өв сангийн тухай хууль батлагдаж, 2016 онд мөрдөгдөхөөр болсон.

Эрдэс баялагийн салбарт хэрэгжиж байгаа гол хуулиудын товч танилцуулгыг доор үзүүлэв.

#### **3.1.1.2 Ашигт малтмалын тухай хууль, 2006**

2006 оны 7 дугаар сард Монгол Улсын Засгийн газраас ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор одоогийн ашигт малтмалын тухай хуулийг баталсан.

#### **3.1.1.2.1 2015 онд Ашигт малтмалын тухай хуульд орсон өөрчлөлтүүд**

"Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-иар хүчин төгөлдөр болсон "Ашигт малтмалын тухай хууль"-д орсон дараах чухал нэмэлт, өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтын шинэчлэлт болон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход тавигдах тодорхой шинэ шаардлагуудын тухай нэмэлт өөрчлөлт,
- Төмөрлөг бус металл, эрдэнийн чулуу хайгуулын тусгай зөвшөөрлийн шаардлагын тухай нэмэлт өөрчлөлт,
- Төмөрлөг бус металл, эрдэнийн чулууны хайгуул хийх болон цуглуулахад бусад түгээмэл тархацтай ашигт малтмалын адил тусгай зөвшөөрлийн шаардлага,
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр төлөөгүйгээс үүсэх торгуулийг төлөх шаардлагын тухай нэмэлт өөрчлөлт,
- Орон нутгийн хуулийн этгээдийг ач холбогдлоор нь эрэмблэх тухай нэмэлт өөрчлөлт.

Худалдан авалт хийхдээ бараа материал, ажил, үйлчилгээ үзүүлж чадах, шаардлагатай стандартуудыг хангах, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд тэргүүн ач холбогдол өгөхөөс гадна, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэхдээ Монголын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явагдаж байгаа боловсруулах үйлдвэрлэлд нэн тэргүүний ач холбогдол өгч, зах зээлийн үнээр нийлүүлэх ёстой.

#### **3.1.1.2.2 Шинээр хэрэгжүүлж байгаа журмууд**

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн шаардлагаар Уул уурхайн яамнаас хэрэгжүүлэх олон төрлийн журмуудыг батлах ба үүнд дараах журмууд багтана:

- Монгол улсын эрдэс баялгийн бодлого хэрэгжилтийг дэмжих зорилгоор хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагын төлөөллийн тэгш байдлыг хангасан орон тооны бус бодлогын зөвлөлийг байгуулах журам,
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах уул уурхай болон уурхайн баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам;
- Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам;
- Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам;
- Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагатай хамтран ашигт малтмалын баялаг, ордын нөөц, хайгуулын ажлын үр дүнг нийтэд нээлттэй тайлагнах журам;
- Тогтмол давтамжтай тайлан, төлөвлөгөө боловсруулах эцсийн хугацааг тодорхой болгож, хугацааг сунгах тухай нэмэлт өөрчлөлт;
- Ашигт малтмалын тухай хуулийг зөрчихөд төлөх мөнгөн хариуцлагыг нэмэгдүүлэх тухай нэмэлт өөрчлөлт;
- Ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн байгууллагад илүү эрх мэдэл олгох тухай нэмэлт өөрчлөлт,
  - УИХ-д шинэ стратегийн орд танилцуулан УИХ-аар батлуулах Засгийн газрын эрхийг өргөжүүлж УИХ-д стратегийн ордын ангиллаас хасах санал гаргах, батлуулах эрхийг Засгийн газарт өгөх тухай нэмэлт өөрчлөлт;

- Ашигт малтмалын асуудлаарх Засгийн газрын эрх мэдлийг нэмэгдүүлж, үндэсний геологийн алба байгуулах болон стратегийн ач холбогдол бүхий ордын хил хязгаарыг хангах эрх мэдлийг олгох тухай нэмэлт өөрчлөлт;
- Уул уурхайн яамны эрх мэдэл нэмэгдүүлж, уул уурхайн үйл ажиллагааг зохицуулах, түүнчлэн ашигт малтмалын нөөц, ордын нөөцийг ангилах, зөвлөмжөөр хангах үйл ажиллагааг зохицуулахын тулд хэд хэдэн шинэ дүрэм, журмыг хэрэгжүүлэх эрх мэдлийг олгох тухай нэмэлт өөрчлөлт;
- АМГ-ын эрх мэдлийг нэмэгдүүлж, Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийн бүртгэл хөтлөх эрх мэдэл болон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг GPS-ийн солбилцолоор тодорхойлох эрх мэдлийг олгох тухай нэмэлт өөрчлөлт;
- Мэргэшсэн мэргэжилтнүүд болон эрх бүхий байгууллагуудын тухай нэмэлт өөрчлөлт: Мэргэшсэн мэргэжилтнүүд болон эрх бүхий байгууллага нь одоо хайгуулын ажил, ашигт малтмалын ордын техник, эдийн засгийн судалгааны үр дүн, түүний магадлагааны талаар нэгдсэн тайланг гаргах эрх бүхий байна.
- Үндэсний геологийн алба байгуулах тухай нэмэлт өөрчлөлт: Үндэсний геологийн алба байгуулагдах бөгөөд АМГ-аас дараах чиг үүргийг өгнө. Үүнд:
  - геологи, геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн, зураг зүйн үйл ажиллагаа явуулах, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт хайгуул, судалгаа хийх;
  - ашигт малтмалын илэрцийн тархалтын судалгаа явуулах, Монгол Улсын нутаг дэвсгэрт эрдэс судлалын судалгаа хийх, ашигт малтмалын ирээдүйн төлөвийг үнэлэх;
  - сонирхсон хувь хүмүүст зориулсан геологи, уул уурхай, ашигт малтмал, (нууц гэж ангилаагүй бол) -ийн мэдээллийн санг бий болгох, мэдээллийн сангийн үйл ажиллагааг дэмжих;
  - Ашигт малтмалын үндэсний нэгдсэн бүртгэл хөтөлж, нөөцийн өөрчлөлтийг бүртгүүлэх.

Үүний зэрэгцээ нэмэлт өөрчлөлтийн хуулиар танилцуулагдсаны дагуу, удаан хүлээгдсэн "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай хууль"-ийг ("Хориг хүчингүй болгох тухай хууль") Монгол Улсын Их Хурал 2012 оны 1 дүгээр сарын 12-нд баталсан ба энэ хууль нь хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг хойшлуулсан. 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс хойш Монгол Улсын Их Хурал гаргасан дунд хугацааны хойшлуулах тухай цуврал хуулиудын хамгийн сүүлийнх нь Хориг тавих тухай хууль байсан.

Хориг цуцлах тухай хууль гаргаснаар Монгол улсын Засгийн газар нь хүнд байдалд байгаа эдийн засгаа сайжруулахын тулд улсын байгалийн баялагаа ашиглах үе шаттай арга хэмжээнүүд авч хэрэгжүүлээд эхэлсэн гэдэг ойлголтыг бизнес эрхлэгч нарын дунд төрүүлсэн.

### **3.1.1.3 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001**

2001 оны 2 дугаар сард Монгол Улсын Их Хурал ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэх үйл явцыг тодорхойлж, зохицуулах зорилгоор тусгай зөвшөөрөл олгох тухай хуулийг баталсан. Уг хуульд уул уурхайн салбартай холбоотой дараах заалтууд орсон. Үүнд:

- Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас олгогдож буй ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг тухайн лицензийн харъяалагдах аймгийн Засаг дарга зөвшөөрсөн байх ёстой.



- Тус хууль нь орон нутгийн засаг захиргаа, өөрөө удирдах байгууллага болон улсын мэргэжлийн хяналтын газрын геологи, уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн биелэлтэнд хяналт тавих үүрэг, хариуцлагыг тодорхойлсон.
- Ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани болон хувьцаат компанид олгоно. Монгол Улсын иргэн, гадаадын иргэнийг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчээр бүртгэхийг зөвшөөрөхгүй.

2015 онд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд 4 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон ба эдгээр нэмэлт өөрчлөлтүүд нь уул уурхайн салбарт хамаарахгүй байна.

#### **3.1.1.4 Газрын тосны тухай хууль, 2014**

Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын тосны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2014 оны 7 дугаар 01-ний өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Газрын тосны тухай хууль 9 бүлэг 45 зүйлтэй. Өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан Газрын тосны тухай хууль нь 1991 онд батлагдсан. Монгол Улсад уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох зорилтын хүрээнд Улсын Их Хурлаас “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ыг баталсан. Түүнчлэн газрын тосны тухай хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулж, газрын тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны талаарх ойлголт, төрийн байгууллагууд болон нутгийн удирдлагын байгууллагын эрх хэмжээг тодорхой болгох, роялти, татварын хувь хэмжээ, түүнийг оногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, газрын тос эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаатай холбоотой харилцааг илүү нарийн зохицуулах зайлшгүй шаардлага гарсан.

Газрын тосны тухай хууль нь 9 бүлэгтэй ба Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосыг эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгад газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажлыг хуулийн этгээд төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгэх, улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газарт газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийх, шатдаг занарын эрлийн үед зөвхөн өрөмдлөг хийж болохоор болсон.

Түүнчлэн газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төрлийг бий болгосон бөгөөд эдгээр тусгаар зөвшөөрлийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох, хайгуулын болон ашиглалтын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ хийх эрхтэй байх, бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг Засгийн газар батална.

Газрын тосны салбараас улсын төсөвт орох татварын орлогын зарим хэсгийг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт хуваарилах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Ингэснээр уг үйл ажиллагаанаас орон нутгийн иргэд, байгууллагын хүртэх үр ашиг, оролцоо нэмэгдэх юм.

Газрын тосны нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээ, түүнийг хуваарилах зарчим, түүнчлэн өртөг нөхөгдөх зардал болон өртөгт газрын тосыг тооцох аргачлалыг хуульчилсан.

Газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчин, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй ажиллагаа, мэдээ, тайлан гаргах үйл ажиллагааны талаар хүлээх үүргийг нарийвчлан тодорхойлж, эдгээрийг зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлагыг ч хуульд тодорхой тусгасан.

Түүнчлэн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай давхацсантай холбоотой маргааныг шийдвэрлэх, түүхий тос, байгалийн хий, уламжлалт бус газрын тосны болон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа давхацсан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь харилцан гэрээ байгуулж, бие биенийхээ үйл ажиллагаанд саад болохгүйгээр ажиллах эрх зүйн үндэс бүрдсэн.

Мөн нутгийн удирдлагын байгууллагын газрын тос, уламжлалт бус газрын тосны салбарын хүрээнд эдлэх, эрх үүрэг, оролцоог тодорхой болгосны зэрэгцээ сум, дүүргийн Засаг дарга нь гэрээлэгчтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллахаар тусгасан нь компанийн нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх боломжийг хуулийн зохицуулалт дор хамааруулсан байна.

Хуулийн бас нэг онцлог зохицуулалт бол гэрээлэгчийн санхүү, хөрөнгө оруулалтын тайланд санхүүгийн хяналт шалгалт хийх, баталгаажуулах асуудлыг эрх бүхий аудитын байгууллага тодорхой хугацаанд давтамжтайгаар хийж байх, энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө буюу 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан Газрын тосны тухай хуулийн дагуу байгуулсан гэрээнд төлбөр, зардал, өртөг нөхөлт, бүтээгдэхүүн хуваалтыг тухайн гэрээнд заасан хувь, хэмжээгээр зохицуулах, нөөц ашигласны төлбөр төлөхгүй байгаа гэрээний тухайд төрийн захиргааны байгууллага гэрээлэгчтэй харилцан тохиролцож уг төлбөрийн хэмжээг тогтоохоор тусгасан.

Хууль батлагдсанаар газрын тос болон уламжлалт бус газрын тосны эрх зүйн орчин тодорхой болж, газрын тосны салбарт төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын эрх, үүрэг, газрын тосны нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн хураамжийн хувь хэмжээ, түүнийг ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх болон тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, газрын тос эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгосон байна.

Монгол Улсад баригдах газрын тосны боловсруулах үйлдвэрийн түүхий эдийг дотоодоос хангах, улмаар газрын тосны бүтээгдэхүүний хувьд импортоос хамааралтай байдлаас гарах, экспорт нэмэгдэх, гадаад валютын нөөц өсөх, ажлын байр нэмэгдэх зэрэг нийгэм, эдийн засгийн эерэг үр дагаврыг бий болгоход ач холбогдолтой болсон.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах үед мөрдөгдөж байсан татварын нөхцөлийг хадгалсанаар хөрөнгө оруулалтын эрх зүйн таатай орчин бүрдэх юм.

**3.1.1.5 Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009**

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан.

**3.1.1.6 Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, 2015**

Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар шинэчлэгдэн батлагдсан.

Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Засгийн газрын дараах тогтоол, шийдвэрүүд гарч байсан.

Засгийн газрын тогтоолууд	Огноо	Тайлбар
Засгийн газрын 174 дүгээр тогтоол	2011.06.08	Алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт “Ашигт малтмал хайх ашиглахыг хориглосон гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг”-ийг хавсралтаар баталсан. ЗГ-ын 2014 оны 260, ЗГ-ын 2015 оны 130-р тогтоолоор өөрчлөлт орсон.
Засгийн газрын 194-р тогтоол	2012.06.05	Монгол улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг 1 дүгээр, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг 2 дугаар, Ойн сан бүхий газрын хилийн заагийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсан. ЗГ-ын 2014 оны 260, ЗГ-ын 2014 оны 281, ЗГ-ын 2015 оны 130-р тогтоолоор тус тус нэмэлт өөрчлөлт орсон.
Засгийн газрын 260 дугаар тогтоол	2014.08.14	Засгийн газрын 174 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Ашигт малтмал хайх ашиглахыг хориглосон гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг”-т өөрчлөлт оруулсан.
Засгийн газрын 130 дугаар тогтоол	2015.04.06	Засгийн газрын 174 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Ашигт малтмал хайх ашиглахыг хориглосон гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг”-т өөрчлөлт оруулсан.
Засгийн газрын 120 дугаар тогтоол	2015.3.3	“Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээний загвар”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсан.
Засгийн газрын 289 дүгээр тогтоол	2015.7.7	Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 1 дүгээр, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Ойн сан бүхий газрын хилийн зааг”-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтаар баталсан. Мөн энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай” ЗГ-ын 174 дүгээр тогтоол, “Хилийн заагийг тогтоох” тухай 194 дүгээр тогтоолын 2 дугаар

				<i>хавсралтыг хүчингүй болгосон.</i>
Засгийн газрын дугаар тогтоол	302	2015.7.20		Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан <i>Монгол улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 1 дүгээр, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Ойн сан бүхий газрын хилийн зааг"-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 2 дугаар, Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн солбицолд оруулахгүй цэгүүдийг 3 дугаар хавсралтаар тус, тус баталсан.</i>
Засгийн газрын дугаар тогтоол	155	2016.03.14		Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан <i>"Монгол улсын нутаг дэвсгэр дэх гол мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн зааг"-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 1 дүгээр, уг тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Ойн сан бүхий газрын хилийн зааг"-ийн солбицолд оруулах өөрчлөлтийг 2 дугаар хавсралтаар тус, тус баталсан.</i>

Уг хуулийг хэрэгжүүлэх явцад дараах ажлын хэсгүүд байгуулагдан ажилласан байна. Үүнд:

- Уул уурхайн сайдын 2015 оны 59 дүгээр тушаалаар алт олборлолтыг нэмэгдүүлэх Ажлын хэсэг,
- Уул уурхайн сайд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2015 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 97/А-227 тоот тушаалаар байгуулагдсан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсэг,
- Монгол улсын Шадар сайд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Уул уурхайн сайдын 2015 оны 108/а/358/213 тоот хамтарсан тушаалаар батлагдсан хилийн заагийн маргаан шийдвэрлэх Ажлын хэсэг,
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайд нарын хамтарсан 2015 оны А230/127 дугаар тушаалаар “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ыг батлан гаргасан,
- Ашигт малтмалын газрын даргын 2015.08.21-ний өдрийн а/71 дугаартай тушаалаар батлагдсан ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайг МУ-ын Засгийн газрын 2015.07.07-ны өдрийн 289 дүгээр тогтоолд нийцүүлэн цэгцлэж зохион байгуулах дэд даргаар ахлуулсан Ажлын хэсэг,
- Ашигт малтмалын газрын даргын 2016 оны 4 дүгээр сарын 12 -ны өдрийн а/15 дугаартай тушаалаар батлагдсан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулсаныг нотлох уулын ажлын тайлан ирүүлээгүй боловч мэргэжлийн байгууллагаар газар дээр нь маркшейдерийн хэмжилт хийлгэж үйл ажиллагаа явуулснаа нотлуулсан тусгай зөвшөөрлийн талбай дээр нь ажиллах, хэмжилт хийж , дүгнэлт гаргах Ажлын хэсэг.

**3.1.1.7 Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулинд өөрчлөлт орсноор авсан арга хэмжээ болон хийж буй ажлууд**

“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн үйлчлэлд нийт 656 ашиглалтын тусгай зөвшөөрөл хамрагдсан ба үүнээс Уул уурхайн хэлтэст 577 ашиглалтын тусгай зөвшөөрөл, Нүүрсний хэлтэст 79 ашиглалтын тусгай зөвшөөрөл хамрагдсан.

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

АМГТГ-ын Уул уурхайн хэлтэс нь дээр дурьдсан шинэ журам, шийдвэрийн үр дүнд гарах шаардлагатай өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн тулд эдгээр 577 уул уурхайн лицензийг шалгаж байна. Одоогоор авсан арга хэмжээг харуулбал дараах байдалтай байна.

Бодит байдал	Тоо
Хориглосон талбайн хилийн зааг /УБЭ, ОС, УС/-аас бүрэн чөлөөлөгдсөн /давхцалгүй/	263
Кадастрын даргын шийдвэрээр цуцлагдсан	73
Шийдвэрлэх шатандаа яваа	241
<b>Бүгд</b>	<b>577</b>

Хориглосон талбайн хилийн заагаас бүрэн чөлөөлөгдсөн 263 тусгай зөвшөөрлийг ашигт малтмалын төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Ашигт малтмалын төрөл	Тусгай зөвшөөрлийн төрөл
Алт	154
Вольфрам	5
Төмөр	5
Хар тугалга	8
Холимог металл	4
Молибдени	3
Зэс	1
Ховор металл	3
Мөнгө	1
Барилгын металл	65
Бусад	14
<b>Бүгд</b>	<b>263</b>

73 тусгай зөвшөөрөл Кадастрын даргын шийдвэрээр цуцлагдсан байна.

Үлдэх 241 ашиглалтын тусгай зөвшөөрлийг доорх байдлаар шийдвэрлэж байна. Үүнд:

Шийдвэрлэх асуудлууд	ТЗ-ийн тоо	Тайлбар
<i>Ойн тухай хуулиар зохицуулах</i>	40	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд БОНХАЖЯ-наас ойн үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах тухай мэдэгдсэн,
<i>Энгийн хамгаалалтын бүсийн хилийн зааг дотор олборлолтын үйл ажиллагаа явуулж байсан эсэх талаар геологи, мэдээллийн санд хадгалагдаж байгаа уулын ажлын тайлан болон дэвсгэр зурагт шүүлт хийж, дүгнэлт гаргасан.</i>	107	- Усны сан бүхий газрын <i>энгийн хамгаалалтын бүсэд олборлолтын үйл ажиллагаа явуулсан</i> – 28. Эдгээрээс 11 ашиглалтын тусгай зөвшөөрлийн усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолтын үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулан АМГ, МХЕГ-аар баталгаажуулж, аймгийн Засаг дарга нараар баталгаажуулахаар хүргэгдээд байна. Аймгийн Засаг дарга нар гэрээг баталгаажуулахын тулд аж ахуйн нэгжүүдээс их хэмжээний мөнгө нэхэх, аж ахуйн нэгжийг өөрийн харъяалалд шилжүүлэх зэрэг хууль бус шаардлага тавьж байгаа тухай гомдол гаргаж байна.Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргаас өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг өөрийн харъяа бүртгэлтэй байх гэсэн шаардлага тавьж байгаа тухай албан бичиг /2016.04.04-ний өдрийн 07/215/-ээр АМГ-т мэдэгдсэн. Дархан-Уул аймгаас “Хатантүшиг трейд” ХХК-ийн гэрээг баталгаажуулж явуулсан байна. Баянхонгор аймаг аж ахуйн нэгжүүдийг 100 сая төгрөг тушаавал гэрээг баталгаажуулна гэсэн тухай аж ахуйн нэгжээс гомдол гаргасан боловч АМГ-т аймгийн зүгээс ямар нэг тайлбар ирүүлээгүй байна.

			<ul style="list-style-type: none"> <li>- Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй – 57. Эдгээр ашиглалтын тусгай зөвшөөрлийн усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй давхацсан хэсгийг буцаан өгөх тухай албан бичиг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн байна.</li> <li>- Зөрчилтэй, дүгнэлт гаргах боломжгүй – 22. Үүнд уулын ажлын дэвсгэр зураг нь солбицолгүй, орон нутгийн солбицолтой эсвэл уулын ажлын дэвсгэр зураггүй зэрэг зөрчил илэрсэн байна.</li> </ul>
Хууль гарснаас хойш олгогдсон	16		“Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль” гарснаас хойш олгогдсон учир энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай давхацсан хэсгийг хасуулах
Урсац бүрэлдэх эхийн хилийн заагтай давхацсан тул цуцлагдсан	79		Үүнээс хуулийн хугацаанд өргөдөл ирүүлсэн боловч урсац бүрэлдэх эхийн хилийн заагтай ихэнх хэсэг нь давхацсан тул нөхөх олговор олгон цуцлах 29 тусгай зөвшөөрөл, хуулийн хугацаанд өргөдөл ирүүлээгүй 50 тусгай зөвшөөрөл байна.
<b>Бүгд</b>	<b>241</b>		

### 3.1.1.8 Цөмийн энергийн тухай хууль, 2009

Цөмийн энергийн тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, хүн ам, нийгэм, байгаль орчныг ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

### 3.1.1.9 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах тусгай зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 3.1.1.10 Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл, 2014

Эрдэс баялагийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг 2014 оны аравдугаар сарын 13-нд Монгол Улсын УИХ-д танилцуулж байсан. Хуулийн төсөл нь 4 бүлэг, 17 зүйлтэй. Хуулийн төсөлд зааснаар энэ хуулийн зорилт нь ашигт малтмалын салбар дахь ил тод байдлыг хэрэгжүүлэхэд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ил тод байдлын тайлан тушаахтай холбогдсон харилцааг багтаасан, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн тайлангуудад үндэслэн ашигт малтмалын салбарын ил тод байдлын нэгдсэн тайлан бэлтгэх болон нэгдсэн тайлангийн талаар олон нийтэд мэдээлэх харилцааг мөн багтаасан.

Хуулийн төсөл Засгийн газар, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэгдээд, одоо УИХ-аар хэлэлцүүлэх ажил хүлээгдэж байна.

### 3.1.1.11 Төрөөс эрдэс баялагийн салбарт 2025 он хүртэл баримтлах бодлого

Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого<sup>3</sup> нь хувийн хэвшилд түшиглэсэн, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгож, үндэсний язгуур эрх ашгийг хангахад чиглэнэ.

<sup>3</sup> <http://www.legalinfo.mn/law/details/9756>

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын зорилго нь хөрөнгө оруулалтын тогтвортой орчныг бүрдүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, дэвшилтэт техник, технологи, инновацийг дэмжих замаар ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэхэд оршино.

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг бусад салбарын бодлоготой харилцан уялдуулан хөгжүүлнэ.

Энэхүү бодлогын баримт бичиг нь төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах зарчим, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэх бөгөөд тэдгээр нь эрдэс баялгийн салбарын хууль тогтоомж, дунд, урт хугацааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, төсөлд тусгагдан хэрэгжинэ.

### ***3.1.1.12 Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого***

Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогын <sup>4</sup> гол зорилго нь Монгол Улсын үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, газрын тосны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах, үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгоход оршино.

### ***3.1.1.13 Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого***

Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын<sup>5</sup> зорилт нь цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болох, улмаар цөмийн энергийг эдийн засаг, нийгмийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд аюулгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэхэд оршино.

### ***3.1.1.14 Аудитын тухай хууль, 1997, 2015***

Аудитын тухай хууль 1997 онд анх батлагдан гарснаас хойш 7 удаа нэмэлт өөрчлөлт орж, 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр шинэчилсэн найруулгыг УИХ-аар баталж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.

Шинэчилсэн найруулгаар хуулинд дараах гол өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнд:

- Аудитын үйл ажиллагааны чанарт хяналт тавих тогтолцооны эрх зүйн үндэсийг цэгцтэй тодорхойлж, хариуцан хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг тодорхой болгосон,
- Санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх үүрэгтэй аж ахуйн нэгж байгууллагыг тодорхойлох шалгуурыг нийт хөрөнгийн хэмжээгээр биш, “нийтийн ашиг сонирхолын аж ахуйн нэгж байгууллага” гэсэн ойлголтод үндэслэх зарчмыг баримталсан.

<sup>4</sup> <http://www.legalinfo.mn/annex/details/3386?lawid=6616>

<sup>5</sup> <http://www.legalinfo.mn/annex/details/3309?lawid=6174>



- Аудитын олон улсын стандартыг мөрдөх, орчуулах, хэрхэн хэрэгжүүлэх талаар аргачлалыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтэд хариуцуулсан,
- Тодорхой аж ахуйн нэгж байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлж байгаа аудитын байгууллагыг 5 жил байхаар хуульчилсан.
- Аудитор болон аудитын байгууллагын хараат бус байдлын зарчим, шалгуурыг илүү тодорхой болгосон.
- Аудитын олон жижиг компаниудыг нэгтгэх, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэн улс орны болон бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх чадвартай болгохын тулд 4-өөс доошгүй хугацаагүй эрхтэй МНБ-той аудитын байгууллага нийтийн ашиг сонирхлын болон том аж ахуйн нэгж байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх эрхтэй байхаар тусгасан.
- Төрийн болон эрх бүхий төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын гишүүд болон өмчлөгчийн хүсэлтээр аж ахуйн нэгж байгууллагын аудитор нь холбогдох аудитын ажил гүйцэтгэдэг байх зохицуулалтыг тусгасан.

### **3.1.1.15 Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2001, 2015**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 1993 онд анх батлагдан гарснаас хойш 2002, 2003, 2006 болон 2011 онд нийт 6 удаа удаа нэмэлт өөрчлөлт орсноор 2015 оны 12 сарын 31-нийг хүртэл мөрдөгдсөн. УИХ-аас 2015 оны 06 сарын 19-нд шинэчилэн найруулсан НББ-ийн тухай хуулийг баталснаар нягтлан бодох бүртгэл, аудитын тогтолцоог орчин үеийн шаардлага, олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл аудитын үйл ажиллагаанд олон улсын стандартыг мөрдөх, санхүүгийн тайланг хэрэглэгчид болох аж ахуйн нэгж байгууллагын гишүүд, хувьцаа эзэмшигчид, банк санхүүгийн байгууллагын болон төрийн санхүүжилтийг аж ахуйн нэгж байгууллагын санхүү, эдийн засгийн бодитой мэдээлэлд тулгуурлан хийдэг тогтолцоо бүрдүүлэх асуудлыг хуульчилсан.

Энэ хууль хэрэгжснээр нийтийн ашиг сонирхлын аж ахуйн нэгж байгууллага болон жижиг дунд аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх болон санхүүгийн тайлагналын үйл ажиллагаа олон улсын стандартад нийцэх юм.

Энэ хууль нь 2016 оны 01 сарын 01-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэн.

### **3.1.1.16 Татварын ерөнхий хууль, 2008**

ТЕХ нь Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх зүйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулдаг ба 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан. Анх батлагдснаас хойш 2015 оны 12 дугаар сарын 31 хүртэл нийт 22 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон.

## **3.1.2 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОН ХҮРТЭЛХ ХУГАЦААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР<sup>6</sup>**

Улсын Их Хурлын ээлжит 7 дахь удаагийн сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016 оны Улсын Их Хурлын сонгуульд оролцсон Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд сонгогчдын санал, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд

<sup>6</sup> Эх сурвалж: <http://zasag.mn/news/khotolbor>



үндэслэн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлсон. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үндсэн зорилгын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан. Үүнд:

1. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.
2. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.
3. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.
4. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.
5. Газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.
6. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
7. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.
8. Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно.
9. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.
10. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанктай хамтран шийдвэрлэнэ.
11. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
12. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.
13. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.
14. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
15. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.
16. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.
17. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.

## Уул уурхайн салбарын талаар Монгол Улсын их хурлын тогтоолд орсон өөрчлөлтүүд

### 2015 оны 02 сарын 13 өдөр

“Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын их хурлын 35 дугаар тогтоолын 8.2 заалтад өөрчлөлт оруулж, дараах байдлаар найруулсан. Үүнд:

Монгол Улсад цөмийн энерги болон цацраг идэвхт ашигт малтмал ашиглах, цөмийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, цөмийн технологи нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, бүрдүүлэх, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг Цөмийн энергийн комисс хэрэгжүүлнэ<sup>7</sup>.

### 2015 оны 01 сарын 23 өдөр

2007 оны 02 сарын 06 өдрийн УИХ-ын 27-р тогтоолоор батлагдсан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын жагсаалтад 2015 оны 01 дүгээр сарын 23-ны 11 тоот тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын ордыг нэмж оруулахаар баталсан.

### Газрын тосны салбартай холбоотой гарсан эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт, журам заавар

№	Нэр	Батлагдсан огноо	Баримтын төрөл	Гол агуулга, тайлбар
1.	Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар	2015.03.16 Засгийн газрын тогтоол №104	Гэрээ, эрх зүйн акт	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчийн хооронд байгуулсан болон байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол Улсын хэмжээнд тогтсон нэг загварт шилжүүлэх.
2.	Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журам	2015.07.07 Засгийн газрын тогтоол №295	Журам	Монгол Улсын нутаг дэвсгэрт уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах.
3.	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон сум, дүүргийн Засаг даргын хооронд байгуулах “Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээ”-ний загвар	2015.11.02 Засгийн газрын тогтоол №430	Гэрээ, эрх зүйн акт	Газрын тосны ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон сум, дүүргийн Засаг даргын хоорондох байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлэх асуудлыг зохицуулах.
4.	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журам	2015.09.04 Уул уурхайн сайдын 196 тоот тушаал	Журам	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах харилцааг зохицуулах.
5.	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн	2016.03.16 Уул уурхай, БОНХАЖЯ-ын сайдын А/28-А/69	Журам	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах харилцааг зохицуулах.

<sup>7</sup> Энэ заалтыг 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 35 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

авах журам	хамтарсан тушаал		
6. Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журам	2015.03.12 Уул уурхайн сайдын 53 тоот тушаал	Журам	Монгол Улсын газрын тосны салбарын инженерүүдэд мэргэжлийн зэрэг олгох, түүнийг төрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулж, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах, газрын тос, уламжлалт бус газрын тосны салбарын инженерүүдэд мэдлэг, мэргэшлийн үр чадвар, түвшин, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх, бүтээл, түршлагыг үнэлэх, тэдний ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.
7. “Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага” журам	2015.09.04 Уул уурхайн сайдын 197 тоот тушаал	Журам	Газрын тосны илрэлийн урьдчилсан үнэлгээ, газрын тосны ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, газрын тосны орд ашиглах төлөвлөгөөнд /техник, эдийн засгийн үндэслэлд/ тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэх, хүлээн авахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах
8. “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага” журам	2015.03.10 Уул уурхайн сайдын 49 тоот тушаал	Журам	Монгол Улсын Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Эрлийн гэрээний дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын анхдагч болон боловсруулалт, тайлал хийсэн материал, үр дүнгийн тайланг боловсруулан Газрын тосны газар (ГТГ)-т хүлээлгэн өгөх харилцааг зохицуулах.

### 3.1.3 ТӨСВИЙН БОДЛОГО (ШААРДЛАГА 2.1)

#### 3.1.3.1 Төсвийн тогтолцоо

Монгол Улсын нэгдсэн төсөв нь доорх төсвүүдээс бүрдэнэ.

- Улсын төсөв,
- Орон нутгийн төсөв,
- Хүнийн хөгжлийн төсөв
- Нийгмийн даатгалын сангийн төсөв

УИХ-аас баталсан Засгийн газар бүрдүүлэн, зарцуулах төсвийг **улсын төсөв** гэнэ.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах төсвийг **орон нутгийн төсөв** гэнэ. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.

Төсвийн орлого нь тогтворжуулалтын сангийн болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ. Тэнцвэржүүлсэн орлого нь үрсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрдэнэ. Татварын болон татварын бус орлогоос үрсгал орлого нь бүрдэнэ. Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа болон үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно. Төрийн

өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

**Хүний хөгжлийн сангийн** эх үүсвэр болон зарцуулалтын дэлгэрэнгүйг Бүлэг 3.8.3-аас харна уу.

**Нийгмийн даатгалын сангийн** орлого дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

- 1) даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- 2) ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл;
- 3) сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, үнэт цаасны арилжаанаас олсон орлого;
- 4) нийгмийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд оногдуулсан алданги;
- 5) улсын төсвөөс олгох хөрөнгө;
- 6) бусад эх үүсвэр.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу дор дурдсан зориулалтаар зарцуулна:

- 1) тэтгэвэр, тэтгэмж олгох;
- 2) нийгмийн даатгалын байгууллага, үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;
- 3) хууль тогтоомжид заасан бусад төлбөр, зардлыг санхүүжүүлэх.

### **3.1.3.2 Төсвийн хууль тогтоомжууд**

Монгол Улсын төсвийн бодлого доор дурьдсан хуулийн хүрээнд зохицуулагдана.

#### **Төсвийн тухай хууль**

Энэ хуулийн зорилт нь төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### **Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010**

2010 оны 6 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас улсын ашигт малтмалын нөөцийг, тогтвортой өсөн нэмэгдэх, бага инфляцийн дагуу ашиглаж байгаа эсэхийг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан. Энэ хууль нь зарчмын хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Энэхүү хуулиар ирээдүйн тэнцвэрт алдагдлын хувь, өрийн зөвшөөрөгдөх хэмжээ, зарлагын өсөлтийн хувь болон төсвийн орлогын тооцооллын процесс зэргийг тодруулж өгсөн. Үүнд:
  - ЗГ-ын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх. (60% болж өөрчлөгдсөн ба энэ заалтыг 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан)
  - Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байна.

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.
- Төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлсон байх. Энэхүү хүрээ нь Засгийн газрын санхүүгийн зорилтуудыг, түүний хүлээгдэж буй төсвийн гүйцэтгэл, болон макро эдийн засгийн (ажил эрхлэлтийн түвшин, хэрэглээний үнийн индекс, гэх мэт) болон дараагийн гурван жилд төсвийн төсөөлөл (төсвийн тэнцэл, төсвийн хөрөнгө оруулалт, гэх мэт) агуулсан байх ёстой.

### **Засгийн газрын тусгай сангийн тухай хууль**

Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### **Ирээдүйн өв сангийн тухай хууль**

Ирээдүйн өв сангийн тухай хууль нь 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр батлагдаж, 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс бүх нийтээр дагаж мөрдөхөөр болсон.

Энэ хуулийн зорилт нь нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн өгөөжийг хуваарилах, сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах, макро эдийн засгийн тогтвортой, үр ашигтай удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Сангийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 3.8.3-аас харна уу.

## **3.2 УУЛ УУРХАЙ**

### **3.2.1 МОНГОЛЫН АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ**

2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,899 компани 3,329 тусгай зөвшөөрөлтэй талбай дээр 57 төрлийн ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байна.

Бид АМГТГ-аас Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөс батлагдсан Монгол улсын ашигт малтмалын нийт нөөцийн хэмжээг харуулсан мэдээллийг хүссэн боловч одоогийн байдлаар улсын хэмжээгээр нэгтгэж, нөөцийн хөдөлгөөнийг тооцсон мэдээлэл байхгүй гэсэн хариулт өгсөн.

2015 календарийн жилд бүртгэгдсэн нөөцийг 2016 оны 9 дүгээр сарын 5-ны байдлаарх нөөцийн нийт дүнгийн хамт доорх хүснэгт ("2015" гэсэн багана)-д харуулсан. Монголын Ашигт малтмалын нөөцийг Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) бүртгэж, тайлагнадаг.

№	Ордын төрөл	Нөөц	Нэгж	Бүртгэсэн нөөц	
				2015	2016-09-05
1	Алтны үндсэн орд	хүдэр	Мян.тн	8,242.52	62,864.24
		Металл-алт	кг	28,044.25	33,819.66

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

№	Ордын төрөл	Нөөц	Нэгж	Бүртгэсэн нөөц	
				2015	2016-09-05
		Металл-мөнгө	кг	36,178.50	6,526.06
		Cu	Мян.тн		4.73
		Mo	Мян.тн		1.50
2	Алтны шороон орд	Шлих	кг	6,800.54	6,564.33
		Металл-алт	кг	6,129.85	5,940.19
3	Төмөр	хүдэр	Мян.тн	202,501.99	17,839.47
		металл	Мян.тн	31,911.38	5,260.50
		Zn			163.34
		Вольфрам			19.54
		Молибден			7.34
4	Зэс	Хүдэр	Мян.тн		2,042,008.33
		металл	тн		7,789,023.59
		Металл-алт	кг		815.0
		молибден			326,265.37
5	Молибден	хүдэр	Мян.тн	314,823.50	
		металл	Мян.тн	286,71	
		экМо	тн	336,397.62	
		W	тн	74,205.50	
6	Гянтболд (WO3, жWO3)	Хүдэр	Мян.тн	254.48	
		металл	тн	2,950.50	
		Sn	тн	456.0	
7	Газрын ховор элемент (исэл)	хүдэр	Мян.тн	268,175.53	
		Металл	Мян.тн	1,203.14	2,263.79
		Li2O	Тн		14,504.49
		Rb2O	Тн		4,250.82
		Cs2O	тн		586.46
8	Нүүрс	Цэвэр	Сая.тн	4,254.34	1,295.43
		Чулууны үетэй	Сая.тн	4,603.60	1,397.98
9	Хайлуур жонш	хүдэр	Мян.тн	5,139.67	801.11
		металл	Мян.тн	2,248.72	335.00
10	Шохойн чулуу		Мян.тн	118,156.07	155,388.34
11	Барилгын чулуу		мян.м3	100,199.48	130,833.55
12	Элс-хайрга		мян.м3	25,006.86	4,446.33
13	Гөлтгөнө		Мян.тн	18,061.22	
14	Уран	Хүдэр	Мян.тн	9,043.22	214,534.22
		Металл	тн	7,885.72	4,922.25
15	Манган	Хүдэр	Мян.тн	11,791.65	
		металл	Тн	941.25	
		Хүдэр-Mn3O4	Мян.тн	8,238.52	
		Металл- Mn3O4	Мян.тн	819.25	
16	Бал чулуу	Хүдэр	Мян.тн		8,600.04
		Металл			712.05
17	Цахиурын элсэн чулуу	Металл	Мян.тн		17,266.79
18	Шавар		Мян.тн		1,355.77
19	Холимог металл	Хүдэр	Мян.тн		15,091.37
		Молибден	Тн		8,908.24
		Зэс	Тн		57,547.25
		Эк Зэс	Тн		84,546.65
		WO3	Тн		21,150.52
		Мөнгө	кг		28.09
		Цинк	Тн		41,043.13
		Хөнгөн цагаан	Тн		1,534.88
		Be	Тн		9,363.85
		Vi	Тн		3,533.18
		экWO3	Тн		31,109.93

Эх сурвалж: АМГ-ын Геологи хайгуулын хэлтэс

Нүүрс

## **Монгол улсын нүүрсний салбарын нөөц баялаг, хөгжил**

Монгол орны хувьд нүүрс нь эрчим хүчний үндсэн эх үүсвэр төдийгүй манай улсын эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч үнэт баялаг болж байна.

Өнөөгийн дэлхийн жилийн хэрэглээгээр газрын тосны нөөц 50 жил, байгалийн хийн нөөц 70 жил байхад нүүрс 250 жилийн нөөцтэй байна гэж үздэг. Манай улсын нүүрсний геологийн таамаг нөөц 162.3 тэрбум тонн, цаашдаа өсөх магадлалтай гэж тогтоосон бөгөөд 20 гаруй тэрбум тонн нүүрсний нөөцийг урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын үр дүнгээр тогтоосон 15 сав газрын хүрээнд 300 гаруй орд, илрэл байгаа бөгөөд манай орон нүүрсний нөөцөөр дэлхийн эхний 10 орны тоонд багтдаг.

## **Зэс**

### **Оюу Толгой ХХК**

Оюу Толгой ХХК<sup>8</sup> нь дэлхийн хамгийн том зэс-алтны ордод олборлолт явуулах уурхайг бүтээн байгуулж байна. Тус орд нь хамгийн багадаа 50 жилийн хугацаанд ашиглахуйц хэмжээний ихээхэн нөөцтэй юм. Оюу Толгойн ордыг Канадын Туркойз Хилл Ресурс компани 2001 онд анх нээсэн. Дэлхийн уул уурхайн томоохон компаниудын нэг Рио Тинто нь Туркойз Хилл Ресурс компаний хувьцааны дийлэнх хувийг эзэмшдэг бөгөөд энэхүү төсөлд 2005 оноос эхлэн идэвхтэй оролцож байна. 2010 оноос Рио Тинто нь хувь нийлүүлэгчдийг төлөөлөн төслийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон.

Оюу Толгой ХХК-ийг Туркойз Хилл Ресурс (66%) болон Эрдэнэс Оюу Толгой ХХК (34%) хамтран эзэмшдэг бөгөөд Эрдэнэс Оюу Толгой компанийг Монгол улсын Засгийн газар эзэмшдэг. Тогтвортой хөгжлийн ерөнхий бүтэц Оюу Толгой нь Монгол улсын түүхэнд хийгдэж буй хамгийн том хөрөнгө оруулалт юм. Тус төсөлд 6 тэрбум ам. долларын капитал хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд нэмэлт 1 тэрбум ам. долларыг хайгуул, үнэлгээний ажилд зарцуулжээ.

Энэхүү хөрөнгө оруулалт нь 2010 оны байдлаар 6.2 тэрбум ам. долларын дотоодын нийт бүтээгдэхүүн бүхий Монгол улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэхүйц чухал ач холбогдолтой юм. Олон улсын валютын сангийн тооцоогоор Монгол улсын Засгийн газар нь Оюу Толгой төслийн үр дүнг голлон хүртэгч байх бөгөөд нийт ашгийн 71 хүртэлх хувийг Монгол улс хүртэх юм.

Тус төсөл нь Монгол улс дахь томоохон ажил олгогч билээ. Бүтээн байгуулалтын оргил үед төсөл дээр 15,000 гаруй хүн ажиллах бөгөөд эдгээрийн 10,000 нь Монголчууд байх юм.

### **"Эрдэнэт үйлдвэр" ХХК**

Монгол-Оросын "Эрдэнэт үйлдвэр" ХХК<sup>9</sup> нь зэс, молибдений хүдрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивдээ томоохонд тооцогддог үйлдвэр юм. 1978 онд хоёр орны засгийн газар хоорондын гэрээний дагуу "Эрдэнэтийн овоо"-ны орд газарт байгуулагдсан.

---

<sup>8</sup> <http://ot.mn/>

<sup>9</sup> <https://www.erdenetmc.mn/>

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Жилд 26 сая тонн хүдэр боловсруулж 530.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 4.5 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг. Гэвч тус үйлдвэрийн ашиглах нөөц саяхан нэмэгдсэн. Уул уурхайн яамнаас Эрдэнэтийн овоо орчимд хайгуул хийж байсан таван лицензийг төрийн мэдэлд авсан билээ. Ингээд нөөц нь гурван сая тонн зэс, 55 мянган тонн молибденээр нэмэгджээ. Энэ нөөцийг 24 тэрбум ам.доллараар үнэлж буй аж.

### **Төмөр**

2012 оны эцсийн байдлаар Монгол улсын хэмжээнд төмрийн хүдрийн нөөц (А+В+С) 1 тэрбум тн байна гэж улсын ашигт малтмалын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн байна. Нийтдээ 28%-60%-ийн дундаж агуулгатай 46 орд бүртгэгдсэнээс 50 сая тонноос дээш нөөцтэй ордуудад Төмөртэй, Баянгол, Цахиурт-Овоо, Таяннуур, Эрээн, Дарцагтын төмрийн хүдрийн ордууд багтсан байна.

### **Алт**

Монгол Улсын Засгийн газраас 1992, 2000 онуудад “Алт хөтөлбөр”- үүдийг баталж хэрэгжүүлсэн нь Монгол улсын эдийн засгийн засгийн өсөлтийг дэмжих, тухайн үеийн эдийн засгийн хүндрэлийг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2015 оны 10 дугаар сарын мэдээгээр алтны салбар нь ДНБ-ний 2.6 хувь, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн 9.6 хувь, экспортын орлогын 9.1 хувийг тус тус эзэлж байна.

Өнөөдөр Монгол улсын алтны нөөц 2000.0 гаруй тонн байна. Сүүлийн жилүүдэд алтны салбарын хууль эрх зүй, татварын орчин сайжирснаар алт тушаалтын болон экспортын орлого тогтвортой өсч байна. 2012 онд алтны олборлолт 5.9 тонн байснаа 2014 онд 12.0 тонн, 2015 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 15.0 тонн болж өсөхөөр байна.

Монголбанкинд тушаасан алт 2013 онд 6.0 тонн байснаа 2014 онд 12.7 тонн болж нэмэгдсэн. Бичил уурхайчдын Монголбанкинд тушаасан алтны эзлэх хувь 2013 онд 0.1 хувь байснаа 2014 онд 25.5 хувь, 2015 оны 10 сард 45.7 хувь болж өсчээ. 2014 оныг 2013 онтой харьцуулахад алт тушаалтын орлого 270.4 сая ам.доллар байснаа 514.5 сая ам.доллар болж бараг 2 дахин өсчээ.

### **Хайлуур жонш**

Хайлуур жонш буюу фтор нь өнгөт болон хар төмөрлөгөөс гадна хими, анагаах ухаан, оптикийн салбарт өргөнөөр хэрэглэгддэг газрын шүлтэт металл юм.

Манай орон энэ түүхий эдийн олборлолт, экспортоор 1980-аад онд дэлхийд тэргүүлдэг байжээ. Манай улс жилд 400 мянган/тн хайлуур жонш олборлож байна. Олборлолтын хэмжээгээрээ дэлхийд гуравдугаарт буюу БНХАУ, Мексикийн дараа ордог байна.

### **Молибдени**

БНХАУ-д молибдений баяжмалын эрэлт бүүрсан байгаа учир зах зээл ерөнхийдөө удаашралтай байгаа боловч молибдений гол уурхайнууд үйлдвэрлэлээ тогтоосон хэмжээгээр, тогтмол явуулсаар байна.

2013 он гэхэд, молибдений үйлдвэрлэл нь 3.8 мянган тонн (47% -ийн агууламжтай) буюу өмнөх оны мөн үеийнхээс 4.7% -иар бүүрсан хэдий ч Монгол Улс молибдени үйлдвэрлэлээрээ дэлхийд 13-т орж байна.



### **Цайр**

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн судалгааны өнөөгийн түвшинд цайр, хар тугалганы 15 орд, 120 орчим илэрц нээгдэн судлагдсан байна. 2013 оны байдлаар Монгол Улс 104 мянган тонн цайрын баяжмал олборлосон байна.

### **Уран**

Өнөөгийн байдлаар Монгол орны хэмжээнд ураны 11 ордын хэмжээнд 75 орчим мян.тн геологийн нөөц, баялаг зэргээр 1.5 орчим сая.тн таамаг нөөцийг тогтоогоод байна. 11 ордын хэмжээнд бодогдсон 75.2 орчим мян.тн нөөцөөс 7 ордын 67.3 орчим мян.тн нөөц эдийн засгийн хувьд ашигтай үйлдвэрлэлийн нөөцөд тооцогдож байна. Дээрх нөөц нь дэлхийн ураны нөөцийн 1 орчим хувь буюу дэлхийн цөмийн эрчим хүчний 1 жилийн хэрэглээг хангах боломжтой юм.

№	Ордууд	Нөөц, мян.тн U	Нөөцийн зэрэглэл
1	Дорнод	28,868	C1+C2
2	Гурванбулаг /төв хүдрийн биет/	8,580	B+C
3	Нэмэр	2,528	C2
4	Мардай	1,104	C1+C2
5	Улаан	270	C1+C2
6	Хараат	7,288	B+C
7	Хайрхан	8,406	B+C
8	Нарст	1,000	P1
9	Дулаан уул	9,888	B+C
10	Гурван сайхан	4,250	C
11	Өлзийт	3,076	C
<b>Нийт нөөц</b>		<b>75,258</b>	

### **3.2.2 СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ОРДУУД**

“Ашигт малтмалын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 1.5-д “Засгийн газар нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох тухай саналыг Улсын их хуралд өргөн мэдүүлнэ” гэж заасан байна.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тодорхойлолт: “Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн түвшинд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд болзошгүй нөлөөтэй байж болох ; эсхүл тухайн жилд нийт ДНБ-ний 5% -иас илүү үйлдвэрлэх боломжтой эсвэл үйлдвэрлэж байгаа ордын хэмжээ юм”.

Стратегийн ач холбогдолтой эрдэс баялагт ус, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийг хамааруулах ба “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэдэгт Монгол Улсын Их хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтад заагдсан нэр бүхий 15 ордыг хамааруулдаг байна.

Стратегийн ач холбогдол бүхий ордуудын нөөц:

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Нөөц (мян.тонн)	Тайлбар
1.	Таван толгой	Чулуун нүүрс	Өмнөговь, Цогтцэций	6,400,000	Тавантолгой ХК, Энержиресорс ХХК, Дайцуки ХХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна.
2.	Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь, Гурвантэс	126,000	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.
3.	Багануур	Хүрэн нүүрс	Улаанбаатар, Багануур	600,000	Нөөц тооцсон талбайг хамааруулна. “Багануур” ХК олборлодог.
4.	Шивээ Овоо	Хүрэн нүүрс	Говьсүмбэр, Шивээговь	646,000	Нөөц тооцсон талбайг хамааруулна. “Шивээ Овоо” ХК олборлодог.
5.	Мардай	Уран	Дорнод, Дашбалбар	0.0011	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
6.	Дорнод	Уран	Дорнод, Дашбалбар	0.0289	
7.	Гурван булаг	Уран	Дорнод, Дашбалбар	0.0161	
8.	Төмөртэй	Төмрийн хүдэр	Сэлэнгэ, Хүдэр	229,000	Уг ордын тусгай зөвшөөрлийг “БЛТ” ХХК эзэмшиж байсныг 2006 онд цуцалсан. Нөөц тооцсон талбайг хамааруулна.
9.	Оюу толгой	Зэс, молибдени	Өмнөговь, Ханбогд	26,300 (Зэс) 0.019 (Мөнгө)	Ордын нөөцийн тооцоо бүхий тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэхэд бэлтгэж байна. Бүлэг ордын хэмжээгээр ойлгоно.
10.	Цагаан суварга	Зэс, молибдени	Дорноговь, Мандах	10,600	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
11.	Эрдэнэт	Зэс, молибдени	Орхон, Баян-Өндөр	1,200,000	
12.	Бүрэнхаан	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	192,000	Хөвсгөлийн их дархан цаазат газрын гадна ногдох нөөц тооцогдсон хэсэгт дөрвөн компани хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.
13.	Бороо	Алт	Сэлэнгэ, Баянгол	0.025	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.
14.	Төмөртэйн овоо	Цайр, хар тугалга	Сүхбаатар, Сүхбаатар	7,700	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.

Д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Нөөц (мян.тонн)	Тайлбар
15.	Асгат	Мөнгө	Баян-Өлгий, Ногооннуур	6,400	Монгол Улс-ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээ бүхий хамтарсан Монголросцветмет нэгдэл тусгай зөвшөөрлийг нь эзэмшиж байгаа.
16	Гацуурт <sup>10</sup>	Алт	Сэлэнгэ, Мандал	-	Ордын хил хязгаарыг Засгийн газар тогтооно.

Эх сурвалж: Монголын Ашигт малтмалын газар

### 3.2.3 БИЧИЛ УУРХАЙ

Ашигт малтмалын илрэл бүхий нийт 238 орд, газарт бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж байгаагийн 181 буюу 76.1 хувь нь 8 аймагт байршиж, тэдгээрийн 44 нь Төв аймагт; 33 нь Говь-Алтай аймагт; 25 нь Дорноговь аймагт; 20 нь Хэнтий аймагт; 17 нь Ховд аймагт; Сэлэнгэ, Өмнөговь аймагт тус бүр 16 нь; 10 нь Увс аймагт байна.

Ашигт малтмалын орд олонтой дээрх 8 аймгийн 7.0 мянган бичил уурхай эрхлэгчдийн 1.8 мянга буюу 25.0 хувь нь Төв аймагт; 1.7 мянга буюу 24.4 хувь нь Увс аймагт; 1.3 мянга буюу 17.9 хувь нь Сэлэнгэ аймагт; 0.8 мянга буюу 10.7 хувь нь Говь-Алтай аймагт; 0.6 мянга буюу 9.0 хувь нь Ховд аймагт; үлдсэн 0.9 мянга буюу 13.0 хувь нь Дорноговь, Өмнөговь, Хэнтий аймагт байна.

Нэгж орд газарт ногдох бичил уурхай эрхлэгчд<sup>11</sup>-ийн тоог аймаг, нийслэлээр авч үзвэл Улаанбаатар хотод 420, Баянхонгор аймагт 321, Хөвсгөл аймагт 212, Увс аймагт 171, Дархан-Уул аймагт 148, Өвөрхангай аймагт 108, Сэлэнгэ аймагт 78, Дүндговь аймагт 52, Говьсүмбэр аймагт 52 ногдож байна. Харин Өмнөговь аймагт 11, Дорнод аймагт 12, Хэнтий аймагт 14 ногдож, нэгж орд газарт ногдох бичил уурхай эрхлэгчдийн тоогоор нягтаршил багатайд орж байна.

Засгийн газрын 2010 оны 12 дугаар сард Засгийн газрын 308 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг баталж, түүнийг хэрэгжүүлж байна. Бичил уурхайчдын 70 гаруй хувь нь алтны салбарт ажиллаж байна. Алтны бичил уурхайчдын дийлэнхи нь алтны үндсэн болон шороон ордод олборлолт явуулж байна. Монгол улсын хэмжээнд 30 гаруй мянган бичил уурхайчид<sup>12</sup> улирлын чанартайгаар алт олборлох үйл ажиллагаа эрхэлж, өөрөө өөртөө ажлын байр гаргаж, орлогын эх сурвалжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2014 онд 5.3 мянган гишүүдтэй 41 нөхөрлөл ажиллаж, сүүлийн жилүүдэд нөхөрлөл болон нөхөрлөлд хамрагдах иргэд, бичил уурхай эрхлэгчдийн тоо нэмэгдэж байна. Алтны бичил уурхайчид 2006 онд 2.1 тонн алт олборлож байсан бол 2013 онд 1.3 тонн, 2014 онд 1.5 тонн алт олборлосон байна.

<sup>10</sup> Энэ заалтыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нэмсэн

<sup>11</sup> Эх сурвалж: Бичил уурхай эрхлэгчдийн судалгааны тайлан-Үндэсний статистикийн хороо, Швейцарийн хөгжлийн агентлаг, 2013 он

<sup>12</sup> Эх сурвалж: “Алт 2025” хөтөлбөрийн суурь судалгааны тайлан

### 3.2.3.1 Хууль, эрх зүйн орчин

Хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааг дэмжих зорилгоор МУЗГ-аас гарсан эрх зүйн баримт бичгүүдийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- МУЗГ-ын Үйлдвэр худалдааны сайдын 2002 оны 05 сарын 24-ний өдрийн 53 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалыг үйлдвэрлэлийн бус аргаар олборлох түр журам” нь эрх зүйн анхны баримт бичиг болсон.
- 2008 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр МУЗГ-ын “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай” 28 дугаар тогтоол гарч, уг тогтоолд “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа зарим иргэдийн алтны үндсэн ордын хүдрийг баяжуулах цехийн үйл ажиллагааг 3-4 газарт зохион байгуулах тухай” заасан,
- МУЗГ-ын 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 71 дүгээр тогтоолоор “Бичил уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх дэд хөтөлбөр”, 72 дугаар тогтоолоор “Хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” –ыг тус тус баталсан.
- 2008 оны 3 сарын 12-ны өдөр “Налайхын нүүрсийг хувиараа ашиглаж байгаа иргэдийн үйл ажиллагааг зохицуулах тухай” 89 дүгээр тогтоол,
- 2010 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, бичил уурхайн талаарх геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг хуульчилж улмаар тус хуулийн 3.1.2-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална” гэж заасан байна.
- МУЗГ-аас 2010 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 308 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг баталж өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

### 3.2.3.2 Бичил уурхайн эрх зүйн орчны шинэчлэлийн талаар мэдээлэл

Эрх зүйн орчин	Заалтууд
2014 оны 7 сарын 01-ний өдөр “ашигт малтмалын тухай хууль”	<p>4.1.23. “бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл ордын талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг;</p> <p>20.1. Энэ хуулийн 53.1.1, 56.1.3-56.1.5-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл нь дуусгавар болсон, цуцлагдсан бол төрийн захиргааны байгууллага доор дуурдсан журмын дагуу сонгон шалгаруулалт явуулж тусгай зөвшөөрлийг шинээр олгоно.</p> <p>7.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно. Байгалийн өнгөт болон үнэт чулууг түүх, олборлох үйл ажиллагааг ердийн ашигт малтмалын ажил тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэнэ.</p> <p>11.1.13. Улсын төсвийн хөрөнгөөр илрүүлсэн эрдсийн хүримтлал бүхий талбайд тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах, бичил уурхайн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох дүгнэлт гаргах;</p> <p>35.6. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд, бичил уурхайгаас алт олборлогч нь олборлосон алтаа тухайн санхүүгийн жилдээ багтааж тушаана.</p> <p>66.1.9. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, албан тулаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.</p>
Засгийн газрын 2012-	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгож хэрэгжилтэд

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Эрх зүйн орчин	Заалтууд
2016 оны мөрийн хөтөлбөр	тавих хяналтыг сайжруулах;
Монгол Улсын Их Хурлын 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого”	3.1.2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч иргэдийг хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг төрөөс бодлогоор дэмжиж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;
Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”	2.64. “Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.  2.69. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2014 онд Ашигт малтмалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд болон Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогын хэрэгжилтийн хүрээнд Уул уурхайн сайдын 2015.02.25-ны өдрийн дугаар 34 тоот тушаалаар Засгийн газрын 2010 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

### 3.2.3.3 Нөхөн сэргээлтийн байдал

Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхайн төслийн санхүүжилтээр “АНУ-ын Азийн сангийн байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II” төсөлтэй хамтран бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэгдсэн орхигдсон нийт 9 аймгийн 14 сумын 23 газар буюу 144.3 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн.

Нөхөн сэргээлт хийсэн байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Аймаг, сумын нэр	Загвар нөхөн сэргээлтийн талбайн нэр, нөхөн сэргээсэн газрын хэмжээ (га).	Ордын төрөл	БУ-н болон Нөхөн сэргээлтийн ТББ-ын нэр	Хэрэгжүүлсэн хугацаа (Техникийн болон Биологийн нөхөн сэргээлт)
1	Баянхонгор, Баян-Овоо	Алтан ус (5 га)	Алтны шороон орд	Алтан усны хөгжил	2014 оны 7/20-9/21
2	Баянхонгор, Жаргалант	Мандал бүүрэг ба Зүүн салаа (6 га)	Алтны шороон орд	Байдрагийн хөгжил	2014 оны 7/16-9/15
3	Баянхонгор, Галуут	Шар хуруу (6.7 га)	Алтны шороон орд	Бат сайхан сэтгэл	2014 оны 7/20-9-20
4	Хэнтий, Норовлин	Өвдөг ухаа (6 га)	Алтны шороон орд	Норовлин хамтын хүч	2014 оны 7/16-9/15
5	Говь-Алтай, Есөнбулаг	Зүрх толгой (10.1 га)	Алтны шороон орд	Газар шороо ард түмний баялаг	2014 оны 7/16-9/15
6	Говь-Алтай, Есөнбулаг	Майхны хуруу (12.1 га)	Алтны шороон орд	Буюн рашаант нутаг	2014 оны 7/16-9/15
7	Говь-Алтай, Есөнбулаг	Майхны хуруу (10.6 га)	Алтны шороон орд	Ван тайж	2014 оны 7/16-9/15

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

8	Дорноговь, Айраг	Нийт (12 га) "64" (5 га) "19" (7 га)	Жоншны үндсэн орд	Эх орон хамтын хүч	2014 оны 7/16-9/23
9	Дорноговь, Айраг	Нийт (2.8 га) Бороодой (1.3 га) Тагт (1.5 га)	Жоншны үндсэн орд	Хутагтын үр сад	2014 оны 7/16-9/23
10	Сэлэнгэ, Мандал	Ноёд (1 га)	Алтны үндсэн орд	Дууш мандал хайрхан	2014 оны 8/11-9/15
11	Увс, Өмнөговь	Орлогын гол (10 га)	Алтны шороон орд	Бид намырын эзэд Баян нутгийн хишиг	2015 оны 7/05-9/03
12	Ховд, Алтай	Халтар уул (11 га)	Алтны шороон орд	Алтайн хөгжил-Иргэдийн оролцоо	2015 оны 7/05-9/03
13	Ховд, Булган	Цоохор нуур (6 га)	Алтны үндсэн ба шороон орд	Увс хааны үрс	2015 оны 7/05-9/03
14	Ховд, Үенч	Цагаан чулуут (12 га)	Алтны шороон орд	Үенч алтан нутаг	2015 оны 7/05-9/03
15	Дундговь, Өлзийт	Шар хошуу ба Хөтөл (10 га)	Алтны шороон орд	Өлзийт хишиг бүян	2015 оны 7/03-9/03
16	Өмнөговь, Гурвантэс	Дэвтээр (10 га)	Алтны үндсэн ба шороон орд	Тэсийн хөгжилд бидний оролцоо	2015 оны 7/05-10/05
17	Өмнөговь, Сэрвэй	Нийт (10 га) Дайргат (4 га) Чавганц толгой ба 850-ын жалга (6 га)	Алтны үндсэн ба шороон орд	Ногоон сэрвэй	2015 оны 7/03-9/03

### 3.2.3.4 Бичил уурхайн талбайн дүгнэлт:

2016 оны байдлаар АМГТГ-аас бичил уурхайн зориулалтаар нийт 1797.24 га талбайд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой гэсэн дүгнэлт гаргасан байна.

Дүгнэлтийн дэлгэрэнгүйг харуулбал дараах байдалтай байна.

Он	Хамрагдсан аймаг сумдын тоо	Талбайн тоо	Талбайн хэмжээ (га)
2012	10 аймаг, 10 сум	25	856.55
2013	1 аймаг, 1 сум	3	15.87
2014	6 аймаг, 6 сум	10	56.21
2015	10 аймаг, 10 сум	23	641.24
2016 оны 10 сарын байдлаар	7 аймаг, 8 сум	26	227.37
<b>Дүн</b>	<b>34 аймаг, 35 сум</b>	<b>87</b>	<b>1797.24</b>

### 3.2.3.5 Баяжуулах цехийн мэдээлэл

Төв аймгийн Борнуур, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Сэлэнгэ аймгийн Мандал сумдад алтны үндсэн ордын баяжуулах цехүүд баригдсан. Эдгээрээс Сэлэнгэ аймгийн Мандал суманд үйл ажиллагаагаа явуулж байгаа “Сүрлэг Мандал” ХХК-ийн баяжуулах цех, Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Хотгорын хүдэр компанийн баяжуулах цехүүд холбогдох зөвшөөрлийг авч үйл ажиллагаа явуулж байна. Харин Мандал сумын орон нутгийн өмчит баяжуулах цех болон Борнуур суманд баригдсан баяжуулах цехийн “Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ” өнөөдрийг хүртэл батлагдаагүй тул албан ёсоор үйл ажиллагаа явуулаагүй байна.

### 3.2.3.6 Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалын хэмжээ, борлуулалт

Бичил уурхайн 308-р журмын 3.10 “Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг батлагдсан маягтын дагуу гаргаж, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх” тухай заасны дагуу АМГТГ-аас сумдад албан тоот хүргүүлсэн боловч сумдын засаг дарга нар бичил уурхайн талаарх мэдээллийн албан хариуг АМГТГ-т өнөөг хүртэл ирүүлээгүй байна. Иймд бичил уурхайн

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

эрхлэгчдийн олборлосон ашигт малтмалын талаарх албан ёсны статистик мэдээлэл одоогоор байхгүй байна.

Харин Монгол банкинд тушаасан алтыг иргэдээс болон аж ахуйн нэгжүүдээс гэж ангилж харж болох ба 2016 оны 3-р улирлын байдлаар Монгол банкинд алт олборлогч аж ахуйн нэгж, иргэдээс нийт 17,841 кг алт тушаасан байна.


Улирал	Алт тушаасан аж ахуй нэгжийн тоо	Тушаасан алтны хэмжээ, кг	Алт тушаасан иргэдийн тоо	Иргэдээс тушаасан алтны хэмжээ
1	560	1,862.19	405	1,196.58
2	1,342	4,610.61	789	2,523.81
3	1,318	5,195.20	616	2,453.10
<b>Нийт</b>	<b>3,220</b>	<b>11,668.00</b>	<b>1,810</b>	<b>6,173.49</b>

### 3.2.3.7 Бичил уурхай эрхлэгчдийн мэдээлэл

Өнөөдрийн байдлаар Бичил уурхайн нэгдсэн “Дээвэр” холбоонд 406 нөхөрлөлийн 3592 бичил уурхай эрхлэгчид бүртгэлтэй байна. Энэхүү холбооны орон нутаг дахь гишүүн ТББ-уудын мэдээллийг Хавсралт 28-аас харна уу.

### 3.2.3.8 Бичил уурхайн аюулгүй ажиллагаа

Бичил уурхай дахь хөдөлмөрийн оюулгүй ажиллагааг сайжруулах уурхайн осолд гэмтлээс урьдчилан сэргийлэхийн тулд Швейцарийн хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төсөл болон Онцгой байдлын ерөнхий газрын Уул уурхайн аврах ангитай 2006 оноос бичил уурхайчдад ХАБЭА-н сургалт зохион байгуулж байна. Удаа дараагийн сургалт, сурталчилгааны үр дүнд зохион байгуулалтанд орсон бичил уурхайчдын дунд осол гэмтлийн тоо буурсан. Тухайлбал: 2015 онд нийт 5154 хүн бичил уурхайн аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдсан бөгөөд үүнээс 2785 нь бичил уурхайчид, 2369 нь төрийн албан хаагч болон орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн алба хаагчид байсан.



### 3.2.4 ЗАСАГЛАЛ

Уул уурхай (газрын тосноос бусад) эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо дараах хуулиудаар зохицуулагдана. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль



- Цөмийн энергийн тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль

Зарим тохиолдолд "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль" ("Урт нэртэй хууль") нь үйлчилдэг. Монгол Улс өөр тус тусдаа хууль тогтоомж, дүрэм журмын үйлчлэлээр тухайн ашигт малтмалын ордуудыг хэд хэдэн төрлөөр ангилдаг.

Ашигт малтмалын тухай хуулинд (Бүлэг 6. Ашигт малтмалын орд газруудын ангилал) дараах байдлаар ашигт малтмалын ордыг ангилдаг гэж заасан.

- стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд,
- түгээмэл тархацтай ашигт малтмалын орд,
- ердийн ашигт малтмалын орд

#### **3.2.4.1 Стратегийн орд**

Монгол Улс нь "стратегийн" гэх тодотголтой 16 орд газартай, 39 орд газрыг шинээр бүртгүүлэхээр зэхэж байна. Одоо байгаа 16 орд газрын жагсаалтыг Бүлэг 3.2.1.9-өөс харна уу.

#### **3.2.4.2 Түгээмэл тархацтай орд**

Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна. Барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой байгал дээр элбэг тархалттай хурдас чулуулгийн хуримтлал, элс, хайрга, шар шавар зэргийг түгээмэл тархацтай ашигт малтмалд оруулдаг. Үндсэндээ барилгын материалын эрдэс түүхий эд гэж ерөнхийд нь ойлгож болно. Ашигт малтмалын хууль үйлчилснээс хойших хугацаанд түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглах ашиглалтын лицензийн тоо ялангуяа орон нутагт хэд дахин өссөөр байна.

#### **3.2.4.3 Ердийн ашигт малтмал**

Ашигт малтмалын тухай хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон түгээмэл тархацтай ашигт малтмалын ордоос бусад ордыг ердийн ашигт малтмалын ордод хамааруулахаар заасан.

Ашигт малтмалын тухай хуулиар дээрх аль ч ангилалд эрэл хайгуул, олборлох үйл ажиллагаа явуулахаас өмнө тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

### **3.2.5 ЛИЦЕНЗ ОЛГОЛТ**

Олборлох салбарт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдэд төрийн захиргааны төв болон бусад байгууллагаас дараах тусгай зөвшөөрөл олгодог байна. Үүнд:

<b>Байгууллага</b>	<b>Тусгай зөвшөөрөл</b>	<b>Тайлбар</b>
Уул уурхайн яам (Цөмийн энергийн тухай хууль болон Монгол Улсын	Цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх тусгай зөвшөөрөл Цацраг идэвхт ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад



Байгууллага	Тусгай зөвшөөрөл	Тайлбар
Ерөнхийлөгчийн зарлигт үндэслэн тусгай зөвшөөрөл олгох эрхийг Ашигт малтмалын газарт олгосон)	Цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх тусгай зөвшөөрөл	хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно.
Ашигт малтмалын газар	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Шинээр авах, хугацааг нь сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, бусдад шилжүүлэх, барьцаалах, нөхөн авахад хамааралтай
	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл	
Газрын тосны газар	Импортлох тусгай зөвшөөрөл	Авах, хугацааг нь сунгах, бусдад шилжүүлэх - Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг импортлоход
	Бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Авах, хугацааг нь сунгах, бусдад шилжүүлэх - Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг агуулахаас худалдах үйл ажиллагаа
	Жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл	Авах, хугацааг нь сунгах, бусдад шилжүүлэх - Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийг түгээх станцаас худалдах үйл ажиллагаа
Цөмийн энергийн комисс	Цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно
	Цөмийн төхөөрөмж ашиглах тусгай зөвшөөрөл	
	Цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах тусгай зөвшөөрөл	
	Цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах тусгай зөвшөөрөл	
Байгал орчин аялал жуулчлалын яам	Ус ашиглах зөвшөөрөл	Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл. Зөвшөөрлийг бусдад шилжүүлэх хориотой
Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар	Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах	Тусгай зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг худалдах, бэлэглэх, барьцаалах болон өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад шилжүүлэхийг хориглоно
	Цацрагийн үүсгүүрийг угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах тусгай зөвшөөрөл	
	Цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл	
	Цацрагийн үүсгүүрийн хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл	
Өмчийн харилцааны газар/Байгаль орчин аялал жуулчлалын яам	Газар ашиглах, эзэмших зөвшөөрөл	Газар ашиглах, эзэмших эрх олгох, бүртгэл хийх, хугацааг нь сунгах, гэрээ байгуулах, гэрээний үүргийг хянах. Мөн газрыг барьцаалсан бол бүртгэх

Эх сурвалж: Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнгийн хийсэн Олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын "ашиг хүртэгч жинхэнэ эзэд"-ийн ил тод байдлыг хангах чиглэлээрх боломжит байдлын урьдчилсан судалгаа

### 3.2.6 ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ (ШААРДЛАГА 2.2.А.1)

Хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэх, олгох үйл явц болон хайгуулын тусгай зөвшөөрлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл рүү шилжүүлэх, мөн шинэ оролцогч талд нөгөө тал нь тусгай зөвшөөрлөө шилжүүлэх үйл явцыг дараагийн хэсэгт диаграмаар харуулсан.

Сонирхсон этгээд нь Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн (2014), Ашигт малтмалын тухай хуулийн (2006) нэмэлт өөрчлөлт заалтын дагуу тухайн тусгай зөвшөөрлийг тендерээр олгох шаардлагатай байхаас бусад тохиолдолд шууд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл АМГ-т хүсэлтээ гаргаж болно.

Хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэх тохиолдолд дараах заалтууд хамрагдана:


- Төрийн санхүүжилтээр хийгдсэн геологийн судалгааны ажлаар тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайд хүсэлт гаргавал,
- нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу улсаас буцаан авсан тусгай зөвшөөрлийг дахин олгох бол,

Нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль нь дараах тодорхой нөхцөл байдалд уул уурхайн тусгай зөвшөөрлийг тендерээр олгохыг шаарддаг:


- Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө уул уурхайн тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг гаргаагүй бол,
- Төрийн санхүүжилтээр хайгуул хийж, нөөц тодорхойлсон талбайд уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох бол

Дараах диаграмаар өргөдлийн үйл явцыг тайлбарласан.


3.2.6.1 Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явц



3.2.6.2 Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц



3.2.6.3 Тусгай зөвшөөрөл шилжүүлэх үйл явц



3.2.6.4 Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт, дахин олгох үйл явц

Үе шат	Төрийн захиргааны байгууллага	Үйл явц
1-р үе шат	АМГ	Сонгон шалгаруулах үйл явцыг эхлүүлж, захирамж гаргах
2-р үе шат	АМГ	Олон нийтэд сонгон шалгаруулалтыг зарлах
3-р үе шат	АМГ	Сонгон шалгаруулалтын саналыг хүлээж авах. Сонгон шалгаруулалтыг анх зарласнаас хойш дуусах хугацаа нь 30 хоногоос багагүй байх ба сонгон шалгаруулалтад оролцогчид дараах баримт бичгийг хавсаргана. <ul style="list-style-type: none"> <li>- Сонгон шалгаруулалтад оролцох санал</li> <li>- Санал гаргагчийн албан ёсны тодорхойлолт</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</li> <li>- Монгол улсад татвар төлөгч болохыг тодорхолсон баримт</li> <li>- Сонгон шалгаруулалтын босго үнийг Монгол банкинд бүртгэлтэй арилжааны банкинд хугацаатай байршуулсан баталгаа</li> <li>- Тухайн талбайд гүйцэтгэх хайгуул болон ашиглалтын ажлын төрөл хэмжээ, хугацаа, өртөг болон байгаль хамгаалахад зарцуулах зардлыг тоймлон тусгасан төсөл, төсвийн санал</li> <li>- Хайгуул болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт /баримтыг нотариатоор батлуулсан байна/</li> <li>- Мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал, / баримтыг нотариатоор батлуулсан байна/</li> <li>- Хайгуул, ашиглалт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг явуулах дэвшилтэт арга аргачлал, технологийн шийдэл,</li> <li>- Байршил болон огтолцлыг харуулсан талбайн зураг</li> <li>- Үйлчилгээний хөлс төлсөн баримт</li> </ul>
4-р шат	АМГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтын саналыг нээх (бүх эрх бүхий оролцогчдыг байлцуулна. Нэг оролцогч талаас нэг итгэмжлэгдсэн төлөөлөгч байна)
5-р шат	АМГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтад оролцогчдыг дараах баримтад үндэслэн үнэлнэ. Техникийн санал (50%) <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн талбайд гүйцэтгэх хайгуул болон ашиглалтын ажлын арга аргачлал, төрөл хэмжээ, хугацаа болон байгаль хамгаалах асуудлыг тусгасан төсөл, төсвийн санал</li> <li>- Нотариатаар гэрчлүүлсэн хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулах техник, тоног төхөөрөмжийн жагсаалт</li> <li>- Нотариатаар гэрчлүүлсэн мэргэжлийн боловсон хүчин, мэргэшсэн ажилтнаар хангагдсан байдал,</li> <li>- Хайгуул, ашиглалтын явцад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх дэвшилтэт техник, технологийн шийдэл</li> <li>- Орон нутагтай хэрхэн хамтран ажиллах санал, төлөвлөгөө</li> </ul> Санхүүгийн шалгуур (50%)
6-р шат	АМГ-ын сонгон шалгаруулах комисс	Сонгон шалгаруулалтад ирүүлсэн үнийн саналыг нээх
7-р шат	АМГ	Сонгон шалгаруулах комиссын шийдвэрийг батлах. Сонгон шалгаруулалтын саналд үнэлгээ хийж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор ялагчийг зарлана.
8-р шат	АМГ	Эхний жилийн төлбөрийг АМГ-ын даргын шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөх
9-р шат	АМГ-ын Кадастрын хэлтэс	АМГ-ын даргын болон сонгон шалгаруулах комиссын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийг олгох

Эх сурвалж: АМГ-ын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулах журам



### 3.2.7 ЛИЦЕНЗ ОЛГОХОД АШИГЛАДАГ ТЕХНИКИЙН БОЛОН САНХҮҮГИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (ШААРДЛАГА 2.2.А.1)

Лицензийг олгоходоо доорх хүснэгтэд дурьдсан шалгуур үзүүлэлтүүдээр үнэлдэг.

Д/д	Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	Өгөх оноо	Нийт оноо
<b>ҮНИЙН САНАЛ</b>			
1	<p><b>Сонгон шалгаруулалтын үнийн санал:</b> Тухайн сонгон шалгаруулалтын талбайд өгсөн үнийн саналыг доорх томъёогоор бодож бутархай тоог аравтын орны нарийвчлалтай эрэмбэлэн үнэлнэ.</p> <p><b>40 x (S-S<sub>б</sub>)</b> <b>10 +</b> <b>S<sub>м</sub> - S<sub>б</sub></b></p> <p><b>S:</b> Оролцогч <b>S<sub>б</sub>:</b> Босго үнэ <b>S<sub>м</sub>:</b> Хамгийн өндөр үнийн санал</p>		10-50 хүртэл
2	<p><b>Геологи хайгуулын ажил явуулах төслийн баримт бичгийн үнэлгээ</b> Сонгон шалгаруулалтад оролцогчийн геологи хайгуулын ажлын төслийн баримт бичигт үнэлгээ хийнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>Геологи хайгуулын ажлын арга, аргачлал оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судалсан бол-5 Геологи хайгуулын ажлын арга, аргачлал оновчтой, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй бол-3 Геологи хайгуулын ажлын арга, аргачлал оновчгүй, өмнөх судалгааны материалыг бүрэн судлаагүй бол-0</li> <li>Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн төлөвлөлт Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн ажлын нэр төрөл, түүнд зарцуулах зардал, хэрэгжүүлэх хугацааг харгалзан: Бүрэн хангалттай-5 Хангалттай-3 Хангалтгүй-0</li> <li>Ажиллах хүчин Төсөлд ажиллах монгол ажилтнуудын тоо, нийт ажилтнуудад эзлэх хувь 90%-аас дээш монгол ажилтантай бол-5 90 буюу түүнээс доош бол-3</li> <li>Орон нутагтай хэрхэн хамтран ажиллах талаар Хамтын ажиллагааны нэр төрөл, түүнд зарцуулах зардал нь Ашигт малтмалын 42.1 дэх хэсэгт зааснаас илүү үйл ажиллагаа хэрэгжүүлэх бол-5 Ашигт малтмалын 42.1 дэх хэсэгт заасныг хангаж байгаа бол-3 Санал хангалтгүй бол-0</li> </ul>	<p>0-5 оноо</p> <p>0-5 оноо</p> <p>3-5 оноо</p> <p>0-5 оноо</p>	3-20
3	<p><b>Геологи хайгуулын ажлын туршлага</b> Сонгон шалгаруулалтад оролцогчийн геологи хайгуулын ажлын туршлага зэргийг харгалзан үнэлнэ.</p> <p>Монголын геологи хайгуул, уул уурхайн салбарт 3-аас доошгүй жил хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулсан</p> <p>Геологи хайгуул, уул уурхайн салбарт ажилласан туршлагагүй хэдий ч бусад салбарт 10-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан</p>	<p>10 оноо</p> <p>5 оноо</p>	3-10

Д/д	Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	Өгөх оноо	Нийт оноо
	Шинээр үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж	3 оноо	
4	<b>Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал, тэдгээрийн түршлага, чадвар</b> <i>Сонгон шалгаруулалтад оролцогчийн геологи хайгуулын ажил гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдлыг харгалзан үнэлнэ.</i>		6-10
	<ul style="list-style-type: none"> <li>Тус компанид МУ-ын зөвлөх болон мэргэжсэн геологич ажиллах тохиолдолд</li> <li>Геологич мэргэжлийн үндсэн ажилтантай тохиолдолд</li> <li>Гэрээгээр геологич ажиллуулах тохиолдолд</li> </ul>	10 оноо 8 оноо 6 оноо	
5	<b>Техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал</b> <i>Сонгон шалгаруулалтад оролцогчийн геологи хайгуулын ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдлыг харгалзан үнэлнэ.</i>		6-10
	<ul style="list-style-type: none"> <li>Тус компани геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн өрөм, геофизикийн багажтай</li> <li>Тус компани геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрөм, геофизикийн багажны 50-аас доошгүй хувийг түрээсэлдэг</li> <li>Тус компани геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрөм, геофизикийн багажаа бүгдийг нь түрээсэлдэг</li> </ul>	10 оноо 8 оноо 6 оноо	
	<b>Нийт оноо</b>		28-100

### 3.2.8 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ӨРГӨДЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

АМГ нь 2015 оноос эхлэн Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохдоо ил тод, нээлттэй байлгах, төрөөс үзүүлж буй үйлчилгээг хүнд сурталгүй, чирэгдэлгүй, хүртээмжтэй үзүүлэх зорилгоор тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авах, шийдвэрлэх ажиллагааг “нэг цонх”-ны үйлчилгээнд шилжүүлсэн байна.

АМГ нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой эсэхэд л хариу өгөх ба тусгай зөвшөөрлийн талаар орон нутгийн удирдлагуудад уламжилж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлээд, олгох боломжтой гэвэл олгодог, татгалзсан хариу ирүүлбэл үндэслэлийг нь судалж үздэг байна.

Ашигт малтмалын тухай хуулинд Засаг даргын татгалзах үндэслүүдийг зааж өгсөн байдаг ба орон нутгийн удирдлагууд хуульд заасан үндэслэлээр татгалзах хариугаа ирүүлэх ёстой.

2015 онд Хайгуулын тусгай зөвшөөрөл авахаар өргөдлийн дугаар авч, цахимаар өргөдөл гаргасан хуулийн этгээдүүдийн статистик мэдээллийг доор харуулав.

Үзүүлэлтүүд	Тоо
Олгосон нийт дугаарын тоо	3,915
Хүлээж авсан өргөдлийн тоо (Дэлгэрэнгүйг Хавсралт 16ж-ээс харна үү)	2,335
Орон нутгаас санал авахаар илгээсэн өргөдлийн тоо	1,778
Үүнээс: Орон нутаг дэмжсэн өргөдлийн тоо	567
Орон нутаг татгалзсан өргөдлийн тоо	767
Орон нутгаас хариу ирүүлээгүй өргөдлийн тоо	444




## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Бид өргөдлийн дугаар авсан хуулийн этгээдүүдийн жагсаалт, дугаар авсан хугацаа, цаг минутын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүссэн боловч АМГТГ-т энэ мэдээллийг гаргаж өгөх боломжгүй гэсэн хариулт өгсөн.

Хавсралт 16ж-д өргөдлийг бүртгэсэн цаг хугацаа гэсэн баганад бүртгэгдсэн цаг минут нь Кадастрын бүртгэлийн системийн цаг тул дугаар авсан хуулийн этгээдүүдийн бодит цагаас зөрүүтэй гэдгийг мэдэгдсэн.

Мөн кадастрын бүртгэлийн системд орон нутгаас ирүүлсэн саналын анхдагч мэдээлэл нь бүртгэгдээгүй тул бидний шаардсан орон нутгийн саналыг харуулсан мэдээлэл бүрэн гарах боломжгүй байна.

Доорх диаграммаар 2009-2015 оны хооронд тусгай зөвшөөрөл авахаар гаргасан хүсэлтийн тоог олгосон тусгай зөвшөөрлийн тоонд харьцуулан харуулав:



Эх үүсвэр: АМГТГ-ын статистик мэдээлэл

### **3.2.9 2015 ОНД ШИНЭЭР ОЛГОСОН БОЛОН ШИЛЖҮҮЛСЭН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮД (ШААРДЛАГА 2.2.А.III)**

АМГТГ-ын олон нийтэд мэдээлсэн уул уурхай, геологийн статистик мэдээлэлд тусгай зөвшөөрлийн цэвэр өөрчлөлт нь 2014-2015 оны хооронд 593-аар нэмэгдсэн гэж дурьдсан байна.

Лиценз эзэмшигчдийн бүх өөрчлөлтийн дэлгэрэнгүйг ОУИТБС-ын тайланд тусгах нь Стандартын шаардлага юм. 2014 оноос 2015 оны хооронд уул уурхайн лицензэд гарсан хэд хэдэн өөрчлөлтийг авч үзэхэд АМГТГ-ын гаргасан тоон мэдээллийг ашиглаж лицензийн хөдөлгөөнийг тохируулах боломжгүй байсан.

АМГТГ нь жил бүрийн олгосон лицензтэй холбоотой жил бүр гарсан хэд хэдэн асуудлуудын талаарх мэдээллийг ирүүлсэн. Үүнд:

Тусгай зөвшөөрлийн төрлөөр	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016-09
Ашиглалтын тусгай зөвшөөрөл	1091	1085	1158	1198	1237	1301	1,391	1,494	1575
Хайгуулын тусгай зөвшөөрөл	4111	3659	2979	2572	2303	1717	1,345	1,835	2349

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Нийт	5,202	4,744	4,137	3,770	3,540	3,018	2,736	3,329	3,924
------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------	-------

2008-2015 оны хооронд тусгай зөвшөөрлийн бүртгэлд гарсан өөрчлөлтийг харуулсан АМГТГ-ын статистик мэдээллийг доор харуулав. Үүнд:

	Өөрчлөлтүүд	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016-09
1	<b>Шинээр олгосон</b>	<b>1358</b>	<b>628</b>	<b>235</b>	<b>79</b>	<b>95</b>	<b>75</b>	<b>113</b>	<b>827</b>	<b>647</b>
	Ашиглалт	110	78	90	79	95	75	97	91	67
	Хайгуул	1248	550	145	0	0	0	2	697	552
	Сонгон шалгаруулалтаар							14	39	28
2	<b>Талбай буцаасан</b>	<b>184</b>	<b>232</b>	<b>105</b>	<b>89</b>	<b>141</b>	<b>146</b>	<b>119</b>	<b>150</b>	<b>123</b>
	Ашиглалт	7	2	6	4	7	16	13	25	22
	Хайгуул	177	230	99	85	134	130	106	125	101
3	<b>Цуцалсан/хүчингүй болсон</b>	<b>231</b>	<b>713</b>	<b>458</b>	<b>275</b>	<b>270</b>	<b>347</b>	<b>123</b>	<b>173</b>	<b>157</b>
	Ашиглалт	47	75	39	65	139	43	14	10	16
	Хайгуул	184	638	419	210	131	304	109	163	141
4	<b>Дуусгавар болсон</b>	<b>347</b>	<b>274</b>	<b>248</b>	<b>225</b>	<b>175</b>	<b>253</b>	<b>289</b>	<b>179</b>	<b>90</b>
5	<b>Шилжүүлсэн</b>	<b>681</b>	<b>439</b>	<b>448</b>	<b>441</b>	<b>200</b>	<b>8</b>	<b>51</b>	<b>88</b>	<b>108</b>
	Ашиглалт	83	63	59	58	47	8	38	46	36
	Хайгуул	598	376	389	383	153	0	13	42	72
6	<b>Сунгуулсан</b>	<b>620</b>	<b>354</b>	<b>791</b>	<b>997</b>	<b>601</b>	<b>317</b>	<b>444</b>	<b>336</b>	<b>336</b>
7	<b>Барьцаалсан</b>	<b>86</b>	<b>75</b>	<b>50</b>	<b>62</b>	<b>38</b>	<b>61</b>	<b>40</b>	<b>22</b>	<b>18</b>
	Ашиглалт	49	46	36	39	22	42	34	22	16
	Хайгуул	37	29	14	23	16	19	6	0	2
8	<b>Барьцаа чөлөөлсөн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>28</b>	<b>42</b>	<b>31</b>	<b>29</b>	<b>24</b>	<b>14</b>
	Ашиглалт				8	15	29	24	19	10
	Хайгуул				20	27	2	5	5	4
9	<b>Нөхөн олгосон</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>94</b>	<b>56</b>	<b>15</b>	<b>11</b>	<b>19</b>	<b>20</b>
	Ашиглалт				29	16	9	7	10	12
	Хайгуул				65	40	6	4	9	8

АМГТГ нь тусгай зөвшөөрлийн жилийн турш хийгдсэн хөдөлгөөний нэгдсэн статистик мэдээллийг АМГТГ-ын вебсайт дээр олон нийтэд ил тод болгодог.

АМГТГ-ын Кадастрын бүртгэлийн системээс бидэнд ирүүлсэн 2015 оны 12 сарын 31-нээрх тусгай зөвшөөрлийн үлдэгдэл нь АМГТГ-ын вебсайт дахь тусгай зөвшөөрлийн үлдэгдэлтэй тохирохгүй ба жилийн турш шинээр олгосон, хасагдсан, цуцлагдсан зэрэг тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний цэвэр дүн нь 2014 болон 2015 оны тусгай зөвшөөрлийн үлдэгдлүүдийн өөрчлөлттэй тохирохгүй байна. АМГТГ-ын Статистик мэдээллийн хэлтэс нь Кадастрын бүртгэлийн системээс гарсан мэдээллийг нэгтгэж, олон нийтэд ил тод болгодог боловч цэвэр өөрчлөлтийг тооцож, тэнцүүлдэггүй байна.

Бид энэхүү үл нийцлийн талаар АМГТГ-ын мэргэжилтнээс тодруулахад хэд хэдэн хүндрэлтэй асуудал үүсээд байгаа нь энэ зохисгүй тайлагналыг үүсгэж байж магадгүй гэж тайлбарласан.

АМГТГ нь лицензийн олголт болон тухайн хугацааны шилжилт, хөдөлгөөнийг найдвартай, үнэн зөв бүртгэх нь чухал юм.

2015 оны 12 сарын 31-нээрх ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн үлдэгдэл, шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлийн жагсаалтыг Хавсралт 16-ээс харна уу.

АМГТГ-аас тусгай зөвшөөрлүүдийг шинээр олгох болон шилжүүлэхтэй холбоотой ямар нэгэн хууль, дүрэм журмыг зөрчсөн асуудал гараагүй гэж мэдэгдсэн.

### 3.2.10 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН БҮРТГЭЛ (ШААРДЛАГА 2.3)

АМГ-ын кадастрын бүртгэлийн системд 3,800 тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээлэл байна. Үндсэн мэдээлэл нь хэрэгцээтэй үед хураамж төлбөргүйгээр авах боломжтой ба илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд бүртгүүлэх шаардлагатай байна. Бүх шинэ хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдөл, өргөдлийн үйл явц, өөрсдийн тусгай зөвшөөрлийн төлбөр хураамж, тендер, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгаа газрууд, тендер зарлагдах хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талбайнууд мөн бусад дэлгэрэнгүй мэдээллийг зөвхөн бүртгэгдсэн хэрэглэгч нар л харж болохоор байна.

Олон нийтэд ил тод тусгай зөвшөөрлийн бүртгэл	Онцгой эрхтэйгээр харах тусгай зөвшөөрлийн бүртгэл
Бүртгэлийн дугаар	Бүртгэлийн дугаар
Регистрийн дугаар	Регистрийн дугаар
Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
Тусгай зөвшөөрлийн төрөл	Тусгай зөвшөөрлийн төрөл
Байршлын нэр	Байршлын нэр
Талбайн хэмжэ	Талбайн хэмжэ
Талбайн солбицол	Талбайн солбицол
	Аймаг
	Олгосон өдөр
	Дуусах өдөр
	Компанийн төрөл
	Хот
	Хүчинтэй эсэх

Монголын ОУИТБС-ын цахим систем<sup>13</sup>-д Ашигт малтмалын газрын кадастрын бүртгэлийн онцгой эрхтэйгээр харах дата мэдээлэл дээр үндэслэн аймаг суманд хэдэн ширхэг тусгай зөвшөөрөл олгогдсон, эдгээр тусгай зөвшөөрлийг ямар компани эзэмшдэг, тусгай зөвшөөрлийг аль аймгийн аль суманд олгосныг газрын зураг дээр шууд харж болох байдлаар хийж, нийтэд ил тод болгосон байна.

ОУИТБС-ын Шаардлага 2.2-д дараах мэдээллүүдийг олон нийтэд ил тод болгохыг шаардсан. Үүнд:

- лиценз эзэмшигч(ид);
- лицензийн талбайн солбилцол.
- лиценз авахаар хүсэлт гаргасан болон лиценз олгосон огноо, лицензийн хүчинтэй хугацаа;
- олборлолт эрхэлж буй тохиолдолд олборлосон бүтээгдэхүүн

Дэлхийн Банкны техникийн туслалцааны хөтөлбөрийн дэмжлэгээр Ашигт малтмалын газраас 2014 онд нэвтрүүлсэн Уул уурхайн Кадастрын Цахим Систем (УКЦС) нь ашигт малтмалын

<sup>13</sup> <http://www.eitimongolia.mn/en>

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

салбарт олгогдсон тусгай зөвшөөрлүүд, тэдгээрийн газар нутгийн хамрах хүрээ, мөн тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой зарим дүрэм журам, баримт бичгийг нийтэд нээлттэйгээр интернэтэд байршуулжээ.

Нэгэнт ил тод болгосон мэдээллүүдийг ОУИТБС-ын Шаардлага 2.2-той харьцуулж үзэхэд тусгай зөвшөөрлийг олгосон талбайн солбицол АМГ-ын цахим тайланд нийтэд ил тод болоогүй, зөвхөн онцгой эрхтэйгээр харах зөвшөөрөлтэй этгээдүүд харах боломжтой байна. Монголын ОУИТБС-ын цахим хуудсанд газрын зураг дээр байршил нь харагдаж байгаа боловч солбицол нь тодорхой бус байна.

Газрын тос, байгалийн хийн салбар болон цацраг идэвхт ашигт малтмалын салбарт олгогдсон тусгай зөвшөөрлийн мэдээллийг эдгээр салбаруудыг хариуцдаг Газрын Тосны Газар, Цөмийн Энергийн Газар (ЦЭГ)-ууд нийтэд ил болгоогүй байна.

2015 оны 12 сарын 31-нээрх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүтцийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

	Эзэмшигч		Тусгай зөвшөөрөл		Талбай (сая.га)	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай	287	15%	582	17%	3.05	22%
Хамтарсан хөрөнгө оруулалттай	124	7%	278	8%	1.81	13%
Дотоодын 100 хувийн хөрөнгө оруулалттай	1488	78%	2469	74%	9.07	65%
<b>Бүгд</b>	<b>1899</b>	<b>100%</b>	<b>3329</b>	<b>100%</b>	<b>13.93</b>	<b>100%</b>

### 3.3 УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН АЖИЛ, (ШААРДЛАГА 3.1)

#### 3.3.1 2015 ОНД УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭСЭН ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН АЖИЛ

2015 онд улсын төсвийн хөрөнгөөр дараах ажлуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэж ажилласан байна. Үүнд:

- 1:50,000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хүрээнд 46 төсөл хэрэгжсэнээс 3 төсөл нь олон улстай хамтарсан байдлаар, бусад 43 төсөл нь дотоодын аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлсэн байна.
- УГЗ 1:200,000 масштабын геологийн зураглал
- Сэдэвчилсэн судалгааны ажил
  - Өмнөд говь-2012, 1:200000 масштабын гидрогеологи-геоэкологийн иж бүрдэл зураг, геоэкологийн үнэлгээ;
  - Газрын ховор элемент-2013, монгол орны газрын ховор элементийн металлогени, хэтийн төлөвийн судалгаа;
  - Геологийн мэдээллийн сан;
  - Астер 3D, сансрын зургийн нэгдсэн боловсруулалт хийх;
  - Баруун монголын цул сульфидын хүдэржилт, түүний хэтийн төлөв;

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

- Монгол орны бүс нутгийн металлогени, ашигт малтмалын ордын төрлүүдийн тархалт, байршлын зүй тогтол
- Хамтын ажиллагааны төсөл
  - Монгол алтай-50, Монгол-Чехийн хамтарсан 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил;
  - Хасагт-50, Монгол-Польшийн хамтарсан “Хасагтын талбайн геологийн судалгаа, эрлийн ажил” төсөл;
- Геофизикийн судалгаа
  - Алтай-1 талбайд гүйцэтгэх 1:200000 масштабын агаарын геофизикийн 5 сувгийн судалгааны ажил
  - Алтай-2 талбайд гүйцэтгэх 1:200000 масштабын агаарын геофизикийн 5 сувгийн судалгааны ажил

2015 онд улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж, тайланг хамгаалсан, геологийн даалгаврын хугацаа сунгагдсан, 2015 онд Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх төслүүдийн байдлыг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Эцсийн үр дүнгийн тайлан хамгаалсан		Геологийн даалгаврын хугацаа сунгагдсан		ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх	
	Компанийн нэр	Төслийн нэр	Компанийн нэр	Төслийн нэр	Компанийн нэр	Төслийн нэр
1	“Алтай нэгдэл” ХХК	Бардам уул-50	“Судалт мана” ХХК	Баяндалай-50	“Талст дөл” ХХК	Цогт-50
2	“Алтай нэгдэл” ХХК	Хавирга уул-50	“Монгол зүрх сэтгэл” ХХК	Улаанбадрах-50	“Гоби эксплорейшн” ХХК	Эмээлцэгийн нуруу
3	“Хөвсгөл геологи” ХХК	Өнгөтийн нуруу-50	“Гурван талст” ХХК	Онц уул-50	“Гео магнат ресурс” ХХК	Жинст -50
4	“Хөвсгөл геологи” ХХК	Рашаант-50	“Талст дөл” ХХК	Цогт-50	“Жинст уул” ХХК	Тогоо хайрхан-50
5	“Геомин” ХХК	Ихэрийн хяр-50	“Гоби эксплорейшн” ХХК	Эмээлцэгийн нуруу	“Жи Жи Ай Эс” ХХК	Хайрхан уул-50
6	“Эрээн чулуу” ХХК	Улаан дэл	“Гео магнат ресурс” ХХК	Жинст-50	“Цагдуултайн ундрага” ХХК	Бурхант толгой-50
7	“Эс Жи Эйч” ХХК	Замлин богд-50	“Цагдуултайн ундарга” ХХК	Бурхант толгой-50		
8	“Жи Жи Ай Эс” ХХК	Хавтгай уул-50	“Тэргүүн ресурс” ХХК	Хөхнуур -50		
9	“Цахиур оргил” ХХК	Сэрвэн уул-50	“Плагиоклаз” ХХК	Дэвсэгийн нуруу-50		
10	“Гео эрэл” ХХК	Сайн цагаан-50	“Жи Си Эс” ХХК	Шивээт-50		
11	“Гео эрин” ХХК	Хамарын толгод-50	ШУТИС	ГХЭ-2013		

2015 онд 2 ба 3 дахь жилийн хээрийн ажил дуусч, завсрын борлуулалт эхэлсэн төслүүдийн жагсаалт:

№	Компанийн нэрс	Төслийн нэр	№	Компанийн нэрс	Төслийн нэр
1	Геологийн судалгааны төв ТӨҮГ	Алтайн нуруу-50	20	Гурван талст ХХК	Хайлааст уул-50
2		Шивээт уул-50	21	Талст дөл ХХК	Баян-Индэр-50
3		Төв ази-3D	22	Цагдуултайн ундрага ХХК	Бурхант толгой-50
4		Гео мэдээллийн сан-2013	23		Дорнод монгол-ҮИИ-200
5		Сансрын зургийн тайлалт-2013	24	Судалт мана ХХК	Чандмань уул-50
6		Монгол алтай-50	25	Гео орон ХХК	Дэлгэрхаан -50
7		Цогт цэций-50	26		Цул сульфид БМ-2014

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

№	Компанийн нэрс	Төслийн нэр	№	Компанийн нэрс	Төслийн нэр
8	Алтай нэгдэл ХХК	Булган-50	27	ШУТИС	ГХШЭ-2013
9		Дөрөө нуур-50	28		Металлогени-2014
10		Ар чулуут-50	29	Эрдэнийн эрэл ХХК	Улаан толгой-50
11		Буурал хайрхан-50	30	Минторес ХХК	Эргэлийн зоо-50
12	Хөвсгөл геологи ХХК	Хөхөлзэгийн говь-50	31	Литолог ХХК	Тойрмын хөндий-50
13		Хулгарын элс-50	32	Геосан ХХК, Саммит ХХК	Алтай-1
14		Тахилт-50	33	Магнет сүрвэй ХХК	Алтай-2
15	Геомин ХХК	Суман хад-50	34	Тэргүүн ресурс ХХК	Хөхнуур-50
16	Магма майнз ХХК	Төв монгол-200-IV	35	Плагиоклаз ХХК	Дэвсэгийн нуруу-50
17	"Эс Жи Ай Эс" ХХК	Дорнод монгол-200-IV	36	Жи Си Эс ХХК	Шивээт-50
18	Эрээн чулуу ХХК, Дархан мяндар уул ХХК	Өлийн овоот-50	37	Жи Жи Ай Эс ХХК	Хайрхан уул-50
19	Эрээн чулуу ХХК	Төв монгол-V-50	38	Найманбат ХХК	Бударын чулуу-50

Дээрх төслүүдийг санхүүжүүлэхэд улсын төсвөөс дараах хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:

Төслийн нэр	2015 оны санхүүжилтийн төсөв	2014 оны үлдэгдэл санхүүжилт	2015 оны нийт гүйцэтгэл	Төсвийн олгогдоогүй үлдэгдэл
УГЗ-200 төсөл	525,013,987	175,487,332	330,456,519	19,070,135
1:50000 масштабын төсөл	7,100,044,899	1,312,804,799	5,556,739,523	230,500,577
Сэдэвчилсэн судалгааны төсөл	3,431,566,995	197,798,620	2,970,642,559	263,125,816
Хамтын ажиллагааны төсөл	284,474,119	58,845,149	225,626,866	2,104
<b>Нийт</b>	<b>11,341,100,000</b>	<b>1,744,935,900</b>	<b>9,083,465,467</b>	<b>512,698,633</b>

### 3.3.2 ХУВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ХАЙГУУЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2015 онд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчид геологи, хайгуулын ажилд 104,7 тэрбум төгрөгийн зардлыг зарцуулсан ба нийт зардлын төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Сая төгрөгөөр	2010	2011	2012	2013	2014	2015
Бэлтгэл ажил	4,677.5	5,051.8	4,882.8	3,842.3	3,146.2	2,988.7
Зураглалын ажил	2,270.0	3,957.4	4,714.8	2,328.8	3,006.8	2,303.2
Эрлийн ажил	2,862.7	6,880.8	3,925.7	2,530.5	2,535.4	1,575.2
Сорьцлолт	2,561.0	5,684.4	6,603.1	2,659.3	2,259.7	2,041.1
Геофизикийн ажил	20,581.7	28,835.7	23,573.7	13,427.2	12,413.9	10,692.5
Уулын ажил	4,495.4	7,389.5	5,153.1	2,530.8	4,887.8	2,780.2
Өрөмдлөг	107,941.6	190,240.1	208,018.8	82,575.7	86,233.0	49,461.5
Геохимийн ажил	377.0	1,562.5	3,292.1	2,133.4	746.0	779.1
Лаборатори	7,693.4	19,023.1	22,152.4	10,889.8	10,490.8	6,680.6
Топогеодезийн ажил	1,680.3	5,778.5	2,348.2	1,880.4	1,357.9	1,634.3
Гидрогеологийн ажил	510.3	2,571.0	4,116.9	751.6	2,781.3	2,549.9
Тээвэр	5,724.2	6,526.7	6,685.8	5,182.5	3,780.9	3,079.8
Суурин боловсруулалт	4,609.4	10,475.1	18,540.5	11,233.7	21,563.1	11,005.0
Байгаль орчны нөхөн сэргээлт	675.1	699.8	1,424.7	1,382.0	2,015.8	1,746.6
Талбайн сорьцлолт	1,547.9	2,140.3	862.1	416.6	1,484.7	428.9
Геоморфологи	-	-	11.0	25.3	-	20.6
Археологи	-	-	1,070.9	528.3	123.0	96.8

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Сая төгрөгөөр	2010	2011	2012	2013	2014	2015
Палеонтологи	-	-	925.4	448.9	88.3	43.3
Бусад	4,752.0	3,280.7	8,092.8	5,328.7	1,506.9	4,791.0
<b>Дүн</b>	<b>172,959.5</b>	<b>300,097.4</b>	<b>326,394.8</b>	<b>150,095.8</b>	<b>160,421.5</b>	<b>104,698.3</b>

2015 онд хувийн хөрөнгөөр геологи хайгуулын ажилд хамгийн их зардал гаргасан ААН-үүдийн жагсаалт

№	ААН-ийн нэрс	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ, га-гаар	Нийт зардал сая.төгрөгөөр	Ашигт малтмалын төрөл
1	"Шаньси көүк энд көүл кемикөлс юнион Монголиа" ХХК	XV-014859	12268.62	4,371.2	Нүүрс
2	"Оюут-Улаан" ХХК	XV-017387	6647.05	4,268.4	Алт
3	"Эф Ви Эс Пи" ХХК	XV-013598	183145.4	4,221.2	Зэс
4	"Кожеговь" ХХК	XV-011946	36300.59	4,073.7	Уран
5	"Кожеговь" ХХК	XV-011921	17783.99	2,980.0	Уран
6	"Өү Жи Си Эйч Эл" ХХК	XV-007560	2000.03	2,977.3	Зэс
7	"Болд төмөр ерөө гол" ХХК	XV-008888	3393	2,880.7	төмөр
8	"Альшаахайрхан" ХХК	XV-018976	1304.81	2,430.8	бал чулуу
9	"Миллениум сторм" ХХК	XV-015446	11801.37	2,268.7	алт
10	"Харанга сүмбэр" ХХК	XV-014568	6467.48	2,092.7	манган
11	"Блэкрот" ХХК	XV-013580	1080.16	2,087.1	нүүрс
12	"Альшаахайрхан" ХХК	XV-011602	290322.33	2,079.7	бал чулуу
13	"АГМ майнинг" ХХК	XV-017452	111247.8	1,874.8	зэс, алт
14	"Билэгт хайрхан уул" ХХК	XV-020097	27349.74	1,818.2	нүүрс
15	"АГМ майнинг" ХХК	XV-014917	6475.74	1,583.0	алт
16	"Эко-Алт" ХХК	XV-011398	2228.1	1,573.6	алт
17	"Илч хүчирт" ХХК	XV-012221	4759.17	1,530.3	нүүрс
18	"Кожеговь" ХХК	XV-012251	91076.6	1,336.1	Уран
19	"Кожеговь" ХХК	XV-004817	38450	1,319.6	Уран
20	"Туншан шиандон" ХХК	XV-014091	1073.84	1,303.3	молибден
21	"Алтайр гоулд" ХХК	XV-014916	999.6	1,234.6	Алт
22	"Билэгт хайрхан уул" ХХК	XV-020098	23062.99	1,143.9	Нүүрс
23	"Ориент" ХХК	XV-018708	4903.59	1,135.1	зэс
24	"Орчлон орд" ХХК	XV-014569	1240.93	1,039.6	зэс
	<b>Дүн</b>			<b>53,623.6</b>	

### 3.3.3 ҮЙЛДВЭРЛЭЛ

Олон улсын зах зээлд эрдэс баялгийн түүхий эдийн үнэ уналтад байсан хэдий ч 2015 онд 250 гаруй уул уурхайн үйлдвэр идэвхтэй ажиллаж, ДНБ-ний 16.7 хувь, үндэсний аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн 63.2 хувийг, экспортын 87.8 хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн байна. (Эх сурвалж: <http://en.montsame.mn/mining/%E2%80%9Cmining-made-788-percent-total-export-revenue%E2%80%9D>)

Уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Эрдэс бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2013	2014	2015	2015 оны өсөлт, -бууралт
Нүүрс	Мянган тонн	30,123.3	25,287.8	24,205.9	-4.3%
Газрын тос	Мянган баррель	5,128.9	7,405.3	8,769.3	18.4%
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	Мянган тонн	803.0	1,080.4	1,334.7	23.5%
Молибдений баяжмал	Тонн	3,732.1	4,054.0	5,207.0	28.4%
Алт	Тонн	8.9	11.5	14.6	27.0%
Хайлуур жонш	Мянган тонн	161.7	303.0	183.5	-39.4%
Хайлуур жоншны баяжмал	Мянган тонн	76.4	71.9	47.3	-34.2%
Төмрийн хүдэр	Мянган тонн	5,011.9	6,293.1	4,273.6	-32.1%
Төмрийн хүдрийн баяжмал	Мянган тонн	6,124.0	3,967.4	1,899.8	-52.1%
Цайрын баяжмал	Мянган тонн	104.1	93.2	89.6	-3.9%
Гянтболдын баяжмал	Тонн	-	1,024.2	1,024.0	0.0%
Давс олборлолт	Тонн	657.6	1,378.4	1,685.6	22.3%

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, хуудас 358

Уул уурхай, олборлолтын салбарын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үнийн дүн, нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Эрдэс бүтээгдэхүүн /сая төгрөгөөр/	2013	2014	2015	2015 оны өсөлт, -бууралт
Нүүрс олборлолт	1,461,124.9	1,081,737.7	975,148.3	-9.9%
Газрын тос олборлолт	770,940.1	1,125,185.0	755,544.4	-32.9%
Металлын хүдэр олборлолт	3,273,705.6	6,467,457.5	6,412,398.1	-0.9%
Бусад ашигт малтмал олборлолт	113,897.3	137,919.3	122,230.5	-11.4%
Уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагаа	480,087.5	458,986.5	420,330.0	-8.4%
Нийт	6,099,755.4	9,271,286.0	8,685,651.3	

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, хуудас 353

### 3.3.4 ЭКСПОРТ

Монгол улсын нийт экспорт өмнөх оныхоос 1,104.9 сая ам.доллар буюу 19.1 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний экспорт 1,113.1 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин үндсэн төмөрлөг бүтээгдэхүүнийх 24.6 сая ам.доллар, үнэт чулуу, металл, алтных 15.8 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Эх сурвалж: Статистикийн бюллетень- 2015, хуудас 11 Экспортод гаргасан Эрдэс баялагийн зарим бүтээгдэхүүний тоо хэмжээг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн	2013	2014	2015
Боловсруулаагүй газрын тос /сая баррель/	5.2	6.9	8.1
Хагас боловсруулсан алт /тонн/	7.6	10.0	11.3
Зэсийн баяжмал /мянган тонн/	649.8	1,379.0	1,477.8
Нүүрс /мянган тонн/	18,373.1	19,499.0	14,472.6
Төмрийн хүдэр, баяжмал /мянган тонн/	6,724.5	6,324.7	5,065.1

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, хуудас 287,



Олборлох салбарын экспортын хэмжээг үнэмлэхүй дүнгээр болон нийт экспортод эзлэх хувь хэмжээгээр харуулбал:

/сая ам.доллараар/	Уул уурхайн салбарын экспорт	Уул уурхайн салбарын нийт экспортод эзлэх хувь	Улсын нийт экспортын хэмжээ
2014	5,196.7	90.0%	5,774.3
2015	4,098.9	87.8%	4,669.3

Эх сурвалж: Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын Макро эдийн засгийн бодлогын хэлтсийн өгсөн мэдээлэл

### 3.4 ГАЗРЫН ТОС БОЛОН ХИЙ

#### 3.4.1 НӨӨЦ

Монгол улсын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөл газрын тосны хайгуулын гурван талбайн хувьд нөөцийг тооцоолж хүлээн авсан. Эдгээр талбайн нөөцийг 2016 оны 10-р сарын 1-ний байдлаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Талбайн нэр	Баталгаат нөөц Сая.тонн	Ашиглалтын баталгаат нөөц Сая.тонн
1	Тосон-Уул XIX талбайн	179,02	20,17
2	1997БХГ-т талбай	26,05	2,07
3	Тамсаг XXI талбайн	127,5	21,018
	<b>Дүн</b>	<b>332,64</b>	<b>43,25</b>

#### 3.4.2 ГАЗРЫН ТОСНЫ ЛИЦЕНЗ ОЛГОЛТ

##### 3.4.2.1 Засаглал

Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь Газрын тосны хуулиар зохицуулагдах бөгөөд газрын тос, байгалийн хийн хайгуул хийх, олборлох зөвшөөрөл нь компанийн гарын үсэг зурсан бүтээгдэхүүн хуваах гэрээгээр (БХГ) зохицуулагддаг юм. БХГ-нд ашиглагддаг стандарт нэр томъёог <http://www.legalinfo.mn/law/details/215> вебсайтаас олж болно.

Тусгай зөвшөөрөл олгох болон олгосон тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын Тосны Газар байсан бол 2016 оноос энэ газар нь АМГ-тай нийлж, АМГТГ болсон<sup>14</sup>.

##### 3.4.2.2 Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа (Шаардлага 2.3)

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий дараах хайгуулын 25 талбайд 19 гэрээлэгч Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан, ажиллаж байна. Үүнд:

№	БХГ-т талбайн нэр	Гэрээлэгч компанийн нэр	БХГ байгуулсан огноо	Тусгай зөвшөөрлийн төрөл
1	БХГ-т 97	Доншен Газрын Тос Монгол ХХК	1997.01.24	Ашиглалт
2	Тамсаг XXI	Петрочайна Дачин Тамсаг Монгол ХХК	1995.12.21	Ашиглалт

<sup>14</sup> (<http://www.pam.gov.mn/>)

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

№	БХГ-т талбайн нэр	Гэрээлэгч компанийн нэр	БХГ байгуулсан огноо	Тусгай зөвшөөрлийн төрөл
3	Буйр XXII		1993.03.29	
4	Тосон уул XIX		1993.04.26	Ашиглалт
5	Төхөм X /Урд/	Монголын Алт ХХК	2012.07.06	
6	Нялга XVI	Шейман ресурс ХХК	2007.04.18	Хайгуул
7	Сулинхээр XXIII	Шунхлай Энержи ХХК	2009.05.22	Хайгуул
8	Галба XI	Зон Хэн Юу Тиан ХХК	2009.04.27	Хайгуул
9	Увс I	Монголиа гладвилл Увс петролиум ХХК		Хайгуул
10	Матад XX	Петро Матад	2006.05.26	Хайгуул
11	Богд IV	Капкорп Монголиа		Хайгуул
12	Онги V		2009.07.08	Хайгуул
13	Дарьганга XXIV	Апекспро Инвестмэнт ХХК	2011.02.09	Хайгуул
14	Хөхнуур XVIII	ЭН ПИ АЙ ХХК	2009.07.06	Хайгуул
15	Баянтүмэн -17	Магнай Трейд ХХК	2009.12.23	Хайгуул
16	Цайдам-26			Хайгуул
17	Төхөм /хойд/- 10	Сансарын Геологи Хайгуул ХХК	2009.07.10	Хайгуул
18	Номгон IX		2014.01.20	Хайгуул
19	Цагаан Элс-13	Гоби Энержи партнерс	2009.04.21	Хайгуул
20	Зүүнбаян - 14			Хайгуул
21	Хэрлэн тохой XXVIII	Хонг Конг Вэлпэк Индастриал ХХК		Хайгуул
22	Борзон-7	Импайр Газ Монголиа	2009.06.25	Хайгуул
23	Сүхбаатар-27	Вольф петролеум ХХК	2012.01.02	Хайгуул
24	Тариач- 15	Чайна Голден Сий	1997.02.02	Хайгуул
25	Хар-Ус II	Ренова Илч ХХК	2015.09.10	Хайгуул

Дээрх талбайн солбилцолын мэдээллийг Хавсралт 16(з)-ээс харна уу.

### **3.4.2.3 Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа**

Газрын тосны гурван төрлийн тусгай зөвшөөрөл байдаг. Үүнд:

- Эрлийн тусгай зөвшөөрөл,
- Хайгуулын тусгай зөвшөөрөл - (БХГ шаардлагатай),
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл – (БХГ шаардлагатай)

Газрын тосны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Газрын тосны тухай хуулинд дараах байдлаар заасан байдаг. Үүнд:

### **3.4.2.4 Эрлийн тусгай зөвшөөрөл олгох**

1. Хуулийн этгээд газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийх хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад гаргана.
2. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 16.1-д заасан эрэл хийх хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд судалж, шийдвэр гаргана.
3. Тухайн талбайд эрэл хийх хүсэлтийг хоёр ба түүнээс дээш хуулийн этгээд гаргасан тохиолдолд төрийн захиргааны байгууллага харьцуулсан дүгнэлт хийж, шийдвэр гаргана.

4. Төрийн захиргааны байгууллага эрэл хийх шийдвэр гаргахдаа дараах нөхцөлийг харгалзана:

- хүсэлт гаргагч нь техник, технологи, мэргэжлийн болон санхүүгийн чадавхтай эсэх;
- эрлийн ажлын арга, аргачлал нь олон улсын жишигт нийцсэн эсэх;
- байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө.

#### **3.4.2.5 Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох**

1. Энэ хуулийн 17.6-д заасан гэрээлэгч нь хайгуулын тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргана.
2. Төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 18.1, 18.2-т заасан баримт бичгийг хянан үзэж, хайгуулын тусгай зөвшөөрлийг хайгуулын хугацаагаар дараах этгээдэд олгож, сунгана:
  - эрлийн ажлын үр дүнд бүтээгдэхүүн хуваах гэрээ шүүд байгуулсан;
  - энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ байгуулсан.

#### **3.4.2.6 Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох**

1. Газрын тосны нөөцийг хүлээн авах тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гэрээлэгч ашиглалтын үйл ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргана.
2. Гэрээлэгч ашиглалт эхлэхээс өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл авах бөгөөд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс ашиглалтын хугацаа эхэлнэ.
3. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг холбогдох хуулийн дагуу төрийн захиргааны төв байгууллага гэрээлэгчид олгож, сунгана.

### **3.4.3 2015 ОНД БАЙГУУЛСАН БҮТЭЭГДХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ (ШААРДЛАГА 2.2)**

2015 онд бүтээгдэхүүн хуваах гэрээг Ренова Илч ХХК болон АМГТГ-ын хооронд байгуулсан байна. Тусгай зөвшөөрөл олгох болон БХГ байгуулах үйл ажиллагаа нь дээр дурьдагдсан журмын дагуу явагдсан гэж АМГТГ-аас мэдэгдсэн.

ОУИТБС-ын 2013 оны тайлантай холбоотойгоор Уул уурхайн сайдаас Хараат бус Хянагч-нэгтгэгчид ирүүлсэн албан бичиг, 2014 оны хууль эрх зүйн өөрчлөлтөөс үүдэж эдгээр мэдээллийг нийтэд ил тод танилцуулах ёстой гэж бид ойлгож байгаа.

Бид 2015 онд хийгдсэн БХГ-үүдийн олон нийтэд нээлттэй байх ёстой мэдээллийн эх үүсвэрийг олж үзэж чадаагүй ба 2015 онд хийгдсэн бүх БХГ-үүдийн хуулбарыг хүссэн.

АМГТГ бидний хүсэлтэд “АМГТГ нь гэрээний нэг тал болохын хувьд гэрээлэгчид мэдэгдэн хариу ирүүлсний дараа гэрээг ил тод болгох нь зүйтэй” гэсэн утга бүхий хариу ирүүлсэн.

АМГТГ нь шаардлагатай бүх зөвшөөрлийг олж авахаар хүлээж байгаа” гэсэн хариуг АМГТГ-аас авсаны дараагаар Ренова Илч ХХК-иас 2015 онд байгуулсан БХГ-ний хуулбарыг ирүүлэхийг хүссэн. Бид энэхүү тайланг бичих үед БХГ-ний хуулбарыг хүлээж аваагүй.

### 3.4.4 ГЭРЭЭНИЙ ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ (ШААРДЛАГА 2.4)

Засгийн газар нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний мэдээллийг ил тод болгоход татгалзах зүйлгүй байгаа бөгөөд Бүтээгдэхүүн хуваах гэрээг олон нийтэд мэдээлэхийг үүрэг болгосон Засгийн газрын 222 тоот тогтоолыг 2012 оны 7 дугаар сарын 4-нд баталсан.

Ашигт малтмал, газрын тосны газрын<sup>15</sup> вебсайтанд "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний мэдээллийг 2014 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хойш шинэчлэл хийгээгүй байна. Мөн тус тойм мэдээлэлд, өргөдөл гаргасан огноо, олгосон огноо, үргэлжлэх хугацаа болон талбайн солбицол, үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүний мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газраас олон нийтэд ил болгоогүй байна.

### 3.4.5 ҮЙЛДВЭРЛЭЛ

Сүүлийн 3 жилийн хугацаанд газрын тосны үйлдвэрлэлийн хэмжээ өссөн.

/мянган баррелаар/	2013	2014	2015*
Боловсруулаагүй газрын тос	5,128.9	7,405.3	8,769.3

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, хуудас 358, Урьдчилсан гүйцэтгэл

Засгийн газрын 2016 оны 2-р сарын 1-ний хуралдаанаар газрын тос боловсруулах үйлдвэр, дамжуулах хоолой барих шийдвэр гаргасан. Тус үйлдвэр нь жилдээ 2.5 сая тонн шатахуун үйлдвэрлэх хүчин чадалтай байна. Түүхий эдээ дотоодоосоо бүрэн хангах боломж бүрдэнэ гэж үзэж байна. Монгол Улсын нефтийн жилийн хэрэглээ 1.2 сая тонн байдаг.

### 3.4.6 ЭКСПОРТ

Экспортолсон боловсруулаагүй газрын тосны хэмжээ 2015 онд дараах байдалтай байсан. Боловсруулаагүй газрын тосны экспорт сүүлийн гурван жилийн хугацаанд байнга өссөн байна.

/мянган баррелаар/	2013	2014	2015
Боловсруулаагүй газрын тос	5 243.8	6 885.1	8 135.2

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, хуудас 290, Урьдчилсан гүйцэтгэл

## 3.5 ОЛБОРЛОХ САЛБАРЫН ЗҮГЭЭС ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

### 3.5.1 ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН ХЭМЖЭЭ (ШААРДЛАГА 6.3.А)

Уул уурхай, олборлох аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гарц 2014 он болон 2015 онд буурсан, аж үйлдвэрийн салбарын нийт гарц буурсан учраас ДНБ-д эзлэх хувь эдгээр жилүүдэд тогтвортой байсан.

Монгол улсын аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээг 2012-2015 оноор харуулбал дараах байдалтай байна.

<sup>15</sup> <http://www.pam.gov.mn/content/Бүтээгдэхүүн-Хуваах-Гэрээний-дагуу-газрын-тосны-хайгуулын-үйл-ажиллагаа-явуулж--10135.shtml>

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Аж үйлдвэрийн салбар Тэрбэм төгрөгөөр	2012	2013	2014	2015
Боловсруулах үйлдвэрлэл	3,012.1	3,212.8	4,042.7	3,741.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	824.1	904.5	842.8	1,024.6
Ус хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	198.1	226.8	246.2	283.1
Уул уурхайн бүс	4,034.3	4,344.1	5,131.7	5,048.8
Уул уурхай, олборлолт	5,787.0	6,099.8	9,271.3	8,685.6
Нийт	9,821.3	10,443.9	14,403.0	13,734.4
Уул уурхай, олборлолтын эзлэх хувь	58.9%	58.4%	64.4%	63.2%

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, хуудас 353

Уул уурхай, олборлох салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг харуулбал дараах байдалтай байна.

Уул уурхай, олборлолт- ДНБ	2012	2013	2014	2015
Тэрбум төгрөгөөр	2,742.80	2,849.40	3,661.00	3,867.70
ДНБ-д эзлэх хувиар	16.40%	14.90%	16.50%	16.70%

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, хуудас 209

### 3.5.2 ОЛБОРЛОХ САЛБАРААС ОРСОН ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО(ШААРДЛАГА 6.3.В)

2010-2014 онуудад олборлох салбараас Монгол улсын нэгдсэн төсөвт (улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжлийн сан, нийгмийн даатгалын сангаас бүрдэнэ) төвлөрсөн орлого 1.1 их наяд төгрөгөөс 1.7 их наяд төгрөг болтлоо өсч, 2015 онд 1.4 их наяд болж буурсан байна.

Олборлох салбараас улсын нэгдсэн төсөвт төвлөрсөн орлогыг нэгдсэн төсвийн орлоготой харьцуулан харуулбал дараах байдалтай байна.



Эх сурвалж: ОУ-ийн орлогын мэдээллийг ОУИТБС-ын тайлангаас, нэгдсэн төсвийн мэдээллийг Сангийн яамнаас тус тус авав.

2015 онд Засгийн газар нийт 2415 компаниас хүлээн авсан 1,546.4 тэрбум төгрөгийн орлогыг тайлагнасан. Үүнээс үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайгаас өөр салбарт үйл ажиллагаа

явуулдаг боловч материаллаг хэмжээний татвар төлсөн 26 тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн орлогыг хасаж тохируулсны дараах байдлаар Засгийн газрын нийт хүлээж авсан орлого нь 1,422.2 тэрбум төгрөг байна.

### 3.5.3 ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКСПОРТ (ШААРДЛАГА 6.3.C)

3.2.3 болон 3.3.4-с харна уу.

### 3.5.4 ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ ДЭХ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ(ШААРДЛАГА 6.3.D)

Үндэсний Статистикийн Хорооны мэдээлснээр, 2015 онд Монгол улсын нийт 1,151.2 мянган хөдөлмөр эрхлэгчдийн 42.6 мянга нь уул уурхайн салбарт ажиллаж байсан.

Уул уурхайн салбарт ажиллагсдын тоо 2014 онд 9.4 мянгаар бүүрсан боловч 2015 онд 1.7 мянгаар эргэн өссөн байна. Уул уурхайн салбар дахь ажил эрхлэлтийн тооцоололд гар аргаар олборлолт эрхлэгчид болон бичил уул уурхайн салбаруудыг оруулаагүй байна.

/мянган хүн/	2012	2013	2014	2015
Уул уурхай, олборлолтын салбарын хөдөлмөр эрхлэлт	46.7	50.3	40.9	42.6
Нийт хөдөлмөр эрхлэлт	1,056.4	1,103.6	1,110.7	1,151.2
Уул уурхай, олборлолтын салбарын ажил эрхлэлтийн эзлэх хувь	4.4%	4.6%	3.7%	3.7%

Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, хуудас 54

Үйлчилгээ үзүүлсэн гадаадын иргэдийн тоо<sup>16</sup> 2015 онд 16,643 иргэн байсан бөгөөд үүний 23.7% буюу 3,944 иргэн уул уурхай, олборлолтын салбарт үйлчилгээ үзүүлсэн байна.

Мөн Монгол улсад хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн тоо 2015 онд нийт 6,779 иргэн байсан ба үүний 21,37% буюу 1,499 иргэн нь уул уурхай, олборлолтын салбарт ажиллаж байсан.

## 3.6 ЗАСГИЙН ГАЗРЫН ИНСТИТУТ

Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамгийн их оролцоотой Засгийн газрын байгууллагуудын нэрсийг, ажил үүргийн ерөнхий чиглэлийн хамт дор харуулав.

Монгол улсын Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан 382 дугаартай тогтоолоор яамдуудын бүтэц, зохион байгуулалтыг ба өөрчлөлтийг 2015 оны бүтэцтэй харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 382 тоот Монгол улсын Засгийн газрын тогтоолоор дахин зохион байгуулсан <sup>17</sup>	2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 тоот Монгол улсын Засгийн газрын тогтоолоор дахин зохион байгуулсан <sup>18</sup>	Вебсайтууд
1 Уул уурхайн яам	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	<a href="http://www.mmhi.gov.mn/">http://www.mmhi.gov.mn/</a>

<sup>16</sup> Эх сурвалж: Хөдөлмөрийн зах зээлийн статистик мэдээллийн танилцуулга, 2015

<sup>17</sup> Source: <http://www.legalinfo.mn/annex/details/6597?lawid=10791>

<sup>18</sup> Source: <http://legalinfo.mn/annex/details/7381?lawid=12053>

2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 382 тоот Монгол улсын Засгийн газрын тогтоолоор дахин зохион байгуулсан <sup>17</sup>		2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 тоот Монгол улсын Засгийн газрын тогтоолоор дахин зохион байгуулсан <sup>18</sup>	Вeбсайтууд
2	Ашигт малтмалын газар	Ашигт малтмал, газрын тосны газар	<a href="http://www.mrpam.gov.mn/">http://www.mrpam.gov.mn/</a>
3	Газрын тосны газар		
4	Байгаль орчин, ногоон хөгжил, ачлал жуулчлалын яам	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	<a href="http://www.mne.mn/">http://www.mne.mn/</a>
5	Хөдөлмөрийн яам	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	<a href="http://www.khun.gov.mn/">http://www.khun.gov.mn/</a>
6	Татварын алба	Татварын алба	<a href="http://www.mta.mn/">http://www.mta.mn/</a>
7	Гаалийн ерөнхий газар	Гаалийн ерөнхий газар	<a href="http://www.customs.gov.mn/">http://www.customs.gov.mn/</a>
8	Үндэсний аудитын газар	Үндэсний аудитын газар	<a href="http://www.audit.mn/">http://www.audit.mn/</a>
9	Цөмийн энергийн комисс	Цөмийн энергийн комисс	<a href="http://www.nea.gov.mn/">http://www.nea.gov.mn/</a>
10	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	<a href="http://www.pcsp.gov.mn/">http://www.pcsp.gov.mn/</a>

### 3.6.1 УУЛ УУРХАЙН ЯАМ (УУЯ)

Уул уурхайн яамны үндсэн зорилго нь ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулж, эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгоход оршино.

Уул уурхайн салбар, Хүнд үйлдвэрийн салбар, Түлш, газрын тосны салбар, Геологийн талаарх хууль, тогтоомж, бодлого, дунд, үрт хугацааны стратеги, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжилтэд дотоодын хяналт-шинжилгээ хийх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь тус яамны зорилго юм.

### 3.6.2 АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР (АМГ)

Ашигт малтмалын газар нь Уул уурхайн яамны харъяа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлийн өрөгдөл боловсруулах, олгох үүрэг бүхий ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг юм.

АМГ-ын бусад ажлын хураангуйг дараах байдлаар дүгнэж болох юм:

- ЗГ-т салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх бүх талын таатай орчинг бүрдүүлэх.
- Ашигт малтмалын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх.

### 3.6.3 ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Монгол Улсын ГТГ-ын зорилго нь газрын тосны салбарын хөгжил болон хөрөнгө оруулалтыг дэмжих Засгийн газрын бодлогыг мэдээлж дэмжлэг үзүүлэх явдал юм. ГТГ нь үйлчлүүлэгчдэд үр ашигтай, шударга үйлчилгээгээр хангахад чиглэгдсэн байдаг.

ГТГ-ын одоогийн тэргүүлэх чиглэл нь Газрын тос олборлох болон цэвэршүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, уламжлалт болон уламжлалт бус газрын тосны хайгуулын үйл ажиллагааг дэмжиж хүчин чадлыг нэмэгдүүлэх зэргээс бүрдэнэ.

ГТГ нь засаг захиргаа, хайгуул, хяналт-шинжилгээ, үнэлгээ, ашиглалт, худалдан авалт, технологи, санхүү, хөрөнгө оруулалтын гэсэн 7-н хэлтэс албуудтай үйл ажиллагаа явуулж байна.

#### **3.6.4 БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ (БОНХАЖЯ)**

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тусгай зөвшөөрлөө хүлээж аваад 30 хоногийн дотор байгаль хамгаалах төлөвлөгөө БОНХАЖЯ-нд ирүүлэх ёстой байдаг ба яам уг тайланг хүлээн авч, хянах үүрэгтэй.

Мөн яам нь компаниудын байгаль хамгаалах, нөхөн сэргээх ажилд төсөвлөсөн зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлдэг. Тухайн компани байгаль хамгаалах төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлээгүй нөхцөлд уг 50%-ийг төлөвлөсөн зориулалтаар нь БОНХАЖЯ зарцуулах эрхтэй.

#### **3.6.5 ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ**

Хөдөлмөрийн Яам нь иргэдийн хөдөлмөрийн гэрээ, ядуурлыг бууруулах, ажиллах нөхцлийг сайжруулах, амьдралын өртгийн асуудал зэргийг мөн Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлт болон гаднаас ажиллах хүч авах асуудлуудыг хариуцаж ажиллах үүрэгтэй.

Тус яам нь ажил эрхлэлт болон зохистой ажлын орчныг дэмжих, мэргэжил чадварыг хөгжүүлснээр хүний нөөцийг сайжруулах, ажиллах хүчний өрсөлдөх, хөрвөх чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор бодлогоо хэрэгжүүлдэг.

#### **3.6.6 ТАТВАРЫН АЛБА**

Үндэсний татварын алба нь Татварын ерөнхий газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагчаас бүрдэнэ. Татварын ерөнхий газрын чиг үүрэг дараах байдалтай байна:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах
- Татварын хууль тогтоомжийн даган мөрдөлтөнд хяналт тавих  
Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх



Тус татварын алба одоогоор "Дэлхийн Татварын Стандарт"-ыг жишигт хүрэх таван жилийн хөтөлбөрийн дунд үедээ явж байна.

Үр дүнтэй мэдлэг ба ногоон эдийн засагт зориулсан татварын эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг агуулсан Үндэсний татварын албаны хөтөлбөрийн хөгжлийн зорилго нь мэдээлэл технологийн шинэчлэлд сүүрилсэн татварын удирдлагыг хөгжүүлэх, олон улсын түршлагыг нэвтрүүлэх мөн эрсдлийн удирдлагын арга техникийг боловсруулах хэрэгсэл болон эрсдэлтэй татвар төлөгчдөд аудит хийх зэргийг хөгжүүлэх юм.

Татварын шинэчлэлийн хүрээнд 2015 оны 7 дугаар сарын 9-нд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг УИХ шинэчлэн баталсан. Энэхүү хуулиар цахим төлбөрийн баримтын бүртгэлийн системийг 2016 оны 1-р сарын 1-ээс эхлэн ашиглалтанд нэвтрүүлсэн. Монгол улсад хийгдсэн бараа, үйлчилгээний борлуулалтыг цахим баримтын бүртгэлийн системд бүртгэснээр Монгол улсын албан татвар төлөгчдийн борлуулалтын орлогыг ил тод болгож, далд эдийн засгийг бүүруулж байна.

### **3.6.7 ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Монгол Улсын Гаалийн ерөнхий газар<sup>19</sup> нь улсын төсвийн ашигийг бүрдүүлэхээр татвар, хураамж хураах уламжлалт үүргээ нийгмийн сайн сайхныг дээдлэж, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах болгон өргөжүүлж байна.

Азийн хөгжлийн банк болон БНСУ-ын Засгийн газрын тусламжтайгаар хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд Гаалийн байгууллага нь захиргааны байгууллага бус, үйлчилгээний байгууллага руу шилжиж байна. Гол зорилго нь хил дамнасан худалдааны явцад тулгарч буй аливаа хүнд суртал, бэрхшээлийг шийдвэрлэх үр дүнтэй гарцыг зорчигчдод бий болгох явдал байсан юм.

Сүүлийн жилүүдэд Гаалийн Ерөнхий Газрын үйл ажиллагаанд томоохон шинэчлэл хийгдсээр байна. Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагааг автоматжуулах, цахимжуулах ажлыг хэрэгжүүлсэнээр гаалийн ажилчдын үйл ажиллагааг ил тод болгох ба үүний үр дүнд авилга, хүнд сурталаас ангид, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэх юм.

### **3.6.8 ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИСС**

"Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын тогтоолын дагуу Цөмийн энергийн газар Монгол Улсын тохируулагч агентлагаар Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд үүргээ гүйцэтгэн ажилладаг.

Тус Агентлаг нь цөмийн энергийг ашиглах, цөмийн энергийн технологийг нэвтрүүлэх, Монгол Улсын төрийн бодлогын хүрээнд цөмийн энергийн талаар шинжлэх ухааны судалгааг зохион байгуулах, цөмийн болон цацраг идэвхт бодисын аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг хянах, үнэлэх үүрэгтэй.

<sup>19</sup> Эх сурвалж: <http://www.customs.gov.mn/>

Агентлаг нь гурван газартайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Уг 3 газар нь Төрийн захиргааны удирдлагын газар, Цөмийн энергийн газар, Цөмийн болон цацрагийн хяналтын газар.

Тус агентлагийн гол хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах хэлбэртэй байна.

- Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги олборлох, цөмийн технологи ашиглах, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал, хяналтыг хангах талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Цацраг идэвхт ашигт малтмалын боловсруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах;
- Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологийн хэрэглээ;
- Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, илэрсэн зөрчлийг арилгах байх арга хэмжээ авах;

### **3.6.9 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллага бөгөөд Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт захирагддаг. Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглодог.

Улсын Их Хурлаас бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд санхүүжилтийн эх үүсвэрээс нь үл хамааран аудит хийх бүрэн эрхтэй байдаг.

### **3.6.10 ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРОО**

ТӨХ нь төрийн эзэмшлийн эсвэл ихэнх хувь нь төрийн эзэмшил бүхий 89 байгууллага, аж ахуйн нэгжийг эзэмшдэг. Уг Хороо нь төрийн өмчит компаниудын үйл ажиллагааны ил тод байдал болон хувьчлалын ил тод байдлыг хангаж ажиллах үүрэгтэй. Төрийн өмчийн хороо нь төрийн өмчийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, хамгаалах ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий Засгийн газрын үндсэн бүтцийн байгууллага юм.

## **3.7 ОЛБОРЛОХ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО**

### **3.7.1 ТӨРИЙН ӨМЧИЙН КОМПАНИУД (ТӨК) ШААРДЛАГА 2.6(В)**

ОУИТБС-ын Стандарт (2.6.а)-д ОУИТБС-ын тайлагналын зорилгоор төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг “төрийн нэрийн өмнөөс олборлох үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд” гэж тодорхойлсон. Уг стандартаар ОУИТБС-ын тайлан ТӨААН-ийн талаар өргөн цар хүрээний мэдээллийг хамруулахыг шаарддаг. Тухайлбал, “тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газрын тос болон байгалийн хийн компаниудад эзэмших өөрсдийн хувь эзэмшлийн түвшинг ил тод болгоно. Энэ нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн салбар болон хамтарсан аж ахуйн нэгжид бас хамааралтай бөгөөд тайлангийн хугацаанд эзэмшилд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийг ил тод болгох ёстой”.

2015 онд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын төрийн эзэмшлийн хувь хэмжээнд ямар нэгэн өөрчлөлт гараагүй.

### **3.7.1.1 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолын дагуу Худалдан авах ажиллагааны газар нь татан буугдаж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53-р зүйлд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт чиг үүрэг шилжсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 55 дугаар зүйлд Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компаний хэлбэрт оруулан хувьцаа, ногдол хувийг нь худалдах замаар хувьчилж болно. Энэ тухай шийдвэрийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана гэж заасан. /Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар болон 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиудаар өөрчлөлт оруулсан/

Эдийн засаг нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс төр зарим хувьцааг нийтэд санал болгохгүй, өөрийн өмчлөлдөө авч үлдэн төрийн өмчийн оролцоотой этгээд үүсгэж болно.

Мөн Энэ хуулийн 56 дугаар зүйлд компани болон өөрчлөгдсөн төрийн өмчит үйлдвэрийн газрын болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцаа, ногдол хувийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр чөлөөтэй, эсхүл багцалсан хэлбэрт оруулан биржээр болон биржийн гадуур арилжиж худалдах тухай заасан. /Энэ хэсэгт 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн хуулиар болон 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиудаар өөрчлөлт оруулсан/

2016 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэдээллээр Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд нийт 89 байгууллага бүртгэлтэй байна. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хувь эзэмшлийг эзэмшлийн төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Төрөл	Тоо
Төрийн өмчит үйлдвэрийн газар	24
Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани	8
Төрийн өмчит хувьцаат компани	44
Төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани	3
Төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани	2
Хувь нийлүүлсэн нийгэмлэг	1
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл хэрэгжүүлдэггүй компаниуд	7
Нийт	89

*Эх сурвалж: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар*

Дээрх жагсаалтанд орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд ороогүй.

### **3.7.1.2 Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниуд**

2016 оны 10 дугаар сарын 10-ны байдлаар Ашигт малтмал, газрын тосны газраас ирүүлсэн мэдээллээр дээрх компаниудаас олборлох салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой дараах 16 байгууллага байна. Доорх хүснэгтэд ОУИТБС-ын нэгтгэлд хамрагдсан болон хамрагдаагүй компаниудын мэдээллийг хураангуйлсан.

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Түүнчлэн засгийн газар нь ураны салбарт үйл ажиллагаа явуулдаг Мон Атом ХХК-ийг эзэмшдэг боловч тус компани нь 2015 оны 7 дугаар сарын 6-нд Мончех ураниум ХХК-д лицензээ шилжүүлсэн байна.

№	Регистрийн №	Байгууллагын нэр	Нэгтгэлд хамрагдсан эсэх	Ашигт малтмал	Өмчийн хэлбэр	Тусгай зөвшөөрлийн тоо
<b>Нэгтгэлд хамрагдсан компаниуд</b>						
1.	5124913	Эрдэнэс Монгол ХХК	тийм	төрөл бүрийн	100% төрийн өмчит	4
2.	2004879	Шивээ овоо ХК	тийм	нүүрс	Эрдэнэс монгол ХХК 90%, бусад 10%	1
3.	2008572	Багануур ХК	тийм	нүүрс	Эрдэнэс монгол ХХК 75%, бусад 25%	3
4.	5435528	Эрдэнэс таван толгой ХК	тийм	нүүрс	Эрдэнэс монгол ХХК 100%	8
5.	2074192	Эрдэнэт үйлдвэр ХХК	тийм	зэс, молибден	МУ-ын ЗГ 51%, Монголын зэс корпораци ХХК 49%	7
6.	2550466	Монголросцветмет ХХК	тийм	алт, хайлуур жонш, нүүрс, мөнгө	МУ-ын ЗГ 51%, Монголын зэс корпораци ХХК 49%	31
7.	2051303	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК	тийм	төмрийн хүдэр	100% төрийн өмчит	3
<b>Нэгтгэлд хамрагдаагүй компаниуд</b>						
8.	9011706	ШШГЕГ-ын харъяа Булган аймгийн хорих 439-р анги	үгүй	барилгын материал	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1
9.	9103619	ШШГЕГ-ын харъяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	үгүй	барилгын материал	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1
10.	9069798	ШШГЕГ-ын харъяа Хорих 443-р анги	үгүй	нүүрс	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1
11.	2076675	УБТЗ-ын Чулуун завод	үгүй	барилгын материал-хайрга	МУ-ын ЗГ 50%, ОХУ-ын ЗГ 50%	1
12.	2683857	ШШГЕГ-ын харъяа Авдрантхайрхан ХХК	үгүй	боржин чулуу	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1
13.	2053152	ШТН	үгүй	барилгын материал	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1
14.	9073523	ШШГЕГ-ын харъяа Хэнтий аймаг дахь Шүүхийн Шийдвэр Биелүүлэх Алба	үгүй	барилгын материал	Төрийн өмчит аж ахуйн нэгж	3
15.	5976723	Мончех ураниум ХХК	үгүй	уран	МУ-ын ЗГ 51%, ЧУ-ын ЗГ 49%	1
16.	9102981	Уул уурхайн аврах анги	үгүй	нүүрс	Төрийн өмчит аж ахуйн нэгж	2

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий дараах орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд байна. Үүнд:


№	Регистрийн №	Байгууллагын нэр	2015 оны нэгтгэлд хамрагдсан эсэх	Ашигт малтмал	Өмчийн хэлбэр	Тусгай зөвшөөрлийн тоо
1.	2016656	Таван толгой ХК	тийм	нүүрс	Орон нутгийн өмч 51%, хувийн өмч 49%	1
2.	2034859	Могойн гол ХК	тийм	нүүрс	Орон нутгийн өмч 51%, хувийн өмч 49%	1
3.	2014491	Баян тээг ХК	тийм	нүүрс	Орон нутгийн өмч 70%, хувийн өмч 30%	1
4.	3675416	Сүхбаатар уул уурхай	үгүй	вольфрам	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	1

Улсад төлсөн татварын хэмжээ нь материаллаг эсэхээс шалтгаалан төрийн өмчит 7, орон нутгийн өмчит 3 компани нэгтгэлд хамрагдсан ба төрийн өмчит 9, орон нутгийн өмчит 1 компани нэгтгэлд хамрагдаагүй байна.

### 3.7.1.3 Эрдэнэс Монгол ХХК

Эрдэнэс Монгол ХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг боловсруулах болон эзэмшихэд ЗГ-ын хувьцааг төлөөлөх зорилгоор байгуулагдсан тусгай зориулалтын компани юм.

Тус компани нь Монгол Улсын уул уурхайн хамгийн том хөрөнгө болох есөн компанийн хувьцааг эзэмшдэг. Үүнд: Оюу Толгой ХХК (Эрдэнэс Оюу Толгой ХХК-аар дамжуулан шууд бусаар), Эрдэнэс Таван Толгой ХК, Багануур ХК, Шивээ Овоо ХК, Монатом ХХК, Гашуун сүхайт авто зам ХХК, Эрдэнэс Метан ХХК, Эрдэнэс шивээ энерги ХХК болон Эрдэнэс Ассет менежмент ХХК.



Эх сурвалж: Эрдэнэс Монгол ХХК

### **Эрдэнэс Монгол ХХК-ийн үүсгэн байгуулалт (100% төрийн өмчит)<sup>20</sup>**

Эрдэнэс Монгол ХХК өөрийн охин компаниудаараа дамжуулан зэс, алт, молибден, мөнгө, коксжуулсан хүдэр, цайрын баяжмал, төмрийн хүдэр, холимог металл болон фосфорит үйлдвэрлэх зэргээр уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг. Компани нь 2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Засгийн Газрын 266 дугаар тогтоол болон 2007 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн Өмчийн Хорооны 52 дугаар тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан ба Улаанбаатар хотод байрладаг.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг тодорхойлсон УИХ-ын 27 дугаар тогтоолтой холбогдуулан эдгээр стратегийн орд газраас олсон уул уурхайн салбарын орлогыг хуримтлуулж, Монгол Улсын иргэн бүрт тэгш хуваарилах тухай Хүний хөгжлийн сангийн тухай хуулийг 2009 онд баталсан.

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 8.2-т заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг ТӨААН-үүд хэрэгжүүлнэ гэж тусгасан. *(Уг хуулийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцохоор заасан бөгөөд үүнийг 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсон.)*

МУ-ын ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолоор<sup>21</sup> “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ыг баталсан.

Энэхүү журмын 2.6-д “Эрдэнэс монгол” ХХК-ийн харъяа төрийн өмчийн оролцоотой “Эрдэнэс таван толгой” ХК, “Эрдэнэс оюу толгой” ХК, “Багануур” ХК, “Шивээ овоо” ХК, “Мон-Атом” ХХК зэрэг төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг “Эрдэнэс монгол” ХХК томилж чөлөөлнө гэж заасан.

2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн ЗГ-ын 347 дугаар тогтоолоор өөрчлөн батлагдсан компанийн дүрмийг 2016 оны 104 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан<sup>22</sup>.

### **Гашуун сүхайт авто зам ХХК (Эрдэнэс Монгол ХХК 40%, Энержи ресурс ХХК 40%, Эрдэнэс таван толгой ХХК 20% эзэмшдэг)**

Гашуун Сүхайт Авто Зам ХХК нь Тавантолгойн нүүрсний бүлэг ордоос гашуун сүхайт боомт хүртэлх экспортын тээврийн зориулалттай хатуу хучилттай авто замын засвар арчлалт, ашиглалтыг нь хариуцах зорилготойгоор “Эрдэнэс Монгол ХХК” 40%, “Энержи ресурс” ХХК 40 % “Эрдэнэс Таван Толгой ХХК” 20 %-ийн хөрөнгө оруулалттай байгуулагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны “Авто замын тухай” 83-р тогтоолын хүрээнд “Энержи ресурс” ХХК-иас олгосон санхүүжилтээр Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орших Ухаа худгийн уурхайгаас Гашуун сүхайтын хилийн боомт хүртэлх 239 км уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалт бүхий хүнд даацын хатуу хучилттай авто замыг 2011 онд барьж уг замын ашиглалт, засвар үйлчилгээ, арчлалт, харуул хамгаалалт, аюулгүй ажиллагааг хариуцан ажиллаж ирсэн.<sup>23</sup>

<sup>20</sup> Эх сурвалж: 2014 оны МОУИТБС-ын нэгтгэл тайлан болон Эрдэнэс Монгол ХХК-ийн цахим хуудас

<sup>21</sup> Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/12142?lawid=12142>

<sup>22</sup> Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/annex/details/7188?lawid=11796>

<sup>23</sup> [http://qsr.mn/?page\\_id=177](http://qsr.mn/?page_id=177)

### **Эрдэнэс Метан ХХК (Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг)**

Эрдэнэс Метан ХХК нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр уламжлалт болон уламжлалт бус газрын тосны эрэл, судалгаа хийх, хөрөнгө оруулалт татах, үндсэн үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлт хийх, дээрх чиглэлүүдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК-ийн 100% охин компани хэлбэрээр 2016 оны 2-р сард байгуулагдсан. Эрдэнэс Метан ХХК нь 12 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

### **Эрдэнэс Ассет менежмент ХХК (Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг)**

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн шийдвэрээр 2016 оны 2 дугаар сард байгуулагдсан. Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлэх, Санхүү тооцоо, судалгаа, шинжилгээ хийх, Хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд төсөл, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Батлагдсан бүтцийн орон тоо 6.

### **Эрдэнэс шивээ энерги ХХК (Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг)**

Стратегийн ач холбогдол бүхий Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн эрчим хүчний цогцолбор төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий төслийн нэгжийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дэргэд байгуулсан. Төсөл хэрэгжсэнээр нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж бий болж, 150 тэрбум тонн орчим нүүрсний нөөцийнхөө зарим хэсгийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэгч, экспортлогч орон болох зорилготой.<sup>24</sup>

### **Эрдэнэс Оюу толгой ХХК (Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг)**

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 348 дугаар тогтоол болон Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудаар төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр үүсгэн байгуулсан."Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь Оюу Толгой ХХК-ийн хувьцааны 34 хувийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн эзэмших эрхийг Эрдэнэс Монгол ХХК-иас албан ёсоор шилжүүлэн авч үйл ажиллагаагаа явуулж байна. Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн үндсэн зорилго нь Монголын талын 34 хувийн хувьцааг эзэмшин, Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаанд оролцож, ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх үйл ажиллагаа байна гэж компанийн дүрэмд тодорхойлсон. Тус компани нь 17 хүний орон тоогоор ажиллаж байна.

### **Оюу Толгой ХХК (Монгол Улсын ЗГ шууд бусаар 34%-ийг эзэмшдэг)**

2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Түркоиз Хилл компанийн толгой компани болох Рио Тинто компанитай байгуулсан гэрээний дагуу “Эрдэнэс Монгол” ХХК нь ЗГ-ын нэрийн өмнөөс “Оюу Толгой” ХХК-ийн 34%-ийг эзэмшиж байсан. Эрдэнэс Монгол ХХК нь 2011 онд өөрийн эзэмшилийн бүх хувьцааг охин компани болох Эрдэнэс Оюу Толгой ХХК-д шилжүүлсэн.

### **Шивээ овоо ХК (Эрдэнэс Монгол ХХК 90% эзэмшдэг, 10% бусад)**

---

<sup>24</sup> <http://zasag.mn/news/view/11273>

Шивээ овоо ХК 1990 оны 07 дугаар сарын 31-ны өдөр байгуулагдсан. Тус компанийн хувьцааны 90%-ийг төрийн өмчит, 10% нь 3300 гаруй хувьцаа эзэмшигчдэд хувьчлагдсан байна. Монгол Улсын эрчим хүчний нийт нүүрсний хэрэгцээний 30%, “ДЦС-4” -ийн нүүрсний хэрэгцээний 40%-ийн хэрэгцээг хангаж байна. 2016 онд 547 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 оны Засгийн газрын 100 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани хэлбэрээр ажиллаж байна. Компани нь Шивээ сервис ХХК-ийг хувьцааг 100% эзэмшдэг.

**Багануур ХК (Эрдэнэс Монгол ХХК-75%, Монголын үндэсний нүүрсний корпораци ХХК-21.06%, бусад-3.94%)**

1978 он “Багануурын нүүрсний уурхай” нэртэйгээр байгуулагдсан. Одоогийн байдлаар Багануур ХК-ийн хувьцааны 75%-ийн төрийн өмчит, 21.06%-ийг Монголын үндэсний нүүрсний корпораци ХХК, үлдсэн 3.94%-ийг хуулийн этгээд, хувь хүн эзэмшиж байна.

Тус компани нь төвийн бүсийн эрчим хүчний системийг цахилгаан дулаанаар хангаж буй ДЦС2, ДЦС3, ДЦС4, Амгалангийн ЦС, ДДЦС, ЭДЦС, Багануурын ДС, Налайхын ДС-д нүүрсээ нийлүүлдэг. Нийт 1119 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 оны Засгийн газрын 100 дугаар тогтоолоор Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр ажиллаж байна.

Багануур ХК нь нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 70 хувь, нийт нүүрсний хэрэглээний 60 хувийг нийлүүлж байна.

Багануур ХК нь Багануур-илч ХХК болон Багануур-сувилал ХХК гэсэн охин компаниудтай. Мөн Мон-Цахим ХХК-ийн 46 хувийг эзэмшдэг.

Багануур-Илч ХХК 1993 оноос Багануур ХК-ийн Төлөөлөгчийн газар нэртэй ажиллаж байгаад 2000 оны 1-р сарын 1-ээс Багануур ХК-ийн 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани болон зохион байгуулагдсан. Улаанбаатар хотын дүүрэг, дагуул хот, сум суурин газруудын халаалтын уурын зуух болон айл өрхийг нүүрсээр хангахаас гадна ресторан, караоке, билльярдын үйлчилгээ эрхэлдэг.

Багануур-Сувилал ХХК 1990 оноос Багануурын уурхайн нийгэм ахуйн хэсэг нэртэй үйл ажиллагаагаа явуулж байгаад 2000 оноос “Багануур-Сувилал” ХХК болон зохион байгуулагдсан. Тус компани нь нэг дор 100 сувилуулагч хүлээн авч эмчилгээ сувилгаа үзүүлэх хүчин чадалтай, 160 хүний суудалтай 2 зоогийн газар, нэг ээлжинд 31 хүн хүлээн авах зочид буудлын үйл ажиллагаа явуулдаг.

Мон-Цахим ХХК нь 1996 онд байгуулагдсан бөгөөд үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайн болоод бусад бүх төрлийн тоног төхөөрөмжийн цахилгааны засвар үйлчилгээ үзүүлдэг.

**Эрдэнэс Таван Толгой ХК (Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг)**

Эрдэнэс-Таван толгой төсөл 2010 оны 08 дугаар сарын 27-ны өдөр хэрэгжих эхлэл тавигдаж, уурхайн уулын ажил албан ёсоор эхэлсэн. Энэ дагуу Тавантолгойн нүүрсний орд газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий Эрдэнэс-Таван толгой хувьцаат компанийг УИХ, Засгийн газрын шийдвэрийн дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компанийн хэлбэрээр 2010 оны 12 дугаар сарын 23-нд байгуулж, үйл ажиллагаагаа эхэлсэн. Эрдэнэс-Таван толгой ХК нь



стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн чиглэлээр ажилладаг. Эрдэнэс-Таван толгой ХК нь нийт 588 ажилтантай бөгөөд 100 хувь монгол хүн ажиллаж байна.

“Эрдэнэс Таван толгой” ХК нь 2011 оны 7 дугаар сарын 26-нд Хятадын төрийн өмчит Чалко компанитай Нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулан урьдчилгаа төлбөр болох 350 сая ам.долларыг авсан. Нийт урьдчилгаа төлбөрөөс 96 сая ам.доллар үлдсэн бөгөөд тус урьдчилгаа төлбөрийг барагдуулахын хүрээнд 2016 оны 2 дугаар сараас эхлэн Чалко компанид сар тутам дор хаяж 200 мянган тонн нүүрс нийлүүлэхээр тохиролцсон<sup>25</sup>. 2014 оны 8 дугаар сарын 20-ний өдрийн ЗГ-ын 268 дугаар тогтоолор “Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол, “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн, Таван толгойн ордыг ашиглах эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд борлуулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах, мэргэшсэн удирдлагын багийг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх асуудлыг улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байдлаар шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас “Таван толгойн нүүрсний ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох нээлттэй уралдаант шалгаруулалт”-ын үйл ажиллагааг явуулсан байна.

#### **Мон атом ХХК (Эрдэнэс Монгол ХХК 100% эзэмшдэг)**

Мон атом ХХК-ийг Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор байгуулах шийдвэр гарсан. Тус компанийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт уран болон бусад төрлийн цацараг идэвхт ашигт матмал, газрын ховор элементийн эрэл, тандан судалгаа, хайгуулын ажлыг гүйцэтгэн нөөцийг тогтоох, тэдгээрийг олборлох, ашиглах, цөмийн түлш, эрчим хүчний үйлдвэрлэл эрхлэх, тэдгээрт шаардлагатай материаллаг бааз болон үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, энэ салбар дахь гадны болон хувийн хөрөнгө оруулалттай төслүүдэд төрийн өмчийн оролцоог хэрэгжүүлэхэд оршдог.

Одоогоор 6 хүний орон тоогоор ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 68 дугаар тогтоолоор тус компанийг Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани хэлбэрээр шилжүүлсэн.

Арева группийн веб сайтанд мэдээллэснээр Мон-Атом ХХК нь АРЕВА Майнс ХХК-ийн хамтрагч төрийн өмчит компаниар томилогдсон бөгөөд тус компанийн 34%-ийг эзэмшдэг.

АРЕВА Майнс ХХК нь Монгол Улсын Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгох ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр олборлолтын үйл ажиллагаа явуулдаг компани юм<sup>26</sup>.

#### **Улаанбаатар Төмөр Зам чулуун завод (Монгол Улсын ЗГ 50%, ОХУ-ын ЗГ 50%)**

<sup>25</sup> <http://www.erdenestt.mn/?p=1471>

<sup>26</sup> <http://mongolia.areva.com/scripts/mongolie/publigen/content/templates/Show.asp?P=94&L=MN>

Улаанбаатар Төмөр Замыг МУ-ын ЗГ 50%-ийг, үлдсэн 50%-ийг ОХУ-ын ЗГ эзэмшдэг. Түүний нэг салбар нэгж болох чулуун завод нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд 1956 оноос хойш Дорноговь аймгийн Даланжаргалан суманд хайрга олборлолтын үйл ажиллагааг явуулж байна.

**Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэр ХХК (Монгол Улсын ЗГ 51%-ийг эзэмшдэг, хувийн эзэмшил 49%)**

Уулын Баяжуулах Эрдэнэт Үйлдвэр ХХК нь дэлхийд томоохонд тооцогддог зэсийн уурхай, баяжуулах үйлдвэр юм. Анх 1978 онд Монгол – Орос хоёр орны Засгийн Газар хоорондын гэрээний дагуу үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн. Тэр үеэс эхлэн ОХУ-ын ЗГ 49%-ийг эзэмшсээр ирсэн. Жилд 26 сая тонн хүдэр боловсруулж 530.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 4.5 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг.

2016 онд Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн ОХУ-ын эзэмшилд байсан 49%-ийг “Монголын зэс корпораци” ХХК эзэмших болсон.<sup>27</sup>

**Монголросцветмет (Монгол Улсын ЗГ 51%-ийг эзэмшдэг, хувийн эзэмшил 49%)**

Монголросцветмет нь хайлуур жоншны уул уурхайн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд одоогийн байдлаар гурван далд уурхайн орд, хоёр ил уурхайн орд болон боловсруулах үйлдвэрийн хүчин чадалтай компани юм. Компани нь хүчил болон төмөрлөгийн хайлуур жоншны, мөн алтыг баяжуулан боловсруулах үйл ажиллагаа явуулдаг.

2016 онд Монголросцветмет компанийн ОХУ-ын эзэмшилд байсан 49%-ийг “Монголын зэс корпораци” ХХК эзэмших болсон.

**МонЧех Ураниум ХХК**

2015 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын төрийн өмчит Мон-Атом ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Галбадрал болон Ураниум Индастри ХК-ийн ТУЗ-ийн дарга М. Клэчка нар хамтарсан МонЧех Ураниум компани байгуулахаар Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд гарын үсэг зурсан байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын системээс харахад 2015.07.06-ны өдөр Мон-Атом төрийн өмчит ХХК нь Хэнтий аймгийн Норовлин сумын ХҮ-018953 тоот лицензээ Мончех ураниум ХХК-д шилжүүлсэн байна.

**Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр (100% төрийн өмчит)**

Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр нь 1990 онд Дархан-Сэлэнгийн төмрийн хүдрийн уурхайн үйлдвэрт суурилан үүсгэн байгуулагдсан. Төмөрлөгийн хүдрийн стратегийн ач холбогдол бүхий орд газрын нөөц нь ойролцоогоор 230 сая тонн байна. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг хөгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд төмрийн хүдрийн нойтон соронзон боловсруулах цогц үйлдвэрийг 2014 онд байгуулсан.

<sup>27</sup> <http://www.mcc.mn/project.html>

#### **3.7.1.4 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд**

##### **Тавантолгой ХК (Орон нутгийн эзэмшил 51%, хувийн эзэмшил 49%)**

Тус уурхай нь зах зээлийн нөхцөлд зохицон 1994 оны 12 дугаар сарын 05-ны Засгийн газрын өмч хувьчлалын комиссийн хүрлын 42 тоот тогтоолоор төрийн өмч давамгайлсан Тавантолгой ХК болсон байна. 1995 оноос эхлэн Тавантолгой ХК нь орон нутгийн өмчит компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тавантолгойн нүүрсний орд нь Өмнөговь аймагт, Хятад – Монголын хилээс ойролцоогоор 270 км-ийн зайтай байрладаг.

##### **Могойн Гол ХК (Орон нутгийн эзэмшил 51%, хувийн эзэмшил 49%)**

Могойн Гол ХК нь 1970 онд үүсгэн байгуулагдсан нүүрс олборлодог компани юм. Уурхай нь Хөвсгөл аймагт байрладаг бөгөөд 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй байна.

##### **Баян Тээг ХК (Орон нутгийн эзэмшил 70%, хувийн эзэмшил 30%)**

Баян Тээг ХК нь 1961 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд нүүрсний уурхайн орд газар нь Өвөрхангай аймагт буюу Улаанбаатар хотоос 560 км зайтай байрладаг. 1995 онд хувьцаат компани болж дахин зохион байгуулагдсан ба хувьцааны 70% нь төрийн эзэмшилд байдаг. 1994 оноос хойш Монголын Хөрөнгийн Биржэд бүртгэлтэй байна.

#### **Бусад ТӨААН-үүд**

АМГ-аас ирүүлсэн тусгай зөвшөөрлийн мэдээлэлд үндэслэн бидний нэгтгэлийн хүрээнд хамрагдаагүй зарим ТӨААН-үүд байгааг бид олж мэдсэн ба компаниуд нь улсын төсөвт бага хэмжээний татвар төлдөг тул нэгтгэлд хамрагдаагүй байна. Эдгээр ТӨААН-үүдэд Авдрант хайрхан ХХК, Хорих 439-р анги, Хорих 443-р анги, Уул уурхайн аврах анги, Хэнтий аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Сүхбаатар уул уурхай болон аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба багтаж байна. Дээрх байгууллагуудын ихэнх нь түгээмэл тархацтай ашигт малтмал болон уул уурхайн орд газрын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд нэг байгууллага нь (Сүхбаатар уул уурхай) Сүхбаатар аймагт вольфрам уурхайн орд газрын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

#### **3.7.1.5 Төлөөлөн Удирдах Зөвлөл**

ТӨААН-үүдээс нийт 8 байгууллага нь ТУЗ-ийн мэдээллийг ирүүлсэн бөгөөд ТУЗ-ийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 21-с харна уу.

#### **3.7.1.6 Төрийн өмчит компаниудын засаглалын үнэлгээний судалгаа**

МУ-ын Санхүүгийн зохицуулах хороо, Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн хөтөлбөр хэрэгжүүлэх албанаас гаргасан МУ-ын Компанийн засаглалын үндэсний тайлан 2015-д28 МУ-ын компанийн засаглалыг үнэлсэн бөгөөд үүн дотроо төрийн өмчит компани (ТӨК)-иудын засаглалын өнөөгийн байдлыг үнэлсэн байна. Энэхүү судалгааны хүрээнд 2013 онд хийсэн

<sup>28</sup> <http://governance.mn/upload/files/2016/01/07/c6eca79876616ea9a1ca86172d0805f7.pdf>

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

судалгааны аргачлалыг ашиглан 2015 он хүртэл хугацаанд хэрхэн өөрчлөлт, ахиц дэвшил гарсан эсэхийг үнэлж дүгнэсэн байна.

Судалгаанд төрийн өмчит нийт 51 компанийг хамруулсанаас Эрдэнэт үйлдвэр ХХК, Багануур ХК, Эрдэнэс Монгол ХХК, Шивээ овоо ХК, Мон-Атом ХХК, Эрдэнэс таван толгой ХК зэрэг 6 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниуд хамрагдсан байна.

Судалгааны асуулгыг төрийн өмчит компаниудын баримталбал зохих сайн засаглалын үндсэн зарчмуудын дагуу бүлэглэн авч үзсэн судалгааны үр дүнг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Зарчмууд	Үр дүн
1. Зохицуулалтын үр дүнтэй тогтолцоо бүрдүүлсэн байдал	Төрийн өмчит компаниудад эрх зүйн зохицуулалтын үр дүнтэй тогтолцоо бүрдүүлснийг үнэлэх асуулгаар төрийн зохицуулалтын болон хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг заагласан эрх зүйн тогтолцоо бүрдсэн боловч дүрэм, журмыг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байна. Өнгөрсөн онтой харьцуулахад ТӨК-ийн зээл, санхүүжилтийн асуудал нь төрөөс хараат бус болж байгааг харуулж байгаа бөгөөд харин нийгмийн нийтлэг эрх ашгийг хамгаалахад чиглэсэн боловч компанийн ашгийн төлөө үндсэн зорилгод нийцхээргүй үүрэг, хариуцлага хүлээлгэсэн шийдвэр гаргах тал дээр цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна гэж үзсэн байна. Санхүүжилтийн эх үүсвэр тал дээр харьцангуй уян хатан бодлого баримтлах тал дээр хувьцаа эзэмшигчдийн зүгээс анхаарах шаардлагатай гэсэн байна.
2. Засгийн газар Төрийн өмчит компанийн хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлж байгаа байдал	ТӨХ <sup>29</sup> болон ТӨК-ийг хянах үүрэг бүхий засгийн газрын агентлагууд энэхүү үүргээ хангалттай биелүүлдэг бөгөөд төрийн төлөөлөл болон ТӨК-ийн хоорондын харилцааны зохицуулалт нь компанийн дотоод баримт бичигт тодорхой тусгагдсан байгаа юм байна. Мөн ТӨК-уудын гүйцэтгэх удирдлага компанийн үйл ажиллагааг Засгийн газраас хараат бусаар удирдах нөхцөл бололцоо өнгөрсөн оныхтой харьцуулбал харьцангуй дээрдсэн харагдаж байгаа боловч зарим компанийн хувьд ТУЗ нь эрх зүйн чадамжгүй байсаар байна. ТУЗ-ийн гишүүн болон бусад эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компаниуд хийсэн сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлүүд огт хийгдээгүй гэсэн мэдээллийг компаниуд өгч байгаа нь магадгүй сонирхлын зөрчилтэй хэлцлийг тодорхойлж чадахгүй байгааг илэрхийлж байж болзошгүй. ТӨК-иудын хувьд компанийн засаглалыг хэрэгжүүлэх шаардлага нэн тэргүүнд тавигдаж байгаа энэ үед ТӨК-ийн төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч нь Компанийн засаглалын үндэсний зөвлөл зэрэг ТББ-уудтай хараат бус гишүүдийг сонгох тал дээр хамтран ажиллах боломжийг судлах шаардлагатай юм.
3. Бүх хувьцаа эзэмшигчдэд тэгш, шударга хандах	ТӨК-иудын ТУЗ-ийн зүгээс бүх хувьцаа эзэмшигчдэд адил тэгш хандах, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангахад чиглэсэн бодлого баримталдаг гэж үздэг юм байна. Харин томоохон хувьцаа эзэмшигчийн хувьд Засгийн газрын зүгээс ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох асуудалд шударга зарчим баримталж чадахгүй бөгөөд төрийн өмчийн компанийн ТУЗ-д улс төрийн эсвэл тодорхой өндөр албан тушаалтны төлөөний хүн орох явдал байсаар байгаа нь харагдаж байна.
4. Оролцогч талуудтай харилцах харилцаа	Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг холбогдох хуулиудад тодорхой заасан байдаг тул ТӨК-ийн хувьд тэдгээрийг биелүүлж ажиллах үүрэгтэй. Тэдгээрээс гадуур үйл ажиллагаа явуулсан тохиолдолд үүсэх хариуцлага, эрсдлээ хүлээх ёстой болно. Компани харилцагч талуудтайгаа ихэвчлэн тодорхой гэрээ байгуулах замаар харьцдаг. Эдгээр гэрээг байгуулахад баримтлах өөрийн онцлогийг тусгасан ёс зүйн нийтлэг бодлого, зарчмыг засаглалын бодлогод тусгасан байх ёстой. Иргэний хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон дампуурлын тухай хуульд, аливаа компаниас өрсөлдөгчөө болон бусад оролцогч талуудыг хохироосон үйл ажиллагаа явуулсан бол хохирлоо барагдуулах талаар гомдол гаргах талын асуудал нь нийтлэг жишгийн дагуу нилээд сайн зохицуулагдсан байгаа. Судалгаанаас үзэхэд ТӨК-үүд гадны болон дотоодын оролцогчидтой хуулийн хүрээнд

<sup>29</sup> ТӨХ-г ЗГ-ын 2016 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 5-р тогтоолоор татан буулгасан бөгөөд уг тогтоолыг ЗГ-ын 2016-7-27-ны өдрийн 3-р тогтоолоор хүчингүй болсонд тооцож, ТӨХ-ны чиг үүргийг ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шилжүүлсэн.

Зарчмууд	Үр дүн
	гэрээний үндсэн дээр харилцдаг болох нь харагдаж байна. Хэдийгээр ТӨК-уудын мэдээлэл нээлттэй гэж өөрсдөө үзэж байгаа боловч гадны оролцогч талууд, сургалт судалгааны байгууллага, иргэдийн зүгээс тэдний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан зэрэг мэдээлэлтэй танилцах боломж хангалтгүй байгаа юм.
5. Ил тод байдал, тайлагнал	Ил тод байдлын тухай асуулга явуулахад ТӨК-ийн мэдээллийн ил тод нээлттэй байдал өнгөрсөн оныхоос харьцангуй сайжирсан байна. ТӨК-иуд жилийн эцэст хөндлөнгийн аудитаар хянагдсан санхүүгийн тайлан болон үйл ажиллагааны тайлангаа хуулийн дагуу тайлагнахаас өөр хэлбэрээр мэдээллээ ил тод тайлагнах тал дээр дутагдалтай байна гэж дүгнэж болно. Ялангуяа бизнесийн ёс зүй, компанийн засаглалын мөрдөлт, эрх мэдэл бүхий албан тушаалтан түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл, компани дээр хийгдэж буй их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийн талаар төдийлөн ил тод тайлагнахгүй байна. Мэдээллийн технологийн хөгжлийн үр дүнд мэдээллийг хямд хялбар, түргэнээр сонирхогч бүх этгээдэд хүргэх боломжтой болсоны нэг хэлбэр нь компанийн вэб сайт билээ. Цаашид төрийн өмчит компаниудын ил тод байдлыг хангах зорилгоор компанийн өөрийн вэб сайтыг байнгын ажиллагаатай болгон шилэн данстай холбох шаардлагыг компанийн эрх бүхий албан хаагчдад хүргүүлэх нь зүйтэй юм.
6. Дотоод аудит	Компанийн үйл ажиллагаа нь компанийн эрхэм зорилго, зорилтот нийцэж байгаа эсэх, удирдлагаас гарч буй шийдвэр зохих ёсоор биелэгдэж байгаа эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих бүтцийн нэгж байх зайлшгүй шаардлагатай. Энэ үүргийг дотоод аудит гүйцэтгэнэ. Ялангуяа ТӨК-ийн хувьд засаглах болон гүйцэтгэх удирдлага тусдаа байдаг. Иймд гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТӨХ-ны шууд удирдлагад ажиллаж түүнд ажлаа тайлагнадаг дотоод аудитын алба хэрэгжүүлэх шаардлагатай.
7. ТУЗ-ийн гишүүдийн хариуцлага	Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан ТУЗ тусгай чиг үүрэг бүхий хороодтой байх, ТУЗ-ийн гишүүд засаглалын сургалтанд заавал хамрагдах зэрэг заалтуудын дагуу ТӨК-иудын ТУЗ-д Төрийн өмчийн хорооны оролцоотой өөрчлөлт шинэчлэлийг хийж байгаа нь харагдаж байна. Мөн ТӨК-иудын ТУЗ нь үйл ажиллагаагаа төлөвлөж түүнийхээ дагуу үйл ажиллагаагаа явуулдаг ба гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулан ажиллаж, түүний үйл ажиллагааг тогтмол үнэлж дүгнэдэгээс гадна өөрийн үйл ажиллагааны тухай хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнадаг тогтолцоо бүрдэж байгаа нь харагдаж байна. Харин гүйцэтгэх захирлыг томилохдоо улс төрийн нөлөөллөөс ангид бөгөөд зөвхөн нэр дэвшүүлэх хорооны зөвлөмжийг баримтлах зарчим хангалтгүй байгаа нь харагдаж байна.

### 3.7.1.7 Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээ

2016 оны 5 дугаар сард НҮБХХ-ийн захиалгаар, тус байгууллагын боловсруулсан ‘Олборлох салбар дахь авлигын эрсдэлийг бүүруулах’ олон улсын аргачлалыг ашиглан “Хараат бус судалгааны хүрээлэн” (IRIM)-ээс хайгуулын, ашиглалтын өмнөх, ашиглалтын, хаалтын үе шатууд дахь авлигын эрсдэлийг тодорхойлсон байна<sup>30</sup>.

2015-2016 оны Дэлхийн өрсөлдөх чадварын тайланд Монгол Улс албан бус төлбөр, хээл хахууль гэсэн үзүүлэлтээр 0-7 түвшингээс 3.8 оноо авч 140 орноос 77-д жагссан байна.

Судалгааны үр дүнд геологи, уул уурхайн салбарт геологи хайгуул, ашиглалтын өмнөх, ашиглалтын, хаалтын үе шатанд хамгийн түгээмэл 15 төрлийн авлигын эрсдэл байгааг тодорхойлж, эрсдэлийн түвшинг нь тооцсон.

Эрсдэлүүд	Эрсдэлийн түвшин
<b>ЭРСДЭЛ 1.</b> Өргөдлийн журмаар тусгай зөвшөөрөл авах	Өргөдлийн журмаар тусгай зөвшөөрөл авах үе шатанд шийдвэр гаргах үйл явцтай холбоотой авлигын эрсдэл бодитой байна. Нэгдсэн мэдээллийн сан байхгүй, орон нутгаас санал авах харилцааг нарийвчлан зохицуулаагүй, тусгай зөвшөөрөл хүсэхэд хавсаргаж буй материалууд шаардлага хангаж байгаа эсэх талаар мэдээлэл ил тод биш байгаа зэрэгтэй холбоотой байна.

<sup>30</sup>[http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/democratic\\_governance/CorruptionRiskAssessmentinMiniSectorofMongolia.html](http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/democratic_governance/CorruptionRiskAssessmentinMiniSectorofMongolia.html)

Эрсдэлүүд	Эрсдэлийн түвшин
<p>үе шат</p> <p><b>ЭРСДЭЛ 2.</b> Сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой</p>	<p>Сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой авлигын эрсдэл байна. Үүний шалтгаан нь тус комиссыг томилох, гүйцэтгэх үүргийг нарийвчлан зохицуулаагүй, комиссын гишүүнээр зөвхөн Ашигт малтмалын газрын мэргэжилтнүүд ажилладаг зэрэг юм.. Түүнчлэн зохих журмын дагуу зөвшөөрөл авах өргөдөл гаргасан уул уурхайн компаниудад шийдвэр гаргах эрх бүхий этгээд татгалзсан санал өгөх, үгүйсгэсэн шийдвэр гаргах үйл явц нарийн зохицуулалтгүй байна. Тиймээс хайгуулын үе шатанд сонгон шалгаруулалт хийж буй комиссыг томилох, эцсийн шийдвэр гаргах үйл явцыг зохицуулах, сонгон шалгаруулалтын үйл явц, үр дүнг ил тод мэдээлэх ажлыг зохицуулсан журам, хуулийн зүйл заалтыг нарийвчлан тусгах, холбогдох баримт бичгийг төрийн болон орон нутгийн бусад байгууллагад ил тод болгох хэрэгтэй байна.</p>
<p><b>ЭРСДЭЛ 3.</b> Хайгуулын шатанд орон нутгийн Засаг дарга, ИТХ-аас санал авах</p>	<p>Хайгуулын шатанд орон нутгийн Засаг дарга, ИТХ-аас санал авахтай холбоотой авлигын эрсдэл бодитой байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгож болох талбайн талаар санал авахад орон нутгийн Засаг дарга, Газрын алба Газрын тухай хуулийг баримтална гэдэг бол компаниуд Ашигт малтмалын тухай хуулийг баримталдаг. Гэтэл эдгээр хууль хоорондоо зөрчилддөг. Үүнтэй холбоотой хайгуул хийхээр ирүүлсэн компаниудын саналд орон нутаг дийлэнхидээ татгалзсан хариуг өгдөг боловч хэсэг хугацааны дараа зөвшөөрсөн хариу болж өөрчлөгддөг. Мөн орон нутгаас санал авах хугацааг хэрхэн тооцох нь тодорхойгүй, аймгийн ба сумын ИТХ хоорондын харилцааг нарийвчлан зохицуулах, сумын ИТХ-ыг хуралдуулах зардал, боломжтой шууд холбоотой. Тиймээс эдгээр харилцааг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. АМГ-ын хувьд, газрын бүртгэлийн талаарх мэдээллийн санг тогтмол шинэчлэх, БОАЖНХЯ, АМГ-ын Кадастрын хэлтэс хоорондоо дундын нэгдсэн мэдээллийн сантай болох, мөн орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай холбоотой мэдээллийг хуваалцдаг нэгдсэн тогтолцоотой болох хэрэгтэй.</p>
<p><b>ЭРСДЭЛ 4.</b> Ашигт малтмалын нөөцийн тооцоо, үнэлгээний дүгнэлтэд нөлөөлөх</p>	<p>Ашигт малтмалын нөөцийн тооцоо, үнэлгээний дүгнэлтэд нөлөөлөхтэй холбоотой авлигын эрсдэл байна. Уул уурхайн компани нь ашгаа нэмэгдүүлэх, олборлох ёстой нөөцийн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлээс сэргийлж ашигт малтмалын нөөцийг багаар тогтоолгох эрмэлзэлтэй байдаг. Энэ тохиолдолд нөөцийн тооцоо, үнэлгээний дүгнэлтэд нөлөөлөхийн тулд авлигын эрсдэл үүсдэг. Мөн ашигт малтмалын тооцоо, үнэлгээ буруу, зөрүүтэй гэсэн шалтгаанаар өргөдлийн талаас илүү хувь нь буцаагдаж байгаа нь ашигт малтмалын нөөцийн тооцоо, үнэлгээ хийх арга аргачлал, техник технологи дутмаг, түүнийг ашиглах мэргэжилтний чадавхи, түршлага сул байгаатай холбоотой. Хэрвээ буруу дүгнэлт гаргасан тохиолдолд тооцох хариуцлагын тогтолцоо сул бөгөөд дүгнэлтийн эцсийн шийдвэрийг гаргахад оролцож буй Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр гаргах үйл явц, ажиллах механизмыг ил тод, хариуцлагатай болгож сайжруулах хэрэгтэй.</p>
<p><b>ЭРСДЭЛ 5.</b> ТЭЗҮ-гийн дүгнэлтийг хурдан шуурхай батлуулах</p>	<p>ТЭЗҮ-гийн дүгнэлтийг хурдан шуурхай батлуулахтай холбоотой авлигын эрсдэл үүсч байна. ЭБМЗ нь компаниудаас ирүүлж байгаа ТЭЗҮ-ийг ямар комисс, ямар дарааллаар хэрхэн яаж батлах үйл явцыг нарийвчлан зохицуулаагүй байгаа нь авлигын эрсдэл үүсэх шалтгаан болж байна. Мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан байдлын үнэлгээ боловсруулах болон батлах шатанд үнэлгээ хийж буй, түүнийг хянан хэлэлцэж буй шинжээчид, зөвлөлийн гишүүд нь аль аль талд ажиллах боломжтой байгаа нь ашиг сонирхлын зөрчлийг бий болгож байна.</p>
<p><b>ЭРСДЭЛ 6.</b> Бүтээн байгуулалтын зөвшөөрлүүдийг богино хугацаанд авах</p>	<p>Бүтээн байгуулалтын зөвшөөрлүүдийг богино хугацаанд авахтай холбоотой авлигын эрсдэл байна. Ашиглалтын өмнөх шатанд уул уурхайн компаниуд багадаа 10 гаруй гаруй гаруй байгууллагаас зөвшөөрөл авах, ойролцоогоор 90-ээс доошгүй тооны (уул уурхайн компаний хэмжээ, олборлож буй ашигт малтмалын төрлөөс хамаарч өөр өөр байдаг) баримт бичиг бүрдүүлдэг. Тиймээс ашиглалтын тусгай зөвшөөрөл авах явцад зайлшгүй бүрдүүлэх баримт бичгүүдийг хурдан шуурхай хянуулах, өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх, бүтээн байгуулалтын зөвшөөрлүүдийг богино хугацаанд авахтай холбоотой авлигын эрсдэл үүсдэг. Үүний шалтгаан нь зөвшөөрөл олгож буй байгууллагад олон тооны өргөдөл ирдэг учраас ажлын ачаалал их, өргөдлийг хэлэлцэх, шийдвэрлэж буй талаарх мэдээлэл ил тод бус байдаг. Мөн чанар хангахгүй өргөдөл, түүнд хавсаргах материалыг батлуулахын тулд хахууль өгөх эрсдэл үүсдэг. Ашиглалтын өмнөх шатанд бүтээн байгуулалтын зөвшөөрлийг авахтай холбоотой хүнд суртал мөн гардаг бөгөөд судалгааны зорилгоос шалтгаалан эдгээр зөвшөөрөл бүрийг нэг бүрчлэн судлаагүй болно.</p>
<p><b>ЭРСДЭЛ 7.</b> Уул уурхайн компанийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт</p>	<p>Уул уурхайн компанийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалттай холбоотой авлигын эрсдэл. Давхардсан, ач холбогдол багатай олон тооны хяналт шалгалт нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж, хяналт, шалгалт хийж буй ажилтнуудын далд хэлбэрийн ашиг сонирхлыг нэмэгдүүлэх эрсдэл бий болгож байна. Ялангуяа мэргэжлийн хяналтын байгууллага, Засаг дарга нараас хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалттай холбоотой авлигын эрсдэл байна. Хуулиар зарим хязгаарлалт хийдэг ч ийм төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхдээ компаниудад урьдчилан мэдээлэл өгдөггүй, хяналтын удирдамж, арга зүй</p>



Эрсдэлүүд	Эрсдэлийн түвшин
	тодорхойгүй байдаг учраас авлигын эрсдэл үүсэх шалтгаан болдог. Компаниудын зүгээс зөвшөөрөл, хяналт шалгалттай холбоотой хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаа нь хууль бүс үйл ажиллагаа явуулах эсвэл хууль бүс шалгалт, шахалтанд өртөх, улмаар авлигын эрсдэл бий болгодог. Тиймээс компаниудын засаглалын тогтолцоо, хариуцлага, дотоод чадавхийг сайжруулахад анхаарах хэрэгтэй.
<b>ЭРСДЭЛ 8.</b> Компаниудаас орон нутагт үзүүлж байгаа хандив, тусламж	Компаниудаас орон нутагт үзүүлж байгаа хандив, тусламжтай холбоотой авлигын эрсдэл нийтлэг байна. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан орон нутагтай байгуулах загвар гэрээ 2016 оны 3 дугаар сарын 28-нд батлагдсан. Орон нутгийн гэрээтэй холбоотойгоор ИТХ ба Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдийг чадавхийг сайжруулах, сургалт зөвлөгөөгөөр хангах, орон нутгийн гэрээний сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх нь чухал. Хандив, тусламжтай холбоотой авлигын эрсдэлийг бууруулах нэгэн чухал хүчин зүйл нь ОУИТБС юм. Тиймээс Санаачилгыг цаашид улам бүр боловсронгуй болгож, илүү үр дүнтэй, бодитой хэрэгжих гарцыг нээж, энэхүү харилцааг тусгайлан зохицуулдаг тусгай эрх зүйн актыг батлан гаргах, орон нутагт байгаа салбар зөвлөлүүдийн институтыг бэхжүүлэхэд онцгой анхаарч, чадавхижуулах шаардлагатай.
<b>ЭРСДЭЛ 9.</b> Орон нутгийн иргэд уул уурхайн компанийн хоорондын зөрчил	Орон нутгийн иргэд уул уурхайн компанийн хоорондын зөрчилтэй холбоотой авлигын эрсдэл. Орон нутагт уул уурхайн компаниудад хандах хандлага сөрөг, уул уурхайн компанийн орон нутагт тайлагнадаг, мэдээлэл өгдөг тогтолцоо дутмаг байгаа нь иргэд ба тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компанийн хооронд зөрчил үүсэхэд нөлөөлдөг. Энэ байдлыг ашиглан зарим иргэд компаниудаас хахууль авах эрсдэл бодитой байна. Тиймээс компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, орон нутагтай ажиллах стратеги, мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах, орон нутгийн иргэдэд үнэн зөв мэдээлэл өгдөг тогтолцоог бий болгох, усны асуудлаар иргэдийн оролцоотой мониторинг хийх зэрэг үйл ажиллагаа чухал юм. Уул уурхайн салбарын мэргэжлийн ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих, чадавхийг бэхжүүлж, хяналт шалгалт, зөвшөөрөл өгөх үе шатанд хөндлөнгийн хараат бүс шинжээчдийн оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай.
<b>ЭРСДЭЛ 10.</b> Ашигт малтмал ашиглах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	Ашигт малтмал ашиглах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлантай холбоотой авлигын эрсдэл. Ашиглалтын үе шатанд компани үйл ажиллагаагаа хэвийн явуулахын тулд анхны боловсруулсан төлөвлөгөөгөө цаг хугацаа хэмнэх үүднээс хурдан батлуулах, эсвэл чанарын шаардлага хангаагүй төлөвлөгөө, тайланг дахин сайжруулалт оруулалгүй батлуулах, зөрчилтэй тайланд тавигдаж буй торгуулийн хэмжээг бууруулахын тулд хахууль өгөх эрсдэл үүсдэг. АМГ-т байгууллагад ирж буй төлөвлөгөө, тайлан хууль, журамд заасан хугацаа дуусахын өмнө олноороо ирдгээс түүнийг хянах ажилтнуудын ачааллыг огцом нэмэгдүүлдэг. Компанийн талаас эдгээр төлөвлөгөө ба тайланг боловсруулахад шаардлагатай нөөцийг төлөвлөж ач холбогдол өгдөг байх нь туйлын чухал байна.
<b>ЭРСДЭЛ 11.</b> Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг батлуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг батлуулахтай холбоотой үүсдэг авлигын эрсдэл. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайланг боловсруулахад компаниуд хангалттай ач холбогдол өгдөггүй, хуурамч төлөвлөгөө гаргах, учруулсан хохирлыг багасгаж тайлан гаргах нь түгээмэл байна. Уул уурхайн компаниуд Байгаль орчны үнэлгээний тайлан гэх мэт шаардлагатай тайлан, бичиг баримтыг хуульд заасан зохих стандартын дагуу бэлтгэх чадавхи сул, компанийн удирдлагын зүгээс ач холбогдол өгдөггүй, ор нэр төдий хийдэг нь нийгэмд уул уурхайн салбарын нэр хүнд унахад ихээхэн нөлөөлж байна. БОНХАЖЯ-ны хувьд байгаль орчны үнэлгээг хийх үйл ажиллагааг сайжруулах, хуульд заасан байгаль орчны үнэлгээг хийхэд олон нийтийн оролцоог хангах заалтуудыг хэрэгжүүлэх нь чухал байна.
<b>ЭРСДЭЛ 12.</b> Ашигт малтмалын борлуулалттай холбоотой авлигын эрсдэл	Ашигт малтмалын борлуулалттай холбоотой авлигын эрсдэл. Борлуулалттай холбоотой татвар, тайлан, гаальтай холбоотой авлигын багц эрсдэл нүүгдмал мөртлөө түгээмэл гарч байгааг зөвхөн татвараар жишээлэн тус тайланд оруулав. Цаашид эдгээрийг нарийвчлан судлахыг үнэлгээний баг санал болгож байна.
<b>ЭРСДЭЛ 13.</b> Уурхайг хаах шийдвэр гаргуулах	Уурхайг хаах шийдвэр гаргуулахтай холбоотой авлигын эрсдэл нь “Уурхайг түр болон бүрмөсөн хаах журам”-д хаалтын комиссын гишүүдийг хэрхэн томилох, томилогдсон комисс нь ямар удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж акт үйлдэх талаар нарийвчлан заагаагүй, үүнийг зохицуулах журам байхгүйгээс үүсч байна. Энэ нь хаалтын шатанд акт үйлдэж буй орон нутгийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллагууд ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах, авлигын эрсдэл үүсэх нөхцөл бий болгож байна.
<b>ЭРСДЭЛ 14.</b> Уул уурхайн хаалттай холбоотой эрх зүйн зохицуулалт	Уул уурхайн хаалттай холбоотой эрх зүйн зохицуулалт дутуугаас үүдэлтэй авлигын эрсдэл. Уул уурхайн хаалтын үйл ажиллагааг зохицуулах хуулийн заалт, журмууд нь тодорхойгүй, хэт ерөнхий байгаа нь компаниудыг нөхөн сэргээлт хийх, орон нутагт уурхайг хүлээлгэн өгөх шатанд хариуцлагаас зайлсхийхэд хүргэж байгаа тул уурхайн хаалттай холбоотой хууль тогтоомжийг цоо шинээр боловсруулах шаардлагатай байна.

Эрсдэлүүд	Эрсдэлийн түвшин
<p>дутуу</p> <p><b>ЭРСДЭЛ 15.</b></p> <p>Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө</p>	<p>Нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөтэй холбоотой авлигын эрсдэл үүсэх шалтгаан нь тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хуулийн заалт байхгүй, мөн барьцаа хөрөнгийг төвлөрүүлж байгаа сан нь ил тод, хариуцлагатай байх зарчмуудыг хангадаггүй, УУЯ ба БОНХАЖЯ-ны хамтын ажиллагаа дутагддаг зэрэгтэй холбоотой. БОНХАЖЯ нөхөн сэргээхтэй (дүйцүүлэн нөхөн сэргээх) нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгөтэй холбоотой менежментийг сайжруулах ил тод, хариуцлагатай болгох шаардлагатай. ОУИТБС-ын олон улсын хэмжээнд баримтлах бодлогуудад авлигаас сэргийлэх, засаглалыг сайжруулах талаар шаардлагууд орсон байна. Эдгээрийг энэ салбарын бодлого, холбогдох яамдын авилгатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй.</p>

Эх сурвалж: “Хараат бус судалгааны хүрээлэн” ТББ-ын хийсэн Монголын уул уурхайн салбарын авилгын эрсдэлийн үнэлгээ

### 3.7.2 ГАЗРЫН ТОСНЫ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО

2014 оны 7 дугаар сард Монгол Улсын УИХ-с Газрын тосны тухай шинэчилсэн хуулийг баталж, 1991 оны хуулийг хүчингүй болгосон. Уламжлалт газрын тосны бүтээгдэхүүнээс гадна, энэхүү хуульд занарын элс, нүүрсний давхаргын метан хий болон байгалийн битум зэрэг бусад ашигт малтмалын нөөцүүд хамрагдсан. Гол зохицуулагчийн хувьд ГТГ нь БХГ-г байгуулах (ЗГ-ын зөвшөөрөлтэй), жилийн төлөвлөгөө батлах болон хураамжийн төлөлтөд хяналт тавих зэрэг асуудлуудыг хариуцна.

Шинэчилсэн хуулийн 7, 8 болон 9 дүгээр зүйлүүд нь газрын тосны салбар дахь төрийн оролцоог дэлгэрэнгүй тодорхойлсон. Тухайлбал, шинэчилсэн Газрын тосны тухай хуулийн дагуу ГТГ нь боломжит гэрээлэгчтэй ирээдүйн гэрээ байгуулах болон ирээдүйн гэрээ эзэмшигчидтэй БХГ-ний хэлэлцээр хийх үүрэгтэй байхад ЗГ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч болон ГТГ хоорондын БХГ-г батлах эрхтэй байна. ГТГ болон ЗГ-аас гадна, УУЯ нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг гаргах болон сунгах, мөн хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ирүүлсэн нөөцийн тооцооллыг батлах үүрэг хүлээнэ.

2005 онд батлагдсан Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль<sup>31</sup>-ийн 5, 6 дугаар зүйлүүдэд Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаархи төрийн оролцоог тусгасан.

### 3.7.3 ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ТӨААН-ҮҮДИЙН САНХҮҮГИЙН ХАРИЛЦАА (ШААРДЛАГА 2.6.A)

Төрийн өмчит компани, Засгийн газар хоорондын санхүүгийн харилцааг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар нийтлэг зохицуулдаг.

ЗГ болон ТӨААН-үүдийн татвараас бусад мөнгөн шилжүүлэг нь үндсэндээ 2009 оноос хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хүний хөгжил сангийн тухай хуулиар зохицуулагддаг. Хүний хөгжил сангийн тухай хуулийн дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого, Сангийн хөрөнгийг арвижуулах зорилгоор дотоодын

<sup>31</sup> <http://www.legalinfo.mn/law/details/214?lawid=214>



## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас, өрийн бичиг, хадгаламж хэлбэрээр оруулсан хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашиг зэргийг Санд төвлөрүүлнэ. Харин уг хуулинд заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээлийн тодорхой хэсгийг хүний хөгжил санд шилжүүлдэг байсныг 2016 оны 1 сарын 29-ний өдрийн шинэчлэлтээр хүчингүй болгосон.

Сангийн яамны 2015 оны Хүний хөгжил сангийн мэдээгээр 2015 онд 70 тэрбум төгрөгийн ногдол ашиг тус санд төвлөрүүлэхээр төсөвлөсөн боловч гүйцэтгэлээр ямар нэгэн ногдол ашиг төвлөрөөгүй байна. Хүний хөгжил сангийн 2015 оны хувьцааны ногдол ашгийн 70.0 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөө тасарсан нь “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Совет хуралдаагүй ба ногдол ашиг хуваарилах шийдвэр гараагүйтэй холбоотой байна. Бусад төрийн өмчит уул уурхайн компаниудын ногдол ашиг төлөлтийн талаар Сангийн яамнаас тодруулахад 2015 онд ногдол ашиг хүлээн аваагүй гэж мэдэгдсэн.

Компаниудаас авсан нэмэлт мэдээллийн маягтаар орон нутгийн өмчит Баянтээг, Могойн гол, Тавантолгой зэрэг орон нутгийн өмчит хувьцаат компаниуд нь ногдол ашгийн мэдээллээ дараах байдлаар ирүүлсэн. Үүнд:

(сая төгрөгөөр)

Регистрийн #	2014491	2034859	2016656	
Компанийн нэр	Баянтээг ХК	Могойн гол ХК	Тавантолгой ХК	
2014 оны цэвэр ашиг	348	97	4437	
2015 оны цэвэр ашиг	463	79	572	
2014 оны цэвэр ашгаас зарласан нийт ногдол ашиг (2015 онд олгосон)	25	8	16,747	
Ногдол ашгийн хуваарилалт	Хувьцаа эзэмшигчдэд	8	4	8325
	Ногдол ашиг	18	4	8,423
2015 оны цэвэр ашгаас зарласан нийт ногдол ашиг (2016 онд олгосон)	25	4	0	
Ногдол ашгийн хуваарилалт	Хувьцаа эзэмшигчдэд	8	2	0
	Ногдол ашиг	18	2	0
	Хүлээн авсан байгууллага	Орон нутгийн засаг захиргаа	Хөвсгөл аймгийн өмчийн алба	Өмнөговь аймгийн ЗДТГ

Эх сурвалж: Компаниудаас авсан мэдээлэл

Тавантолгой ХК нь нийт 52,665,200 ш хувьцаатай бөгөөд үүний 51 хувийг буюу 25,805,948 ш хувьцааг орон нутаг, 49%-ийг буюу 26,859,252 ш хувьцааг 1165 бусад хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. 2015 онд нийт 16,747 сая төгрөгийн ногдол ашиг зарласан бөгөөд үүний 1,537 сая төгрөгийг Өмнөговь аймгийн ЗДТГ-д мөнгөөр төлж, үлдсэн 6,804 сая төгрөгийг 2012 оны тооцоондоо суутган төлсөн байна. Нийт 8,325 сая төгрөгийг бусад хувьцаа эзэмшигчдэд тараасан.

### **Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль**

1996 онд УИХ-аас төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг баталсан.

Хуулийн 15 дугаар зүйлд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина гэж заасан.

Хуулийн 16 дугаар зүйлд Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана. /Энэ хэсгийг 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/ Гэхдээ тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр богино хугацаанд авах зээл, үнэт цаасанд хамаарахгүй. Мөн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зээл хамаарахгүй.

### 3.7.4 ТӨААН ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ (ШААРДЛАГА 4.5)

Бид нэгтгэлд хамрагдсан ТӨААН нүүрсний компаниудаас 2015 онд нийлүүлсэн нүүрсний талаарх мэдээллийг хүссэн. Дараах 3 ТӨААН нүүрсний мэдээллүүдээ ирүүлсэн. Үүнд:

№	Станцууд	ДЦС-ын... хувийг нийлүүлдэг	2015 онд нийлүүлсэн нүүрс				1 тн нүүрсний дундаж үнэ ам.доллар	1 тн дулааны нүүрсний дундаж үнэ /дэлхийн зах зээл/
			мян.тн	сая.төг	1 тн нүүрсний дундаж үнэ	1 тн нүүрсний өртөг төгрөг		
<b>Багануур ХК</b>								
1	"ДЦС-4" ТӨХК	60%	1,635	43,467	26,588	29,300	\$ 13.24	\$ 38.12
2	"ДЦС-3" ТӨХК	100%	1,267	33,542	26,480			
3	"ДЦС-2" ТӨХК	100%	225	5,684	25,321			
4	"ДДЦС" ТӨХК	60%	108	2,697	25,069			
5	"Амгалан ДС"ХХК	100%	39	1,037	26,590			
6	"БНДС" ТӨХК	100%	59	1,618	27,612			
<b>Шивээ-Овоо ХК</b>								
1	"ДЦС-4" ТӨХК	40%	1700	35,802	21,060	21,551		
<b>Шарын гол ХК</b>								
1	"ДДЦС" ТӨХК		273	7,664	28,093			
2	"ЭДЦС" ТӨХК		286	8,026	28,037			

Эх сурвалж: ОУ-ийн компаниудаас авсан мэдээлэл, ОУ-ын 33-ийн үнийг АМГТГ-ын статистик мэдээлэл

Төгрөгөөрх нүүрсний борлуулалтын үнийг ам.долларт хөрвүүлэхдээ Монголбанкны 2015 оны дундаж албан ханшийг ашигласан.

Дээрх хүснэгтээс харахад ТӨААН-үүд нь дулааны цахилгаан станцуудад зах зээлийн үнээс 3 дахин бага үнээр нүүрс нийлүүлж байна. Энэ нь Багануур ХК (2015 онд 4.8 тэрбум төгрөг), Шивээ Овоо ХК (2015 онд 1.7 тэрбум төгрөг) зэрэг компаниудыг алдагдалтай ажиллахад нөлөөлж байна.

УИХ-ын 2015 оны 70 дугаар тогтоолоор “Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл” батлагдсан нь эдийн засгийн уналттай үед цагаа олсон шийдвэр байсан. Уг тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс 2015-2016 онуудад хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг баталсан.

Үүний дагуу Эрдэнэс Монгол ХХК нь Багануур ХК болон Шивээ Овоо ХК-иудын хувьчлал, төрийн эзэмшлийг багасгах бэлтгэл ажлыг хариуцан ажиллаж байна.

### 3.7.5 ЗЭЭЛ БОЛОН ЗЭЭЛИЙН БАТАЛГАА (ШААРДЛАГА 2.6(В))

МУ-ын Хөгжлийн банкны 2015 оны 12 дугаар сарын байдлаарх санхүүжилтийн тайлан мэдээгээр уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дараах төслүүдийг санхүүжүүлсэн. Үүнд:

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Төслийн Эхлэх-дуусах хугацаа	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт /өссөн дүнгээр/ (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн нөхцөл /жилээр/		Зээлдэгчийн нэр	Эргэн төлөгдөх огноо
					Хүү	Хугацаа		
1	Эрдэнэс тавантолгой Эрдэнэс тавантолгой Эрдэнэс тавантолгой	2012-2017	250.0 сая ам.доллар	138,686.0	7.35%	5.0	Эрдэнэс тавантолгой ХК	10/5/2017
				139,256.0	7.38%	3.0		2/1/2016
				94,280.0	-	-		Хаагдсан.
2	Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл	2014-2015	991.9 сая төгрөг	585.5	10.0%	2.7	Уул уурхайн яам	2/15/2017
3	Оюу толгой төслийн санхүүжилт	2014-2016	10 сая ам.доллар	4,922.8	7.65%	2.0	Сангийн яам	11/12/2016
4	Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрлэл	2014-2015.04 сар	3.0 сая ам.доллар тай тэнцэх 5.6 тэрбум төгрөг	5,643.0	10.0%	3.3	Мон-Лаа ХХК	12/11/2017
5	Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх	2013 - 2018.04 сар	18.6 тэрбум төгрөг	18,634.0	9.6%	5.0	Багануур ХК	4/24/2018
6	Геологийн төв лаборатори	2013-2017.07 сар	379.9 сая төгрөг	379.9	9.0%	3.0	Геологийн төв лаборатори ТӨҮГазар	8/12/2017
7	Төмөртэй ордоос Хандгайт өртөө хүртэлх төмөр зам	2014 оны 2-р улирал - 2015 оны 3-р улирал	71.3 сая ам.доллар	133,740.3	8.0%	4.0	Кью Эс Си ХХК	12/3/2018

Эх сурвалж: МУ-ын Хөгжлийн банк

Дээрх хүснэгтээрх зээлүүдийн талаар товч танилцуулбал:

#### Эрдэнэс тавантолгой төсөл

Төслийн зорилго нь олборлолт, тээвэрлэлт зэрэг үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх.

Тавантолгой уурхай нь 6.0 тэрбум тонн коксжих нүүрсний нөөцтэй Дэлхийд томоохонд тооцогдох уурхай юм. Тус уурхайгаас 2011 онд 1.0 сая тонн, 2012 онд 2.5 сая тонн, 2013 онд 2.1 сая, 2014 онд 5.7 сая, 2015 оны 12 дугаар сарын байдлаар 4.2 сая тонн нүүрс экспортлосон.

### **Таван толгойн цахилгаан станц төсөл**

Төслийн зорилго нь Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн 450 МВт-ын хүчин чадал бүхий цахилгаан станц барих. Эхлэх 2013 он - Дуусах 2017 он, Гэрээний дүн - 15.98 сая доллар Санхүүжүүлсэн дүн - 14.82 сая ам доллар /5,0 сая ам.доллар/ . Төслийн хүрээнд 450 МВт хүчин чадал бүхий цахилгаан станц, Тавантолгой-Оюутолгой хооронд 150 км цахилгаан түгээх шугам барина. Төслийн хэрэгжилтийн хүрээнд ТЭЗҮ, БОННУ боловсруулах, геологи, геодези, археологи, палеонтологийн судалгаа, нүүрсний шинжилгээ зэрэг ажлуудыг хийсэн бөгөөд хөрөнгө оруулагч нарыг сонгон шалгаруулахаар төслийн техникийн даалгаврыг урьдчилсан байдлаар сонгогдсон 4 компанид хүргүүлсэн.

### **Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төсөл**

Төслийн зорилго нь Хүрэн нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх технологи нэвтрүүлж, жилд дунджаар 16.0 тэрбум шоо метр хий үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрүүд, гадаргын усны болон хий дамжуулах нийт 1500 км урттай хоолойнууд барьж, аж үйлдвэрийн томоохон кластер үүсгэх юм.

Хүрэн нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийг барих төслийн нэгжийн үйл ажиллагааг эхлүүлэн, үйлдвэрийн техник эдийн засгийн үзүүлэлт болон холбогдох судалгаа, шинжилгээ, төлөвлөлтийн ажлыг хийж, төсөл хэрэгжүүлэх урьдчилсан бэлтгэлийг хангахаар ажиллаж байгаа.

### **Оюу толгой төслийн санхүүжилт**

Оюутолгой төслийн далд уурхайг ашиглалтанд оруулах ажлын хүрээнд шаардлагатай зөвлөх үйлчилгээ авахаар болсон бөгөөд 2015 оны 12 сарын байдлаар хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

### **Төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрлэл**

“Мон-лаа” ХХК нь “Төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр”-ийн тоног төхөөрөмжийг БНХАУ-аас худалдан авахаар гэрээ байгуулж, тус гэрээний дагуу төлөх ёстой нийт төлбөрийн үлдэгдэл 50 хувь болох 3.0 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн зээлийн гэрээг Хөгжлийн банкнаас байгуулж, санхүүжилтийг олгосон. Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын технологи сайжирч, шинээр ажлын байр бий болох, иргэдийн амьжиргаанд эерэгээр нөлөөлөх боломжтой.

### **Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг өргөтгөх**

Төслийн хүрээнд “Багануур” ХК нь нүүрс тээврийн 4, хөрс тээврийн 4 автомашин, 1 бульдозер худалдан авч, нүүрс бутлан ачих байгууламжийн өргөтгөлийг 2014 оны 1 дүгээр сард ашиглалтанд оруулаад байна.

### **Геологийн төв лаборатори төсөл**

Төслийн зорилго нь “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын тоног төхөөрөмжийг шинэчилснээр “Оюутолгой” ХХК-ийн баяжуулах үйлдвэрээс экспортод гаргаж буй бүтээгдэхүүнд хөндлөнгийн хяналт хийх.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь Оюу Толгойн зэсийн уурхайн зэс, алтны баяжмалд хяналтын шинжилгээг 2013 оны 6 дугаар сараас эхлэн хийж байна. Хөгжлийн банкны санхүүжилтээр тоног төхөөрөмжийг шинэчилснээр ISO 10378 стандартын дагуу алт, мөнгөний агууламжийг өндөр нарийвчлалтайгаар богино хугацаанд тодорхойлох боломжтой болсон.

### Төмөртэй ордоос Хандгайт өртөө хүртэлх төмөр зам

Төслийн зорилго нь Улсын Их Хурлын 2008 оны 35 дугаар тогтоол, 2010 оны 36 дугаар тогтоол, 2012 оны 37 дугаар тогтоол, Засгийн газрын 2008 оны 153 дугаар тогтоол, 2014 оны 169 дүгээр тогтоолын хүрээнд Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулж, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөх ажлын нэг хэсэг болох Төмөртэй ордоос Хандгайт өртөө хүртэл 33.4 км төмөр зам барьж, ашиглалтанд оруулна.

Төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын нутагт байрлах Төмөртэй ордоос Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах Хандгайт өртөө хүртэл 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт ашиглалтанд оруулах юм.

### 3.7.6 ЗЭЭЛИЙН БАТАЛГАА (ШААРДЛАГА 2.6(В))

Эрдэнэс тавантолгой ХК эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор Хаан банкнаас авсан 35.0 сая ам.долларын зээлд Хөгжлийн банкнаас баталгаа гаргасан. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Хаан банкнаас авсан зээлийн үлдэгдэл 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5.2 сая ам.доллар байна. Тавантолгой уурхай нь 6.0 тэрбум тонн коксжих нүүрсний нөөцтэй Дэлхийд томоохонд тооцогдох уурхай юм. Тус уурхайгаас 2011 онд 1.0 сая тонн, 2012 онд 2.5 сая тонн, 2013 онд 2.1 сая, 2014 онд 5.7 сая, 2015 оны 12 дугаар сарын байдлаар 4.2 сая тонн нүүрс экспортлосон.

### 3.7.7 МУХБ-НААС ЭНЭХҮҮ НЭГТГЭЛД ХАМРАГДСАН КОМПАНИУДАД УУЛ УУРХАЙН БУС ЧИГЛЭЛЭЭР ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ

Мөн МУХБ-наас энэхүү нэгтгэлд хамрагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад уул уурхайн салбараас бусад салбарт дараах зээлийг олгосон байна. Үүнд:

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Төслийн эхлэх, дуусах хугацаа	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт /өссөн дүнгээр/ (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн нөхцөл /жилээр/		Зээлдэгчийн нэр	Эргэн төлөгдөх огноо
					Хүү	Хугацаа		
1	Тавантолгой-Гашуунсүхайтын авто замын төсөл	2010.11-2011.11	170.6 тэрбум төгрөг	170,595.5	4.250%	6.0	Эрдэнэс монгол ХХК	2/12/2020
2	Барилгын арматурын үйлдвэрийн төсөл	2013 он - 2015.04 сар	22.7 сая ам.доллар	32,028.7	8.0%	3.6	Бэрэн групп	11/15/2017
3	Байшин үйлдвэрлэх комбинат	2013.08.20 - 2015.08.20	13.1 сая евро	22,034.6	8.0%	8.0	Эрэл ХХК	8/19/2021
	Байшин үйлдвэрлэх комбинат			17,921.1	8.17%	6.7		6/14/2022
	Байшин үйлдвэрлэх			2,244.3	4.786%+ euribor	4.9		4/28/2019

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

№	Төсөл хөтөлбөрийн нэр	Төслийн эхлэх, дуусах хугацаа	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт /өссөн дүнгээр/ (сая төгрөгөөр)	Санхүүжилтийн нөхцөл /жилээр/		Зээлдэгчийн нэр	Эргэн төлөгдөх огноо
					Хүү	Хугацаа		
	комбинат							
	Байшин үйлдвэрлэх комбинат	2013.08.20 - 2015.08	14 сая ам.доллар	25,972.2	4.4%+eu ribor	4.8		4/28/2019
4	"Монцемент" төсөл	2013 оны 07-р сар	65.0 сая ам.доллар	67,447.1	7.79%	5.0	Монполимент ХХК	10/28/2019
	"Монцемент" төсөл	Дуусах 2015 оны 3 дугаар улирал, 2016 он		59,112.3	8.45%	4.3		10/28/2019

Эх сурвалж: МУ-ын Хөгжлийн банк

### **Тавантолгой-Гашуунсүхайтын авто замын төсөл**

Төслийн зорилго нь Монгол улсын Засгийн газрын 2010 оны 3-р сарын 31-ний өдрийн “Авто замын тухай” 81 дүгээр тогтоолоор Нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, говийн бүсийн эко системийг хамгаалах зорилгоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа Худаг-Гашуун Сүхайтын боомт хүртэлх хатуу хучилттай 245 км авто замыг барих.

Тус зам нь 2012 оны 1-р сард ашиглалтанд орсноор Таван толгойн орд газарт үйл ажиллагаа явуулж буй үүрхайнууд, тээвэрлэгч болон “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн хооронд зохих гэрээ байгуулан тээвэрлэлт хийгдэж ирсэн. 2014 оны 2 дугаар сараас 12 дугаар сарын хооронд Монгол Улсын нийт нүүрсний экспортын хэмжээ 18.3 сая тонн хүрсэн бол тус замыг ашиглан 5.2 сая тонн нүүрс тээвэрлэсэн байна. Ухаахудаг-Гашуунсүхайт чиглэлд “Говийн зам” ХХК-ийн барьсан авто зам, “Энержи ресурс” ХХК-ийн барьсан Гашуунсүхайт боомтын дэд бүтцийг төрийн өмчит “Эрдэнэс МГЛ” ХХК-ийн мэдэлд шилжүүлэх Засгийн газрын 2013 оны 299 дүгээр тогтоол гарсан.

### **Барилгын арматурын үйлдвэрийн төсөл**

Төслийн зорилго нь төслийн үр дүнд UNF Electric Arc Furnace технологитой жилд 100 мянган тонн өндөр чанарын ган цувимал бүтээгдэхүүний үйлдвэр бий болох бөгөөд Монгол улсад төмрийн хүдрийг бүрэн боловсруулан эцсийн ган бүтээгдэхүүн үйлдвэрлэх металлургийн цогцолбор үйлдвэр шинээр бий болно.

“Бэрэн групп” ХХК нь “Барилгын арматурын үйлдвэр”-ийн тоног төхөөрөмжүүдийг Сингапур улсын FABER компаниас худалдан авахаар гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний дагуу туслах тоног төхөөрөмжийн төлбөрийн 80 хувь, үндсэн тоног төхөөрөмжийн төлбөрийн 20 хувийг хэсэгчлэн санхүүжүүлэхээр шийдвэрлэж, холбогдох гэрээнүүдийг байгуулан, туслах тоног төхөөрөмжийн гэрээний дагуу 80 хувь болох 17.7 сая ам.долларыг 2 үе шаттайгаар олгосон.

### **Байшин үйлдвэрлэх комбинат**

Төслийн зорилго нь УИХ-ын 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, Засгийн Газрын 2014 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан

"Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор иргэдийг хямд орон сууцаар хангахад чиглэгдсэн.

Засгийн Газрын 2014 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 113 дугаар тогтоолыг үндэслэж, 2014 оны 4 дүгээр сард Герман улсын Коммерц банкнаас 13,115,000.0 еврогийн зээл авах гэрээг байгуулсан. Тус ажлын хүрээнд "Эрэл" ХХК-тай зээлийн болон холбогдох гэрээнүүдийг байгуулж, 2014 оны 5 дугаар сард 12,145,000.0 еврогийн аккредитивийн эрхийг нээж, үүрэг хүлээсэн болно. Энэхүү санхүүжилтийн хүрээнд Коммерц банкны ирүүлсэн мэдэгдлийн дагуу 11.0 сая еврогийн зээл буюу нийт зээлийн 84%-ийг "Эрэл" ХХК-д олгосон байна.

Мөн уг төслийн хүрээнд "Байшин үйлдвэрлэх комбинат-1" төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 14.0 сая хүртэлх ам.доллартай тэнцэх төгрөгийг Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. "Эрэл" ХХК-д Европын стандартад нийцсэн Герман улсын Байшин үйлдвэрлэх комбинат байгуулахад зориулж 14.0 сая ам.долларын зээлийг 96 сарын хугацаатай, жилийн 8 хувийн хүүтэй олгосон.

### **Монцемент төсөл**

Төслийн зорилго нь Жилд 1.0 сая тонн цемент үйлдвэрлэх үйлдвэрийг дэд бүтцийн хамт барих. "Монполимет" ХХК болон түүний охин компани "Сэнжсант" ХХК-ийн хэрэгжүүлж буй "Монцемент" төслийн цементийн үйлдвэрийг түлхүүр хүлээлгэн өгөх нөхцөлөөр, олон улсын стандартын дагуу барьж байгуулах гүйцэтгэгчээр Швейцарь улсын Holcim Групптэй хамтарсан БНХАУ-ын Хуашин цемент компани сонгогдон ажиллаж байгаа. "Хуашин Цемент" ХХК нь цементийн үйлдвэрийн зураг төсөл, тоног төхөөрөмж үйлдвэрлэл, нийлүүлэлт, барилгын болон тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтын ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд цементийн шугам 100%, чулуунцарын шугам 90%, дэд бүтэц 100%, нийт барилгын ажил 94%-ийн гүйцэтгэлтэй байна. Үйлдвэрийн цементийн шугамыг ашиглалтанд оруулж, 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдөр нээлтээ хийсэн.

### **3.7.8 ОРОН НУТАГТ ХИЙГДЭЖ БУЙ ТӨЛБӨР (ШААРДЛАГА 4.6)**

Бид нэгтгэлд хамрагдсан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдээс орон нутгийн хэмжээнд хийгдсэн төлбөрийн мэдээллийг нэмэлт мэдээллийн маягтаар ирүүлэхийг хүссэн. 2015 онд орон нутгийн хэмжээний төлбөрийн мэдээлэл дараах байдалтай байна. Үүнд:

ААН-ийн нэр	Хэнд төлсөн	Төлбөрийн утга	Дүн (сая төгрөгөөр)
Баянтээг ХК	Өвөрхангай аймгийн, Нарийтээл сум, Татварын алба	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	12
	Өвөрхангай аймгийн, Нарийтээл сум, Татварын алба	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	2
	Өвөрхангай аймгийн, Нарийтээл сум, Татварын алба	Газрын төлбөр	2
	Өвөрхангай аймгийн, Нарийтээл сум, Татварын алба	Ус ашигласны төлбөр	1
	Өвөрхангай аймгийн ЗДТГ	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	16

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

ААН-ийн нэр	Хэнд төлсөн	Төлбөрийн утга	Дүн (сая төгрөгөөр)
		<b>Дүн</b>	<b>33</b>
Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК	Дархан татварын хэлтэс	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	7
	Дархан татварын хэлтэс	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	38
	Дархан татварын хэлтэс	Газрын төлбөр	62
	Дархан татварын хэлтэс	Ус ашигласны төлбөр	7
	Дархан татварын хэлтэс	Бусад	25
		<b>Дүн</b>	<b>138</b>
Могойн гол ХК	Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	10
	Хөвсгөл аймаг Татварын хэлтэс	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1
	Хөвсгөл аймаг Татварын хэлтэс	Газрын төлбөр	3
	Хөвсгөл аймаг Татварын хэлтэс	Ус ашигласны төлбөр	0
	Хөвсгөл аймгийн орон нутгийн төрийн өмчийн алба	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	2
	Хөвсгөл аймгийн ЗДТГ	Нөхөн төлбөр	1
		<b>Дүн</b>	<b>17</b>
Монголросцвет мет ХХК	Хэнтий аймгийн болон БЗД-ийн татварын хэлтэс	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	51
	Хэнтий аймгийн болон БЗД-ийн татварын хэлтэс	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	11
	Хэнтий, Дорноговь, Төв болон НӨХГазар	Газрын төлбөр	30
	Хэнтий, Дорноговь аймаг	Ус ашигласны төлбөр	220
	Хэнтий аймаг	Бусад	5
		<b>Дүн</b>	<b>318</b>
Оюу Толгой ХХК	БЗД-ийн Татварын хэлтэс, Өмнөговь аймаг Ханбогд сум	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	9,165
	СБД-ийн Татварын хэлтэс, Өмнөговь аймаг Ханбогд сум	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	43
	Өмнөговь аймгийн Татварын хэлтэс, Ханбогд сум	Газрын төлбөр	1,849
	Өмнөговь аймаг Ханбогд сум	Ус ашигласны төлбөр	12,692
	ХУД-ийн Татварын хэлтэс	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	399
	МХЕГ	Торгууль	1
	СБД, ХУД, ЧД-ийн Татварын хэлтэс	Бусад	2
		<b>Дүн</b>	<b>24,151</b>
Тавантолгой ХК	Өмнөговь аймаг Татварын хэлтэс	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	24
	Өмнөговь аймаг Татварын хэлтэс	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1
	Өмнөговь аймаг Татварын хэлтэс	Газрын төлбөр	59
	Өмнөговь аймаг Татварын хэлтэс	Ус ашигласны төлбөр	29
	Өмнөговь аймаг ЗДТГ	Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	1,537
	Өмнөговь аймаг МХЕГ	Торгууль	0
		<b>Дүн</b>	<b>1,651</b>
Шивээ-Овоо ХК	Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	74
	Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	2



ААН-ийн нэр	Хэнд төлсөн	Төлбөрийн утга	Дүн (сая төгрөгөөр)
	Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс	Газрын төлбөр	3
	Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс	Ус ашигласны төлбөр	520
	Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэс	Бусад	200
		<b>Дүн</b>	<b>801</b>
Эрдэнэс Монгол ХХК	Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1
		<b>Дүн</b>	<b>1</b>
Эрдэнэс Таван толгой ХК	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын татварын хэлтэс	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	49
	Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	5
	Өмнөговь аймгийн татварын хэлтэс	Газрын төлбөр	237
	Өмнөговь аймгийн татварын хэлтэс	Ус ашигласны төлбөр	55
	<b>Дүн</b>	<b>347</b>	
Эрдэнэт үйлдвэр ХХК	Орхон аймгийн ЗДТГ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,316
	Орхон аймгийн ЗДТГ, БЗД-ийн татварын хэлтэс	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	55
	Орхон, Булган аймгийн ЗДТГ, НӨХГазар	Газрын төлбөр	7,978
	Орхон аймгийн ЗДТГ	Ус ашигласны төлбөр	10,126
	Булган аймгийн ЗДТГ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	44
	<b>Дүн</b>	<b>22,519</b>	

### 3.7.9 ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАЙ АДИЛ ТӨСТЭЙ ТӨЛБӨР (ШААРДЛАГА 6.2)

Стандартын шаардлагын дагуу төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрт төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хүлээн зөвшөөрсөн нийтийн нийгмийн хөрөнгө оруулалт, тухайлбал нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, түлшний татаас, засгийн газрын өрийн төлбөр гэх мэт улсын төсвөөс гадуурх зардлууд ордог.

Компаниуд төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрийн мэдээлэл байхгүй гэсэн эсвэл хариу ирүүлээгүй.

## 3.8 ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ БОЛОН ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТ

### 3.8.1 ЕРӨНХИЙ

#### 3.8.1.1 Төсвийн орлогын бүрдүүлэлт

Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд улсын ба орон нутгийн төсөвт нийт 20 гаруй татвар, төлбөр, хураамжийг төвлөрүүлдэг. Тэдгээрийг Төсвийн тухай хуулинд тусгайлан тусгасан байдаг.

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Монгол Улсын Төсвийн тухай хууль нь анх 1992 оны 12 сарын 21-нд батлагдаж, 2002, 2011 шинэчлэгдсэн. 2011 оны 12 сарын 23-нд батлагдсан Төсвийн тухай хууль нь 2013 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.

Улсын болон орон нутгийн төсвийн орлогын бүрдэлтийг хүснэгтээр харуулбал:

Улсын төсвийн орлого	Орон нутгийн төсвийн орлого		
	Аймаг/нийслэлийн төсвийн орлого	Сум/дүүргийн төсвийн орлого	
<b>Татварын орлого</b>			
Орлогын болон хөрөнгийн татварууд	<ul style="list-style-type: none"> <li>- ААНОАТ</li> <li>- НӨАТ</li> <li>- Гаалийн албан татвар</li> <li>- Онцгой албан татвар</li> <li>- МУ-д зорчих гадаадын иргэнд виз олгоход авах тэмдэгтийн хураамж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох албан татвар</li> <li>- Хотын албан татвар</li> <li>- Үл хөдлөх эд хөрөнгийн татвар</li> <li>- Өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар</li> <li>- Улсын тэмдэгтийн хураамж (УТХ тухай хуулийн 11.2-оос бусад)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар</li> <li>- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-ээс бусад орлогод ногдох татвар (хөрөнгө борлуулсны, бооцоот тоглоом, түрээсийн орлого г.м)</li> <li>- Улсын тэмдэгтийн хураамж (УТХ тухай хуулийн 11.2-оос бусад)</li> </ul>
Эрдэс баялагийн татварууд	<ul style="list-style-type: none"> <li>- АМНАТ /100%/</li> <li>- Газрын тосны нөөц ашигласны төлбөр /70%/</li> <li>- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр (хайгуул, ашиглалт) /100%/</li> <li>- Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөр (хайгуул, ашиглалт) /70%/</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөр (хайгуул, ашиглалт) /20%/</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөр (хайгуул, ашиглалт) (10%)</li> <li>- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр</li> </ul>
Байгалийн бусад баялгийн татвар, төлбөрүүд	<ul style="list-style-type: none"> <li>- Ус бохирдуулсны төлбөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүн амын унд, ахуйн хэрэгцээний зориулалтаар ус, рашаан ашигласны төлбөр</li> <li>- Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж</li> <li>- Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж</li> <li>- Байгалийн ургамал ашигласны төлбөр</li> <li>- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр</li> </ul>
Байгаль орчинтой холбоотой татварууд	<ul style="list-style-type: none"> <li>- Автобензин, дизелийн түлшний албан татвар</li> <li>- Агаарын бохирдлын төлбөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар</li> <li>- Газрын төлбөр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хог хаягдлын үйлчилгээний хураамж</li> <li>- Галт зэвсгийн албан татвар</li> </ul>
<b>Татварын бус орлого</b>			
	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Хүний хөгжил сангийн тухай хуулийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг</li> <li>- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого</li> <li>- 3. Хууль тогтоомжийн дагуу аймаг/нийслэлийн (сум/дүүргийн)</li> </ul>	

Улсын төсвийн орлого		Орон нутгийн төсвийн орлого	
		Аймаг/нийслэлийн төсвийн орлого	Сум/дүүргийн төсвийн орлого
	3.2.1-д зааснаас бусад төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг - Төрийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого - Хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх бусад орлого	төсөвт төвлөрүүлэх бусад орлого	

Эх сурвалж: Төсвийн тухай хууль, Олборлох үйлдвэрлэлийн орлогын менежмент, Гэрээг Партнерс ХХК, 2016

2010-2015 оны Эрдэс баялгийн татвараар Улсын төсөвт төвлөрсөн орлогуудыг Сангийн яамны төсвийн мэдээнд тусгагдсанаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(тэрбум төгрөгөөр)

Орлогын төрөл	2010	2011	2012	2013	2014	2015
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	20.6	26.9	28.2	38.9	44.3	40.1
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	-	-	-	139.3	173.3	183.1
Газрын тосны орлого	54.7	75.9	108.4	187.7	285.6	164.3

Эх сурвалж: СЯ

Төсвийн тухай хуулийн дагуу 2013 он хүртэл АМНАТ нь орон нутагт хуваарилагддаг байсан учир 2010-2012 онуудад орлого бүртгэгдээгүй байна.

### 3.8.1.2 Олборлох үйлдвэрлэлийн орлогын төвлөрөл болон хуваарилалт

Төсвийн орлого талаасаа олборлох салбарыг эдийн засгийн бусад салбараас онцгойруулдаг тусгай татвар, төлбөрт ашиг малтмалын нөөц ашигласны төлбөр /АМНАТ/, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн болон газрын тосны орлого багтдаг. Зөвхөн олборлох үйлдвэрлэлээс л бүрэлддэг эдгээр орлогоор Хүний хөгжлийн сан, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан зэрэг тодорхой сангуудыг санхүүжүүлэхээр хуульчилсан байдаг тул юунд, хэрхэн зарцуулагдаж байгааг ямар нэг хэмжээнд мэдэх, хянах боломж бий. Иймд эдгээр сангийн зарцуулалт, ялангуяа ОНХНС-гийн хөрөнгийн зарцуулалтыг судалж, шалгадаг<sup>32</sup>.

Харин Улсын төсөвт төвлөрдөг ОУ-ийн орлогын чамгүй хэсгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), гаалийн татвар болон БХГ-ний дагуу ЗГ-т ногдох газрын тосны орлого бүрдүүлдэг. Гэвч, эдгээр орлогыг бусад салбараас бүрдэж буй ижил нэр төрлийн орлогоос салгаж ялгах, ямар төрлийн орлогоор ямар зардлыг санхүүжүүлэхийг тодорхойлох боломж, тодруулж заасан хуулийн зохицуулалт, дүрэм журам байдаггүй. Иймд олборлох салбараас улсын эсвэл орон нутгийн төсөвт төвлөрсөн орлого нь бусад төрлийн татвар, төлбөр, хураамжтай нийлж улсын төрийн сангийн “том тогоонд” төвлөрөөд, нэгдсэн журмаар зарцуулагддаг тул, зарцуулалтыг ОУ-ийн болон ОУ-ийн бус гэж орлогын төрлөөр ангилж тайлагнахад хүндрэлтэй, ихэнх тохиолдолд боломжгүй байдаг (СЯ; ТБТГ, 2015).

<sup>32</sup>Олборлох үйлдвэрлэлийн орлогын менежмент, Гэрээг Партнерс ХХК, 2016

Эрдэс баялгийн татварууд болох АМНАТ, Газрын тосны нөөц ашигласны төлбөр, Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр (хайгуул, ашиглалт), Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөр (хайгуул, ашиглалт) зэргийн хуваарилалтыг Төсвийн тухай хуулийн 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн нэмэлт өөрчлөлтийн дагуу харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- **Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын хуваарилалт дараах байдалтай байна:**



\*Улсын төсвийн 30%-ийг дотор нь Мега буюу томоохон төслүүд, Эрдэнэт, Оюутолгой, Тавантолгойн гэх мэт ордын АМНАТ-ийг улсын төсөвт 100% үлдээгээд бусад уурхайнуудаас орж ирсэн АМНАТ-ийг 70%, 20%, 10% гэж хуваана. 70% нь улсын төсөвт, 20% нь аймгийн Орон нутгийн хөгжлийн санд, 10% нь сумын Орон нутгийн хөгжлийн санд төвлөрнө. Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан руу шилжүүлэхдээ тухайн орон нутагт хийж буй олборлолтын хэмжээг харгалзан үздэг.

Төсвийн тухай хуулийн 2015 оны 5 дугаар сарын 21-ний нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн 60.5 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн хөгжлийн сан нь энэ хуулийн 60.2.6-д заасан орлогын 33-аас доошгүй хувийг ашигт малтмалын олборлолт хийсэн сум, дүүргийн хөгжлийн санд олгоно” гэсэн нэмэлт оруулсан.


- **Газрын тосны нөөц ашигласны төлбөр**



- **Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр**



- **Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр**




### 3.8.1.3 Олборлох салбараас орж ирсэн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж бүртгээгээгүй тохиолдол (Шаардлага 5)

Бид улсын төсөвт бүртгээгүй байж болох орлогын мэдээлэл, ирээдүйд авах татварыг урьдчилан авчигсан боловч өрөөр гэж бүртгэсэн байж болох мэдээллийг ирүүлэхийг Сангийн яамнаас хүссэн. Бидэнд ирүүлсэн мэдээллээр “Оюутолгой” ХХК-иас татварын урьдчилгаанд авсан 250.0 сая ам.долларын төлбөрөөс 2015 оны эцэст 20.8 сая ам.доллар буюу 41.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн 2015 онд Эрдэнэс Тавантолгойн компаниас татварын урьдчилгаа 416.1 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулж дууссан.

### 3.8.1.4 Орлогын тогтвортой байдал, байгалийн баялагаас хамааралтай байдал (Шаардлага 5.3.в)

Ирээдүйд төсвийн мөчлөгт гарах өөрчлөлтүүдийн талаарх таамаглал, олборлох салбарын үйлдвэрлэлийн

хэмжээний талаарх төсөөлөл, ашигт малтмалын зах зээлийн үнийн төлөв байдал, олборлох салбараас орох орлогын хэмжээний тухай урьдчилсан тооцоо, олборлох салбарын орлогын улсан төсөвт эзлэх урьдчилан таамаглаж буй хувь хэмжээ зэрэг мэдээллийг



Сангийн яамнаас ирүүлэхийг хүссэн.



Манай улс зэсийн баяжмал, нүүрс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш зэрэг нийт 20 төрлийн эрдэс бүтээгдэхүүн экспортолдог. Эдгээр бүтээгдэхүүний экспортоос хамаарч улсын төсөвт төвлөрдөг орлого сүүлийн 5 жилд төсвийн орлогын 23 орчим хувийг эзэлж ирсэн бөгөөд 2011 онд 35 хувьд хүрч байсан нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч, 2016 онд сүүлийн 5 жилийн хамгийн бага түвшин буюу 14

хувьд хүрэх хандлагатай байна. Үүнээс үзэхэд уул уурхайн салбараас хамаарах төсвийн орлогын хамаарал жил ирэх тутам буурч байгаа эерэг дүр зураг ажиглагдаж байна.

Уул уурхайн салбараас 2017 онд нийт 1,004.4 тэрбум төгрөг төвлөрөхөөр байгаа нь 2015 оны гүйцэтгэлээс 11 хувиар буурахаар байгаа бол 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 35 хувиар өсөхөөр байна. Ирэх онд уул уурхайн салбарын орлого ийнхүү өсөхөд “Оюу толгой”, “Таван толгой”, “Гацуурт” төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлснээр нийт 195.1 тэрбум


МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

төгрөгийн орлогыг нэмж төвлөрүүлэхээр тооцсонтой холбоотой байна. Уул уурхайн салбараас 2017 онд төвлөрөх нийт орлогын 92 хувийг алт, зэс, нүүрсний орлогоос бүрдүүлэхээр байна. Үүнээс: 22 хувийг буюу 226 тэрбум төгрөгийг нүүрс, 63 хувийг буюу 638 тэрбум төгрөгийг зэсийн баяжмалын экспортоос төвлөрүүлэхээр байна.


№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Биет хэмжээ	2017 оны төлөвлөгөө /тэрбум төгрөгөөр/					
			ААНОАТ	АМНАТ	Ногдол ашиг	Бусад татвар	Гаалийн хураамж	Нийт
1	Алт /тн/, дотоодод	14.8	8.4	28.5	-	19.2	-	56.0
	Нүүрс /сая тн/	31.3	27.5	61.3	-	102.2	34.6	225.5
2	Экспортын нүүрс	23.0		56.9	-		34.6	
	Дотоодын нүүрс	8.3		4.4	-		-	
3	Зэсийн баяжмал /мян.тонн/, дагалдах эрдсүүд орсон	1,500.0	72.8	183.8	6.9	372.0	2.3	<b>637.7</b>
4	Цайрын баяжмал /мян.тонн/	80.0	3.4	7.8	-	2.1	0.1	<b>13.4</b>
5	Төмрийн хүдэр /сая.тонн/	6.0	1.7	21.2	-	4.7	9.0	<b>36.6</b>
6	Бусад		1.9	14.7	-	18.1	0.41	<b>17.1</b>
<b>НИЙТ ДҮН</b>			<b>115.7</b>	<b>317.3</b>	<b>6.9</b>	<b>518.2</b>	<b>46.3</b>	<b>1,004.4</b>

Нийт уул уурхайн орлогод нүүрсний орлогын эзлэх хувь 2011 онд 35 хувь байсан бол энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд нүүрсний үнэ тасралтгүй буурсантай холбоотойгоор ирэх онд 22 хувьд хүрэхээр байна. Төсвийн орлогын томоохон эх үүсвэр болох зэсийн баяжмалын экспортоос төвлөрүүлэх орлого нь сүүлийн 5 жилд дунджаар нийт уул уурхайн орлогын 60 орчим хувийг бүрдүүлж иржээ. Зэсийн баяжмалын экспорт 2017 онд төдийлөн нэмэгдэхгүй бөгөөд зэсийн зах зээлийн үнээс хамаарч, ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт

**Нүүрсний орлого**



**Зэсийн орлого**



төлбөрийн орлого төсөвт төвлөрөхгүй байхаар

байна. Гэвч уул уурхайн томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажил эхлэхтэй холбогдуулан уул уурхайн салбарын орлого ирэх онд өсөх хандлагатай байна. *Эх сурвалж: Сангийн яам*

“Оюу толгой” ХХК 2017 онд 850 мянган тонн зэсийн баяжмал үйлдвэрлэн борлуулж, төсөвт нийт 462.3 тэрбум төгрөгийн татвар төлөхөөр байгаа бол “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь 650 мянган

тонн зэсийн баяжмал, 4,219 тонн молибдены баяжмал олборлож, төсөвт 175.4 орчим тэрбум төгрөгийн татвар, ногдол ашгийн орлогыг төвлөрүүлэхээр тооцлоо.

“Оюу толгой”, “Таван толгой”, “Гацуурт”-ын төслийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхтэй холбоотойгоор нийт орлогод эзлэх үүл уурхайн салбарын орлогын хувь 2017 онд дунджаар 17 орчим хувьд хүрнэ гэж таамаглаж байна.

### 3.8.2 ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН (ШААРДЛАГА 5.2)

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгө юм.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын эх үүсвэр нь:

- импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 5 хувь /энэ заалтыг 2015.11.10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулж, 2016.09.09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан. 2017.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/
- ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 5 хувь
- орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бүс байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив
- газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогын 30 хувь.

Хот, дүүрэг, аймаг, сум болгон өөрийн хөгжлийн сантай байх бөгөөд эдгээрийг орон нутгийн хөгжлийн сан гэнэ.

Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн орлогын эх үүсвэр нь:

- орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;
- энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө
- татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр
- тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж.
- ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь /Энэ заалтыг 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар нэмсэн/
- ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь



МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

2013 онд Сангийн яамнаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн системийг нэвтрүүлсэн. Уг системээс 2013 оноос хойших хугацааны орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хуваарилалтыг аймаг, нийслэл, сум, дүүргээр харах боломжтой<sup>33</sup>.

ОНХНС-гаас тухайн жилд орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59.3-т заасны дагуу, мөн ОНХНС болон ОНХС-гаас олгох шилжүүлэг тооцох аргачлал ёсоор дараах итгэлцүүрт үндэслэн тогтоодог. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн индекс – харгалзах хувийн жин 25 хувь;
- Хүн амын тоо – харгалзах хувийн жин 25 хувь;
- Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ – харгалзах хувийн жин 25 хувь;
- Орон нутгийн татварын идэвх санаачлага – харгалзах хувийн жин 25 хувь.

2015 онд ОНХНС-ийн олгохоор тооцсон нийт 105.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн 70.4 хувь буюу 77.6 тэрбум төгрөгийг дотоодын НӨАТ, 18.2 хувь буюу 19.4 тэрбум төгрөгийг АМНАТ, 5.9 хувь буюу 6.3 тэрбум төгрөгийг аймаг, нийслэлээс төвлөрүүлсэн орлогын дахин хуваарилалт, 5.5 хувь буюу 5.9 тэрбум төгрөгийг газрын тосны НӨАТ-аас бүрдүүлсэн байна.

ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орогын шилжүүлэг 21.2 тэрбум төгрөгөөр дутуу олгогдсон нь аймаг, нийслэлээс төвлөрүүлж дахин хуваарилах орлогын төлөвлөгөө 40 хувь, газрын тосны НӨАТ-ын орлогын төлөвлөгөө 43 хувиар тасарсантай холбоотой.

Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

<i>Сая төгрөгөөр</i>				
№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Дотоод НӨАТ*25 хувь	72,783.0	82,456.5	113.3
2	АМНАТ*5 хувь	21,347.5	27,152.9	127.2
3	Аймаг нийслэлээс дахин хуваарилах	21,704.4	12,989.2	59.9
4	Газрын тосны НӨАТ*30 хувь	11,324.0	6,415.6	56.6
	Нийт	127,159.0	129,014.1	

Эх сурвалж: УАГ

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд 2015 онд олгосон шилжүүлгийн санхүүжилтийн мэдээг хүснэгтээр харуулбал:

<i>Сая төгрөгөөр</i>									
Аймгийн нэр	Өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-аас шилжүүлсэн санхүүжилт	Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	Хандив	Бусад	Нийт	ОН-ийн орлогын эзлэх хувь	Нийт эх үүсвэр
Архангай	787.9	4,189.9	-	111.3		47.9	159.2	3.07%	5,137.0
Баянхонгор	650.8	4,898.2	-		50.0	392.1	442.1	7.38%	5,991.1
Баян-Өлгий	158.8	3,816.3	-			431.6	431.6	9.79%	4,406.7
Булган	1,802.7	3,588.9	-		257.7	-	257.7	4.56%	5,649.3
Говь-Алтай	1,285.8	4,732.1	-		134.9	44.9	179.8	2.88%	6,197.7
Говьсүмбэр	86.9	2,721.1	887.6	200.0	9.0	-	1,096.6	28.02%	3,904.6
Дархан-Уул	192.4	3,535.5	-		5.9	-	5.9	0.16%	3,733.8
Дорнод	144.9	4,282.9	204.9		-	-	204.9	4.42%	4,632.7
Дорноговь	64.2	3,935.7	167.8		-	-	167.8	4.03%	4,167.7

<sup>33</sup> <http://www.tusuv-oronnutag.mn/>



МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Аймгийн нэр	Өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-аас шилжүүлсэн санхүүжилт	Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	Хандив	Бусад	Нийт	ОН-ийн орлогын эзлэх хувь	Нийт эх үүсвэр
Дундговь	2,372.7	3,777.8	2,444.7		68.5	33.8	2,547.0	29.28%	8,697.5
Завхан	737.1	4,006.8	340.0	8.1	7.1	-	355.2	6.97%	5,099.1
Орхон	-	3,812.3	978.0		583.8	-	1,561.8	26.21%	5,374.1
Өвөрхангай	398.7	4,615.8	-		-	10.0	10.0	0.20%	5,024.5
Өмнөговь	1,403.1	4,674.9	2,252.0	8,379.5	185.5	-	10,817.0	64.02%	16,895.0
Төв	916.2	3,817.1	-		0.7	778.7	779.4	14.14%	5,512.7
Ховд	162.5	4,338.4	-		120.8	33.9	154.7	3.32%	4,655.6
Хөвсгөл	15.3	4,573.2	-	135.5	-	1,233.7	1,369.2	22.98%	5,957.7
Хэнтий	31.7	4,094.8	647.1	25.7	73.7	130.1	876.6	16.60%	5,003.1
Сүхбаатар	31.4	4,012.4	233.6	1,474.5	1,655.0	870.7	4,233.8	51.15%	8,277.6
Сэлэнгэ	346.2	3,709.6	-	-	-	2.0	2.0	0.05%	4,057.8
Увс	240.8	3,890.9	-	-	559.0	576.6	1,135.6	21.56%	5,267.3
Улаанбаатар	4,619.3	20,960.0	-	-	-	-	-	0.00%	25,579.3
<b>Нийт дүн</b>	<b>16,449.4</b>	<b>105,984.6</b>	<b>8,155.7</b>	<b>10,334.6</b>	<b>3,711.6</b>	<b>4,586.0</b>	<b>26,787.9</b>		<b>149,221.9</b>

Эх сурвалж: УАГ-ын 2015 оны аудитын тайлан

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал:

Аймгийн нэр	Төлөвлөсөн ажил		Худалдан авах ажиллагааны журам /тоогоор/				
	Өмнөх оноос шилжсэн	Шинэ оны ажил	НТШ	ХТШ, ОНОХА	ХА	ШГБ	ХАА зохион байгуулагүй
Архангай	66	149	9	0	39	58	43
Баянхонгор	180	119	8	0	13	98	0
Баян-Өлгий	107	260	5	0	34	184	37
Булган	13	213	14	0	68	103	28
Говь-Алтай	51	229	27	26	27	121	28
Говьсүмбэр	50	82	8	1	9	53	11
Дархан-Уул	76	27	8	0	6	13	0
Дорнод	0	62	7	6	25	18	6
Дорноговь	0	110	10	3	29	68	0
Дундговь	49	161	15	20	43	83	0
Завхан	18	327	31	2	19	227	48
Орхон	36	65	4	0	35	26	0
Өвөрхангай	121	157	10	0	60	87	0
Өмнөговь	65	152	38	1	31	56	26
Төв	48	233	3	0	65	142	23
Ховд	99	226	20	2	61	143	0
Хөвсгөл	35	185	10	0	64	111	0
Хэнтий	73	263	11	0	37	177	38
Сүхбаатар	86	111	10	0	14	87	0
Сэлэнгэ	102	115	7	0	52	27	29
Увс	83	192	5	0	107	27	53

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Аймгийн нэр	Төлөвлөсөн ажил		Худалдан авах ажиллагааны журам /тоогоор/				
	Өмнөх оноос шилжсэн	Шинэ оны ажил	НТШ	ХТШ, ОНОХА	ХА	ШГБ	ХАА зохион байгуулаагүй
Улаанбаатар	77	354	43	85	125	40	61
<b>Нийт дүн</b>	<b>1435</b>	<b>3792</b>	<b>303</b>	<b>146</b>	<b>963</b>	<b>1949</b>	<b>431</b>

Эх сурвалж: УАГ-ын 2015 оны аудитын тайлан

УАГ нь 2016 онд ОНХС-ийн хөрөнгийн 2015 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийсэн.

Аудитын тайлангаар ОНХС-ийн төвлөрөл, түүний зарцуулалттай холбогдож дараах бүлэг үл нийцэл олж илрүүлсэн байна. Үүнд:

- ОНХС-ийн орлогыг хуульд заасан нэр төрөл бүрээр төлөвлөж, хуваарилаагүй байна.
- ОНХС-ийн орлогын шилжүүлгээс бусад эх үүсвэрийг хуульд заасан нэр төрлөөр бүрдүүлээгүй, орлого нэмэгдүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийт 47.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн нь нийт санхүүжүүлсэн хөрөнгийн 35.8 хувийг эзэлж байгаа бөгөөд 0.5 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 32.6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 14.8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг өгсөн байна.

### **3.8.3 ХҮНИЙ ХӨГЖЛИЙН САН**

Монгол Улсын ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэдэд тэгш хүртээхтэй холбоотой нийгмийн харилцааг зохицуулах зорилгоор “Хүний хөгжил сангийн тухай” хуулийг 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр батласан.

Уг хуулийн 18, 19 дүгээр зүйлийг 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс, бусад зүйлийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосон.

Хүний Хөгжил Сангийн орлого дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого;
- ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь;
- дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээрх үнэт цаас, өрийн бичиг, хадгаламжаарх хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашиг (2016.01.29-ний хуулиар хүчингүй болсон)

Уг сангаас Монгол Улсын иргэн дараах хэлбэрээс сонгон хишиг, хувь хүртэх зохицуулалттай:

- Тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр;
- Орон сууц худалдаж авсны төлбөр;

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

- Бэлэн мөнгө;
- Эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөр;
- Хүүхдийн мөнгө.

Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж, хяналт тавьдаг. Хуулинд хүний хөгжлийн санд олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлтийг Улсын их хуралд танилцуулна гэж заасан боловч тийм аудитын тайлан олдоогүй, аудит хийгдээгүй байна.

Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд<sup>34</sup> зааснаар хүний хөгжил сангийн 2015 оны төсөвт 2015 оны төсвийн жилд 357 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 329 тэрбум төгрөгийн зарлагыг баталсан байна. Мөн Хүний хөгжил сангийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтаар нийт 3 тэрбум төгрөгийг Улаанбаатар, Баянгол дүүрэг, Архангай, Хайрхан сумын хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсийн барилга, тоног төхөөрөмжийн худалдан авалтанд төсөвлөсөн байна.

Үндэсний аудитын газрын Хүний хөгжил сангийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайланд<sup>35</sup> дурьдсанаар Хүний хөгжил сангийн санхүүгийн тайлангаар урсгал зардалд 328.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан бөгөөд 308.4 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, хүүхдийн мөнгө 20.4 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Дээрх санхүүжилт 2016 оны 1 дүгээр сард олгогдсон байна.

2010-2015 оны Хүний хөгжил сангийн орлого, зарлагыг хүснэгтээр харуулбал:

(тэрбум төгрөгөөр)

	2010	2011	2012	2013	2014	2015*	Нийт
Орлого	158	314	441	394	427	423	2,157
<i>Үүнээс: АМНАТ-ын орлого</i>	117	138	216	196	288	331	1,286
Зарлага	(316)	(804)	(849)	(278)	(313)	(310)	(2,870)
Зөрүү	(158)	(490)	(408)	116	114	113	(713)

Эх сурвалж: 2010-2014 УСГ, 2015 УАГ-ын аудитын тайлан

Тус сангийн орлогын үндсэн эх сурвалжийн нэг нь АМНАТ-ын орлогын 65 хувь байдаг. Сангийн нийт орлого, үүн дотроо АМНАТ-ын орлого болон нийт зарлагын дүнг харьцуулвал тус орлого нийт орлогын дийлэнхийг бүрдүүлж байна.

Хүний хөгжил сангийн 2015 оны зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

тэрбум төгрөг

Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Нийт зарлагын дүн</b>	<b>328.8</b>	<b>308.4</b>	<b>-20.4</b>
1 Төр хариуцах ЭМНДШ	12	12	-
2 Иргэдэд олгох бэлэн мөнгө (Хүүхдийн мөнгө)	246	225.7	-20.3
3 ЗГ-ын бонд болон урьдчилгаа төлбөрийн хүүгийн зардал	67.4	67.3	-0.1
4 Хөрөнгө оруулалт	3.3	3.3	-
5 Бусад зардал	-	0.2	-

<sup>34</sup> Эх сурвалж: <http://legalinfo.mn/law/details/10754?lawid=10754>

<sup>35</sup> Эх сурвалж: <http://www.audit.mn/wp-content/uploads/2016/08/HVNII-HOGJIL-SANGIIN-OSOV.pdf>

Эх үүсвэр: Сангийн яам

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан 16 хүртэлх насны хүүхэд, өндөр насны тэтгэвэр авагч, хүүхдээ асарч буй эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хугацаат цэргийн албан хаагч, халамжийн тэтгэвэр авагч, их, дээд сургуулийн өдрийн ангийн суралцагчид зэрэг нийт 1.5 сая иргэдийн төрөөс хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөрт 12.0 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Тайлант онд 0-18 насны 1,027.6 мянган хүүхдэд сар бүр олгох 20.0 мянган төгрөгийн тэтгэмжид ХХС-аас нийт 225.7 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүний хөгжил сангийн төсвийн дутагдлыг нөхөх, өрийг дахин санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны хүүгийн төлбөрт 67.3 тэрбум төгрөг төлж, 2015 оны эцсийн байдлаар 486.5 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэлтэй байна.

#### **3.8.4 ИРЭЭДҮЙН ӨВ САН**

Энэхүү ОУИТБС-ын тайлан нь хэдийгээр 2015 оны олборлох үйлдвэрлэлийн талаар боловч бидний нэгтгэлийг хийх явцад мэдэгдэж байгаа 2016 оны мэдээллийг мөн багтаасан. Ирээдүйн өв сангийн тухай<sup>36</sup> хуулийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсанаар Хүний хөгжлийн санг татан буулгасан.

Тус хуульд зааснаар энэхүү сан нь нийт ард түмний өмч байх бөгөөд орлого, эх үүсвэр, хуримтлалын хувьд улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байхаар тусгасан. Хуулийн үйлчлэлийн хүрээнд байгуулагдах “Ирээдүйн өв сан корпораци” нь сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлнэ. Энэ нь 100 хувь Төрийн өмчит хуулийн этгээд байна гэж хуульд заасан. Энэхүү корпораци нь хөрөнгө оруулах шийдвэрийг бусад байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар, бие даан гаргана.

Ирээдүйн өв сангийн эх үүсвэр дараах орлогоос бүрдэнэ:

- Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг,
- Төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь
- Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр орлогоос энэ хуулийн 9.6-д заасны дагуу шилжүүлсний дараа Санд үлдэх хэсэг
- Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, шинээр хууль батлах замаар татвар бий болгох, татварын хувь, хэмжээг өөрчилсөн тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.7-д заасан ашигт малтмал ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдээс улсын төсөвт орох нэмэлт орлогын 50 хувь;
- 2018 оноос эхлэн тухайн жил улсын төсөвт орох энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4-т зааснаас бусад эрдэс баялгийн орлогын суурь жилийн орлогын гүйцэтгэлээс давсан хэсгийн 20 хувь.

<sup>36</sup> Эх сурвалж: <http://legalinfo.mn/law/details/11707?lawid=11707>


Сангийн эх үүсвэр, хөрөнгөөс 2030 он хүртэл зарцуулахыг хориглоно. Өөрөөр хэлбэл үйл ажиллагаа, хяналттай холбоотой зардлаас бусад хэлбэрээр ямар нэг зарцуулалт хийхгүй. Мөн Сангийн хөрөнгийг зөвхөн олон улсын санхүүгийн зах зээлд гаргасан гадаад улсын нутаг дэвсгэрт арилжаалагдаж байгаа хөрөнгө оруулах хэрэгсэлд байршуулна гэж хуулийн 12.1.5-д заасан.

### 3.8.5 ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 16 дугаар зүйлийн 16.1, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2.1 дэх заалтын дагуу гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого болон нэгдсэн төсвийн суурь орлогоос давсан хэсгийг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлж байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасны дагуу 2015 оны нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх зэс, нүүрсийг гол нэр төрлийн эрдэс баялгаар тодорхойлсон.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялаг зэс, нүүрсний 2015 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан өмнөх 12 жилийн үнийн дундаж болон тухайн төсвийн жил, түүний дараахь 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцсон.

Эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасны зарчмын дагуу олон улсад нийтлэг хэрэглэдэг “Bloomberg” мэдээллийн эх сурвалжаас авч ашиглаж 2015 онд нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6,354.7 ам.доллар, баяжуулсан нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 82.5 ам.доллар байхаар тус тус тооцож, зэсийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын санд 29.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, 2015 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн төсвийн тодотголоор 2.3 тэрбум төгрөг болгон бүүрүүлсэн. Харин нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ 2015 оны төсвийн жилд зах зээлийн үнийн таамаглалаас давсан тул тогтворжуулалтын санд нүүрснээс орлого төвлөрөхгүй байхаар тооцсон болно.



Эх сурвалж: СЯ

Зэсийн зах зээлийн үнийн гүйцэтгэл 2015 оны турш тэнцвэржүүлсэн үнээс доогуур байсан тул Төсвийн тогтворжуулалтын санд орлого төвлөрөөгүй боловч 2014 оны зэсийн тэнцвэржүүлсэн болон зах зээлийн үнийн зөрүүгээс бий болсон 2.3 тэрбум төгрөгийг 2015 оны 1 дүгээр сард Төсвийн тогтворжуулалтын санд оруулсан байна. Улмаар 2015 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр Төсвийн тогтворжуулалтын сангийн хуримтлал 314.5 тэрбум төгрөгт хүрсэн. Тус онд ямар нэгэн зарцуулалт хийгдээгүй байна.

### 3.9 БУСАД АСУУДЛУУД

#### 3.9.1 БЕНЕФИЦИАР ӨМЧЛӨГЧ (ШААРДЛАГА 2.5)

##### 3.9.1.1 ОУИТБС-ын шаардлага

ОУИТБС-ын стандарт 2.5-д дараах асуудлуудыг онцолсон. Үүнд:

- ОУИТБС-ын тайланд бенефициар өмчлөлийг ил тод тайлагнах талаарх Засгийн газрын бодлого, мөн ОТАХ-ийн хэлэцүүлгийг баримтжуулан тусгасан байх;
- 2017 оны 01 сарын 01 гэхэд бенефициар өмчлөлийн мэдээллийг ил тод тайлагнах замын зургийг ОТАХ нийтэлсэн байх;
- 2020 оны 1 сарын 1 гэхэд бенефициар өмчлөлийн мэдээллийг ОУИТБС-ын тайланд оруулах эсвэл нийтийн бүртгэлд тусгах зорилгоор хэрэгжүүлэгч улс орнууд цуглуулж, компаниуд ил тод тайлагнах;
- ОУИТБС-ын тайланд хуулийн дагуу өмчлөгч, өмчлөх хувь хэмжээг мөн ил тод тайлагнах ёстой.

##### 3.9.1.2 Бенефициар өмчлөгчийн ил тод байдал

Монгол Улсад олборлох болон аливаа бусад салбар дахь компаниудын ашиг хүртэгч эзэд, эцсийн өмчлөгчийг нээлттэй болгох талаар батлан хэрэгжүүлж байгаа нэгдсэн бодлого байхгүй байна.<sup>37</sup>

Аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагч, өмчлөгчийн мэдээллийг Монголбанк, Татвар, Улсын бүртгэлийн газар, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг төрийн байгууллагууд бүртгэдэг боловч тэдгээр нь хоорондоо үялдаа холбоогүй, мэдээллийн эх үүсвэр нь албан ёсны биш, олон нийтэд зарлахад эрх зүйн зохицуулалтаар хаагдмал байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (20 дугаар зүйл)-ийн дагуу төрийн эрх бүхий байгууллага өөрийн эзэмшил дэх хувь хүний талаарх мэдээллээс эцэг/эхийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг болон ажлын үтаснаас бусад мэдээллийг тухайн хүний бичгэн зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглохоор заасан байна.

Бенефициар өмчлөгчийн мэдээллийг ил тод болгоход Хувь хүний нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль зэрэг хувь хүний мэдээллийн нууцлалыг хадгалах, задруулахыг хориглосон хууль тогтоомжууд нөлөөлж байна. Тухайлбал:

<sup>37</sup> Олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниудын “ашиг хүртэгч жинхэнэ эзэд”-ийн ил тод байдлыг хангах чиглэлээрх боломжит байдлын урьдчилсан судалгаа

- Байгууллагын нууцын тухай хуулийн дагуу тухайн байгууллагын албан үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор үршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно гэж заасан.
- Хувь хүний нууцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан доорх төрлийн нууц мэдээллийг хууль болон итгэмжлэлийн дагуу олж авсан этгээд бусдад задруулахыг хориглодог. Үүнд:
  - захидал харилцааны нууц;
  - эрүүл мэндийн нууц;
  - хөрөнгийн нууц;
  - гэр бүлийн нууц;
  - хуулиар тогтоосон бусад нууц

### **3.9.1.3 Монгол улсын хандлага**


2016 онд ОТАХ-ээс ашиг хүртэгч эзэд буюу бенефициар гэдэг ойлголт, түүний эрх зүйн орчин, боломж, сорилт, асуудал, ашиглаж болох тогтолцоо зэргийг судлах ажлын дэд хэсэг томилон, 2016.08.24-25-нд Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнтэй хамтраад сургалт зохион байгуулж, замын зураг буюу төлөвлөгөө гаргаж байна.

2013 оноос эхлэн үүл уурхай, газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй, ОУИТБ-ын тайлан гаргаж өгдөг компаниудын 5 болон түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг тодруулах асуулга хэрэглэж эхэлсэн. Нэгтгэл тайланд хамрагдсан 250 компанийн 215 нь өөрсдийн хувьцаа, хувьцаа эзэмшигчдийн талаар мэдээлэл өгч, бас нэлээд тохиолдолд бенефициар эзэмшигчдийнхээ талаар мэдээлэл өгсөн юм. 215 компанийн нийт 368 хувьцаа эзэмшигчийг тогтоосон бөгөөд тэдний 215 нь хувь хүмүүс, 144 нь аж ахуйн нэгж байгууллагын ажилтнууд, 13 нь төвийн болон орон нутгийн удирдах байгууллагын ажилтнууд байв.

2014 оны ОУИТБС-ын тайланд хувьцаа эзэмшлийн гурван түвшнийг судлахаар ОТАХ-тэй тохиролцсон юм. Эхний түвшинд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийн наад зах нь 5%-г, хоёр дахь түвшинд давуу эзэмшигчдийн наад зах нь 51%-н түвшнийг хамруулахаар болсон. 2014 онд нийт 236 компаниас 30 компани хувьцаа эзэмшигчдийн мэдээллээ ирүүлж, 6 компанийн эцсийн өмчлөгч ил тод болсон.

2015 оны нэгтгэл тайланд Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс ОТАХ-тэй зөвшилцсөний үндсэн дээр сонгогдсон компаниудаас хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны болон ашиг хүртэгч эздийн мэдээллийг ил тод болгохын тулд компаниудаас дараах алхамуудын дагуу мэдээллээ оруулах маягтыг цахим тайлагналын системд оруулсан. Үүнд:





Хараат бус хянагч-нэгтгэгч нь бенефициар өмчлөгч гэж юу болох, энэ ойлголттой холбоотой маягтыг хэрхэн бөглөх талаар сонгогдсон компаниудад Монголын ОУИТБС-ын Ажлын албатай хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулсан.

2015 оны хувьд бид нийт 202 компаниас дээр дурьдсан аргачлалаар бенефициар өмчлөгчдийн мэдээллийг хүссэн. Эдгээрээс 51 компани мэдээллээ ирүүлсэн бөгөөд ирүүлсэн хариуг хураангуйлан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Тодорхойлогдсон хувьцаа эзэмшигчид (хувь хүн)	26
Ил тод болгоогүй / ил тод болгохоос татгалзсан	9
Корпорацийн хувьцаа эзэмшигч, эцсийн хувь хүн эзэмшигч байхгүй	5
Эзэмшлийн хэд хэдэн давхарга, эцсийн хувь хүн эзэмшигч байхгүй	4
Нээлттэй хувьцаат компани	5
Засгийн газар	1
<b>НИЙТ</b>	<b>51</b>

Компаниудаас ирүүлсэн мэдээллийн дэлгэрэнгүйг Хавсралт 21а-д харуулсан.

### 3.9.2 ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

#### 3.9.2.1 Хууль эрх зүйн орчин

Олборлох салбарт ил байдлыг зохицуулсан хэд хэдэн хуулийн зохицуулалт байдаг. Үүнд:

- 2016 оны 6 сарын 16-нд батлагдсан Мэдээллийн ил байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хууль
- 2014 оны 7 сарын 1-нд батлагдсан Шилэн дансны тухай хууль

- 2015 оны 8 сарын 7-нд батлагдсан Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль

Засгийн Газрын 2012 оны 222-р тогтоолд Хөрөнгө оруулалтын гэрээ, Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ болон тэдгээрийн хэрэгжилтийг нийтэд ил тод болгох ажлыг 2012 оноос туршилтын журмаар хэрэгжүүлж эхлэхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдад даалгасан. Тодорхой гэрээнүүд тухайлбал Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээ, Концессын гэрээнүүд ил болсон.

- УИХ-аас Газрын тосны тухай хуульд 2014 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар уламжлалт бус газрын тостой холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн боломжтой боллоо. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах загвар гэрээнээс гэрээний нууцлалтай холбоотой заалтыг хүчингүй болгосон.
- 2015 оны 6 сарын 19-нд батлагдсан Захиргааны ерөнхий хуульд Засгийн газрын байгууллагуудын байгуулсан гэрээнүүд нь бүгд ил тод байх ёстой гэсэн заалт орсон.
- Сүүлийн жилүүдэд олборлох үйлдвэрлэлд зориулсан авто зам, төмөр зам, цахилгаан, дулаан, ус хангамж бусад ложистикийн бүтцийг дэмжих зорилгоор концессын гэрээг Засгийн газраас байгуулж байна. 2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 болон 6.5.9-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Концессын гэрээ, түншлэлийн Концессын гэрээ, түншлэлийн гэрээний талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлнэ” гэж заасан ба энэ нь гэрээг бүхэлд нь биш, зөвхөн мэдээлэл бэлтгэж олон нийтэд мэдээлэх тухай заалт юм.

### 3.9.2.2 *Бусад үйл ажиллагаанууд*

Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга, тэдгээрийн зарчмууд болон стандартыг нэвтрүүлэхээр тусгасан. Харин Монгол улсын Засгийн газрын 2017-2020 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт уул уурхайн салбарын ил тод байдалтай холбоотой ямар нэгэн заалт ороогүй байна.

Нээлттэй нийгэм форумаас (ННФ) “Эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдал” олон талт оролцогчдын хэлэлцүүлгийг ОУИТБС-ын Ажлын алба, Төлсөн Авсанаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэл, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци (МУУА)-тай хамтран УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Уул уурхайн яамны дэмжлэгтэйгээр 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан.

Хэлэлцүүлгээр эрдэс баялгийн салбар дахь гэрээний ил тод байдалтай холбоотой өнөөгийн хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт, олон улсын түршлага сургамж, гэрээг ил тод болгохтой холбоотойгоор талуудад тулгарч буй асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, олон талын хамтын ажиллагааны талаар хэлэлцэн дараах асуудлуудаар нэгдсэн ойлголт, байр сууринд хүрсэн. Үүнд:

- Эрдэс баялгийн салбарын гэрээний ил тод байдал, мэдээллийн хүртээмж, зохион байгуулалтыг хангах үүднээс Засгийн газар, түүний холбогдох байгууллагаас ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан Тогтвортой байдлын гэрээ, Хөрөнгө оруулалтын гэрээ, Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Геологийн ажлын гэрээ болон Ашиглалтын өмнөх гэрээ зэрэг гэрээнүүдийн эх бичвэрүүдийг мэдээллийн нэгдсэн сан үүсгэж системтэйгээр

байршуулахын сацуу холбогдох төрийн байгууллагын цахим хуудаст байршуулан бүхэлд нь олон нийтэд ил тод болгох;

- Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулах гэрээний ил тод байдлыг нэмэгдүүлж, орон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах болон орон нутгийн иргэдийн онцлог хэрэгцээ шаардлагад тохирсон хэлбэрээр мэдээлэл түгээхэд нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч нар санаачилга гарган хамтран ажиллах; Гэрээ байгуулах, батлах, гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх бүх шатанд мэдээллийг ил тод байлгах, нийтийн сонсгол, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх замаар олон тал, ялангуяа иргэний нийгмийн оролцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Ингэхдээ аль үе шатанд, ямар мэдээллийг, хэрхэн ил тод болгох, гэрээ байгуулах хэлэлцээрийн шатанд олон нийтийг хэрхэн оролцоулах гэх мэт гэрээ байгуулахад олон нийтийн оролцоог хангах журмыг тодорхой хуульчлах зэрэг асуудлуудыг хэлэлцсэн.

Засгийн газрын байгууллагуудаас Монгол улсад мөрдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд геологи, уул уурхай, газрын тосны салбарт дараах төрлийн гэрээнүүд байгуулагдаж байна. Үүнд:

- Бүтээгдэхүүн хуваах гэрээ /газрын тос/
- Бүтээгдэхүүн хуваах гэрээ /занар/
- Концессын гэрээ
- Тогтвортой байдлын гэрээ
- Хөрөнгө оруулалтын гэрээ
- Нутгийн захиргаатай байгуулсан гэрээ
- Ашигт малтмалын газартай байгуулсан гэрээ
- Газрын тосны газартай байгуулсан гэрээ

Ашигт малтмалын тухай хуульд 2014 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр олборлох үйлдвэрлэлийн салбарт байгуулж байгаа гэрээг төр, засгийн 4 байгууллагад батламжлахаар болсон.

- УИХ
- Засгийн газар
- АМГ, ГТГ
- Нутгийн захиргааны байгууллага

Олборлох үйлдвэр хөгжүүлж байгаа тухайн аймаг, суманд нутгийн иргэдийг ажлын байраар хангах, үйлчилгээ, түүхий эдийг авах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зэргээр төслийн өгөөжийг орон нутагт хүртээх зорилгоор нутгийн нийгэм, эдийн засгийг дэмжсэн орон нутагтай хамтран ажиллах гэрээний загвар батлагдсан ба уг загвар гэрээнд ил тод байдал, орон нутгийн иргэдийн оролцоотой холбоотой нилээд тодорхой ахиц, дэвшилттэй зохицуулалтууд орсон байна. Энэхүү гэрээний загварыг Засгийн газраас баталж, орон нутгийн засаг захиргаа уул уурхайн компаниудтай байгуулах юм.

Уул уурхайн яам гэрээний төслийг Дэлхийн банк, Хоган Ловеллс хуулийн фирмтэй хамтран боловсруулаад, гэрээний төслийг мэргэжлийн холбоод, орон нутгийн удирдлагын байгууллага болон иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэлэлцэх юм.

Орд ашиглах гэрээний загварын төслийг Уул уурхайн яамнаас боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулах тогтсон зарчмаар гүйцэтгэж Уул уурхайн сайд батламжилна. Гэрээг АМГ-ын дарга компаниудтай байгуулна.

ОУИТБС-ын стандарт 2.4 дэх шаардлагыг биелүүлэх зорилгоор эрдэс баялгийн гэрээний мэдээллийн нэгдсэн сан хийгдэж байгаа бөгөөд уг санд бүх гэрээнүүд текстээрээ ил тод болгох зорилготой. Уул уурхайн яам, иргэний нийгмийн байгууллагуудын хооронд урьдчилсан тохиролцоо хийгдээд, мэдээллийн сан үүсэх ажил эхэлсэн боловч одоогоор дуусаагүй, Газрын тосны газар БХГ-үүдийг ил болгохоор болсон боловч одоог хүртэл хуулийн өөрчлөлтөөс хойш байгуулагдсан 3 гэрээ ил тод болоогүй байна.

Бид нэгтгэл тайланд хамрагдсан компаниудаас орон нутгийн засаг захиргаатай байгуулсан гэрээний мэдээллийг цахим тайлагналын системд нэмэлт мэдээллийн маягтаар авсан бөгөөд нийт 54 компанийн 141 гэрээний мэдээлэл ирсэн ба дэлгэрэнгүйг Хавсралт 22-оос харна уу.

Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний 3 дугаар сарын хуралдаанаас Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг нийтэд ил тод болгохоор зааж өгсөн нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг Засгийн газраас дэмжиж ажиллаж байгаа бодит жишээ олж байна.

№	Гэрээний төрлүүд	Хүчин төгөлдөр гэрээ гэрээнүүд	Ил тод болгосон байдал	Эх сурвалж
1	Хөрөнгө оруулалтын гэрээ	1	Ил тод болсон	<a href="http://ot.mn/media/ot/content/about_us/IA/Oyu_Tolgoi_IA_MN.pdf">http://ot.mn/media/ot/content/about_us/IA/Oyu_Tolgoi_IA_MN.pdf</a>
2	Тогтвортой байдлын гэрээ	1	Ил тод болсон	
3	Газрын тосны хайгуулын гэрээ	20	Ил тод болоогүй	
4	Газрын тосны олборлолтын гэрээ	3	Ил тод болгох эрх зүйн орчин бүрдсэн боловч УУЯ ил тод болгоогүй байна.	
5	Газрын тосны эрлийн гэрээ	16	Ил тод болоогүй	
6	Орон нутагтай байгуулсан гэрээ	25	МОУИТБС-ын цахим сайтад ил тод болсон	<a href="http://eitimongolia.mn/mn/contracts">http://eitimongolia.mn/mn/contracts</a>

### **3.9.2.3 Ил тод байдлын практик**

ОУИТБС-ын стандартаар гэрээ, лицензийг нийтэд ил тод болгохыг шаарддаг бөгөөд гэрээ/лиценз зэрэг нэр томъёоны хэрэглээг тодорхой тусгасан. (Шаардлага 2.4-с дэлгэрэнгүйг харна уу). Өмнө дурьдсанаас бусдаар эдгээр баримтуудыг Монгол улсад ил тод болгоогүй байна.

## **4 ТОХИРУУЛГЫН ЦАР ХҮРЭЭ БОЛОН АРГА АРГАЧЛАЛ**

### **4.1 ТАНИЛЦУУЛГА**

Харт Нойрс Лтд, Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хамтарсан концерциум (Хараат бус Хянагч-нэгтгэгч) нэгтгэл тайланг гэрээт ажлын даалгаварт тодорхойлсон шаардлагын дагуу

гүйцэтгэх үүрэгтэй. Энэхүү төлбөр, орлогын нэгтгэл нь НББ-ийн мөнгөн суурь дээр үндэслэгдэж нэгтгэгдсэн.

Хэрэв цахим тайлагналын системд төлсөн болон хүлээн авсан байгууллагуудын аль аль нь материаллаг хэмжээний төлбөр эсвэл орлого орхигдуулсан бол бидний ажил эдгээрийг шийдэх бололцоогүй юм.

Хэрэв их хэмжээний орлого ба төлбөрийн мэдээлэл цахим тайлангийн систем/хүлээн авагч болон төлөгч байгууллагуудын аль алины тайлангийн загвар орхигдвол манай ажлын тэдгээрийн илрүүлэлт хангалтгүй болох юм. Бид засгийн газрын агентлагуудаас авсан хийгээд олон нийтийн мэдээллийн эх сурвалжуудад үндэслэн тайлангийн нэгтгэлийг хамрах хүрээтэй холбоотой зөвлөмж өгсөн ба тоо мэдээллийн иж бүрэн байдалд аудит хийгээгүй болно.

Энэхүү ажлыг гүйцэтгэх явцад тайлагнагч байгууллагуудаас хүлээн авсан тайлбар, мэдээлэл үнэн зөв гэдэгт бид найдаж байна.

Бидний тайлан 2016 оны 11 сарын 28-ныг хүртэл хүлээн авсан мэдээллээс бүрдэнэ. Энэ хугацаанаас хойш хүлээн авсан ямар нэгэн мэдээлэл энэхүү тайланд орохгүй.

## 4.2 ЦАР ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ

### 4.2.1 ТАНИЛЦУУЛГА

ОУИТБС-ын нэгдсэн тайлан нь шийдвэр гаргагчдад бодлого боловсруулахад, ард иргэдэд эрдэс баялгийн салбарын баталгаажсан мэдээллийг хүргэхэд чиглэсэн байдаг ба цар хүрээг тодорхойлсноор цаг хугацаандаа, бүрэн бүтэн, найдвартай ОУИТБС-ын нэгтгэл тайлан гарах үндэс суурийг бий болгох юм. Иймд ОУИТБС-ын нэгтгэл тайланд хамрагдах цар хүрээг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Тайланд хамрагдах уул уурхайн салбарын үндсэн мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдсан компаниудаас авах нэмэлт мэдээллүүдийн хүрээг тогтоох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр төлсөн компаниудыг тодорхойлох,
- Тайланд хамрагдах материаллаг төлбөр хүлээж авсан төрийн байгууллагуудыг тодорхойлох,
- Тайлан хамрагдах материаллаг төлбөр бүхий санхүүгийн урсгалуудыг тодорхойлох,
- Тайлагнасан тоо мэдээлэл нь үнэн зөв гэдгээ баталгаажуулах хувилбарууд.

### 4.2.2 ЦАР ХҮРЭЭ БА ЭХЛЭЛИЙН СЕМИНАР

МОУИТБС-ын Ажлын хэсэгтэй Монголын ОУИТБС-ын 2015 оны нэгтгэл тайлангийн ажлын цар хүрээг хэлэлцүүлж, батлуулах зорилгоор 2016 оны 8 дугаар сарын 11-ний өдөр нэг өдрийн семинар зохион байгуулсан. Уг семинарт оролцогч талууд болох засгийн газар, компани болон иргэний нийгмийн төлөөллүүд оролцсон бөгөөд хэлэлцүүлгийг Хараат бус нэгтгэгч удирдан явуулсан.

### 4.2.3 САНХҮҮГИЙН УРСГАЛУУДЫН СОНГОЛТ

МОУИТБС-ын цахим тайлагналын системд оруулсан санхүүгийн урсгал нь өмнөх жилүүдийн туршлагад үндэслэсэн. Биднийг хараат бус нэгтгэгчээр томилох үед гэрээт ажил эхлэхээс өмнө бараг бүх төрийн байгууллагууд болон олон компани цахим тайлагналын системд тайлангаа ирүүлсэн байсан учир системд анхны тайлан оруулах загварыг шалгах боломж хомс байсан. ОТАХ нь МОУИТБС-ын цахим тайлагналын системд бүх компаниуд шаардлагатай мэдээллээ оруулаагүй учир зөрүүгийн материаллагийн түвшинтэй харгалзуулан, бүх материаллаг урсгалыг хамруулан системийн бүх урсгалыг оруулахаар шийдвэрлэсэн. Системд ирүүлсэн тайлан мэдээнд анализ хийж үзэхэд 1,000 сая төгрөгөөс дээших улсын түвшний урсгал нь нийт урсгалын 99.8%-ийг эзэлж байсан.

ОТАХ нь улсын төсөвт төлсөн дараах санхүүгийн урсгалуудыг хамруулахаар шийдвэрлэсэн. Үүнд:-

Санхүүгийн урсгалууд	ЗГ-ын байгуул агууд	Санхүүгийн урсгалууд	ЗГ-ын байгууллагууд
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	ГТЕГ	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	ХЯ
Гаалийн албан татвар	ГТЕГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	АМГТГ
Гаалийн үйлчилгээний хураамж	ГТЕГ	Үүнээс: рояльти	АМГТГ
Автобензин, дизелийн түлшний албан татвар	ГТЕГ	Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМГТГ
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	ГТЕГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	АМГТГ
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	ГТЕГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	АМГТГ
Нэмэгдсэн өртгийн албан татвар	ГТЕГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тухайн жилд гарын үсэг зурсны урамшуулал/зөвхөн 1 жилийн хугацаанд хүчинтэй/	АМГТГ
Агаарын бохирдлын төлбөр	ГТЕГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсний урамшуулал	АМГТГ
Бусад	ГТЕГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт нэмэгдүүлсний урамшуулал	АМГТГ
Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМГТГ	Газрын тосны хайгуулын болон ашиглалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд төлсөн төлбөр	АМГТГ
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	АМГТГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргээ шилжүүлэхэд төлсөн төлбөр	АМГТГ
Байгаль орчныг хамгаалах тусгай дансанд төвлөрүүлсэн орлогын 50%	БОНХАЖЯ	Газрын тосны хайгуулын талбайн захиалгын үйлчилгээний хураамж	АМГТГ
Төрийн өмчийн ногдол ашиг	СЯ	Торгууль	АМГТГ
Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөр	СЯ	Нөхөн төлбөр	АМГТГ
Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Засгийн газарт ногдох орлого	СЯ	Ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	НДЕГ

Эхлэлийн семинарын үед нь дараах орон нутгийн урсгалыг нэгтгэлд хамруулахаар шийдвэрлэсэн. Үүнд:-

- Ус ашигласны төлбөр

- Газрын төлбөр
- Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг
- Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
- Торгууль
- Ус бохирдуулсны төлбөр
- Нөхөн төлбөр
- Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн
- Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг
- Бусад

#### **4.2.4 ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДЫН СОНГОЛТ**

2015 оны ОУИТБС-ын нэгтгэлийн тайланд орох Засгийн газрын байгууллагууд нь сонгогдсон санхүүгийн урсгалуудыг хүлээж авсан байгууллагууд ба ОТАХ-ээс нэгтгэлд хамруулахаар шийдвэрлэсэн Засгийн газрын байгууллагууд нь дараах байдалтай байна. Үүнд:

- Гааль, татварын ерөнхий газар
- Ашигт малтмал, газрын тосны газар
- Сангийн яам
- Хөдөлмөрийн яам
- Нийгмийн даатгалын ерөнхий газар
- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам

ОТАХ-ээс нэгтгэлд хамруулахаар зөвшөөрсөн орон нутгийн байгууллагууд нь дараах байдалтай байна. Үүнд:

- Улаанбаатар хотын ЗДТГ
- Дүүргүүдийн ЗДТГ
- Аймгуудыг ЗДТГ
- Сумдын ЗДТГ

#### **4.2.5 КОМПАНИУДЫН СОНГОЛТ**

Нэгтгэл тайланд хамрагдсан компаниудын сонгох суурь нь засгийн газарт материаллаг төлбөр төлсөн бүх компаниудыг хамруулах байсан. Уг суурь зарчмын дагуу ОТАХ нь улсын болон орон нутгийн түвшинд хийгдсэн төлбөрүүдэд анхаарлаа хандуулж, улсын төсөвт төлсөн материаллаг хэмжээний төлбөр төлсөн компаниудыг хамруулсан.

Бид МОУИТБС-ын цахим тайлагналын систем дээрх 2016 оны 7 дугаар сарын 19-ны байдлаарх мэдээллийг шалгасан. Засгийн газрын зүгээс зарим мэдээллийг дараа нь нөхөж оруулсан бөгөөд олон компаниуд мэдээллээ оруулаагүй байсан. Иймээс материаллаг төлбөр төлсөн компаниудыг сонгохдоо засгийн газрын тайланд үндэслэсэн. Улсын болон орон нутгийн орлогын урсгалын материаллагийн босгыг тодорхойлохдоо тус тусад нь харгалзан үзсэн.

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Засгийн газрын байгууллагуудын цахим тайлагналын системд оруулсан анхны ирүүлсэн мэдээллийг хураангуйлбал:-

Үзүүлэлт	Компаниудын тоо	Сая төгрөг
Улсын татвар, төлбөр, хураамж	1917	1,514,198
Орон нутгийн татвар, төлбөр, хураамж		43,300
<b>Нийт заавал тайлагнах урсгал</b>	<b>1917</b>	<b>1,557,498</b>
Сайн дурын тайлагнал		602
<b>Нийт тайлагнасан урсгал</b>	<b>1917</b>	<b>1,558,100</b>

Заавал тайлагнал урсгал нь бүх байгууллагуудын тайлагнах ёстой урсгал бөгөөд ерөнхийдөө компаниудаас төлөхийг хуулиар шаарддаг төлбөрүүд байна. Сайн дурын урсгал нь ОТАХ-ээс тодорхойлсоноор компаниудаас сайн дурын үндсэн дээр тайлагнахыг шаарддаг урсгал юм. Заавал болон сайн дурын урсгалын 4.2.3 дэх хэсгээс дэлгэрэнгүйг харна уу.

Бид цахим тайлагналын систем дэх компаниудыг хянаж үзэхэд материаллаг хэмжээний татвар, төлбөр, хураамж төлсөн зарим компаниудын үндсэн үйл ажиллагаа нь уул уурхайн үйл ажиллагаа биш байсныг тогтоосон. Эдгээр компаниудын төлсөн татвар, төлбөр, хураамжийн дүнг Засгийн газрын байгууллагуудын тайлагнасан байдлаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Компаниуд	Тайлагнасан орлого (Сая төгрөг)	Компани	Тайлагнасан орлого (Сая төгрөг)
Магнай трейд	87,078	Гангар инвест	346
УБТЗ-ын Чулуун завод	24,190	Агаян	329
Касс таун	1,795	Өндөрбуянт холдинг	323
Гацуурт	1,533	Очир төв	309
Очир ундраа	1,530	Хэрлэн импекс	273
ТЭСО	1,501	Алтайконстракшн	252
Нарантуул трейд	821	Реактив	251
Жи Би Ти Трейдинг	668	Бридж констракшн	245
ЭСТО	601	Итгэлт хүлэг	205
Эм И Эс	475	Ремикон	202
Нэйшнл Инженеринг Групп	394	Ди Эйч Эл	182
Баярс констракшн	365	Геомастер	147
Тэргүүн инвест	358	Хөвсгөл зам	145
<b>Нийт</b>			<b>124,518</b>

Материаллаг байдлын үнэлгээ хийхийн өмнө эдгээр компаниудыг хассан. ОУИТБС-ын цахим тайлагналын системд Засгийн газрын хүлээн авч, тайлагнасан орлого (залруулсан) нь дараах байдалтай байна. Үүнд:-

Үзүүлэлт	Компаниудын тоо	Сая төгрөг
Заавал тайлагнах урсгал	1891	1,432,980
Сайн дурын тайлагнал		602
<b>Нийт тайлагнасан</b>	<b>1891</b>	<b>1,433,582</b>



МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Материаллаг хэмжээний төлбөр төлсөн компаниудыг сонгохдоо дээр дурьдсан залруулагдсан орлогын багцад шинжилгээ хийсэн. Үүнд:

Нийт урсгал	Нийт			Улсын		Орон нутгийн	
	Компанийн тоо	Тайлагнасан урсгал	Эзлэх %	Тайлагнасан урсгал	Эзлэх %	Тайлагнасан урсгал	Эзлэх %
<b>Тэрбум төгрөг</b>		<b>Тэрбум төгрөг</b>		<b>Тэрбум төгрөг</b>		<b>Тэрбум төгрөг</b>	
> 150	3	1,069.5	74.6%	1,044.3	75.1%	25.2	59.0%
>10 <150	7	169.1	11.8%	168.1	12.1%	1.0	2.3%
>1 <10	35	120.5	8.4%	111.1	8.0%	9.5	22.2%
>0.5 <1	25	17.2	1.2%	14.6	1.1%	2.6	6.1%
> 0.1 <0.5	166	32.7	2.3%	30.1	2.2%	2.6	6.1%
<0.1	1,655	24.0	1.7%	22.1	1.6%	1.8	4.2%
	<b>1,891</b>	<b>1,433.0</b>		<b>1,390.3</b>		<b>42.7</b>	

2015 онд улсын төсөвт төлсөн нийт урсгалын 96.2%-ийг 500 сая төгрөгөөс дээш татвар, төлбөр, хураамж төлсөн нийт 70 компани төлсөн нь уг анализаас харагдаж байна. Мөн эдгээр 70 компанийн орон нутгийн төсөвт шилжүүлсэн төлбөр нь орон нутгийн төсвийн орлогын 89.7%-ийг эзэлж байна. Ерөнхийдөө эдгээр 70 компанийн 2015 онд Засгийн газарт (улсын болон орон нутгийн) төлсөн төлбөр нь нийт дүнгээрээ 1,376.3 тэрбум төгрөг буюу Засгийн газрын хүлээн авсан нийт орлогын 94.8%-ийг эзэлж байна.

1. ОУИТБС-ын орлого, төлбөрийг тохируулахтай холбоотой стандартын шаардлагыг хангахын тулд нийт 500 сая төгрөгөөс дээш Засгийн газрын тайлагнасан орлого (улсын болон орон нутгийн)-ыг төвлөрүүлсэн 70 компанийг нэг бүрчлэн хамруулахыг санал болгосон.
2. Орон нутагт 150 сая төгрөгнөөс дээш татвар, төлбөр, хураамж төлсөн 11 компанийг нэг бүрчлэн хамруулахаар санал болгосон.
3. Түүнчлэн, 100-500 сая төгрөг төлсөн 155 компаниудаас 121 компанийг доор дурьдсан хүчин зүйлсийг харгалзан сонголт хийсэн. Үүнд:
  - 1) Улсын болон орон нутгийн төвлөрсөн төлбөрүүдийн цар хүрээг нэмэгдүүлж буй эсэх
  - 2) Засгийн газар болон компаниудын тайлагнасан дүнгүүдийн хооронд материаллаг зөрүү үүсч байвал (жишээ нь: Засгийн газар нийт 100 сая төгрөг хүлээж авсан гэж тайлагнасан боловч, компани 1.0 тэрбум төгрөг төлсөн гэж тайлагнасан, эсвэл эсрэгээрээ байх тохиолдол)
  - 3) Засгийн газрын болон компаниудын тайлагнасан дүнгүүдийн харьцуулалт, өнгөрсөн хугацааны төлбөрийн мэдээлэл гэх мэт бусад хүчин зүйлс.
  - 4) 2015 онд олборлолт явуулж, уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан байх

Дээр дурьдсан аргачлалын дагуу сонголт хийж, сонгогдсон компаниудыг нэгтгэж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

(тэрбум төгрөгөөр)

Босго дүн	Нийт санхүүгийн урсгал		Сонгогдсон компаниудын санхүүгийн урсгал		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Улсын төсөвт 500 саяас дээш татвар төлсөн компаниуд	70	1,376.4	70	1,376.4	100
Улсын төсөвт 100-500 сая төгрөг төлсөн	155	30.0	121	26.1	87

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

компаниуд					
Орон нутгийн төсөвт 150 сая төгрөгөөс дээш татвар төлсөн компаниуд	11	2.6	11	2.6	100
0-100 сая төгрөг татвар төлсөн компаниуд	1655	24.0		0	0
<b>Нийт</b>	<b>1891</b>	<b>1433.0</b>	<b>202</b>	<b>1405.1</b>	<b>98.05</b>

Дээр дурьдсан аргачлалын дагуу нэгтгэлд сонгогдсон 202 компанийн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татварын дүн 2016 оны 7 сарын 19-ны Засгийн газрын тайлангийн нийт санхүүгийн урсгалын 98.05%-ийг эзэлж байна

Компаниудын дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 1-ээс харна уу.

### **4.2.6 2015 ОНЫ ТОХИРУУЛГАД АШИГЛАСАН МАЯГТУУД**

Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж нь Ашигт малтмалын тухай хуулийн 48.10, Газрын тосны тухай хуулийн 36.1, Цөмийн энергийн тухай хуулийн 28.6.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 34.10 заалтуудын дагуу “тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд тухайн жилд улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, олборлосон, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг маягтын дагуу тайлагнаж, олон нийтэд мэдээлдэг” билээ.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд болон төрийн байгууллагуудын МОУИТБС-ын тайланг тайлагнах маягтыг ҮСХ-ны даргын зөвшөөрснөөр Сангийн сайдын 2016 оны 2-р сарын 5-ны өдрийн 43 тоот тушаалаар шинэчлэн баталсан.

Ажлын даалгаварт зааснаар Хараат бус хянагч-нэгтгэгч нь Сангийн яамны баталсан тайлангийн маягт, орлогын урсгалын дагуу зөвшилцсөн материаллаг босгоос дээш давсан “бүх төрлийн материаллаг төлбөр, орлогыг” хамруулан 2015 оны тайлангийн маягтыг боловсруулан ОТАХ-т хүргүүлэхээр заасан.

2016 оны 7 сарын 19-нд Хараат бус хянагч-нэгтгэгч ажлаа эхлэхэд ОУИТБС-ын 2015 оны тайланг 2016 оны 6 сарын 10-ны өдрөөс эхлэн “Цахим тайлагнал”-ын системээр хүлээн авч эхэлсэн байсан тул Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс тайлангийн маягтад саналаа өгч, боловсруулах боломжгүй болсон.

ОУИТБС-ын Ажлын албаны цахим тайлагналын систем нь дээр дурьдсан маягтуудыг нэгтгэн, 1 маягт болгон, 2015 оны тайланг хүлээж авсан. Цахим тайлангийн маягтыг батлагдсан маягттай харьцуулан үзэхэд батлагдсан 6 маягтын мэдээллүүдийг ерөнхийд нь оруулсан, хэлбэрийн хувьд яг адилхан биш боловч санхүүгийн бүх урсгалуудыг хамруулсан байна.

### **4.2.7 МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ БА ХАРЬЦУУЛАЛ**

Хараат бус хянагч-нэгтгэгч нь мэдээллийг одоогийн ашиглаж буй цахим тайлагналын систем дээр үндэслэсэн ба анхны зөрүүг тодруулсан.

Нэгтгэлд хамрагдсан компаниуд руу зөрүү үүссэн татварын төрлүүдээр хавсралт болон Удирдлагын хариуцлагын захидлыг бэлтгэж явуулсан. Мөн төрийн байгууллагууд руу албан бичиг илгээж, хариу авах замаар тохируулгыг хийж, нэгтгэсэн.

Ажлын даалгаварт шаардсан мэдээллүүдийг төрийн байгууллагаас авах, компаниудаас авах гэж 2 ангилах ба цахимаар болон цаасаар авах юм.

Сонгогдсон компаниудаас анхны зөрүүгийн шалтгааныг тодруулсан нэмэлт мэдээллийг цаасан баримтаар, нэгтгэл тайланд орох нэмэлт мэдээллүүдийг цахимаар, эдгээр мэдээлэл нь үнэн зөв гэсэн баталгааг Удирдлагын хариуцлагын захидлаар гаргуулан авсан.

Төрийн байгууллагуудаас тайланд орох уул уурхайн салбарын талаарх үндсэн мэдээлэл, статистик тоон мэдээллүүд болон эдгээрийн үнэн зөвийг баталсан Удирдлагын хариуцлагын захидлыг цаасан баримтаар авсан.

---

#### **4.2.8 МАТЕРИАЛЛАГИЙН БОСГО**

Эхлэлийн семинарийн үед материаллаг бус зөрүүг нэгтгэлийн явцад шалгахгүй байх талаар тохиролцсон. Заавал шалгах шаардлагатай зөрүүний талаар доор харуулав.

##### **4.2.8.1 Улсын түвшний санхүүгийн урсгал**

Засгийн газар болон компаниудын тайлагнасан дүнгийн хоорондын зөрүү нь доорх дүнгээс илүү (дээш, доош) зөрж байвал, тухайн зөрүүг уг түвшнээс доош түвшинд хүртэл зөвшөөрөгдсөн цаг хугацаанд судалж, шалгана.

Шалгах босго нь:-

Аливаа дан санхүүгийн урсгалын хувьд	500.0 сая төгрөгөөс дээш зөрүү
Компанийн хувьд	1,000.0 сая төгрөгөөс дээш зөрүү (цэвэр)

##### **4.2.8.2 Орон нутгийн түвшний санхүүгийн урсгал**

Засгийн газар болон компаниудын тайлагнасан дүнгийн хоорондын зөрүү нь доорх дүнгээс илүү (дээш, доош) зөрж байвал, тухайн зөрүүг уг түвшнээс доош түвшинд хүртэл зөвшөөрөгдсөн цаг хугацаанд судалж, шалгана.

Шалгах босго нь:-

Аливаа дан санхүүгийн урсгалын хувьд	25.0 сая төгрөгөөс дээш зөрүү
Компанийн хувьд	50.0 сая төгрөгөөс дээш зөрүү (цэвэр)

---

#### **4.2.9 МЭДЭЭЛЛИЙГ ЗАДЛАХ ТҮВШИН**

ОУИТБС-ын стандарт 4.7-д “Олон талт оролцогчдын бүлэг нь мэдээллийг олон нийтэд зориулан хэвлэн нийтлэхэд ямар түвшинд хүртэл задлах боломжтой байх асуудлыг зөвшилцөх шаардлагатай. ОУИТБС-ын тайлангийн мэдээлэл нь компаниуд, төрийн байгууллагууд болон орлогын урсгал нэг бүрээр нь дэлгэн харуулах боломжтой байх ёстой” гэж заасан байдаг.

Эхлэлийн семинарын явцад уг аргачлалыг харилцан зөвшилцсөн.

ОТАХ-ийн зарим нэг гишүүдийн зүгээс стандартын шаардлагаас гадна ОУИТБС-ын нэгтгэл тайланг бүсээр нь гаргах, тухайлбал, говийн бүсийн ОУИТБС-ын тайлан гэх мэтээр тайлангаа бэлдсэнээр тайлангийн ашиглалт сайжирна гэж үзэж байгаа. Гэвч Хараат бус Хянагч-нэгтгэгчийн зүгээс ажлын даалгаварт заасан ажлыг тодруулах ба нэгтгэл тайлангийн хугацаанд бүсчилсэн байдлаар тайлан гаргах цаг хугацааны боломжгүй юм.

ОУИТБС-ын стандарт нь тодорхой нөхцөлд төслийн түвшинг тайлагнахыг мөн шаарддаг боловч Монгол дахь төрийн байгууллагууд болон компаниуд нь орлогын мэдээг төсөл хооронд хуваарилдаггүйгээс энэ төрлийн задаргаа ороогүй болно.

Аймаг, нийслэлийн санхүүгийн бус мэдээлэл тайланд тусгагдсан болно.

#### 4.3 ТАЙЛАН, МЭДЭЭЛЛИЙН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

Олон Улсын Аудитын Стандартын (4.9.а) дагуу орлого, төлбөрүүдэд хараат бус, найдвартай аудит хийлгэсэн эсэх талаар үнэлж дүгнэсэн байхыг ОУИТБС-ын Стандарт шаарддаг.

Нэгтгэл тайланг бэлтгэх зорилгын хүрээнд Ажлын даалгаварт ОТАХ, Хараат бус Хянагч-нэгтгэгч нар шаардлагатай гэж үзэн тохирсны дагуу, компаниуд, төрийн байгууллагуудын одоогийн хяналт, аудитын үндсэн ажиллагааны найдвартай байдлыг тодорхойлох, тайлан гаргасан байгууллагуудаас найдвартай байдлын баталгаа авсан талаар мэргэжлийн дүгнэлт гаргуулахыг Хараат бус Хянагч-Нэгтгэгчээс шаарддаг.

Компаниудын санхүүгийн тайлан аудитлагдсан эсэх, компаниудаас ирүүлсэн Удирдлагын хариуцлагын захидал болон Аудиторын мэдэгдлийг харуулсан дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос харна уу.

##### 4.3.1 МОНГОЛ УЛСЫН АУДИТЫН ОРЧИН НӨХЦӨЛ

Монгол улсын төрийн байгууллагуудын аудитын ажиллагааг хэрэгжүүлэх нь Монголын Үндэсний Аудитын Газрын (“МҮАГ”) хариуцах үйл ажиллагаа юм. МҮАГ нь олон улсын аудитын INTOSAI байгууллагын гишүүн бөгөөд тус байгууллагын стандартуудын дагуу үйл ажлаа явуулж байна.

МҮАГ нь Засгийн Газрын яамд, агентлагууд болон төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайлан болон ЗГ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж, УИХ-аар батлуулдаг. МҮАГ нь Засгийн Газрын 2015 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд таван асуудлаар хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд тэдгээр таван хязгаарлалттай дүгнэлтийн нэг нь ЗГ-ын нэгтгэсэн тайланд орсон “Эрдэнэс Монгол” компанийн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл нь 123 тэрбум төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэнтэй холбоотой байгаа юм.

Орон нутгийн төрийн байгууллагууд (аймаг, сумд) санхүүгийн тайлангаа жил тутам гаргаж, МҮАГ-н харьяа орон нутгийн аудитын байгууллагаар хянуулж байх ёстой.

Мөн төрийн өмчит компаниудын жил тутмын санхүүгийн тайланд аудит хийх ажиллагааг МҮАГ хариуцдаг боловч тэдгээр аудитыг гүйцэтгүүлэхийн тулд зохих хэмжээний чадварлаг хувийн

аудитын байгууллагуудыг томилж ажиллуулахыг зөвшөөрдөг бөгөөд бодит практикт голдуу ингэж ажиллаж байна. Тэдгээр аудитын байгууллагууд Аудитын Олон Улсын Стандартын дагуу аудитын ажлыг гүйцэтгэж байна.

Хувийн өмчит компаниуд НББ-ийн тухай хуулийн 4.1-д заасны дагуу СТОУС-ын дагуу санхүүгийн тайлангаа гаргах ёстой бөгөөд нийт борлуулалтын орлогын хэмжээ, эсвэл цэвэр хөрөнгө нь тодорхой түвшнээс давсан бол бүх компаниуд санхүүгийн тайландаа хөндлөнгийн аудит хийлгэж байхыг хуулиар шаарддаг.

#### **4.3.2 ОУИТБС-ЫН ТАЙЛАНГИЙН НАЙДВАРТАЙ БАЙДЛЫГ БАТАЛГААЖУУЛАХ ЯВЦ**

Засгийн Газрын байгууллагууд, ТӨК-иуд болон олборлох компаниуд өөрсдийн мэдээллийг Цахим тайлангийн системд оруулах шаардлагатай бөгөөд шаардлага гарах бүрт нэмэлт мэдээллийг Хараат бус хянагч-нэгтгэгчид өгч байх ёстой байдаг. Тухайн мэдээлэл найдвартай бөгөөд нягт нямбай гэдгийг баталгаажуулах үүргийг тайлан гаргаж байгаа байгууллагууд хүлээдэг.

Тайлагнагч компаниуд өөрсдийн тайлагнасан дүнгийн үнэн зөв болон найдвартай байдлыг баталгаажуулах үүрэгтэй.

Доор заасны дагуу, тайлан гаргаж байгаа байгууллагууд өөрсдийн өгсөн мэдээллийг найдвартай гэдгийг Хараат бус хянагч-нэгтгэгчид батлах үүрэгтэй.

##### **4.3.2.1 Засгийн газрын яам, агентлагууд**

2015 оны тайлангийн хамрах хүрээг хэлэлцэх хурлын үеэр “тайлан гаргаж байгаа төрийн байгууллага/агентлаг бүрийн ахлах удирдлагын төлөөлөл нь тухайн тайлан, мэдээлэлд бичгээр баталгаа гаргаж байх”-аар ОТАХ тохиролцсон юм.

Цахим тайлангийн системд төрийн байгууллагуудын оруулсан ОУИТБС-ын тайлан нь аудитлагдсан байхыг бид зөвлөмж болгосон. Үүний тулд шаардагдах ажлуудыг МҮАГ 2017 оны ажлын төлөвлөгөөндөө хэрхэн нэгтгэж тусгах талаар 2017 оны эхээр (1-р сард) Ажлын хэсэг болон МҮАГ хамтран хурал хийж, хэлэлцэх нь зүйтэй гэж бид зөвлөж байна.

##### **4.3.2.2 Төрийн өмчит компаниуд**

Тайлан гаргаж байгаа ТӨК бүрийн Гүйцэтгэх удирдлага нь өөрсдийн ТУЗ-ийг төлөөлөн тухайн тайлан, мэдээлэлд бичгээр баталгаа гаргаж байхыг, мөн ТӨК бүр аудит хийлгэсэн санхүүгийн тайлангаа өгч байхаар Ажлын Хэсэг тохиролцсон юм.

ТӨК-иудаас ирүүлсэн хариултын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-д, ТӨК-иудын аудит хийлгэсэн санхүүгийн тайлангуудын мэдээг нэгтгэн Хавсралт 19-д үзүүлэв.

Төрийн өмчит бүх компаниудад бид “ОУИТБС-ын тайланд өгсөн мэдээлэл нь АОУС-ын дагуу аудит хийлгэсэн санхүүгийн тайлангуудтай тохирч байгаа бөгөөд үнэн, зөв” гэдгийг тэдгээрийн аудиторроор батлуулан ирүүлэх хүсэлт тавьсан юм.

ТӨК-иудын аудиторруудын ирүүлсэн хариултын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-д оруулав.

#### 4.3.2.3 Компаниуд

Тайлан гаргаж байгаа компаниудын Гүйцэтгэх удирдлага нь өөрсдийн ТУЗ-ийг төлөөлөн тухайн тайлан, мэдээлэлд бичгээр баталгаа гаргаж байхыг, мөн компани бүр аудит хийлгэсэн санхүүгийн тайлангаа өгч байхаар ОТАХ-тэй тохиролцсон юм.

Компаниудаас ирүүлсэн хариултын дэлгэрэнгүй мэдээлэл, компаниудын аудит хийлгэсэн байдлыг Хавсралт 19-д үзүүлэв.

Түүнчлэн, бүх компанид “ОУИТБС-ын тайланд өгсөн мэдээлэл нь АОУС-ын дагуу аудит хийлгэсэн санхүүгийн тайлангуудтай тохирч байгаа бөгөөд үнэн, зөв” гэдгийг тэдгээрийн аудиторроор батлуулан ирүүлэх хүсэлт тавьсан юм.

Компаниудын аудиторын ирүүлсэн хариултын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 7-д орууллаа.

## 5 ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

### 5.1 ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН

#### 5.1.1 АНХЛАН ТАЙЛАГНАСАН УРСГАЛУУДЫН ХУРААНГУЙ

Компаниудын тайлагнасан тодорхой урсгалуудыг энэхүү тайланд “зарласан урсгал” гэж тусгасан бөгөөд эдгээрийг тохируулаагүй байсан. Эдгээр урсгалын талаар энэхүү тайлангийн Бүлэг 4.2.3-т тодорхойлсон. Энэхүү хэсэг нь ОТАХ-ийн баталсан тохируулах шаардлагатай урсгалын хүрээнд бэлтгэгдсэн.

Анхлан тайлагнасан урсгалууд нь дараах байдалтай байна. Үүнд:-

	Засгийн газар (сая төгрөг)	ОУ-ийн компани (сая төгрөг)	Цэвэр анхны зөрүү	
			(сая төгрөг)	%
Төрийн өмчит компаниуд	396,422	374,120	22,302	
Хувийн компаниуд	1,041,604	760,419	281,185	
<b>Нийт</b>	<b>1,438,027</b>	<b>1,134,539</b>	<b>303,487</b>	<b>21.10%</b>

Тохируулгын явцад ажигласнаар дээрх анхны зөрүү нь дараах үндсэн асуудлуудаас үүдэн гарсан байна. Үүнд:

1. Компани эсвэл ЗГ төлбөр/орлогыг илүү эсвэл дутуу тайлагнасан, эсвэл огт тайлагнаагүй.
2. Анхны нэгтгэлээр 76 компани тайлангаа ирүүлээгүйгээс 267.2 тэрбум төгрөгийн зөрүү үүссэн.
3. Төлбөр/орлогыг буруу ангилалд тайлагнасан.
4. Цаг хугацааны зөрүүнээс үүдсэн.

Эдгээрийн талаар энэхүү тайлангийн 5.2 дахь хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан.

## 5.2 АНХНЫ ТОХИРУУЛААГҮЙ ЗӨРҮҮ БОЛОН ТАЙЛАГНААГҮЙ КОМПАНИУД

### 5.2.1 АНХНЫ ЗӨРҮҮ

#### 5.2.1.1 Илүү дутуу тайлагнах

Анхны зөрүү үүсгэж байгаа голлох шалтгаануудын нэг нь ОУИТБС-д цахимаар шивж оруулж байгаа тоон мэдээллээ буруу тайлагнаснаас үүссэн байна.

Байгаль орчин, Аялал жуулчлалын яам нь байгаль хамгаалах зардлын 50 хувийн төлбөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийг тайлагнах үүрэгтэй. Гэвч дээрх хоёр яам нь цахим тайлагналын системд мэдээллээ оруулаагүйгээс 0.7 тэрбум төгрөгийн байгаль хамгааллын зардлын 50 хувь, 5.1 тэрбум төгрөгийн Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөрийн анхны зөрүү тус тус үүсгэсэн байна.

#### 5.2.1.2 Анхлан тайлагнаагүй компаниуд

Цахим тайлагналын системд тайлангаа оруулаагүй 76 компани нь нийт анхны зөрүү 267.2 тэрбум төгрөгийг үүсгэж байна. Томоохон анхны зөрүү үүсгэж байгаа компаниудыг харуулбал:

тэрбум төг

Регистрийн дугаар	Нэрс	ЗГ	Компани	Анхны зөрүү
2075385	Петрочайна Дачин Тамсаг ХХК	175.09	-	175.09
5106567	Сэнж Сант ХХК	20.42	-	20.42
2008572	Багануур ХК	10.44	-	10.44
5435528	Эрдэнэс Таван толгой ХК	9.73	-	9.73
5084555	Саусгоби Сэндс ХХК	8.18	-	8.18
5199077	Өсөх зоос ХХК	6.49	-	6.49
2027194	Эрэл ХХК	5.43	-	5.43
2051303	Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК	4.10	-	4.10
2016656	Тавантолгой ХК	2.23	-	2.23
2705133	Онтрэ ХХК	1.91	-	1.91
2808676	БҮТИ ХХК	1.51	-	1.51
2869594	Альшаа хайрхан ХХК	1.49	-	1.49
2641984	Цемент шохой ХХК	1.14	-	1.14
2057573	Макс Импэкс ХХК	1.05	-	1.05
5796121	Монголиа Гладвилл Увс Петролиум ХХК	0.93	-	0.93
5002486	Жинхуа орд ХХК	0.85	-	0.85
2699869	Металл Опт ХХК	0.72	-	0.72
2113023	Зууннайман суврага ХХК	0.70	-	0.70
5382475	Юүшэнгминг ХХК	0.68	-	0.68
2743744	Монвольфрам ХХК	0.67	-	0.67
	Бусад	13.45		13.45
	<b>Нийт</b>	<b>267.20</b>		<b>267.20</b>

### 5.2.1.3 Буруу ангилалд тайлагнах

Хэд хэдэн тохиолдолд ЗГ болон компаниуд нь буруу ангилалд бүртгэсэн байна. Тухайлбал, гаальд төлсөн НӨАТ-ыг гаалийн албан татвар гэж, гаалийн үйлчилгээний хураамжийг гаалийн албан татвар гэж, улсын төсөвт төлсөн АМНАТ-ыг орон нутагт төлсөн Түгээмэл тархацтай АМНАТ гэж тайлагнасан гэх мэт.

Иймэрхүү буруу тайлагнал нь Засгийн газрын орлого болон компаниудын төлсөн нийт дүнг өөрчилж, цэвэр зөрүүнд нөлөөлөхгүй боловч зөв зохистой орлого/төлбөрийн ангилалд тайлагнах нь чухал ач холбогдолтой байна. Тохируулгын анхны үе шатанд иймэрхүү буруу илэрхийллийг залруулсан.

### 5.2.1.4 Цаг хугацааны зөрүүнээс үүдсэн анхны зөрүү

“Оюутолгой” ХХК 2015 оноос өмнө ААНОАТ болон АМНАТ-ыг урьдчилгаа хэлбэрээр төлж, 2015 онд төлөх ёстой дүнгээсээ суутгуулсныг Засгийн газар 2015 онд хүлээн авсан гэж тайлагнаснаас 92.5 тэрбум төгрөгийн анхны зөрүү үүссэн.

## 5.2.2 ТОХИРУУЛААГҮЙ ҮЛДСЭН ЗӨРҮҮ

Нийт тохируулаагүй цэвэр зөрүү нь 112 сая төгрөг байгаа бөгөөд хүснэгтээр харуулбал:

(сая төгрөг)

	Анхны	Тохируулга	Тохируулгын дараа
Засгийн газрын тайлагнасан	1,438,027	(44,462)	1,393,565
Компанийн тайлагнасан	1,134,539	257,499	1,392,038
ЗГ-аас илүү тайлагнасан компаниудын дүн	25,730	327,617	353,348
ЗГ-аас дутуу тайлагнасан компаниудын дүн	(329,218)	(25,658)	(354,876)
<b>Тохируулаагүй цэвэр зөрүү</b>	<b>(303,487)</b>	<b>301,959</b>	<b>(1,528)</b>
Хасах: тохируулгын явцад тайлангаа ирүүлээгүй компаниуд	-	1,640	1,640
<b>Эцсийн цэвэр тохируулаагүй зөрүү</b>	<b>(303,487)</b>	<b>303,600</b>	<b>112</b>



МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Доорх хүснэгт нь тохируулгын дараах байдлаар компаниас илүү тайлагнасан ЗГ-ын дүн (А багана) болон компаниас дутуу тайлагнасан ЗГ-ын дүн (Б багана) зэргийг тусад нь харуулсан.

Мөнгөн нэгж: сая төгрөгөөр	2015	
	Засгийн газар илүү/(дутуу) тайлагнасан	
Урсгал	А	Б
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	0	78
Гаалийн албан татвар	0	83
Нэмэгдсэн өртгийн албан татвар	0	350
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	0	64
Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	0	752
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	0	5
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	(17)	0
Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	0	235
Гаалийн үйлчилгээний хураамж	0	4
Торгууль	(11)	0
Нөхөн төлбөр	0	0
БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	(14)	0
Бусад	(8)	0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	(5)	0
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	(27)	0
Газрын төлбөр	(53)	0
Ус ашигласны төлбөр	(15)	0
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	0	8
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	(5)	0
Торгууль	(12)	0
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	(1)	0
Бусад	0	67
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	0	52
<b>Цэвэр тохируулаагүй зөрүү</b>	<b>(168)</b>	<b>1,696</b>

Тохируулагдаагүй үлдсэн томоохон зөрүүнүүд нь дараах байдалтай байна. Үүнд:-

Мөнгөн нэгж: сая төгрөгөөр	2015		Тайлбар	
	Компани	Урсгал		Засгийн газар илүү/(дутуу) тайлагнасан
Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК	Газрын төлбөр		25	
Хүдэрэрдэнэ ХХК	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн		13	
Блэйкмаунт Майнинг ХХК	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр		320	Тайлангаа ирүүлээгүй компани
Галакси Майнинг ХХК	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр		242	Тайлангаа ирүүлээгүй компани

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Мөнгөн нэгж: сая төгрөгөөр	2015		Тайлбар	
	Урсгал	Засгийн газар илүү/(дутуу) тайлагнасан		
Компани				
Эм Кэй Эм Эн майнинг ХХК	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр		157	Тайлангаа ирүүлээгүй компани
Гурванбогдын нуруу ХХК	Нэмэгдсэн өртгийн албан татвар		99	Тайлангаа ирүүлээгүй компани
Гурванбогдын нуруу ХХК	Гаалийн албан татвар		47	Тайлангаа ирүүлээгүй компани
Энержи-Импайр ХХК	Гаалийн албан татвар		23	Тайлангаа ирүүлээгүй компани
Ган-Илч ХХК	Нэмэгдсэн өртгийн албан татвар		145	Тайлангаа ирүүлээгүй компани
Энержи-Импайр ХХК	Нэмэгдсэн өртгийн албан татвар		91	Тайлангаа ирүүлээгүй компани
Ган-Илч ХХК	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар		73	Тайлангаа ирүүлээгүй компани
Анхай интернэшнл ХХК	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр		56	Тайлангаа ирүүлээгүй компани
Гурванбогдын нуруу ХХК	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл		61	Тайлангаа ирүүлээгүй компани
Энержи-Импайр ХХК	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл		18	Тайлангаа ирүүлээгүй компани
Энержи-Импайр ХХК	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл		110	Тайлангаа ирүүлээгүй компани
Галакси Майнинг ХХК	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл		25	Тайлангаа ирүүлээгүй компани
Анхай интернэшнл ХХК	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл		29	Тайлангаа ирүүлээгүй компани
Анхай интернэшнл ХХК	Гаалийн үйлчилгээний хураамж		35	Тайлангаа ирүүлээгүй компани
Энержи-Импайр ХХК	Улсын төсөвт төлсөн бусад төлбөр		56	Тайлангаа ирүүлээгүй компани
Монголын Алт МАК ХХК	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	(41)		
Дархан Төмөрлөгийн үйлдвэр ХХК	Газрын төлбөр	(25)		
Баян Айраг Эксплорэйшн ХХК	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	(23)		
Монголын Алт МАК ХХК	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	(20)		
Хос-Хас ХХК	Торгууль	(11)		
Хүдэрэрдэнэ ХХК	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	(13)		
Бусад зөрүү		(35)	70)	
<b>Нийт зөрүү</b>		<b>(168)</b>	<b>1,696</b>	

### 5.2.3 ТАЙЛАГНААГҮЙ КОМПАНИУД

Цахим тайлагналын системд тайлагнасан Засгийн газрын орлогын мэдээнээс нэгтгэлд хамрагдах 202 компанийг сонгосон бөгөөд үүнээс 8 компани нь цахим тайлагналын системээр, мөн тохируулгын явцад нэмэлт хүсэлтээр тайлангаа ирүүлээгүй компаниуд байна. Эдгээр 8 компанийн нийт үрсгал 1,640 сая төгрөг юм.

Тайлагнаагүй компаниудыг хүснэгтээр харуулбал:

#	Регистрийн №	Компанийн нэр	ЗГ-ын тайлагнасан орлого (сая төг)	Тайлбар
1	2863847	Анхай интернэшнл ХХК	127	Лиценз нь шилжсэн.
2	5477301	Блэйкмаунт Майнинг ХХК	320	Холбогдох боломжгүй, олдохгүй байгаа, утас, хаяггүй.
3	5584469	Галакси Майнинг ХХК	267	Татан буугдсан гэж хариу өгсөн.
4	2544695	Ган-Илч ХХК	333	Манай үндсэн үйл ажиллагаа үүл уурхай биш гэж хариу өгсөн.
5	4000617	Энержи-Импайр ХХК	195	Увсын Улаангомд байршилтай боловч үйл ажиллагаа явуулаагүй гэж захирлын дүү нь болох хүн нэг удаа хариу өгөөд дахиж холбогдох боломжгүй болсон.
6	5746035	Эс Эс Жи Пи ХХК	34	Холбогдох ганц утас байгаа боловч авахгүй байгаа.
7	5287227	Эм Кэй Эм Эн майнинг ХХК	157	Холбогдох утас, хаяггүй.
8	5331544	Гурванбогдын нуруу ХХК	207	Лиценз дээрээ үйл ажиллагаа явуулаагүй.
<b>Нийт</b>			<b>1,640</b>	

Засгийн газрын хүлээн авсан дүн дээрх байдлаар тайлагнасан гэж үзвэл эдгээр компаниудаас хүлээн асан орлого нь дангаар болон нийт дүнгээрээ 2015 оны нэгтгэлд материаллаг биш байна. Гэвч эдгээр компаниудын тайлагнаагүй шалтгааныг тус бүрд нь шалгаж, хэрэв цаашид ОУИТБС-ын нэгтгэлд хамруулахаар сонгогдвол тайлангаа ирүүлэхэд нь анхаарахыг зөвлөж байна.

5.3 НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН

5.3.1 УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН (ОРЛОГЫН УРСГАЛААР)

Орлогын урсгал (сая төгрөгөөр)	Анхлан тайлагнасан			Тохируулга		Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
	AFS	AFS	AFS	AFS	AFS	AFS	AFS	AFS
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	259,824	202,784	57,040	(43,187)	13,775	216,637	216,559	78
Гаалийн албан татвар	29,534	43,169	(13,635)	3,215	(10,503)	32,749	32,666	83
Нэмэгдсэн өртгийн албан татвар	128,035	74,157	53,878	(32,346)	21,182	95,689	95,339	350
Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	32	2	30	-	30	32	32	-
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	-	-	-
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	593,167	535,353	57,814	(49,304)	8,446	543,863	543,800	64
Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	21,893	11,905	9,988	111	9,347	22,004	21,252	752
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	2,274	1,639	635	38	668	2,312	2,306	5
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тухайн жилд гарын үсэг зурсны урамшуулал	593	-	593	-	593	593	593	-
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	5,140	(5,140)	16,556	11,433	16,556	16,574	(17)
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсний урамшуулал	-	-	-	-	-	-	-	-
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт нэмэгдүүлсний урамшуулал	-	-	-	-	-	-	-	-
Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	2,014	1,887	128	876	1,003	2,890	2,890	-
Газрын тосны хайгуулын болон ашиглалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд төлсөн төлбөр	-	-	-	-	-	-	-	-

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны тайлан

Орлогын урсгал (сая төгрөгөөр)	Анхлан тайлагнасан			Тохируулга		Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
	AFS	AFS	AFS	AFS	AFS	AFS	AFS	AFS
Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргээ шилжүүлэхэд төлсөн төлбөр	-	76	(76)	76	-	76	76	-
Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	118,769	93,426	25,343	685	25,793	119,454	119,220	235
Агаарын бохирдлын төлбөр	12,171	10,507	1,664	1	1,665	12,171	12,172	(0)
Гаалийн үйлчилгээний хураамж	11,653	16,437	(4,783)	18,710	13,923	30,364	30,360	4
Газрын тосны хайгуулын талбайн захиалгын үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	-	-	-
Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төлсөн сургалтын урамшуулал	1,212	624	588	40	629	1,253	1,253	-
Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	1,205	615	591	61	652	1,267	1,267	-
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
Засгийн газарт төлсөн урьдчилгаа төлбөр	-	-	-	-	-	-	-	-
Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Засгийн газарт ногдох орлого	-	-	-	-	-	-	-	-
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	160,629	9,638	150,991	-	150,991	160,629	160,629	-
рояльти	21,385	3,231	18,154	-	18,154	21,385	21,385	-
Торгууль	-	20,063	(20,063)	6,822	(13,229)	6,822	6,834	(11)
Нөхөн төлбөр	-	242	(242)	196	(46)	196	196	-
БО-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийн хэмжээ	-	678	(678)	480	(184)	480	494	(14)
Бусад	-	234	(234)	104	(122)	104	112	(8)
<b>Улсын түвшний нэгтгэлийн дүн</b>	<b>1,364,391</b>	<b>1,031,806</b>	<b>332,585</b>	<b>(76,865)</b>	<b>254,200</b>	<b>1,287,526</b>	<b>1,286,007</b>	<b>1,519</b>

5.3.2 ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНИЙ УРСГАЛЫН НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН: ОРЛОГЫН УРСГАЛААР

Орлогын урсгал	Анхлан тайлагнасан			Тохируулга		Тохируулгын дараа		
	ЗГ	Компани	Зөрүү	ЗГ	Компани	ЗГ	Компани	Зөрүү
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	16,274	15,063	1,211	(6)	1,210	16,268	16,273	(5)
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	647	344	303	(121)	208	526	553	(27)
Газрын төлбөр	11,401	13,080	(1,679)	262	(1,365)	11,662	11,716	(53)
Ус ашигласны төлбөр	29,847	27,686	2,161	1,089	3,265	30,936	30,951	(15)
Ус бохирдуулсны төлбөр	895	-	895	(867)	28	28	28	(0)
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	2,060	1,192	868	(1,268)	(408)	792	784	8
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	671	2,589	(1,918)	(201)	(2,114)	470	475	(5)
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	2,296	109	2,187	(75)	2,112	2,221	2,221	-
Орон нутгийн төрийн өмчийн ногдол ашиг	-	18	(18)	1,555	1,537	1,555	1,555	-
Торгууль	232	515	(283)	173	(98)	405	416	(12)
Нөхөн төлбөр	56	296	(240)	(29)	(269)	27	27	(0)
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	23	141	(118)	77	(39)	100	101	(1)
Бусад	4,781	397	4,384	(4,085)	233	696	630	67
Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	4,452	41,303	(36,851)	35,899	(1,003)	40,351	40,299	52
<b>Орон нутгийн хэмжээний нэгтгэлийн дүн</b>	<b>73,635</b>	<b>102,733</b>	<b>(29,097)</b>	<b>32,404</b>	<b>3,298</b>	<b>106,039</b>	<b>106,030</b>	<b>9</b>
<b>Нийт</b>	<b>1,438,027</b>	<b>1,134,539</b>	<b>303,487</b>	<b>(44,461)</b>	<b>257,498</b>	<b>1,393,565</b>	<b>1,392,037</b>	<b>1,528</b>

## 6 БУСАД АСУУДЛУУД

### 6.1 БЭЛЭН БУС ОРЛОГО (ШААРДЛАГА 4.1.С)

Нэгтгэлийн үр дүнд компаниуд болон төрийн байгууллагуудын мэдээллийг тулган батажуулсны дараах байдлаар нийт 31,9 тэрбум төгрөгийн мөнгөн бус хандив дэмжлэгийг уул уурхайн компаниуд төрийн байгууллагуудад олгосон байна. Дэлгэрэнгүйг Бүлэг 6.5-аас харна уу.

Нийт мөнгөн бус орлогын бараг ихэнх хувийг "Оюу Толгой" ХХК нь 30.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий цахилгааны шугамын өмчлөлийг "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК-д үнэ төлбөргүй шилжүүлэн өгсөн ба энэ нь 2015 оны мөнгөн бус орлогын 96%-ийг эзлэж байна.

Энэхүү "Оюу Толгой" ХХК-ийн өгсөн мөнгөн бус орлогыг Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн ажилтан Ё.Номинтунгалаг, "Оюу толгой" ХХК-ийн Бүртгэл тайлангийн менежер Н.Бат-Эрдэнэ нарын өгсөн мэдээлэл, Цахилгаан дамжуулах шугамын өмчлөл шилжүүлэх гэрээ, 2015 оны 12-р сарын 31-ний өдрийн холбогдох НӨАТ-ын падаан (№15396), 2013 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн НӨАТ-аас чөлөөлөх тухай Монгол улсын Сангийн сайдын тушаал №233 зэргийг үндэслэн тохируулсан.

### 6.2 ДЭД БҮТЦЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БА БАРТЕРЫН СОЛИЛЦОО (ШААРДЛАГА 4.1.D)

Бид нэгтгэлд хамрагдсан компаниуд болон төрийн байгууллагуудаас 2015 онд дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт ба бартерын солилцооны талаар мэдээлэл ирүүлэхийг хүссэн.

Дараах компаниуд нь ЗГ-ын концессгүйгээр 2015 онд дэд бүтцэд хөрөнгө оруулсан талаараа мэдээллэсэн.

#	Регистрийн #	Компанийн нэр	Хөрөнгө оруулалтын нэр	Хөрөнгө оруулалт хийсэн огноо	Гэрээн дээрх дэлгэрэнгүй мэдээлэл	Хөрөнгө оруулалт /гэрээний дүн/ /сая төгрөг/
1	2855119	Болдтөмөр Ерөө гол	Бохир цэвэр усны шугам засвар	2015/09/29	Ерөө сум Бугант тосгоны бохир цэвэр усны шугам засвар	Бугант тосгон, Ерөө сум, Баянгол сан 100
2	2855119	Болдтөмөр Ерөө гол	Инженер шугам зураг төсөл	2015/10/22	Сэлэнгэ аймаг Ерөө сум Инженерийн шугамын зураг төсөл	Ерөө сум, Зофир ХХК 144
3	2657457	Оюу Толгой	220 квт-ын цахилгааны шугам	2013/05/13	Цахилгааны шугамын өмчлөлийг МУЗГ-т үнэ төлбөргүй шилжүүлэн өгөх	ЦДҮС ТӨХК болон Оюу Толгой ХХК 30,633
4	2657457	Оюу Толгой	Цахилгааны шугам	2015/07/16	Ханбогд сумын цахилгааны шугам татах санхүүжилт	ӨБЦТС ТӨХК болон Оюу Толгой ХХК 270
5	5452503	Эм Эл Цахиурт Овоо	Зам засвар	2015/06/29	Сүхбаатар аймагт зам засах	Ланс констракшн ХХК 2,120
6	2766337	Доншен газрын тос (Монгол)	Дэд станцын барилга угсралтын ажил	2015/04/17	Цооногуудын олборлолтын 6кВ-ийн ЦДАШ, 100кВа болон 50кВа чадалтай 10 ширхэг АТП, дэд станц, 6кВ-ийн 2,5км цахилгаан	"ДГС" ХХК 180



МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны нэгтгэл тайлан

#	Регистрийн #	Компанийн нэр	Хөрөнгө оруулалтын нэр	Хөрөнгө оруулалт хийсэн огноо	Гэрээн дээрх дэлгэрэнгүй мэдээлэл	Хөрөнгө оруулалт /гэрээний дүн/ /сая төгрөг/
					дамжуулах агаарын шугамын барилгын ажил	
7	2766337	Доншен газрын тос (Монгол)	Интернетийн шилэн кабелийг баазын төв серверт холбох ажил	2015/05/08	200 метр интернетийн шилэн кабелийг баазын төв серверт холбох ажил	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК Дорноговь дахь Холбооны газар 2
8	2766337	Доншен газрын тос (Монгол)	Сүлжээний өргөтлийн тоног төхөөрөмж ийн ажил	2015/01/01	35/6кВ-ын Зүүнбаян дэд станцийн 6кВ-ын хуваарилах сүлжээний өргөтгөлийн хийх	"Чингүүд" ХХК 45
9	2766337	Доншен газрын тос (Монгол)	Трансформатор солих ажил	2015/01/14	6кВ гаргалгааны гүйдлийн трансформатор солих ажил	"Хүслийн цагаан уул" ХХК 3
10	2766337	Доншен газрын тос (Монгол)	Ууурхайн зам барилгын ажил	2015/01/01	18,5 км замын хучилтын ажлыг хийж дуусгах, барагшууны урьдчилгаа төлбөр болох 46200000	Дорноговь "АЗЗА" ТӨХК 257

Эх сурвалж: ОУ-ийн компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Дээрх дэд бүтцийн хөрөнгө оруулалтаас товч танилцуулбал:

**“Оюу толгой” ХХК-ийн хөрөнгө оруулалт**

2015 онд “Оюу толгой” ХХК нь өөрийн санхүүжилтээр барьсан Өмнөговь аймаг дахь “Оюу толгой” уурхайн цогцолбороос Монгол Улс болон БНХАУ-ын хил хүртэл 96 км үргэлжилсэн цахилгаан дамжуулах агаарын шугамыг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн өмчлөлд шилжүүлж, ашиглалт засвар үйлчилгээг хариуцах болсон.

Өмнөговь аймгаас БНХАУ-ын хил хүртэлх өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам 96 км урттай, хоёр хэлхээт 220 кВ-ын өндөр хүчдэлийн шугамыг 2011 онд барьсан бөгөөд 2012 оны 7 дугаар сараас ашиглаж эхэлсэн.

2014 оны 8 дугаар сард Засгийн газар, “Оюутолгой” ХХК хооронд байгуулсан “Өмнөд бүсийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ”<sup>38</sup>-ний дагуу “Оюутолгой” ХХК өөрийн хөрөнгөөр барьсан цахилгаан дамжуулах шугамыг төрийн мэдэлд ийнхүү үнэгүй шилжүүлсэн.

**Эм Эл Цахиурт Овоо**

Тус компани нь Сүхбаатар аймгийн Уулбаян суманд байрлах уурхайд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ тус уурхайгаас Бичигтийн боомт хүртэл нийт 300 гаруй км улсын чанартай авто замаар тээвэр хийхээр төлөвлөж байгаа бөгөөд энэхүү улсын чанартай авто замыг шинээр барьж байгуулах ажил дуусаагүй, одоогийн байдлаар шороон замтай байгаа тул уг замын ажил дууссаны дараа тээвэр хийх боломжтой болно. Үүнтэй холбоотойгоор “Лансконстракшн” ХХК-иар зам засварын ажил гүйцэтгүүлэхээр 2.1 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан байна.

<sup>38</sup> <http://www.mongolianminingjournal.com/content/61190.shtml>

### 6.3 НИЙГМИЙН ЗАРЦУУЛАЛТ (ШААРДЛАГА 6.1)

Нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалтад компаниудаас нийгмийн сайн сайханд зориулан гаргасан зардлууд багтдаг ба эдгээр нь ихэвчлэн уурхайн ойр орчмын нутгийн иргэдэд зориулагддаг. Нэгтгэлд сонгогдсон 202 компаниудаас Хавсралт 17-д харуулсан компаниуд өөрсдийн 2015 онд хийсэн нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалтаа тайлагнасан.

#### Оюу толгой ХХК

Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-д зааснаар Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

2015 оны 4 дүгээр сард Оюу толгой ХХК нь Өмнөговь аймаг, Ханбогд сум, Манлай сум, Баян-Овоо сум, Даланзадгад сумуудтай Хамтын ажиллагааны гэрээг байгуулсан байна.

Хөрөнгө оруулалтын гэрээнд заасанчлан Оюу толгой ХХК нь Хөрөнгө оруулагч бөгөөд ОТ Төсөл нь Өмнөговь аймагт оршдог.

Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор Хөгжлийг дэмжих сан (ХДС)-г бий болгож, түүнийг санхүүжүүлэх болон аливаа төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлснээр Оюу толгой ХХК нь орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр үзүүлнэ.

Гэрээнд зааснаар ХДС-г байгуулсны дараа ОТ ХХК нь доор заасан тохируулгын дагуу хуанлийн нэг жилд нийт таван сая Америк доллар (5,000,000 ам.доллар) (эсхүл үүнээс богино хугацаанд хувь тэнцүүлсэн дүнгийн хэмжээгээр)–ыг ХДС-д Төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх зорилгоор ХДС-д шилжүүлнэ.

2017 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тухайн нэг жилд олгох Санхүүгийн дэмжлэгийн хэмжээг дор дурдсан томъёоны дагуу тооцолно:

$$\text{Жил\_Санхүү.дэмжлэг}_t = 5,000,000 \text{ ам.доллар} \times \frac{\text{ХҮИ}_{t-1}^{\text{АНУ}}}{\text{ХҮИ}_{\text{суурь хугацаа}=2015 \text{ оны } 7\text{-р сар}}^{\text{АНУ}}$$

Үүнд:

Жил\_Санхүү.дэмжлэг<sub>t</sub> гэж тухайн t жилд ОТ ХХК-иас олгох Санхүүгийн дэмжлэгийн хэмжээг ойлгоно.

ХҮИ<sup>АНУ</sup><sub>t-1</sub> гэж АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн хорооноос гаргадаг АНУ-ын улирлын зохицуулалт хийгдээгүй Хэрэглээний Үнийн Индексийн (t-1) оны 7 дугаар сарын ерөнхий түвшинг ойлгоно.

ХҮИ<sup>АНУ</sup><sub>суурь хугацаа=2015 оны 7-р сар</sub> гэж АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн хорооноос гаргадаг АНУ-ын улирлын зохицуулалт хийгдээгүй Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 7 дугаар сарын ерөнхий түвшинг ойлгоно.

6.4 ТЭЭВРИЙН ОРЛОГО (ШААРДЛАГА 4.1.F)

Газрын тос, байгалийн хий, байгалийн баялгийн тээвэрлэлтээс олсон орлого нь материаллаг байгаа үед Засгийн газар болон Төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)-үүд хүлээн авсан орлогоо толилуулах шаардлагатай байдаг. Бид Засгийн газар болон ТӨААН-үүдийн хүлээн авсан Монголын уул уурхайн олборлох аж үйлдвэрийн салбарын материаллаг хэмжээний тээврийн орлогыг олж илрүүлээгүй.

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газраас Монгол оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам"-аар эрдэс баялгийн 2015 оны тээвэрлэлтийн талаар дараах мэдээг гаргасан. Үүнд:

№	Ачааны нэр	Вагон/ширхэгээр /		Ачаа /мян. тонноор/	
		2014	2015	2014	2015
1	Чулуун нүүрс	101,010.00	98,758.00	6,596.19	6,435.14
2	Нефть	3,362.00	2,435.00	200.75	142.50
3	Цемент	22,866.00	14,749.00	1,473.00	960.10
4	Хайрга	12,147.00	8,729.00	730.75	555.60
5	Хайлуур жонш	4,990.00	4,350.00	321.95	278.29
6	Зэсийн концентрат	8,788.00	9,237.00	583.85	611.76
7	Төмөрийн хүдэр	70,575.00	61,748.00	4,823.90	4,240.52
8	Цайрын хүдэр	1,640.00	1,400.00	98.71	84.28
9	Хар металл	5,305.00	2,865.00	284.34	149.59
10	Өнгөт металл	311.00	375.00	11.25	16.70
<b>Бүгд</b>		<b>230,994.00</b>	<b>204,646.00</b>	<b>15,124.69</b>	<b>13,474.48</b>

Эх үүсвэр: Зам тээврийн яам

Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газраас улс хоорондын байнгын ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын 2015 оны автозамын тээвэрлэлтийн мэдээг дараах байдлаар гаргаж өгсөн. Үүнд:

Маршрут	Тээсэн ачааны	Ачаа эргэлт	Орлого
	Хэмжээ /мянган тонн/	/мянган тонн км/	/мянган төгрөг/
Маршрут 1: Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Тавантолгой, Ухаа худгийн уурхай Гашуун сухайт-Ганц мод боомт	3,578.1	841,142.7	43,897,243.4
Маршрут 2: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгой Гашуун сухайт Ганц мод боомт	724.8	92,245.0	19,791,800.7
Маршрут 3: Өмнөговь аймгийн Гурван тэс сум Овоот толгой МАК-с Шивээ хүрэн - Сэхээ боомт	3,089.7	185,528.9	17,796,649.0
Маршрут 4: Дорноговь аймгийн Хөвсгөл сумын Айлбаянгийн уурхайгаас Ханги - Мандлын боомт	393.1	37,099.9	5,895,960.0
Маршрут 5: Дорнод аймгийн Тамсагийн сав газраас Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигтийн боомтын чиглэлд	598.3	490,620.8	57,965,047.8
Маршрут 6: Дорнод аймгийн Тамсагийн сав газраас Халх гол сумын Баянхошуу боомтын чиглэлд	313.1	200,357.8	30,329,155.9
Маршрут 7: Ховд аймгийн Дарви сумын Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Булган сумын Ярант-Такешикин боомт	217.9	76,268.2	11,735,489.2
Маршрут 8: Говь-Алтай аймгийн Цээл сумын Таяннуурын уурхайгаас Говь-Алтай аймгийн Бугат сумын Бургастай-Лаомея	816.0	83,191.9	6,936,382.5
<b>Дүн</b>	<b>6,278.6</b>	<b>1,190,761.4</b>	<b>153,884,111.1</b>

Эх сурвалж: Зам тээврийн яам

## 6.5 ХАНДИВ

Олборлох үйлдвэрлэлийн компаниуд нь 2015 онд мөнгөн болон мөнгөн бус хэлбэрийн хандив дэмжлэгийг төрийн болон орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн. Төрийн байгууллагууд болон компаниудаас ирүүлсэн мэдээллүүд нь зөрүүтэй байсан тул тохируулга хийж зөрүүг тохируулсан.

Дээр дурдсанчлан заавал тайлагнах хандив дэмжлэгүүдийг нэгтгэлд оруулж тохируулга хийсэн бол сайн дурын тайлагналын хандив дэмжлэгүүдэд тохируулга хийгээгүй. ОТАХ-ийн зүгээс гаргасан хүсэлтийн дагуу ТББ-д олгосон хандивын мэдээллийг нэгтгэж гаргасан. Энэхүү хандивын дэлгэрэнгүйг Хавсралт 11б-ээс харна уу.

Хандив, дэмжлэгийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 11а-аас харна уу.

2015 онд нэгтгэлд хамрагдсан компаниудаас 98 компани нийт 40.3 тэрбум төгрөгийн мөнгөн болон мөнгөн бус хандивыг олгосон байна. Нийт хандив, дэмжлэгийн 95%-ийг Оюу Толгой ХХК, Бороо Гоулд ХХК, ГБНБ ХХК, Шинь Шинь ХХК, МонЭнКо ХХК гэсэн 5 компани үзүүлжээ.

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг зориулалтаар нь харуулбал дараах байдалтай байна.

Зориулалт	Хандивын дүн (сая төгрөг)	Эзлэх хувь
Боловсрол	2,027	5%
Дэд бүтэц	31,220	77%
Нийгэм	279	1%
Соёл	5,639	14%
Эрүүл мэнд	550	1%
Бусад	636	2%
<b>Нийт</b>	<b>40,351</b>	

Эх сурвалж: Компаниуд болон төрийн байгууллагууд нь мэдээллийг 2 талаасаа баталгаажуулсан.

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг авсан төрийн байгууллагуудын төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хандив хүлээн авагч	Мөнгөн хандив (сая төгрөг)	Мөнгөн бус хандив (сая төгрөг)	Дүн (сая төгрөг)	Эзлэх хувь
Сум, дүүргийн авсан хандив, дэмжлэг	1,323	884	2,207	5.5%
Яам агентлагийн авсан хандив, дэмжлэг	35	9	44	0.1%
Аймаг, нийслэлийн авсан хандив, дэмжлэг	7,072	387	7,459	18.5%
Төрийн өмчит байгууллагад өгсөн хандив	8	30,633	30,641	75.9%
<b>Хандивын тохируулсан дүн</b>	<b>8,438</b>	<b>31,913</b>	<b>40,351</b>	

Тохируулгын дараах байдлаар нийт хандив, дэмжлэгийг авсан аймгуудаар нь харуулбал дараах байдалтай байна.

МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны нэгтгэл тайлан

Хандив хүлээн авагч	Мөнгөн хандив (сая төгрөг)	Мөнгөн бус хандив (сая төгрөг)	Дүн (сая төгрөг)	Эзлэх хувь
Баян-Өлгий	81	-	81	0.2%
Баянхонгор	189	-	189	0.5%
Булган	295	167	462	1.1%
Говь-Алтай	12	32	44	0.1%
Дархан	1	1	2	0.0%
Дорноговь	6	-	6	0.0%
Дорнод	112	265	377	0.9%
Дундговь	7	4	11	0.0%
Өвөрхангай	3	-	3	0.0%
Өмнөговь	6,004	30,950	36,954	91.6%
Сүхбаатар	174	-	174	0.4%
Сэлэнгэ	88	196	284	0.7%
Төв	323	205	528	1.3%
Увс	49	4	53	0.1%
Улаанбаатар	981	4	985	2.4%
Ховд	112	2	114	0.3%
Хөвсгөл	6	-	6	0.0%
Хэнтий	78	-	78	0.2%
<b>Нийт</b>	<b>8,521</b>	<b>31,830</b>	<b>40,351</b>	

## 6.6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

### 6.6.1 ТӨРӨӨС БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ХҮРЭЭНД БАРИМТЛАХ БОДЛОГО

2014-2025 он хүртэл Төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлогод байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн хүрээнд дараах бодлогуудыг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:

- олборлох болон боловсруулах үйлдвэрлэлийн үе шатуудад хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатай, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрт байдлыг хангасан байх;
- төрийн өмчийн аж ахуйн нэгж нь ерөнхий гэрээлэгчийн зарчмаар ажиллаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг хэрэгжүүлэх;
- уурхайн нөхөн сэргээлт, хаалтын стандарт, журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах;
- эрдэс баялгийн олборлох болон боловсруулах үйлдвэрлэлд газрын гүний цэнгэг усыг аль болох ашиглахгүй байх, гадаргын усыг түлхүү ашиглах, холбогдох хуульд заасны дагуу хэрэглэсэн усыг дахин ашиглах, уул уурхайн салбарын ахуйн хэрэглээнд саарал усыг ашиглах, орчин үеийн дэвшилтэт технологийг дэмжих;

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр 2015 онд батлагдсан дүрэм журмын хураангуйг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны нэгтгэл тайлан

№	Тогтоол шийдвэр	Дүрэм журмын дэлгэрэнгүй
1	Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 120 дугаар тогтоол	Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам
2	БОНХАЖ-ын Сайд, УУ-н сайдын хамтарсан тушаал. 2016.03.16 №а-28/а-69	"Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам батлах тухай"
3	БОНХАЖЯ-ын Сайдын 2015.12.16-ны А/419 дугаар тушаал.	"Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авсан тухай актын загвар батлах тухай"
4	БОНХАЖ-ын Сайдын 2015.3.30-ны өдрийн А/138 дугаар тушаал	"Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачилал"

### 6.6.2 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУСГАЙ ДАНС

БОАЖЯ-аас авсан мэдээллийн дагуу 2015 онд нийт 105 компани нөхөн сэргээлтийн зардлын 50 хувь болох нийт 1,027.5 сая төгрөгийг дансанд төвлөрүүлсэн байна. Тусгай данснаас 2015 онд ямар нэгэн зарлага гараагүй байна. 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн эцсийн үлдэгдэл нь доорх хүснэгтэд харуулснаар 10,207 сая төгрөг байна.

Он	Орлого сая төгрөг	Зарлага сая төгрөг	Эцсийн үлдэгдэл сая төгрөг
2006	22	-	22
2007	612	-	634
2008	566	-21	1 179
2009	385	-126	1 439
2010	942	-1	2 380
2011	1 216	-5	3 590
2012	2 014	-16	5 588
2013	1 545	-225	6 908
2014	2 273	-1	9 180
2015	1 027	0	10 207
<b>Нийт</b>	<b>10 602</b>	<b>-395</b>	

Эх сурвалж: Байгаль орчин, Ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн мэдээлэл

2015 онд Эрдэнэт үйлдвэр ХХК тусгай дансанд хамгийн их орлого төвлөрүүлсэн бөгөөд доорх хүснэгтэд орсон компаниуд нь нийт байгаль орчин хамгаалах тусгай дансанд орсон орлогын 50.5%-ийг бүрдүүлсэн байна. Үүнд:

Нэрс	Байршуулсан дүн Мян.төгрөгөөр	Хувь хэмжээ
Эрдэнэт үйлдвэр ХХК	211,500	20.6%
Капкорп Монголиа ХХК	113,791	11.1%
Ачит-Ихт ХХК	41,994	4.1%
Спейшл майнинг сервис ХХК	30,036	2.9%
Баян ХХК	27,243	2.7%
Тайшэндевелопмент ХХК	25,000	2.4%
Хур эрдэнэ баялаг ХХК	24,925	2.4%
Багануур ХК	22,500	2.2%
Цагаан өвөлжөө ХХК	22,000	2.1%
<b>Дүн</b>	<b>518,989</b>	<b>50.5%</b>

Эх сурвалж: Байгаль орчин, Ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн мэдээлэл

Нөхөн сэргээлтийн зардлын 50 хувь болох нийт 1,027.5 сая төгрөгийг дансанд төвлөрүүлсэн бүх 105 компанийн мэдээллийг Хавсралт 23-аас харна уу.

### 6.6.3 УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ, 2006-2015

АМГТГ-ын 2015 оны ашигт малтмалын статистикийн тайланд нийт 871 га талбай газар уулын ажилд хамрагдсанаас 86% буюу 750 га талбай газарт нөхөн сэргээлт хийгдсэн байна. 2015 онд нөхөн сэргээлтийн нийт зардал нь 92,878 сая төгрөг болсон байна.<sup>39</sup>

Уул уурхайн салбарын нөхөн сэргээлтийн гүйцэтгэл									
	Нэгж	Өмнөх жилүүд	2010	2011	2012	2013	2014	2015	Нийт
Уулын ажилд хамрагдсан талбай	Га	18 417	1 709	2 042	1 430	1 038	1 561	871	<b>27 068</b>
Нөхөн сэргээлт хийгдсэн талбай	га	13 170	1 533	1 443	1 402	807	960	750	<b>20 065</b>
Нөхөн сэргээлтийн харьцаа	%	72%	90%	71%	98%	78%	61%	86%	<b>74%</b>
Нөхөн сэргээлтийн зардал	Сая төгрөг	11 183	9 657	7 013	14 808	7 382	9 212	4019	<b>92 878</b>

Сүүлийн 5 жилийн уулын ажилд хамрагдсан талбайг нөхөн сэргээгдсэн талбайтай харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:



Эх үүсвэр: АМГ-ын статистик мэдээлэл

БОАЖЯ-наас нөхөн сэргээлт хийх тусгай зөвшөөрөл авсан компаниудын жагсаалтыг Хавсралт 26-аас харна уу.

Нэгтгэлд хамрагдсан компаниудын нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг Хавсралт 24; 25-ээс харна уу.

<sup>39</sup>Эх сурвалж: Ашигт Малтмалын Газар, Ашигт Малтмалын Сарын Статистик, 2016 оны 9 дүгээр сар



## 6.7 ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ

### 6.7.1 ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА

ОУИТБС-ын Цахим мэдээллийн нэгдсэн сан нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэгч оролцогчдын үйл ажиллагааг хөнгөвчлөх, ил тодын цогц мэдээллийг нэг дороос авах боломжийг бий болгосон веб-д суурилсан програм хангамж юм.

Цахим мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх болсон гол хэрэгцээ, шаардлага зорилго нь Монгол Улс ОУИТБС-д нэгдэн орсон 2006 оноос хойш нийтдээ 9 жилийн тайланг хэвлэн нийтэлж, дэлхийн болон Монголын олон нийтийн хүртээл болгосон боловч энэ их мэдээллийг урьд өмнө нь цаасан байдлаар тайлагнахад материал их зарцуулах, хугацаа алдах, төрөл бүрийн техникийн алдаа гарах, мэдээллийн ач холбогдол, хүртээмж буурах зэрэг хүндрэлүүд гарч байсан тул ОУИТБС-ын тайланг цахимаар тайлагнах, цугларсан мэдээллийг олон нийтэд хурдан, шүүрхай хүргэх, мэдээллийн ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын цахим тайлагналын системийг нэвтрүүлэх” төслийг Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр, Адам Смит интернэйшнл хүрээлэнгийн техник туслалцаатайгаар Монгол Улсын “Интерактив” ХХК 2014-2015 онд гүйцэтгэж, системийг ашиглалтанд оруулаад байна.

Уул уурхайн салбартай холбоотой тухайлбал тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, төлсөн татвар төлбөр, хандив, дэмжлэг зэрэг өргөн цар хүрээний мэдээлэл нэг дор төвлөрч, иргэн, байгууллагын хэн ч хаанаас ч сонирхсон мэдээллээ янз бүрийн хэлбэрээр авах боломжтой болсон нь ОУИТБС-ын Цахим мэдээллийн нэгдсэн сангийн гол ач холбогдол юм.

Цахим тайлагналын системийн үе шатыг харуулбал:


- 2013 оноос системийн судалгаа эхэлсэн,
- 2014 оны 4-р сараас боловсруулах ажил эхэлж 5 сарын хугацаанд амжилттай дүүссэн,
- 2015 оны 1-р сарын 1-ээс 2014 оны ОУИТБС-ын тайланг хүлээн авч эхэлсэн,
- 2015 оны 9-р сараас төслийн 2-р үе шатны ажил эхэлж одоо үргэлжилж байна.

2015 оны 11 сарын 05-нд МОУИТБС-ын анхдугаар Үндэсний чуулганаас ОУИТБС-ын цахим тайлагналын системийг олборлох салбарын ил тод байдлын нэг цэгийн үйлчилгээ болгож өргөжүүлэх, бусад эх сурвалжуудыг холбож, нэг цонхны үйлчилгээ болгох тухай зөвлөмж гаргасан.

ОУИТБС-ын тайланг цахимаар авдаг болсоноор дараах давуу талууд бий болсон. Үүнд:

- Тайлагнах, тайланг хүлээх авах үйл явцыг хялбар болгож цахимжуулах, цаг хугацаа, цаас хэмнэх, хүнд суртлыг бууруулах
- Тайлангийн нэгтгэл, тулган баталгаажуулалтын үйл явцыг хялбаршуулах
- Мэдээллийн бусад эх сурвалжтай холбогдож мэдээлэл солилцох
- Мэдээлэл авахад хялбар, энгийн, ойлгомжтой нэгдсэн систем бий болгож мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ил тод байдлыг дээшлүүлэх

Цахим тайлагналын системийн ерөнхий бүтцийг харуулбал дараах байдалтай байна. Зураг:



#### 6.7.2 ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМИЙН БАЙДАЛ

Нэгтгэлийн явцад МОУИТБС-ийн цахим тайлагналын системийг хянаж үзээд цахим тайлангийн систем хэвийн явагдаж байгаа ба системийн хөгжүүлэлтийн хийгээд хэрэгжүүлэлтийн шатанд өгсөн зөвлөмжүүд биелэгдсэн гэж үзэж байна.

Цахим тайлагналын системийг бүрэн хүлээж авах болон цаашдын хэвийн үйл ажиллагааг хангахад 7.2.6.3 –д өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй.

## 7 ЗӨВЛӨМЖ

### 7.1 ӨМНӨХ ЖИЛИЙН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

ОУИТБС-ын тайлангуудаар өгөгдсөн зөвлөмжүүдийг шалгаж, хэрэгжсэн эсэх болон хэрхэн хэрэгжүүлэх талаар авч үзэх ажлын хэсгийг Монголын ОУИТБС байгуулсан. Бид ажлын хэсгийн гаргасан хэрэгжилтийн үнэлгээний дэлгэрэнгүй мэдээллийг авсан ба Хавсралт 31-д оруулсан.

2014 онд өгөгдсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийн байдлын талаарх дүгнэлтийг дор харуулав:

## МОУИТБС-ын 10 дугаар буюу 2015 оны нэгтгэл тайлан

Зөвлөмжүүд	2014 оны ОУИТБС тайлагнал дахь лавлагаа	2015 оны ОУИТБС тайлагналаарх хэрэгжилтийн явц
Цахим тайлангийн мэдээлэл технологийн платформ, холбогдох мэдээлэл технологийн хяналтууд болон түүний орчинг сайжруулах зорилгоор өргөн хүрээтэй шалгалт явуулах.	6.2.1	Хэрэгжиж байгаа
Цахим тайлангийн систем ашиглан электрон хэлбэрээр цуглуулах үндсэн мэдээллийн хэлбэр, цар хүрээг тодорхойлох болон мэдээлэл цуглуулах маягтын загварыг гаргах үйл явцдаа ОТАХ болон Хараат бус хянагч-нэгтгэгчийг оролцуулах	6.2.2	Хэрэгжиж байгаа
Компаниудад ОУИТБС-ын шаардлага, тайлагналын үйл явц болон ОУИТБС-ын ач холбогдлыг бүхэлд нь илүү сайн сурталчлан таниулах.	6.2.3	Хэрэгжиж байгаа
ЗГ-ын түвшинд аливаа нэг аж ахуйн нэгжийн олборлох үйлдвэрлэлээс эсвэл өөр бусад бизнесийн үйл ажиллагаанаас олсон орлогын урсгалыг хооронд нь ялгаж, ангилах горимыг хэрхэн хэрэгжүүлэх талаар авч үзэх	6.2.4	Хэрэгжиж байгаа
Орлогын урсгалыг төслийн түвшинд задлан харуулахын тулд боломжтой нөхцөлд орлогын урсгалыг төслийн түвшинд хэрхэн ялгах талаар авч үзэх	6.2.5	Хэрэгжээгүй
Хангалттай хэмжээнд ОУ-ийн компаниудын ялангуяа үүн дотроо дунд болон томоохон компаниудын үнэн зөв, иж бүрэн холбоо барих мэдээллийг (и-мэйл хаяг, ашиглалтад буй утасны дугаар болон байршлын хаяг гэх мэт) багтаасан мэдээллийн сан үүсгэн хадгалж, тогтмол шинэчилж байх	6.2.6	Хэрэгжиж байгаа
МОУИТБС-ын Ажлын Албанд тайлагнахыг шаардсан бүх зүйлс болон орлогын урсгалд маш тодорхой зааварчилгаа өгөх.	6.2.7	Хэрэгжиж байгаа
ОУИТБС-ын үйл явцын хүрээнд тайлагнасан санхүүгийн мэдээлэл болон үндсэн мэдээлэлд хязгаарлагдмал баталгаажуулалт шаардлагатай гэдгийг онцолж, энэ талаар компаниудад тодруулж өгөх.	6.2.8	Хэрэгжиж байгаа
Цаашид ЗГ-ын тайлагнасан мэдээллийн баталгаажуулалтын хэлбэрийг тодорхойлж, холбогдох процессыг сайжруулах.	6.2.9	Хэрэгжээгүй
ОУИТБС-ын стандартын дагуу шаардлагатай бүхий л мэдээллийг тайлагнахад нь ТӨААН-ийг дэмжиж ажиллахын зэрэгцээ тайлагналд учирч болох саад бэрхшээлийг олж мэдэх	6.2.10	Хэрэгжээгүй
Уг асуудлуудын хүрээнд кадастрын мэдээллийг олон нийтэд ил тод болгож сайжруулах, мөн өргөдөл гаргасан өдөр олгосон болон дуусгавар болох өдөр зэрэг ОУИТБС-ын стандартаар шаардсан мэдээллийг кадастрын мэдээлэлд хамруулах	6.2.11	Хэрэгжээгүй
Хараат бус хянагч-нэгтгэгчийг аль болох эрт сонгож, үүрэгт ажилд нь оролцуулах шаардлагатай.	6.2.12	Хэрэгжээгүй

## 7.2 ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР ЦААШИД ЗӨВЛӨМЖ

Монгол улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх явдлыг улам сайжруулах талаар 2015 оны ОУИТБС-ын тайланг бэлтгэх явцад үүссэн асуудлаар дараах зөвлөмжүүдийг өгч байна.

### 7.2.1 БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ ОЛОН НИЙТЭД ИЛ ТОД БУС БАЙНА

Бид 2015 онд байгуулагдсан БХГ-нүүдийг ил тод болгох арга замыг олоход бэлэн биш байна. АМГТГ-аас 2015 онд байгуулсан БХГ-ний хуулбарыг гаргаж ирүүлэхийг хүссэн боловч одоог хүртэл ямар ч БХГ-г ирүүлээгүй байна.

ОУИТБС-ын 2013 оны тайлан нэгтгэлийг хийсэн Хараат бус нэгтгэгч нь Уул уурхайн сайдаас тодорхой мэдээллүүдийн зарим заалтыг ил болгоход нууцлахгүй гэдгээ албан бичгээр мэдэгдсэн. Үүнд:

1. БХГ тус бүрийн гарын үсэг
2. БХГ тус бүрээс МУ-ын ЗГ-д ногдох хувь хэмжээ

2014 онд хууль батлагдсанаар БХГ тухайлбал, 2015 онд хийгдсэн БХГ олон нийтэд ил тод болох ёстой гэж бид ойлгож байгаа.

### **Зөвлөмж**

Үндэсний зөвлөлөөс нь энэ асуудлыг Уул уурхайн сайдад даалгаж, АМГТГ нь БХГ-үүдийг олон нийтэд ил болгох нь зүйтэй.

## **7.2.2 ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН МЭДЭЭЛЭЛ**

### **7.2.2.1 ОУИТБС нь тусгай зөвшөөрлийн мэдээллийг ил тод болгохыг шаарддаг**

Одоогийн байдлаар ил тод болгосон байгаа тусгай зөвшөөрлийн мэдээлэл нь ОУИТБС-ын Стандарт 2.3.b-д заасан шаардлагыг хангахгүй байна.

### **Зөвлөмж**

АМГТГ нь олон нийтэд ил тод болгосон тусгай зөвшөөрлийн мэдээлэл нь ОУИТБС-ын Стандартын хамгийн наад захын шаардлагыг хангасан байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. *(энэ зөвлөмжийг өмнө жил бас өгсөн байсан)*

### **7.2.2.2 АМГТГ-ын кадастрын албаны гарсан лицензийн мэдээллийн нийцтэй байдал**

АМГТГ нь хоёр төрлийн тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний нэгтгэлийг гаргадаг. Үүнд:

- iii. 2010-аас 2015 он хүртэлх жил бүрийн эцэст хүчинтэй байгаа ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн нэгтгэл;
- iv. 2015 оны туршид шинээр олгосон, цуцлагдсан, шилжүүлсэн болон бусад өөрчлөлтийг харуулсан хөдөлгөөний шинжилгээ;

2014 болон 2015 оны тусгай зөвшөөрлийн үлдэгдлүүдийн өөрчлөлт нь дээр дурьдсан хоёр нэгтгэлийн дүнгээс зөрүүтэй ба 2015 оны 12 сарын 31-нээрх хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн үлдэгдэлтэй таарахгүй байна. Энэ талаар асуухад АМГТГ нь тусгай зөвшөөрлийн хөдөлгөөнийг тохируулах боломжгүй гэсэн хариулт өгсөн.

Тусгай зөвшөөрлүүдийн хөдөлгөөнөөс үүдсэн энэхүү тодорхой бус зөрүү нь анхаарал хандуулбал зохино. Энэ нь тусгай зөвшөөрлүүдийн бүртгэл хөтлөлттэй холбоотой байж болох юм.

### **Зөвлөмж**

АМГТГ нь лицензийн талаарх тодруулж буй мэдээллээ зохистой эсэхийг нягталж үзэж, Ажлын хэсэг нь энэ асуудлын мөрөөр АМГТГ-т хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.

### 7.2.3 ТӨААН-ИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Эрдэнэс Монгол компанийн 2015 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитор нь аудитын дүгнэлтэнд зааснаар Групп нь 2014 болон 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар уул уурхайтай холбоотой өсөн нэмэгдэж байгаа нөхөн сэргээлтийн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд шаардлагатай ажлын олон талт үнэлгээ хийхгүй байгаа нь холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандарт (НББОУС 37)-ын заалттай нийцэхгүй байна.

Олборлолтын үед болон дараах байгаль орчны нөхөн сэргээлт нь компанийн нийгмийн хариуцлагыг үнэлэх нэг үзүүлэлт бөгөөд Групп нь хуулийн хариуцлагаа биелүүлэх, нөгөө талаас үйлдвэрийн хамгийн сайн практикийг биелүүлэх үүднээс нөхөн сэргээлтийн дэлгэрэнгүй төлөвлөгөөтэй байх ёстой.

#### **Зөвлөмж**

Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь АМГТГ-тай бүх олборлох үйлдвэрлэлийн ТӨААН-үүдийг нөхөн сэргээлтийн иж бүрэн төлөвлөгөөг боловсруулж, цаашдын санхүүгийн тайландаа нөхөн сэргээлтийн зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу тусгахыг зөвлөж байна.

### 7.2.4 ТӨААН-ИЙН САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ

ТӨААН-үүдийн 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлангаас харахад зарим нэг нь нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй холбоотой хязгаарлалттай дүгнэлт авсан байна. 2015 оны Засгийн газрын нэгдсэн аудитын тайланд Эрдэнэс Монгол компанитай холбоотой 123 тэрбум төгрөгийн зөрүүнд хязгаарлалт тавьсан байна.

ОУИБТС нь төлбөр болон орлого нь найдвартай эсэх, хараат бус аудит нь аудитын олон улсын стандартыг мөрдсөн эсэх дээр үнэлгээ хийх шаардлагатай. ТӨААН-үүдийн хараат бус аудитын ТӨААН-үүдийн тайланд илүү баталгаажуулалт өгөх учир санхүүгийн хяналт чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байна. Ажлын хэсэг болон Үндэсний зөвлөл нь ТӨААН-ийн мэдээлэл нь найдвартай эсэхэд анхаарал тавих нь зүйтэй.

#### **Зөвлөмж**

Ажлын хэсэг нь аудитын тайланд өгсөн хязгаарлалтын талаар Сангийн яам болон ТӨААН-үүдтэй зөвшилцөж, санхүүгийн хяналтанд шаардлагатай сайжруулалтыг авч хэрэгжүүлэх төлөвлөгөө цаг хугацаа, боломж нөөц байгаа эсэхийг баталгаажуулахыг зөвлөж байна.

### 7.2.5 БАТАЛГААЖУУЛАЛТ

#### **7.2.5.1 Аудит, баталгаажуулалт: Засгийн газар**

Үндэсний аудитын газар (МҮАГ) нь ОУИТБС-д ирүүлсэн Засгийн газрын тоон мэдээлэлд ямар нэгэн баталгаа өгч чадахгүй байсан. Учир нь УАГ-ын батлагдсан аудитын төлөвлөгөөнд энэ ажил нь тусгагдаагүй байдаг.

### **Зөвлөмж**

ОУИТБС-ын Засгийн газрын тайлагналын баталгаажуулалтыг сайжруулахын тулд Ажлын хэсэг нь МҮАГ-тай хамтран ажиллахыг зөвлөж байна. ҮАГ-ын ажлын төлөвлөгөөнд энэ ажлыг тусгуулсанаар ЗГ-ын ОУИТБС-д ирүүлсэн мэдээнд дүгнэлт өгөхөд шаардлагатай нөөц бололцоо болон цаг хугацаа бүрэлдэнэ.

Дараагийн тайланд энэхүү асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд ҮАГ-ын 2017 оны ажлын төлөвлөгөө батлагдах гэж байгаа энэ үед нэн даруй ҮАГ-тай зөвшилцөх шаардлагатай.

#### **7.2.5.2 Аудит, баталгаажуулалт: Компаниуд**

2015 оны нэгтгэлд хамрагдсан 191 хувийн хэвшлийн компаниудаас 120 компани нь аудитлагдсан санхүүгийн тайлангаа ирүүлээгүй. Компаниудын тайлагнасан дүнд баталгаажуулалт олж авах болон аудитын тайлан авах шаардлагуудыг ОТАХ тодорхойлсон.

Удирдлагын хариуцлагын захидал болон аудитлагдсан санхүүгийн тайлангаа өгөөгүй компаниуд дунд хамгийн өндөр төлбөр төлсөн Топ 10 компанийн 2 нь орж байна.

### **Зөвлөмж**

Эдгээр баталгаажуулалтын асуудлуудын нийцлийн түвшин чухал учир сайжруулах шаардлагатай. ОУИТБС-ын Ажлын алба нь дараагийн ОУИТБС-ын тайланд илүү сайн нийцлийг бий болгохын тулд компаниуд, ТӨААН болон Засгийн газрын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай.

#### **7.2.5.3 Удирдлагын баталгаажуулалт**

2015 оны нэгтгэлд хамрагдсан 191 компаниудаас 45 компани нь ОУИТБС-д ирүүлсэн тоон мэдээлэлдээ ТУЗ-ийн баталгаажуулалтыг ирүүлээгүй. Түүнчлэн 1 ТӨААН болон Засгийн газрын 6 байгууллага нь Удирдлагын хариуцлагын захидлаа ирүүлээгүй нь Ажлын хэсгийн шаардлагатай нийцэхгүй байна.

### **Зөвлөмж**

Эдгээр баталгаажуулалтын асуудлын нийцлийн түвшинг сайжруулах нь чухал ач холбогдолтой. ОУИТБС-ын ажлын алба нь дараагийн ОУИТБС-ын тайлан дахь нийцлийг сайжруулахын тулд компаниуд, ТӨААН болон Засгийн газартай хамтын ажиллагаагаа сайжруулах шаардлагатай.

---

## **7.2.6 ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ**

### **7.2.6.1 Засгийн газар, компаниудын цахим тайлагналын системийн хэрэглээ**

Эхлэлийн үе шатанд бид компани, Засгийн газрын байгууллагуудаас МОУИТБС-ын цахим тайлагналын системд мэдээллээ оруулаагүй зарим байгууллага, компани байгааг дурьдсан. Нэгтгэлд хамрагдсан компаниудаас 2 Засгийн газрын байгууллага, 5 ТӨААН болон 71 уул уурхайн компани мэдээллээ оруулаагүй байсан. Нэгтгэлд хамрагдахгүй гэж үзсэн бусад компаниудаас мөн цахим тайлагналын системд мэдээлэл оруулаагүй компаниуд байсан.

Эдгээр үл нийцсэн компаниудаас маягтын дагуу мэдээлэл цуглуулахын оронд энэ механизмыг цахим тайлагналын системээр хийх зорилготой юм.

### **Зөвлөмж**

ОУИТБС-ын Ажлын алба нь дараагийн ОУИТБС-ын тайлангийн нийцлийг сайжруулах үүднээс компаниуд, ТӨААН болон Засгийн газартай хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэхийг зөвлөж байна. Ажлын хэсэг нь үл нийцэх асуудал гарвал зөвшөөрөл авах механизмыг харгалзан үзэх шаардлагатай.

#### **7.2.6.2 Олборлох үйлдвэрлэлийн бус компаниуд**

Нэгтгэлд хамрагдах компанийг сонгох явцад МОУИТБС-ын цахим тайлагналын системд тайлагнасан хэд хэдэн компани үндсэн үйл ажиллагаа нь олборлох үйлдвэрлэлд хамаарахгүй байгааг тодорхойлсон.

### **Зөвлөмж**

ОУИТБС-ийн ОТАХ нь ОУИТБС-ын тайлан бүрийн өмнө цахим тайлагналын системийг ашиглан тухайн компаниудыг олборлох үйлдвэрлэлийн компани мөн эсэхийг урьдчилан шалгаж байхыг зөвлөж байна.

#### **7.2.6.3 Цахим тайлагналын системийн мэдээллийн технологийн шалгалт**

Ажлын даалгаварт цахим тайлагналын системийн МТ-ийн платформ, холбогдох МТ-ийн хяналт болон МТ-ийн орчны олон талын шалгалт хийхийг шаардсан.

Бид үүний дагуу шалгалтыг хийж системийн хөгжүүлэлт болон хэрэгжилт, түүний үйл ажиллагаа нь зохистой бөгөөд хангалттай хийгдэж байна гэж дүгнэсэн. Гэвч цаашид анхаарах шаардлагатай зарим асуудлаар дараах зөвлөмжийг өгч байна.

### **Зөвлөмж:**

**МОУИТБС-ийн цахим тайлангийн системийг гүйцэтгэгчээс бүрэн хүлээн авахдаа сонгон шалгаруулалтын материалд заагдсан шаардлагын дагуу дараах байдлаар хүлээн авах. Үүнд:**

- Системийг нөөц хувилбартайгаар хүлээн авах
- Системийн хэвийн ажиллагаанд шаардлагатай гарын авлагуудыг хүлээн авах (тухайлбал: Үйлдлийн систем суулгах, түүнд шаардлагатай аюулгүй байдлын тохиргоонуудыг хийх, нөөц хувилбарын тохируулах, өгөгдлийн санг суурилуулах гарын авлага)
- Системд цаашдын хөгжүүлэлтэд шаардлагатай эх кодыг авах
- Системийг дотроос болон гаднаас penetration test болон stress test хийлгэн хүлээн авах

### **Цахим системийн аюулгүй байдлын хувьд**

- Системийг SSL сертификат бүхий хандалттай болгох
- Цахим тайлангийн системийн үйлдлийн системийн шинэчлэлийг (update) байнга хийх
- Системд зөвхөн админ эрх бүхий хэрэглэгчийн хандах ip хаяг болон ямар портоор хандалтыг тохируулах ба бусад шаардлагагүй портыг хаах
- Цахим тайлангийн системийн хандалтын болон халдлагын шинжтэй мэдээллийг илрүүлэх болон таслан зогсоох системд хамруулах

### **Системийн үйл ажиллагааны зохистой байдлыг сайжруулах талаар**

- Цахим тайлангийн системд хандах хэрэглэгчдийн эрх, үүргийг нарийвчлах журамд тусгах



- Цахим тайлангийн системийг байрлуулах компанитай байгуулах гэрээнд тус системд зайлшгүй байх шаардлагатай аюулгүй байдал, нөөц хувилбар, өгөгдлийн санг хуулбарлах хамгаалах, ачааллыг хуваарилах, хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах талаар нарийн тусгах

### **7.2.7 ХАРААТ БУС НЭГТГЭГЧИЙГ ТОМИЛОХ ЦАГ ХУГАЦАА**

(2014 оны зөвлөмжийн давталт)

“Харт Нойрс Лтд” болон “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн консерциумыг Хараат бус нэгтгэгчээр томилох үед ихэнх байгууллагууд МОУИТБС-ын Ажлын албаны цахим тайлагналын системд тайлагнаагүй байсан.

Арай эрт сонгох нь Хараат нэгтгэгчид үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэх, тайлагналын маягтын агуулга гэх мэт талбаруудад ажиллах, ОУИТБС-н тайлагналын шаардлага, мэдээллийн баталгаажуулалт, тайлагнагч аж ахуйн нэгжүүдэд явуулсан заавар, удирдамж зэргийн талаар зөвлөх боломжийг олгох юм. Ингэснээр тохируулгын үйл явц болон мэдээлэл цуглуулалт, ОУИТБС-ын шаардлагын мөрдөлт зэрэг нь сайжирна. Түүнчлэн Хараат бус нэгтгэгчийг арай эрт томилох нь МОУИТБС-ын цаашдын тайлангийн хэвлэн нийтлэлтийн цаг хугацааг тогтооход туслах ёстой.

#### **Зөвлөмж**

Хараат бус нэгтгэгч нь тайлангийн бэлтгэлд орох орцыг ирүүлэхийн тулд аль болох эрт сонгогдож, үйл явцад хамрагдах ёстой. Хараат бус нэгтгэгч нь цахим тайлагналын системийн агуулгын талаар шийдвэр гаргахаас өмнө 1 сарын сүүлээр хамруулах ёстой.



**ХАВСРАЛТУУД**